

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



# ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2020 №01 (71)  
18 дахь жилдээ

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### ЭРХЛЭГЧ

**Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Батбуян БАТ-ЭРДЭНЭ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бөхчулуун Бат-Эрдэнэ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бадам БАТЗОРИГ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Баатар БОЛДБААТАР**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Насанжаргал ГАНБАДРАЛ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Жамсран ДОЛГОРСҮРЭН**  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

**Наваанпэрэнлэй ЖАНЦАН**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Авирмэд ЛХАГВА**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Ганбат ЭРДЭНЭБАТ**  
ДОКТОРАНТ

**Батзэвэг ЭНХБОЛД**  
ДОКТОР (Ph.D)

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**Сэнгээ ГАНТУЛГА**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

**Сэнгээ ГАНТУЛГА**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

### ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

**Бэгзсүрэн Жамсран**

## ГАРЧИГ

### КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: онол-дүн шинжилгээ	<i>Б.Энхболд</i>	<b>4</b>
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам	<i>Ж.Төгс-Очир Ц.Насанбат</i>	<b>16</b>
A brief introduction about fraud in letter of credit payment and Vietnam letter of credit law	<i>Bui Le Thuc Linh</i>	<b>22</b>
Эмх замбараагүйн онол ба экологийн үзэл баримтлалд тулгуурлан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоох нь	<i>Э.Дашгаадан</i>	<b>32</b>
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын онолын асуудалд	<i>Т.Мөнхдалай</i>	<b>39</b>
Далд эдийн засаг ба эдийн засгийн аюулгүй байдлын хамаарлын онолын асуудал	<i>Ү.Анхбаяр</i>	<b>45</b>
Жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн ойлголт, шалтгаан нөхцөл, эрх зүйн зохицуулалт	<i>Э.Оюунтүлхүүр</i>	<b>50</b>

### ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, харьцуулсан эрх зүйн асуудал	<i>Г.Гантөмөр</i>	<b>57</b>
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн судалгаа	<i>Н.Одонтуул</i>	<b>64</b>
Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны үүсэл, хөгжлийн асуудал	<i>Г.Билгүүн</i>	<b>73</b>

### ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Мөрдөн шалгах нууц ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал /ОХУ, Украин, Казахстан, Киргизстан улсын жишээн дээр/	<i>А.Лхамсүрэн</i>	<b>79</b>
Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны уламжлал, шинэчлэл	<i>Б.Номун-Эрдэнэ</i>	<b>83</b>

### ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн албаны галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн ойлголт, ангилал, хэрэглэхэд анхаарах асуудал	<i>Ш.Чулуун</i>	<b>88</b>
Цагдаагийн байгууллагын объектын судалгааны өнөөгийн байдал	<i>Г.Бямбадорж</i>	<b>94</b>

### ИРГЭН, ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Legal regulation for loan contract in mongolia	<i>Otgongerel Jantsan</i>	<b>101</b>
Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ цуцалсан шийдвэрт хийсэн шинжилгээ	<i>Э.Чулуунцэцэг</i>	<b>111</b>

### СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ

Формирования профессиональной культуры будущих юристов на основе контекстного обучения	<i>Светличный Евгений Григорьевич Лейнова Ольга Сергеевна Светличная Надежда Ивановна</i>	<b>121</b>
Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй ярилцлага хийх арга зүй	<i>О.Баяржаргал</i>	<b>125</b>
Head of the state auto inspection the main subject of making road safety	<i>Yagaantsetseg Battulga</i>	<b>130</b>

# КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ: ОНОЛ- ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Энхболд

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,  
криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

### Удиртгал

Цагдаагийн ерөнхий газраас 2019 онд Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг хором”, “Ойлгоё, хүндэлье”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш ээ дүрмээрээ” зэрэг соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ирсэн нь үр дүнтэй ажил болсон гэж үздэг.

Сүүлийн жилүүдэд залилах гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлын хэмжээ 2016 онд 2 тэрбум орчим төгрөг байсан бол 2017 онд 6.4 тэрбум, 2018 онд 9.9 тэрбум төгрөг болж өсөж, 2019 онд 13 тэрбум төгрөгт хүрсэн байна.<sup>1</sup> 2011 онд залилах гэмт хэрэг 688 бүртгэгдэж байсан бол 2019 онд 4600 болж 6.8 дахин өссөн үзүүлэлт гарчээ.

Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор Цагдаагийн Ерөнхий газар, Монгол банк, Монголын банкны холбоо хамтран иргэдийг санхүүгийн залилан, луйвраас сэрэмжлүүлэх зорилго бүхий “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулсны үр дүнд энэ төрлийн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувиар буурсан гэж дүгнэсэн.

Гэтэл урьдчилан сэргийлэх чиглэлээр чиглэсэн арга хэмжээ зохион байгуулаагүй байхад хулгайлах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын болон зам тээврийн осол зэрэг бусад гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2020 оны 1 дүгээр сард буурсан үзүүлэлттэй байгаа нь залилах гэмт хэргийн бууралтад тухайн нөлөөллийн арга хэмжээ бодитой нөлөөлсөн эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм.

Тиймээс залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний үр нөлөөг тоон болон чанарын аргаар дүн шинжилгээ хийж үр дүнг нарийвчлан тооцох шаардлага тулгарч байна.

Дүн шинжилгээ хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын онол- эрх зүйн үндэс, нөлөөллийн арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, тухайн гэмт хэргийн бууралтын хувь хэмжээнд гарсан тооны өөрчлөлт болон иргэдийн хандлагад гарсан өөрчлөлтөд чанарын дүн шинжилгээ хийхийг зорьсон.

### 1. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол-эрх зүйн үндэс

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын агуулга нь иргэдийн аюулгүй тайван орчинд амьдрах эрхийг баталгаатай хангахад чиглэгддэг. Тиймээс эрдэмтэн судлаачид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар онолын олон хувилбарыг боловсруулан иржээ. Криминологийн шинжлэх ухааны уламжлалт хандлагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг “Хүн яагаад гэмт хэрэг үйлддэг бэ?” гэсэн асуултад анхаарал хандуулан хэрэгжүүлж ирсэн бол орчин үед “Гэмт хэрэг хэрхэн үйлдэгдэж байна бэ?” гэдэг асуултад анхаарал хандуулах болсон.<sup>2</sup> Үүнийг нөхцөл байдалд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага буюу “Situational Crime Prevention Approach” гэж нэрлэдэг.

<sup>1</sup> Цагдаагийн ерөнхий газар. “Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал-2019”. УБ., 2020

<sup>2</sup> Brantingham, P. L., Brantingham, P. J., & Taylor, W. (2005). Situational crime prevention as a key component in embedded crime prevention. Canadian Journal of Criminology and Criminal Justice/La Revue canadienne de criminologie et de justice pénale, 47(2), 271292

Нөхцөл байдалд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг буруулахад чиглэгддэг. Энэ нь онолын хүрээнд гэмт хэрэг хаана, хэзээ, хэрхэн үйлдэгдэж байгааг тодорхойлсны үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг.

Орчин үед нөхцөл байдалд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлрээр дараах 3 онолын хандлага давамгайлж байна. Үүнд: 1/Зохист шийдвэр онол- (Rational Choice Perspective), 2/Хэвийн үйл ажиллагааны онол (Routine Activity Approach) 3/Гэмт хэргийн хэв шинжийн онол (Crime Pattern Theory) зэрэг болно.

*Зохист шийдвэр гаргах онол* нь гэмт хэрэг нь зорилготой үйл ажиллагаа бөгөөд гэмт хэрэг үйлдэгчид нь өөрт ашигтай шийдвэр гаргадаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хувьд ашигтай байвал ямар ч хүн гэмт хэрэг үйлдэх боломжтой гэж үздэг.<sup>3</sup> Зохист шийдвэр гаргах онол 18 дугаар зууны утилитарист үзэлд үндэслэсэн учраас криминологийн сонгодог онолтой нийлээд холбоотой. Криминологийн сонгодог онолыг Эрүүгийн хуульд тусгаж хэрэгжүүлсэн бол зохистой шийдвэр гаргах онолыг эдийн засагт тусгаж, хэрэгжүүлсэн байдаг. Харин 1960-аад оноос зохистой шийдвэр гаргах онолыг хууль зүйн шинжлэх ухаанд оруулж, Эрүүгийн хууль тогтоомжийг боловсруулахдаа харгалзан үзэх болсон.

2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд залилах үйлдлийн улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учруулсан тохиолдолд (240.000 төгрөг) гэмт хэрэг болохоор хуульчилсан нь олон талаар эдийн засгийн ашигтай байдлыг гэмт хэрэг үйлдсэн хүмүүст олгож байсан тул 2015 оны Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд хэлбэрийн шинжтэй хохирол учирсан байхыг шаардахгүй байдлаар хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нуугдмал гэмт хэргийг илрүүлж, хяналтад авах боломжийг бүрдүүлсэн байх боломжтой. Дээрх байдлаар хуульчилсан нь залилах гэмт хэрэг үйлдэгчдэд хэрхэн нөлөөлж байгааг тусгайлан судлах шаардлагатай.

*Хэвийн үйл ажиллагааны онол* нь гэмт хэрэг яагаад, хэрхэн үйлдэгддэг хүчин зүйлсийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулдаг.<sup>4</sup> Энэ онолын үүднээс гэмт хэрэг үйлдэгдэхэд (1) гэмт хэрэг үйлдэх сэдэл бүхий хүн, (2) гэмт хэрэгт өртөх боломжтой объект буюу хохирогч, (3) гэмт хэргийг хянах тогтолцоо бүрдээгүй байх гэсэн 3 элемент нөлөөлдөг. Тус онол нь үндсэн гурван элементэд өөрчлөлт оруулсан тохиолдолд гэмт хэргийн түвшин өөрчлөгдөнө гэж үздэг бөгөөд гурван элемент гурвуулаа байгаа тохиолдолд гэмт хэргийн түвшин бүр их есөн нэмэгдэнэ гэж үздэг.

Судлаачид хүнийг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нөлөөллийн олон талт арга хэмжээ хэрэгжүүлэх, гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг хаасан хяналтын тогтолцоог (камерын хяналт, үр нөлөөтэй хууль сахиулах ажил) бүрдүүлж чадсанаар гэмт хэрэг үйлдэх сэдэл бүхий хүн гэмт хэргээс татгалздаг гэж үздэг.<sup>5</sup>

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 6 дугаар сарын 9-ний өдөр баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг 1/ ерөнхий; 2/ тусгай, 3/ нэг бүрчилсэн, 4/ соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлнэ гэж заасан. Хэвийн үйл ажиллагааны онол нь соёл гэгээрүүлэх чиглэлд түлхүү хамаарч байна. Соён гэгээрүүлэх чиглэл гэж "Хүн, хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн цогц арга хэмжээ"<sup>6</sup> гэж заасан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;
- Гэмт хэрэг, зөрчилд өртөх тэдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөх эрсдэлийн талаар таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдэгдэл, зөвлөмж өгөх;
- Этгээдэд өөрийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх;

<sup>3</sup> Cornish, D.; Clarke, R. (1987). "Understanding crime displacement: An application of rational choice theory". *Criminology*. 25 (4): 933–947

<sup>4</sup>Felson, Marcus (1987), 'Routine Activities and Crime Prevention in the Developing Metropolis', *Criminology*, Vol. 25, No. 4, pp. 911-31.

<sup>5</sup> Bowers, K. J., & Guerette, R. T. (2014). Effectiveness of Situational Crime Prevention. In *Encyclopedia of Criminology and Criminal Justice* (pp. 1318-1329). Springer New York.

<sup>6</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.// Төрийн мэдээлэл, УБ., 2019. №42

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэхээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, дадал, чадварыг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах;
- Гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх зэрэг болно.

Тус хуулийн дөрөвдүгээр бүлэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нутгийн захиргааны байгууллагууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн оролцооны талаарх зохицуулалтыг тусгасан нь гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бололцоог хянах зохицуулалт болсон. Тухайлбал, тус хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх”, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний онолын үндэс юм.

*Гэмт хэргийн хэв шинжийн онол* нь тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргийн тоон үзүүлэлт (халуун цэг), гэмт хэрэгт өртөж буй хохирогчдын нийтлэг шинж (давтан хохирох) дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулахад чиглэгддэг.<sup>7</sup> Энэ онол нь гэмт хэрэг үйлдэх таатай орчин, хохирч болох хүмүүсийг гэмт хэрэгтэн сонгодог гэж үздэг бөгөөд тодорхой төрлийн гэмт хэргийг хянах, урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэргийн газрын зураглалыг (Crime mapping, Compstat) өргөнөөр ашигладаг. 2019 оны байдлаар залилах гэмт хэргийг үйлдэгдэж буй нутаг дэвсгэрээр нь авч үзвэл, нийт гэмт хэргийн 85 орчим хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, үүнээс Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж байгаа бол Орхон, Дархан-Уул аймагт хамгийн өндөр үзүүлэлттэй байна.<sup>8</sup>

## 2. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Ятгах тусам нягтал” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд зохион байгуулжээ.

Уг арга хэмжээнд төв, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн бие бүрэлдэхүүн Мөрдөн байцаах алба, тасаг оролцож, залилах гэмт хэргийн үйлдлийн арга, шалтгаан, нөхцөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн 578 ажил, арга хэмжээ зохион явуулж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, мөрдөгчийн мэдэгдэл 228 бичиж, 100 мэдэгдлийн хариуг авч, 45 мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлыг газар дээр нь шалгасан байна.

Арга хэмжээний хүрээнд 326 төрийн, 119 төрийн бус, 402 аж ахуйн нэгж, байгууллагад аяныг сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, иргэдэд чиглэсэн 300 төрлийн 859 ажил арга хэмжээг зохион явуулсан байна.

Улаанбаатар хотын 4 чиглэлийн төв зам дагуу самбар, “JCDecaux” ХХК-ийн 28 автобусны буудал, “ССТS” ХХК-ийн зам дагуух 20 самбар нийт 52 самбарт мэдээлэл байршуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн зөвлөмжийг 20305 ширхэгийг олон нийтэд тарааж, үүрэн холбооны оператор компанийн нийт 2.568.214 хэрэглэгчид “Ятгах тусам нягтал”, “Залилагчид боломж бүү олго” гэсэн агуулгатай зорилтот мессеж хүргэж ажиллажээ.

Хүснэгт№ 1 Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон үзүүлэлт

Д/д	Төрөл	Тоо	Үзсэн хүний тоо	Хуваалцсан тоо	Таалагдсан байдал
1.	Урьдчилан сэргийлэх, нөлөөллийн видео контент	16	3,854,289		

<sup>7</sup> Brantingham, P.L. and Brantingham, P. J. (1993). Environment, routine and situation: toward a pattern theory of crime. New Brunswick NJ, Transaction Publishers, 259-294.

<sup>8</sup> Цагдаагийн ерөнхий газар. “Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал-2019”. УБ., 2020

2.	Цахим шууд дамжуулалт	18	1,254,367		
3.	Зорилтот мэдээ, мэдээлэл	19	1,356,248		
4.	Зурган постер	7	1,568,359	5746	16418
5.	Орон нутгийн мэдээ, мэдээлэл	38	706,968	4536	412290
Нийт		98	8,740,231		

Мөн арга хэмжээний талаар “МҮОНРТ”, “Монгол HD”, “TV5”, “UBS”, “TV9”, “MN25”, “VTV”, “SBN” зэрэг 23 телевиз, өдөр тутмын 5 сонин, 37 сайт, 6 ФМ радиогоор 26 мэдээ сурвалжлага, 112 ярилцлага өгсөн.

Мэдээллийн агуулгыг ангилан авч үзвэл, 1)Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, арилжих, барьцаалах, иргэд хооронд өндөр хүүтэй мөнгө зээлэх нэрээр бусдыг залилах, 2)Гадаад улсад зорчих виз гаргаж өгнө, 3)Иргэдийн цахим шуудан, фэйсбүүк хаягт хууль бусаар нэвтрэн тэдний нэрээр ойр дотны найз, нөхөд, ах, дүү нараас яаралтай мөнгөний хэрэгцээ гарлаа туслаач гэж мөнгө шилжүүлж авах, 4) Иргэдээс гар утас худалдаж авна, утсаар чинь яриад өгье гэх зэргээр гар утас залилах, 5)Хуурамч баримт бичиг ашиглан бусдын эд хөрөнгийн өмчлөх эрхийг залилах, 6)Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны арга буюу олны нэрлэж заншсан сүлжээний бизнес, 7)Төрийн байгууллагад ажилд оруулахад зуучлах нэрээр бусдыг залилах зэрэг үйлдлийн аргаар төрөлжүүлэн залилах гэмт хэрэгт хохирохоос сэрэмжлүүлсэн мэдээ байна.

#### Судалгааны асуулт

##### Таамаглал-1:

*Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн нөлөөллийн арга хэмжээ энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бодитой нөлөө үзүүлсэн байх боллмжтой;*

##### Таамаглал-2:

*Нөлөөллийн арга хэмжээний үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулах байдлаар шууд дүгнэх нь алдаатай байх боломжтой;*

##### Таамаглал-3:

*Нөлөөллийн арга хэмжээний үр нөлөө нь ирээдүйд үйлдэгдэх залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд илүү үр нөлөөтэй;*

##### Таамаглал-4:

*Зарим төрлийн гэмт хэрэг 2020 оны 01 дүгээр сард буурсан үзүүлэлт нь өмнөх саруудад хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээтэй холбоотой;*

##### Таамаглал-5:

*Залилах гэмт хэргээс өөрийгөө хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэгт өртөхгүй байх иргэдийн мэдлэг, хандлагад зэрэг өөрчлөлт гарсан байх боломжтой зэрэг таамаглал дэвшүүлсэн.*

### 3. Дүн шинжилгээ хийсэн арга зүй

**Судалгааны хүрээ:** 1/Залилах гэмт хэргийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өсөлт, бууралтын түвшин, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох; 2/“Ятгах тусам нягтал” арга хэмжээний хүрээнд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн хандлагад гарсан өөрчлөлтийг тодорхойлох; 3/Статистикийн тодорхой аргачлалд үндэслэн залилах гэмт хэргийн чиг хандлагыг тодорхойлох-зэрэг болно.

**Судалгааны арга:** Баримт бичиг, тоон мэдээнд дүн шинжилгээ хийх, санал асуулга, прогнозлох аргыг ашигласан. Тоон мэдээнд дүн шинжилгээ хийхдээ 2019, 2020 оны 1 дүгээр сарын гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээллийг ашигласан, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн хандлагад гарсан өөрчлөлтийг тодорхойлохдоо Улаанбаатар хотын 324 иргэнийг дунд санал асуулгын аргаар явуулсан судалгааны үр дүнг ашигласан бол залилах гэмт хэргийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өсөлт, бууралтын түвшин, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлохдоо “Нэг хором”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш ээ дүрмээрээ”, “Ойлгоё, Хүндэлье” зэрэг өмнө зохиогдож байсан нөлөөллийн арга хэмжээний үр дүнг тус тус харьцуулан дүн шинжилгээ хийсэн болно.

*Тоон мэдээллийг боловсруулсан аргачлал:*

Бодсон томъёо: Өсөлт, бууралтын хувь =  $\frac{\text{Тухайн сарын түвшин}}{\text{Өмнөх сарын түвшин}} * 100\% - 100\%$

Энэ өсөлт, бууралт нэмэх гарвал өссөн, хасах гарвал буурсан гэх үзүүлэлтийг харуулна.

Саруудын дундаж өсөлт, бууралтыг тооцоолох томъёо:

Дундаж өсөлт, бууралтын хувь =  $\frac{2-12 \text{ дахь сарын өмнөх сарын түвшинтэй харьцуулсан өсөлт, бууралтын нийлбэр}}{11}$


#### 4. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд хийсэн шинжилгээ

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэрэг улсын хэмжээнд 2020 оны 1 дүгээр сард 543 бүртгэгдсэн нь өмнөх оны 1 дүгээр сартай харьцуулахад 15.3 хувиар буюу 98 хэргээр буурсан. Үүнээс нийслэлд үйлдэгдсэн гэмт хэрэг 17.1 хувиар буюу 92 хэргээр, орон нутагт үйлдэгдсэн гэмт хэрэг 6 хувиар буюу 6 хэргээр тус тус буурсан байна.

Дээрх тоон мэдээнээс үзэхэд, “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээ залилах гэмт хэргийн гаралтад нөлөөлсөн байх боломжтой ч өмнөх оны мөн үетэй харьцуулж шууд дүгнэх боломжгүй. Гэмт хэргийн нөхцөл байдал нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй шууд холбоотой, түүнээс хамаарч байдаг хувьсамтгай үзэгдэл юм.

2019 онд залилах гэмт хэрэг 7303 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 1931 буюу 26.4 хувиар өссөн бөгөөд хэргийн хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж үзвэл, 5 дугаар сард 780 хэрэг бүртгэгдсэн нь (10.6 хувь) хамгийн өндөр үзүүлэлт байсан бол 7 дугаар сард 417 болж буурсан (5.7 хувь) нь тухайн жилийн хамгийн бага үзүүлэлт байжээ. (График №1)

График №1 Залилах гэмт хэргийн хөдөлгөөнд хийсэн шинжилгээ (2019 оны 1-12 сар, 2020 оны 1 сар)



Залилах гэмт хэргийн сарын дундаж өсөлтийн хурдыг тодорхойлох зорилгоор сар бүрийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж үзвэл, 6, 7 дугаар сард 27 орчим хувь буурсан бол 8 дугаар сард 29.7 хувь өсч, сарын дундаж өсөлтийн хурд 1.43 хувь байжээ. (Хүснэгт №2)

Хүснэгт №2. 2019 онд бүртгэгдсэн залилах гэмт хэрэгт хийсэн динамик эгнээний шинжилгээ (1-12 сар)

2019 он	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	Өсөлт/ бууралт
1 сар	641	
2 сар	556	-13.2
3 сар	597	7.3
4 сар	647	8.3
5 сар	780	20.5
6 сар	572	-26.6
7 сар	417	-27.0
8 сар	541	29.7




9 сар	600	10.9
10 сар	618	3
11 сар	600	-2.9
12 сар	643	7.1
Дундаж өсөлт, бууралтын хувь		<b>1.43</b>
<b>2020 оны 1 сар</b>	<b>543</b>	<b>-15.5</b>
<b>Дунджаас өссөн/ буурсан хувь</b>		<b>-14.07</b>

Дээрх тоон үзүүлэлтээс дүгнэхэд, 2020 оны 1 дүгээр сард залилах гэмт хэрэг 543 бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 15.5 хувиар буурсан нь жилийн дунджаас 14.07 хувиар доогуур үзүүлэлт байжээ.

Мөн 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөн буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь нөлөөллийн арга хэмжээ явуулсантай холбоотойгоор залилах гэмт хэргийн буурсан гэх дүгнэлтийг эргэлзээтэй болгож байна.

Тиймээс сүүлийн 3 жилийн 1 дүгээр сард бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулан дүн шинжилгээ хийсэн болно. Судалгаанаас үзэхэд, хулайлах гэмт хэрэг жил дараалан буурсан бол дээрэмдэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд сүүлийн 2 жил, залилах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд зөвхөн 2020 онд буурсан үзүүлэлттэй байна. (График №2)

График №2 Зарим төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал (2018-2020 он, хувиар)



Дээрх судалгаанаас үзэхэд, түгээмэл үйлдэгддэг зарим төрлийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүгд буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн, 2019 онд бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэргийг сар бүрээр харьцуулан, сарын дундаж өсөлт, бууралтыг 2020 оны 1 дүгээр сартай харьцуулах байдлаар залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулсан нөлөөллийн арга хэмжээний үр дүнг тооцох боломжтой. Зарим төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг тухайн сард хэрэгжсэн нөлөөллийн арга хэмжээтэй харьцуулан үзүүлбэл: (Хүснэгт №2)

Хүснэгт №2 Зарим төрлийг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн динамик эгнээний шинжилгээ (2019, 2020 он)

2019 он	Залилах ЭХ-17.3		Хулгайлах ЭХ-17.1		ХЭМХБЭГХ ЭХ-11.1-11.6		ГБХУ ЭХ-11.7		Дээрэмдэх ЭХ-17.2		ХАБТХАЖЭГ Х ЭХ-27.1-10	
	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)
1 сар	641	(%)	1306	(%)	827	(%)	48	(%)	106	(%)	147	(%)
2 сар	556	-13.2	904	-30.7	740	-10.5	35	-34.2	97	-8.4	155	5.4
3 сар "Нэг хором"	597	7.3	1098	21.4	852	15.1	26	-27.0	127	30.9	224	44.5
4 сар	647	8.3	1071	-2.4	821	-3.6	33	-25.7	108	-14.9	209	-6.6


5 сар	780	20.5	1200	12.0	924	12.5	20	26.9	118	9.2	258	23.4
6 сар "Яараад яахав"	572	-26.6	1034	-13.8	857	-7.2	29	-39.3	87	-26.2	259	0.3
7 сар	417	-27.0	1238	19.7	815	-4.9	25	45	112	28.7	241	-6.9
8 сар	541	29.7	1167	-5.	837	2.6	34	-13.7	99	-11.6	244	1.2
9 сар	600	10.9	1085	-7.0	863	3.1	42	36	90	-9.0	232	-4.9
10 сар "Дураар биш ээ дүрмээрээ"	618	3	1219	12.3	966	11.9	28	23.5	105	16.6	216	-6.8
11 сар	600	-2.9	977	-19.8	834	-13.6	12	-33.3	90	-14.2	180	-16.6
12 сар "Олгоё хүндэлье"	643	7.1	640	-34.4	497	-40.4	48	-57.1	40	-55.5	122	-32.2
Дундаж өсөлт, бууралт		1.43		-4.3		-2.9		-3.1		-4.9		0.06
2020 оны 1 сар Ятгах тусам нягтал	543	-15.5	902	40	651	30	15	25	70	75	120	-1.6
Дунджаас өссөн, буурсан хувь		-14.07		36.6		27.1		21.9		71.1		-1.54

2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх сартай харьцуулвал, залилах гэмт хэрэг 15.5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1.6 хувь буурч, хулгайлах гэмт хэрэг 40.1 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 75 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 25 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30 хувиар тус тус өссөн байна.

Залилах гэмт хэрэг нь үйлдэгдсэн даруйдаа бүртгэгдэх нь харьцангуй цөөн байдгаараа бусад төрлийн гэмт хэргээс онцлогтой юм. "Ятгах тусам нягтал" нөлөөллийн арга хэмжээ энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хангалттай ойлголт өгсөн эсэхийг бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг хугацаагаар шалгаж болно.

2019, 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн залилах гэмт хэргийн үйлдэгдсэн цаг хугацаагаар нь авч үзвэл, (График №3)


График №3 Нэгдүгээр сард бүртгэгдсэн залилах гэмт хэргийн үйлдэгдсэн хугацаа, тоогоор



2019 оны 12 дугаар сард үйлдэгдээд 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн хэрэг 142 байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувь, 1 дүгээр сард үйлдэгдээд тухайн сардаа буюу 1 дүгээр сард бүртгэгдсэн хэрэг 120 байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Харин 3-4 жилийн өмнө үйлдэгдээд 1 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг 33 (3.1 дахин), 5-8 жилийн өмнө үйлдэгдсэн 8 хэргээр (2 дахин) өсчээ. Бусад хугацааны хувьд онцын өөрчлөлтгүй байна. Энэ нь нөлөөллийн арга хэмжээ бүртгэгдсэн хэрэгт бага зэрэг нөлөөлсөн гэж дүгнэж болно.

Нөлөөллийн арга хэмжээ явагдсан хугацаанд залилах гэмт хэрэг үйлдсэн аргыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл, гэрээгээр халхавчилж үйлдсэн хэрэг 5.8 хувь, виз гаргана гэж үйлдсэн хэрэг 16.6 хувиар, цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн хэрэг 50 хувь, хүүтэй мөнгө зээлүүлнэ гэсэн хэрэг 7.4 хувиар тус тус өссөн бол мал мах зарна гэж залилсан хэрэг 52.7, автомашин худалдах, худалдан авах явцад залилсан хэрэг 20 хувь, бусад хэлбэрээр залилсан хэрэг 30.1 хувиар тус тус буурчээ. (График №4)

График №4 Залилах гэмт хэрэг үйлдсэн аргыг харьцуулсан байдал, тоогоор



Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэхдээ гэрээгээр халхавчлах, виз гаргах, цахим хэрэгсэл ашиглах, хүүтэй мөнгө зээлүүлэх зэрэг аргаар үйлдсэн гэмт хэргийн хувьд нөлөөллийн арга хэмжээ шууд нөлөөлөөгүй байна. Дээрх аргаар үйлдэгдсэн гэмт хэргүүд нь үйлдэгдэх үедээ хууль ёсны мэт харагдаж иргэд төөрөгдөх магадлал өндөр, нөгөө талаар нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаас өмнө үйлдэгдсэн байх боломжтой. Иймээс нөлөөллийн арга хэмжээ дээрх аргаар үйлдэгдэж байгаа хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөө үзүүлсэн эсэх нь тодорхой хугацааны дараа бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Харин бага хэмжээний эд хөрөнгө болон эд хөрөнгө нь тэр даруйдаа иргэд хооронд шилжих боломжтой мал мах, автомашин худалдах, худалдан авах болон нэг удаагийн илт хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхэд нөлөөллийн арга хэмжээ шууд нөлөөлсөн гэж дүгнэж болно.

### 5. Иргэдийн хандлагад гарсан өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээ

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээний үр нөлөөг шалгах зорилгоор Улаанбаатар хотын 324 иргэнээс асуулга авч, дүнг нэгтгэсэн.


Судалгаанд оролцогчдын 44.6 хувь эрэгтэй, 55.4 хувь эмэгтэй хүмүүс байсан бөгөөд “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээний талаарх мэдээллийг хамгийн их хүлээн авсан эх сурвалжаа нэрлэнэ үү? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 43.2 хувь нь facebook хаягнаас мэдээлэл хүлээн авсан гэж хариулжээ. (График №3)

График №3 “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээний талаарх мэдээлэл хүлээн авсан эх сурвалж, хувиар



Залилах гэмт хэргийн тархалт хүн амын дунд ямар түвшинд байгааг тодорхойлох зорилгоор “Та болон таны ойр дотны хэн нэгэн хүн өнгөрсөн жилийн хугацаанд ямар нэгэн хэлбэрээр өөрийн эд хөрөнгөө бусдад залуулж байсан тохиолдол байгаа юу?” гэсэн асуулт тавьж, ирээдээс өгсөн асуултыг нэгтгэн харуулбал, (График №4)


График №4 Залилах гэмт хэрэгт хохирсон байдал, хувиар




Судалгаанаас харахад, иргэд өөрөө болон ойр дотны хэн нэгэн хүн залилах гэмт хэргийн улмаас хохирч байсан гэж 63.4 хувь нь хариулжээ. Эндээс үзэхэд, иргэдийн дунд бусдын эд хөрөнгийг залилах явдал бодитойгоор оршиж байгаа харуулж байна.

Иргэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөөллийн арга хэмжээ хэрхэн нөлөөлсөн байдлыг тодорхойлох үүднээс дараах 2 асуултыг тавьж, хариултыг график №5, 6-т нэгтгэн харуулав.


**График №5** “Та энэ аяны хүрээнд өөрийгөө залилах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах хангалттай ойлголттой болсон гэж дүгнэж байна уу?”



**График №6** “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээ залилах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд хангалттай нөлөөлсөн гэдэгтэй санал нийлэх үү?”



Судалгаанд оролцсон иргэдийн 93 орчим хувь нь “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээ хувь хүнд болон олон нийтэд хангалттай мэдээлэл өгч, өөрсдийгөө хамгаалах мэдлэгтэй болгож чадсан гэдэгтэй санал нийлсэн байна. “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээ таныг ямар ба нэгэн чухал шийдвэр гаргахад нөлөөлж чадсан уу? гэсэн асуултад хариулсан байдлыг үзье. (График №7)



Дээрх асуултыг бататгах зорилгоор “*Та цаашид өөрийн эд хөрөнгө, түүний эзэмших эрхтэй холбоотой асуудлыг бусдад шилжүүлэхдээ нягталж сонор сэрэмжтэй байх үүднээс “Ятгах тусам нягтал” зөвлөмжийг баримтлах уу?*” гэсэн асуултад судалгаанд оролцогчид 100 хувь дээрх зөвлөмжийг дагаж мөрдөнө гэж хариулжээ.

### **Дүгнэлт- Хэлэлцүүлэг**

1. Монгол Улс дахь гэмт хэргийн бүтцэд 23.1 хувийг эзэлж байгаа залилах гэмт хэрэг 2019 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувь, өмнөх сартай харьцуулахад 15.5 хувиар тус тус буурчээ. Харин 2019 онд залилах гэмт хэргийн сарын дундаж өсөлт 1.4 хувь байсан бол 2020 оны 1 дүгээр сард өсөлт ажиглагдаагүй, бууралтын цэвэр үзүүлэлт 14.0 хувьтай байсан нь *залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн нөлөөллийн арга хэмжээ урьдчилан сэргийлэхэд бодитой нөлөөлсөн байх боломжтой гэсэн таамаглал батлагдаж байна.* (Хүснэгт №2) Хэвийн үйл ажиллагааны онолын үүднээс авч үзвэл, аливаа хүнийг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нөлөөллийн олон талт арга хэмжээ хэрэгжүүлэх, гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг хаасан хяналтын тогтолцоог (камерын хяналт, үр нөлөөтэй хууль сахиулах ажил) бүрдүүлж чадсанаар гэмт хэрэг үйлдэх сэдэл бүхий хүн гэмт хэргээс татгалздаг гэж үздэг. Ятгах тусам нягтал нөлөөллийн арга хэмжээний хүрээнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх боломж нөхцөлийг хаахад чиглэгдсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 8 сая орчим хүнд нөлөөлжээ.

2. 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, залилах гэмт хэрэг 15.3 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 21.2 хувь, хулгайлах гэмт хэрэг 30.9 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 79.2 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 33.9 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 18.3 хувиар тус тус буурчээ. Сүүлийн 3 жилийн 1 дүгээр сард хулгайлах гэмт хэрэг жил дараалан буурсан бол дээрэмдэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд сүүлийн 2 жил, залилах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд зөвхөн 2020 онд буурчээ. (График №2) Эндээс дүгнэхэд залилах болон хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс бусад хэргүүд 1 дүгээр сард буурдаг зүй тогтол энэ жил мөн давтагдсан байна. Зөвхөн энэ жилийн 1 дүгээр сард буурсан залилах гэмт хэргийн гаралтад “Ятгах тусам нягтал” арга хэмжээ нөлөөлсөн байх боломжтой бол ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амралт эхэлсэн, шинэ төрлийн короновирусын дэгдэлттэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр олон нийтийн ажил, арга хэмжээг хязгаарласан зэрэг хүчин зүйлс нь зам тээврийн осолтой холбоотой гэмт хэрэг буурхад нөлөө үзүүлжээ. *Үүнээс үзвэл зарим төрлийн гэмт хэрэг 2020 оны 01 дүгээр сард буурсан нь өмнөх саруудад хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээтэй холбоотой гэсэн таамаглал бүрэн батлагдахгүй байна.*

3. 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн дээрх гэмт хэргүүдийг өмнөх сартай нь харьцуулан үзвэл, залилах гэмт хэрэг 15.5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1.6 хувиар тус тус буурч, хулгайлах гэмт хэрэг 40.1 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 75 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 25 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30 хувиар тус тус өсчээ. Эндээс дүгнэхэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дээрх төрлийн гэмт хэргүүд буурсан боловч, өмнөх сартай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Улирлын чанартай үйлдэгддэг онцлог гэмт хэргүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулах нь ач холбогдолтой боловч бүх гэмт хэргийг энэ аргачлалаар дүгнэх нь учир дутагдалтай. (Хүснэгт №2) Тухайлбал, согтуугаар үйлдэгддэг хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг жил бүрийн 12, 3 дугаартай сартай харьцуулах нь оновчтой байх талтай ч залилах гэмт хэргийг энэ аргачлалаар дүгнэх боломжгүй. *Дээрх судалгаанаас үзэхэд гэмт хэргийн гаралт харилцан адилгүй байгаа нь нөлөөллийн арга хэмжээний үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулах байдлаар шууд дүгнэх нь алдаатай байх боломжтой гэсэн таамаглалыг бататгаж байна.* Гэмт хэрэг нь нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, бусад өөрчлөлттэй холбоотойгоор өөрчлөгддөг нийгмийн үзэгдэл учраас жилийн дундаж үзүүлэлт, өмнөх сартай нь харьцуулан дүгнэх нь илүү оновчтой.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээ нь ямар төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн бэ? гэдгээс хамаарч тухайн болон дараагийн сарын гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх хандлагатай байна. Тухайлбал, “Нэг хором аян”-ны хүрээнд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2019 оны 3

дугаар сард өмнөх сартай харьцуулахад 15.1 хувиар өсч, 4 дүгээр сард 3.6 хувиар буурсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх сартай харьцуулахад 27.0, 4 дүгээр сард 25.7 хувиар тус тус буурсан, Харин 12 дугаар сард зохион байгуулсан “Ойлгоё, хүндэлье” арга хэмжээний хүрээнд дээрх төрлийн гэмт хэрэг өмнөх сартай харьцуулахад 57.1 хувиар буурсан, “Дураараа биш ээ дүрмээрээ” аяны хүрээнд зам тээврийн осолтой холбоотой гэмт хэрэг өмнөх сартай харьцуулахад 6.8 хувь, дараагийн сард 16.6 хувиар тус тус буурсан байна. Харин “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд залилах гэмт хэрэг өмнөх сартай харьцуулахад 15.5 хувиар буурсан бол 2020 оны 2 дугаар сард 0.2 хувиар өссөн байна. Энэ нь нөлөөллийн арга хэмжээний үр нөлөө нь ирээдүйд үйлдэгдэх залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд илүү нөлөө үзүүлэх боломжтой гэсэн таамаглалыг үгүйсгэж байна.

Нөлөөллийн арга хэмжээ нь гэмт хэргийг тодорхой хугацааны дотор тогтоон барих, бууруулахад илүү үр дүнтэй бөгөөд уг арга хэмжээг зогсоосноор гэмт хэрэг өсөх хандлага ажиглагддаг гэсэн зарим судлаачдын дүгнэлтийг дээрх үр дүн бататгаж байна.<sup>9</sup> Нөгөө талаар залилах гэмт хэргийн талаарх иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэнтэй холбоотойгоор цагдаагийн байгууллагад залилах гэмт хэргийн талаар мэдээллэх хандлага нэмэгдсэн байх боломжтой.

5. Судалгаанаас үзэхэд бага хэмжээний эд хөрөнгө болон эд хөрөнгө нь тэр даруйдаа иргэд хооронд шилжих боломжтой мал мах, автомашин худалдах, худалдан авах болон нэг удаагийн илт хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхэд нөлөөллийн арга хэмжээ шууд нөлөөлсөн бол гэрээгээр халхавчлах, виз гаргах, цахим хэрэгсэл ашиглах, хүүтэй мөнгө зээлүүлэх болон олон шатлалт маркетингийн аргаар үйлдсэн залилах гэмт хэрэгт хэрхэн нөлөөлсөн эсэх тодорхой хугацааны дараа мэдэгдэх боломжтой.

6. Судалгаанд оролцсон 324 иргэдийн 93 хувь нь “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээ хувь хүн болон олон нийтэд хангалттай мэдээлэл өгч, өөрсдийгөө хамгаалах мэдлэгтэй болгож чадсан гэж үзсэн бол цаашид өөрийн эд хөрөнгө, түүний эзэмших эрхтэй холбоотой асуудлыг бусдад шилжүүлэхдээ “Ятгах тусам нягтал” гэсэн зөвлөмжийг тогтмол мөрдлөг болгоно гэж 100 хувь хариулсан нь *залилах гэмт хэргээс өөрийгөө хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэгт өртөхгүй байх иргэдийн мэдлэг, хандлагад эерэг нөлөө өөрчлөлт гарсан гэсэн таамаглал батлагдаж байна.*

### **Зөвлөмж**

1. Залилах гэмт хэрэг болон санхүүгийн луйвраас урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам тооцож байх;
2. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаарх сургалтыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хуульчдаар дамжуулан тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцож байх;
3. Иргэд хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн эрхийг шилжүүлэх гэрээ, хэлцэл хийхдээ хуульчийн зөвлөгөө авах ажилд дэмжлэг үзүүлэх;
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбоотой хойшлуулшгүй мэдээ, мэдээлэл, видео контентыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй нийтэлж, нэвтрүүлэх, энэ чиглэлээр цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагатай санамж бичиг байгуулах, хамтран ажиллах;
5. Хууль зөрчсөн болон хялбар аргаар мөнгө, эд хөрөнгө олох боломжийн талаар олон нийтэд уриалсан, сурталчилсан бизнесийн үйл ажиллагаа, хувь хүний үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, хянах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэртээ тогтмол хяналт тавьж ажиллах;
6. Гадаад улсын виз гаргах, материал хүлээн авах албан ёсны гэрээт компанийн жагсаалтыг тухайн улсын Элчин сайдын яамнаас гаргуулан авч, олон нийтэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах, мэдээллийг тухай бүр шинэчлэх, иргэд визний материал бүрдүүлэн өгөхдөө албан ёсны компани мөн эсэхийг шалгаж хэвшихэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;

<sup>9</sup> Newman, G. R., & Freilich, J. D. (2012). Extending the reach of situational crime prevention. In N. Tilley & G. Farrell (Eds.), *The reasoning criminologist: Essays in honor of Ronald V. Clarke* (pp. 212–225). New York: Routledge

7. Богино хугацаанд өндөр хүүтэй мөнгө зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, таслан зогсоох;
8. Банк, санхүүгийн байгууллагатай хамтран энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулах;
9. Зохистой цахим хэрэглээг бий болгоход чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, цахим орчинд байршуулах мэдээллийн агуулгад хяналт тавих, цахим орчинд бусдад туслахыг уриалсан, хандив бараа ажил үйлчилгээ үзүүлэх санал болгосон мэдээллийг зөвшөөрлтэйгээр байршуулах тогтолцоог бүрдүүлэх боломжийг судалж, нэвтрүүлэх-ээрэг болно.

#### **Ашигласан материал**

1. Цагдаагийн ерөнхий газар. "Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал-2019". УБ., 2020
2. Цагдаагийн ерөнхий газар. "Гэмт хэргийн нөхцөл байдал-2020 оны 02 дугаар сар", УБ., 2020
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.// Төрийн мэдээлэл. УБ., 2019. №42
4. Мөрдөн байцаах алба. "Ятгах тусам нягтал нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлсэн тухай танилцуулга". УБ., 2020
5. Brantingham, P. L., Brantingham, P. J., & Taylor, W. (2005). Situational crime prevention as a key component in embedded crime prevention. *Canadian Journal of Criminology and Criminal Justice*
6. Cornish, D.; Clarke, R. (1987). "Understanding crime displacement: An application of rational choice theory". *Criminology*
7. Bowers, K. J., & Guerette, R. T. (2014). Effectiveness of Situational Crime Prevention. In *Encyclopedia of Criminology and Criminal Justice* (pp. 1318-1329). Springer New York
8. Felson, Marcus (1987), 'Routine Activities and Crime Prevention in the Developing Metropolis', *Criminology*
9. Newman, G. R., & Freilich, J. D. (2012). Extending the reach of situational crime prevention. In N. Tilley & G. Farrell (Eds.), *The reasoning criminologist: Essays in honor of Ronald V. Clarke* (pp. 212–225). New York: Routledge

## МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Ж.Төгс-Очир  
Ц.Насанбат

### Оршил

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь үндэсний хил хязгаарыг үл хүндэтгэдэг бөгөөд ямар ч улс орон энэ төрлийн гэмт хэргийн аюул заналхийлэлд өртөмтгий байдаг. Энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд аливаа улс орон нь хариу үйлдэл үзүүлэх үр дүнтэй тогтолцоог бий болгосон байвал зохино. Ийм үр дүнтэй тогтолцоотой байлгахын тулд

Санхүүгийн хориг арга хэмжээ авах бүлэг буюу ФАТФ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг улс орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөмж болгохын зэрэгцээ уг зайлшгүй биелүүлэх зөвлөмжүүдээ өөрийн хяналтын болон хориг арга хэмжээ авдаг онцлог арга замаар хэрэгжүүлж байдаг. ФАТФ-аас 2017 онд Монгол Улсын МУТСТ тогтолцоонд техникийн болон үр дүнтэй байдлын үнэлгээ хийгдсэн. Монгол Улс нь хугацаатай үүрэг даалгавар авч МУТСТ тогтолцоогоо бэхжүүлэх чиглэлээр ажилласан боловч зарим шалгуур үзүүлэлтүүдэд хангалтгүй үнэлгээ авсан тул Монгол Улс 2019 оны 10 дугаар сард ФАТФ-ын «саарал жагсаалт»-д орсон. Үүний дотор мөнгө угаах олон төрлийн суурь гэмт хэргээр мөрдөн шалгаж буй болон шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо хангалтгүй байсан нь ФАТФ-ын «саарал жагсаалт»-д орох нэг шалтгаан болсон юм. Монгол Улс нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин, урьдчилан сэргийлэх тогтолцоо, институцийн чадамж бий болгож байгаа ч мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгох, шүүхээр шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх үндэсний чадамжийг бэхжүүлэхэд тодорхой бодлого гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү өгүүллээр Монгол Улс дахь мөнгө угаах гэмт хэргийн аюул, занал, уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны эмзэг сул байдлыг харгалзан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд үүсдэг нийтлэг хүндрэл бэрхшээл, бий болговол зохих суурь нөхцөлүүд, мөрдөн шалгах ажиллагааны арга барилд өөрчлөлт хийх асуудалд анхаарал хандууллаа.

### Нэг.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх явцад үүсдэг хүндрэл, бэрхшээл:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх явцад нийтлэг хүндрэл, бэрхшээл үүсдэг нь тохиолдлын биш гэдгийг онцлох нь зүйтэй. Энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх нь гагцхүү Монгол Улсын эрх бүхий байгууллагуудын өмнө тулгарч буй тулгамдсан асуудал биш бөгөөд бусад улс орнууд энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд тодорхой саад, бэрхшээлтэй учирдаг аж. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх явцад учирдаг хүндрэл, бэрхшээл, алдаа, дутагдлын талаар 2015 онд “Европын Холбооны Мөнгө Угаахтай Бүлэг” (Moneyval) нь “Зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааны орлогыг угаах арга, хэв шинж тайланг Европын Холбооны гишүүн болон түүнд хамаарал бүхий 30 орчим улс орны эрх бүхий байгууллагууд урьдчилан бэлтгэсэн судалгааны асуумжын тусламжтай боловсруулжээ.<sup>10</sup> Уг тайланд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх явцад хүндрэл, бэрхшээлийг тодорхойлжээ. Үүнд:<sup>11</sup>

- Мөрдөн шалгах ажиллагаа нь нарийн түвэгтэй, цуглуулсан нотолгооны мэдээллийн учрыг олоход ээдрээтэй. Үүнтэй холбогдуулан энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэхэд олон төрлийн мэргэжлийн агентлаг, байгууллагуудын туслалцаа, дэмжлэг, тусгай мэдлэг, туршлага шаардагддаг;
- Олон улсын хамтын ажиллагааны шугамаар тэр дундаа оффшор санхүүгийн төвүүдээс мэдээлэл гаргуулах, нотлох баримт цуглуулахад удаашралтай, зарим тохиолдолд боломжгүй байдаг;
- Хилийн чанадаас мэдээлэл цуглуулах явцад оффшор компаниудын эцсийн өмчлөгчдийн мэдээлэл хэрэгт авагдсан нотлох баримттай авцалдахгүй байх

<sup>10</sup> Албани, Армени, Австри, Азейрбажан, Белги, Босни Херцоговин, Бутан, Болгар, Кипр, Чех, Дани, Фижи, Франц, Гүрж, Гуатемал, Унгар, Итали, Литва, Макау, Малта, Молдов, Монтенегро, Польш, Сан Марино, Серби, Словак, Словени,Украин

<sup>11</sup>Typologies report on laundering the proceeds of organized crime  
[http://www.coe.int/t/dghl/monitoring/moneyval/Activities/MONEYVAL\(2015\)20\\_typologies\\_launderingtheproceeds oforganisedcrime.pdf](http://www.coe.int/t/dghl/monitoring/moneyval/Activities/MONEYVAL(2015)20_typologies_launderingtheproceeds oforganisedcrime.pdf)



тохиолдол гардаг. Энэ нь жинхэнэ өмчлөгчийг нуухын тулд олон тооны давхар халхавч компани, дундын зуучлагчийг ашигладагтай холбоотой.

- Өөрөө мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй байх эсхүл өөрөө мөнгө угаах гэмт хэргийн шинж тэмдэг, нотлох баримт байсаар байтал мөрдөх алба, прокурорын байгууллага ийм үйлдлээр зүйлчлэн шалгадаггүй байх.<sup>12</sup>
- Гэмт хэргийн орлогыг угаах төлөвлөгөө, схем гаргахад илт дэмжлэг үзүүлсэн, санхүүгийн байгууллагуудад байршуулсан, шилжүүлсэн, тээвэрлэсэн, хүргэсэн гуравдагч этгээдийг мөнгө угаах хэрэгт холбогдуулан шалгахын оронд үндсэн гэмт хэргийн хамтран оролцогчоор татаж шалгах явдал нийтлэг байдаг. Энэ тохиолдолд гуравдагч этгээдийг мөнгө угаасан үйлдэлд холбогдуулан шалгах эрх бүхий байгууллагын зайлшгүй биелүүлбэл зохих үлгэрчилсэн аргачлал, заавар, чиглэл байдаггүйтэй холбоотой байдаг аж;
- Мөрдөн байцаагч болон прокурорууд хэргийн нөхцөл байдлыг үнэлэхдээ эсрэг тэсрэг үзэл бодол, байр суурьтай байх хандлага. Нэг талаас эрх бүхий Мөрдөх байгууллага нь суурь гэмт хэргээс гадуур хийгдсэн аливаа санхүүгийн гүйлгээ, хөрөнгө оруулалт нь мөнгө угаасан үйлдэлд тооцогдоно гэж үздэг. Нөгөөтэйгүүр, шүүгч, прокурорууд нь хэрвээ санхүүгийн гүйлгээ, хөрөнгө оруулалт нь суурь гэмт хэрэгтэй холбогдож байвал эдгээр идэвхитэй үйлдэл нь тусдаа гэмт хэрэгт тооцогдох шаардлагагүй гэсэн эсрэг байр суурь баримталдаг;
- Хэрэг амжилттай хянан шийдвэрлэхэд бүрдүүлэх нотлох баримтын шаардлагын талаарх прокурорууд дунд ойлголт жигд бус (хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэт хянуур, хашир бодлого явуулдаг), мөн шүүх, шүүгч бүр хэрэг, нотлох баримт, үйл баримтын талаар харилцан ялгаатай үзэл бодол, байр суурь тогтмол баримталдаг;
- Гэмт этгээдийн субъектив санаа, зорилго, сэдлийг нотлоход нотолгооны өндөр зэрэглэлийн стандарт шаардагддаг. Мөнгө хөрөнгийг гэмт үйл ажиллагаанаас олсоныг ялладагч мэдэж байсан, мэдэх боломжтой байсныг энгийн аргаар нотлоход ярвигтай байдаг.
- Мөрдөн, прокурор, шүүгчдэд чиглэсэн тусгайлсан сургалтын хөтөлбөр дутмаг байдгаас дутуу мөрдөн байцаалт хийгдсэн, итгэл үнэмшил муутай хэргүүд шүүхээр хянан шийдвэрлэгдэх тохиолдол гардаг. Түүнчлэн хэргийг шүүхэд танилцуулахдаа энгийн болон ойлгомжтой аргаар танилцуулдаггүй. Нарийн төвөгтэй хэргийг энгийн, ойлгомжтой, цэгцтэй аргаар танилцуулах нь өндөр ур чадвар бөгөөд ялангуяа иргэдийн төлөөлөл оролцож буй шүүх хуралд туйлын чухал юм;
- Авлига, хээл хахууль. Гэрч, прокурор, банк санхүүгийн байгууллагын удирдах ажилтан, шүүгч, мөрдөн байцаагч нарт хөндлөнгөөс нөлөөлөх;
- Гэрч мэдүүлэг өгөхөөс зайлсхийх;
- Санхүүгийн мэдээллийн албаны эрх хэмжээ, чадамжийг үр дүнтэй ашигладаггүй байх (гүйлгээ түдгэлзүүлэх, банкны дансанд хяналт тавих, дүн шинжилгээний ур чадвар гэх мэт);
- Нарийн төвөгтэй хэрэг хянан шийдвэрлэхэд мөрдөгч, прокурор, шүүгчийн ажлын ачааллыг зохицуулахгүй байх;
- Шууд бус нотлох баримт (нөхцөл байдалд суурилсан) ашиглан хууль бус орлогыг нотлоход чиглэсэн эрх бүхий байгууллагын бодлого, үйл ажиллагаа, санаачлага дутагдах<sup>13</sup>.

Европын Холбооны Мөнгө угаах тэмцэх бүлэг (Moneyval)-ийн хийсэн дээрх судалгааны үр дүн нь практик ач холбогдол бүхий чухал асуудлуудыг хөндсөний зэрэгцээ мөнгө угаахтай тэмцэх чадамж бүрдүүлж буй бусад улс орнуудын эрх бүхий байгууллагуудын зайлшгүй харгалзан үзвэл зохих тулгамдсан асуудлуудыг тусгажээ. Иймд Монгол Улсын эрх бүхий мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд улс орнуудад үүсдэг нийтлэг хүндрэл, бэрхшээлийг судлан харьцуулж засаж залруулахад илүүдэхгүй юм.

<sup>12</sup> Тухайлбал, төсвийн хөрөнгийг завшиж гэмт хэргийн орлого бий болгосон гэмт этгээд уг хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нуун дарагдуулах, хууль ёсны болгож хувиргахын тулд мөнгө угаах үйл ажиллагааг өөрөө гардан зохион байгуулсан, гүйцэтгэсэн бол мөнгө угаасан үйлдэлд хариуцлага хүлээлгүй тухайн төсвийн хөрөнгийн завшсан үйлдлээр илүү хөнгөн ял шийтгэл хүлээгээд өнгөрөх боломжтой байдаг.

<sup>13</sup> МУТС-тэй тэмцэх олон улсын байгууллага, бус нутгийн байгууллагуудын судалгаа, тайланг эрх бүхий байгууллагууд ажлын практиктаа ашигладаг байх нь эдгээр төрлийн хэргүүдийг хянан шийдвэрлэхэд үр нөлөөтэй байдаг.

**Хоёр.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд бий болгох шаардлагатай суурь нөхцөлүүд:**

Монгол Улс нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд урт хугацаанд суурь нөхцөлүүдийг бүрдүүлэх шаардлагатай байна. ФАТФ нь 2018 онд прокурор, шүүгч нарт зориулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх судалгааг гишүүн орнуудын хамт гаргасан бөгөөд уг судалгаанд үр нөлөөтэй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тэмцэх тогтолцоотой байхын тулд хэд хэдэн суурь нөхцөлүүдийг бүрдүүлсэн байхыг зөвлөдөг.<sup>14</sup>

***Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдлийг тодорхойлох, оновчтой бодлого стратеги гаргаж хэрэгжүүлэх***

After the shipment of Vietnamese seafood enterprises arrived to the port assigned by buyer, Echopack took the goods. Later, negotiating banks in Vietnam sent documents to General Equity Bank requesting to pay. However, General Equity Bank delayed responding to the negotiating bank and refused to pay due to the invalid LC. Later, General Equity Bank sent an email notifying that the signatures within the document that the negotiating bank demonstrated were different from the signature of buyer that the issuer had on the document which applicant used to register to open LC. Then, they sent back the document to Vietnam, however the documents came back without one out of three original bills of lading. While sending the collection of documents for payment under the terms of LC, General Equity knew the documents were invalid but still let Echopack get the original bill of lading to get the goods.

Indeed, under the guidance of UCP 600 rules, including the signature sample of applicant in the LC is contrary to the provisions of Article 4 UCP 600. The signature sample condition was a nondocumentary condition, it denied the undertaking status of letter of credit and as consequence, this condition should not be applied.

A credit by its nature is a separate transaction from the sale or other contract on which it may be based. Banks are in no way concerned with or bound by such contract, even if any reference whatsoever to it is included in the credit. Consequently, the undertaking of a bank to honour, to negotiate or to fulfil any other obligation under the credit is not subject to claims or defences by the applicant resulting from its relationships with the issuing bank or the beneficiary. (UCP, Article 4)

Sellers and reporting banks cannot conclude whether the signatures of buyer within the document matched the ones on the document when applicants registered to open LC because there were no signature models to compare. The whole process depended entirely on General Equity Bank.

Under the UCP 600 regulations, the bank is responsible for the apparent authenticity of LC according to the independence regulation. Therefore, negotiating bank in Vietnam has no obligation in checking the agreement between parties. But in terms of professional expertise, credibility and enthusiastic customer support, the bank announcement did not show its role in the relationship between the banks and its clients. Throughout this problem, it is clear that Vietnamese banks are passive in their role within international payment, and did not perform fully their role as advisers for enterprises who do the import or export business, as well as Vietnam enterprises lack of necessary

information and practical cases referring to the UCP 600: Vietnam Legal System also is on the urgent to have a code relating to fraud in Letter of credit (LC) payment. In this case, even the LC opened by the General Equity bank violated the UCP 600, however, the banks are guiltiness. Vietnam enterprises have not taken any proceedings against any scam before even If company in Vietnam take action, they may have a chance to get their money back.

According to Vietnam Export and Processing Association, in 2015 - 2016, Vietnam had lost \$ 8 billion in seafood exports mostly due to fraud (Nguyen Trong Thuy, 2019). Frauds have been and are always part of international trade. This case is one of the important reasons to issue some legal documents about payment in international trade, especially fraud in Letter of credit payment. The point is to draw things to minimize losses.

## VI- CONCLUSION

Fraud can impose significant costs on the enterprise. Therefore, it is necessary to have a letter of credit law including fraud to prevent the obstacles happen. Proper fraud risk management contains effective preventive and responsive measures which also apply to fraud risk management programs applied to documentary letters of credit.

All parties involved in the operation of documentary letters of credit are required to implement necessary preventive and responsive measures to mitigate the risk of LC fraud. In addition to analyzing theoretical aspects of fraud in documentary letters of credit, this paper tries to explain the legal system in Vietnam as well as analyzes the different definition for clarifying fraud in United States cases and substantive law. Vietnam's integration in international trade is mainly motivated and oriented by concerns for national interest and security through increased economic power. The letter of credit law in general and fraud rule in particular in Vietnam still need development and it requires more source of law and example like the Article 5 of Uniform Commercial Code. The promulgation of fraud rule has greatly fostered study of the fraud rule, a fact illustrated increase volume of case law on letter of credit fraud and by much more commentary on the fraud rule worldwide. In fact, the influence will have a greater impact on Vietnam legal system because Vietnam is a civil law country, as civil law countries normally look to statutes rather than cases in seeking source of law.

## REFERENCE

- Alavi, H., 2015. Autonomy principle and fraud exception in Documentary Letters of credit, a comparative study between United States and England. *International and Comparative Law review*, 15(2), pp. 47-68.
- Anon., 1990. *An Examination of U.C.C. Article 5 (Letters of Credit)*, không biết chủ biên: Business Law.
- Blodgett, M. S. & Mayer, D. O., 1998. International Letter of Credit: Arbitral Alternatives to Litigating Fraud. *American Business Law Journal*, 35(3), pp. 443-468.
- Buckley, R. P. & Gao, X., 2002. Development of the fraud rule in letter of credit law: The journey so far and the Road ahead. *University of Pennsylvania Journal of International Economic Law*, pp. 663-712.
- Compass Bank v. Morris Cerullo World Evangelism, Corp.* (2015).
- D'Ascenzo, R., 2003. The supreme Court of Ohio's Decision in Mid-America Tire, Inc. v. PTZ trading Ltd., and the Weakening of the Independence Principle. *Capital University Law Review*, 32(4), pp. 1097-1126.
- Dolan, J. F., 1996. *The law of Letter of credit: Commercial and Standby Credits*. không biết chủ biên: Warren, Gorham & Lamont Incorporated, USA.
- Finkelstein, H. N., 1930. *Legal Aspects of Commercial Letters of Credit*. 1 biên tập viên không biết chủ biên: Columbia University Press.
- Gao, X. & Buckley, R. P., 2003. A comparative analysis of the standard of Fraud required under the Fraud rule in Letter of Credit Law. *Duke Journal of Comparative & International Law*, 13(2), pp. 293-336.
- Harper, F. & James, F., 1956. *The Law of Torts*. Boston: Little, Brown & Co., Boston.
- Leacock, S. J., 1984. Fraud in the International Transaction: Enjoining Payment of Letter of credit in International transactions. *Vanderbilt Journal of Transnational Law*, 17(4), pp. 885-924.
- M. Golodetz & Co., Inc. v. Czarnikow-Rionda Co., Inc.* (1980).
- Marine Midland Grace Trust Co. v. Banco del Pais* (1966).
- Maurice O'Meara Co. v. National Park Bank of New York* (1925).

Nguyen Trong Thuy, 2019. *enternews.vn*. [Trực tuyến]

Available at: <https://enternews.vn/rui-ro-trong-giao-dich-quoc-te-khi-lam-an-xuoi-cheo-mat-mai-146884.html>

[Đã truy cập 30 January 2020].

Pilon, M. & Weiler, D., 2011. *The French in Singapore: An Illustrated History (1819-today)*. không biết chủ biên: không biết tác giả

Schmitthoff, C. M., 1980. *Schmitthoff's Export trade: The law and Practice of International trade*. 7 biên tập viên không biết chủ biên: Stevens & Sons.

*Shaffer v. Brooklyn Park Garden Apt.* (1977).

Symons, E. L. J., 1979-1980. Letter of credit: Fraud, Good faith and the Basics for Injunctive Relief. *Tulane Review*, 54(2), pp. 338-381.

*Sztejn v. Henry Schroder Banking Corp.* (1941).

*The Emery-Waterhouse Company v. Rhode Island Hospital Trust National Bank* (1985).

*United City Merchants Ltd. v. Royal Bank of Canada* (1982).

*Ward Petroleum Corp. v. Federal Deposit Ins. Co.* (1990).

## ЭМХ ЗАМБАРААГҮЙН ОНОЛ БА ЭКОЛОГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ТУЛГУУРЛАН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦЛИЙГ ТОГТООХ НЬ

Э.Дашгаадан  
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн  
багш, цагдаагийн ахлах дэслэгч

**Товч агуулга:** Энэхүү өгүүллээр нийгмийн эмх замбараагүйн онол болон Чикагогийн үзэл баримтлалд тулгуулан нийгмийн дунд сөрөг нөлөө үзүүлдэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгааныг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга замын талаар авч үзлээ.

**Түлхүүр үг:** Нийгмийн эмх замбараагүйн онол, гэмт явдлын экологи, төвлөрлийн цэгүүд, уламжлалт нийгмийн хяналтын механизм, нийгмийн хандлага, аюулгүй байдал.

### Оршил

Хүн төрөлхтний амьдралын хурдацтай өөрчлөлт, дайн тулаан, хүн амын өсөлт, төвлөрөлт, эдийн засгийн хямрал ба ашгийн тэгш бус хүртээмж зэргээс үүдэлтэй нийгмийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, олон соёл, угсаа, эдийн засгийн түвшний хүмүүс холимог нийгмийг цогцлоож байна. Нийгмийн амьдралд үүссэн эмх замбараагүй байдлын үр дүнд нийгмийн холбоо суларч, нийгмийн хяналтын механизмын нөлөө багасч, үүний үр дүнд нийгэмд хуулиас гадуур бүлэглэл, гэмт этгээдүүд бий болох нөхцөл бүрддэг.

Хэд хэдэн криминологийн онолын суурь болдог нийгмийн эмх замбараагүйн онолыг дэвшүүлсэн Клиффорд Шав ба Ричард Маккэй нар анхдагч болж, шүүмж дагуулдаг байсан батлагдаагүй гүн ухааны хэлцээс хэтрээгүй ойлголтыг эвдэж үр дүнг сайжруулж, гэмт явдлын экологийн загвар өнөөдөр ч үзэл баримтлалын хувьд нөлөөгөө алдаагүйгээр барахгүй криминологийн бүтээлүүдэд тогтмол ашиглагддаг билээ.

### Үндсэн хэсэг

Орчин үеийн гүн ухаантнуудын нэг Личбах “Рациональ сонголтын онол нь тэр чигээрээ нийгмийн шинжлэх ухаан уу?” /Is Rational Choice all of social science/ нэртэй бүтээлдээ “Нийгмийн бүхий л бодит байдлыг тодорхойлохын тулд хувь хүнийг байгалийн талаас нь дүгнэх боломжгүй, хангалтгүй юм. Учир нь хүмүүсийн хандлага нийгмийн орчноосоо шалтгаалан өөрчлөгддөг”<sup>26</sup> гэжээ.

Маш олон криминологичид “соёл”-ыг гэмт хэрэг, зөрчлийн шалтгааныг бий болгох үндсэн хүчин зүйл гэж үзэхдээ гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд хувь хүний хүчин зүйл, эмгэг нөлөөлдөг гэж дүгнэжээ. Энэ үзэлтэй нэгддэггүй бусад криминологичид гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх үндсэн шалтгаан нь нийгмийг бий болгож байгаа соёлд байдаг гэх үзлээр хүмүүсийн үнэт зүйл, суурин соёл нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх, нөхцөл байдлыг бий болгох үндсэн хүчин зүйл болохыг тайлбарладаг.

Түүхэнд анх удаа гэмт явдал болон орчны хамаарлыг шинжлэх ухааны аргаар судалсан судлаач нар бол Белгийн математикч Адольф Куетлет, Андре-Мишель Гуери нар юм. Куетлет статистик тооцооллоор нийгмийн хүчин зүйлүүд гэмт явдлын түвшингийн хооронд тодорхой нэгэн корелиаци байгааг тогтоосон. Мөн гэмт хэрэг, зөрчлийн түвшин ядуус болон боловсролын түвшин бага, газар нутгийн хувьд өмнөд хэсэгт хүн амын холимог тогтолцоотой газар бусад газраас харьцангуй өндөр байгааг тогтоожээ.<sup>27</sup>

### 1. Чикагогийн үзэл баримтлал

“Гэмт явдлын экологи” /ecology of crime/ нэрээр алдартай болсон гэмт явдлыг физик болон нийгмийн орчинг бүрдүүлдэг хүчин зүйлүүдийн үр дүн гэж үздэг энэ үзлийн гол санааг Родни Старк “тодорхой төрлийн хүмүүс” /kinds of people/ ойлголтоос “тодорхой төрлийн газар” /kinds of places/ ойлголт руу шилжсэн гэж тайлбарлажээ. Криминологийн судалгаанд парадигмын өөрчлөлт оруулсан нь Роберт Парк, Клиффорд Шав, Хенри Маккэй зэрэг социологичид Чикагогийн үзэл баримтлал нэрээр алдаршсан судалгаа байлаа. 1892 онд үүсгэн байгуулагдсан Чикагогийн их сургуулийн Социологийн тэнхим шинэ санаа, судалгаагаараа социологи болон нийгмийн шинжлэх ухаанд үнэмлэхүй хувь нэмэр оруулжээ.

<sup>26</sup> Lichbach, Mark I. 2003. Is Rational Choice Theory All of Social Science? Ann Harbor: The University of Michigan Press

<sup>27</sup> Cordella, Peter and Siegel, Larry. 1996. Readings in Contemporary Criminological Theory. Boston: Northeastern University Press



Тухайн үед социологийн тэнхимд ажиллаж байсан эрдэмтдийн дэвшүүлсэн санаа хожим нь “Чикагогийн үзэл баримтлал” /Chicago school/ гэгдэж суурин хот болон хувь хүний хамаарлыг тодорхойлохоор чиглэсэн эмпирик социологийн арга зүйгээр орчныг судалж эхэлжээ.

## 2. Бургессийн төвлөрсөн бүсийн загвар

Өдөр ирэх тусам нэмэгдэх Чикагогийн хүн ам хотын төвөөс эхлээд зах руу чиглэсэн бүсчлэлд орж байлаа.<sup>28</sup> Эрнест Бургесс 1900-аад оны эхээр хийсэн судалгааны үр дүнд хот ерөнхий 5 бүсчлэлд хуваагдан зохицуулагдсан гэж дүгнэжээ. Бүс болгон эдийн засаг, нийгэм, демографик онцлогтой бөгөөд эдгээр онцлог нь бүс болгонд харилцан адилгүй байгаа учраас энэ загварыг “төвлөрсөн бүсийн загвар” /concentric zone model/ гэж нэрлэжээ.

Эдгээр бүсүүдийг гаднаас дотогш нь дараалуулбал төв ажилчдын бүс, дамжин өнгөрөх бүс, ажилчдын бүс, чинээлэг орон сууцны бүс, хол замд гарагчдын бүс. Судалгааны үр дүнд ийм бүтэц Long Beach, Rochester, Montreal зэрэг хотуудад ч байдаг нь тогтоогджээ. Тухайн үед хэд хэдэн эрдэмтэд энэ бүтцийг ашиглан гэмт хэрэг, зөрчил гэлтгүй маш олон социологийн өгөгдлийг судалж болно гэжээ.<sup>29</sup>

### Бургессийн төвлөрлийн бүсийн загвар



Бургессийн төвлөрлийн бүсийн загварт хамгийн голд төвийн бүс байна. Энэ утгаараа хотын болон эдийн засгийн хөдөлгөх хүч болох юм. Хотод шинээр ирсэн айл өрх, ажил хайж ирсэн өнгөт арьстнууд анхлан хоног төөрүүлэх, товхинох байрууд ч энэ бүст байрлаж байв. Үүнээс гадна хотын гадна өөрийн байшинтай болно гэдэг бол практикт боломжгүй мэт байсан ба учир нь хотоос гадагшлах тусам байшингийн үнэ өсдөг байж.

Энэ тогтолцоон дахь хүмүүс санхүүгийн байдал нь сайжрахын хэрээр төвөөс гадагш нүүдэг, шинээр ирсэн хүмүүс тэдгээрийн оронд суурших зэргээр үргэлжилдэг байв. Хотын төвөөс гадагш чиглэсэн хөдөлгөөний үр дүнд хотын төвд, дамжин өнгөрөх бүст суурин соёлыг бий болгох эдгээр хүмүүс бие биенээ таних, бат бэх харилцаа холбоо үүсгэх, нийгмийн харилцаа үүсгэх хүндрэлтэй байсан.

## 3. Нийгмийн эмх замбараагүйн онол

Чикагогийн их сургуулийн Клиффорд Шав болон Хенри Маккэй зэрэг судлаачид, Парк ба Бургесс нарын хөгжүүлсэн энэхүү загварыг хэрэглэн гэмт хэрэг, хотын бүтцийн харилцан хамаарлыг судалсан ба гэмт хэргийг хотын бүтцийн өөрчлөлтөөс болон нийгмийн зохион байгуулалт дахь өөрчлөлт, эмх замбараагүй байдлаас үүдэн гардаг гэж таамаглажээ. Чикаго хотын гэмт хэргийн түвшин дэх өөрчлөлтийг, Cook County хүүхдийн шүүхэд хүргэгдэн ирсэн хүүхдүүдэд 30 жилийн турш судалгаа хийжээ. Үүний үр дүнд дэвшүүлэн гаргасан санаа нь хожим “Нийгмийн эмх замбараагүйн онол” /Social Disorganization Theory/ гэгдэх болжээ.

Нийт 3 удаагийн статистик судалгаа гэмт хэргийн түвшний ангиллыг авч үзвэл гурвууланд нь ижил корелиаци ажиглагдаж байлаа. Хэдийгээр 30 жил өнгөрч, хотын зохион

<sup>28</sup> Cressey, Paul Frederick. 1938. “Population Succession in Chicago: 1898-1930.” American Journal of Sociology, Vol.44, No.1.pp.89-101

<sup>29</sup> Quinn, James A. 1940. “Burgess Zonal Hypothesis and its Critics.” American Sociological Review. Vol.5, No.2. pp.210-218

байгуулалт болон бусад өөрчлөлт орсон байхад гэмт хэргийн түвшинд өөрчлөлт гарахгүй байсан нь маш сонирхолтой үр дүн юм.<sup>30</sup>

Судалгааны явцад Шав, Маккэй нар гэмт хэргийн түвшин, газар орчны нөхцөл шууд хамааралтай болохыг тогтоосон.

### 3.1.Соёлын зөрчилдөөн:

Шав болон Маккэй гэмт хэргийн үүсэх эх сурвалж нь нийгмийн динамик бүтцэд байдаг гэж үздэг байжээ. Гэмт хэргийн түвшин өндөр газарт ард иргэдийн дунд эв нэгдлийг хангах үнэт зүйл, хэм хэмжээ, итгэл үнэмшил, нэгдмэл соёл зэрэг байхгүй байдаг. Ийм систем байсан ч гэсэн энэ хэсэгт амьдарч байгаа хүмүүс хувь хувийнхаа амьдралыг болгох, мөнгө олоход гэмт хэрэг үйлдэх, зохион байгуулах нь томоохон нөлөө үзүүлдэг учир уламжлалт нийгмийн хяналтын механизм үр нөлөө үзүүлж чадахгүй. Гэмт хэргийн түвшин багатай газар нэгдмэл нэг үнэт зүйл, нийгмийн хяналтын тогтолцоо бүрдсэн байдаг.


Үүнээс гадна хуулиуд өөр өөр соёлуудын хэрэгцээ шаардлагыг ханган зохицуулж чаддаггүй бөгөөд зөрчилдөөн бол энгийн л нэг байдаг үзэгдэл аж. Иймээс Виртийн соёлын зөрчилдөөн гэх судалгааны ажил нь соёлуудын болон эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөний үр дүнд гэмт хэрэг бий болдог гэдэг нь маш бодитой аргумент юм.<sup>31</sup>

### 3.2.Ялгаварт нийгмийн зохион байгуулалт

“Нийгмийн эмх замбараагүйн онол” /Social disorganization/ гэх нэрийг Альберт Кохен болон Садерланд зэрэг криминологичид “ялгаварт нийгмийн зохион байгуулалт” /differential social organization/ гэх нь илүү тохиромжтой бөгөөд агуулгын хувьд ямар нэгэн эмх замбараагүй зүйл байхгүй, нэг нэгэн дотроо зэрэгцэн оршиж байгаа нийгмийн зохион байгуулалт гэж үзжээ.<sup>32</sup>

Үндсэн дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэх, зөрчих гэсэн хоёр тогтолцоо нэгэн зэрэг бий болдог ийм гэмт хэрэг бүхий бүсчлэлд гэр бүлийн гишүүд аль хандлагыг баримтлах асуудалд зөрчилдөөн үүсдэг. Уг нь уламжлалт үнэт зүйлийг баримтлах ёстой гэр бүлийн гишүүд ийм орчин нөхцөлд эргэн тойрны үйл явдалд үл хайхрах, үл тоомсорлох шинжтэй болдог. Ингэснээр гэр бүлийн хэмжээнд хууль бус үйл явдлыг эсэргүүцэхгүй, тэр байтугай зарим гэр бүл, найз нөхдийн хүрээлэл түүнийг нь дэмжиж байж болзошгүй юм. Ийм хүүхэд залуучууд ямар ч саадгүйгээр гэмт хэрэгт холбогдох юм.<sup>33</sup> Тухайн үед Блүмер зэрэг судлаачид нийгмийн эмх замбараагүй байдал хувь хүнд нөлөөлж, хувь хүнээс сөрөг үйл хандлага илрэх шалтгаан болдог гэж үзэж байжээ. Өөрөөр хэлбэл, хэвийн нөхцөл байдалд хувь хүн гаргахгүй үйлдлийг ийм эмх замбараагүй орчин, бусад нийгмийн гишүүдийн нөлөөгөөр шууд гаргана гэсэн үг юм. Хүүхдүүдэд гэр бүл гэхээсээ илүү хамт ихэнх цагийг өнгөрүүлж буй нөхдийнхөө дүрэм журмыг дагах ёстой мэт мэдрэмж төрнө. Энэ нь ч гэр бүлийн нөлөөг багасгаж, хүүхдийг гэмт хэрэгт уруу татагдах нөхцлийг хялбаршуулж өгнө.

#### Гэмт хэргийн шалтгаан /Shaw, McKay/



Товчхондоо Шав болон Маккэй нарын дүгнэснээр ялгаатай соёл, хүн амын хөдөлгөөн, сул эдийн засаг, гэр бүлийн тогтворгүй байдал зэрэг онцлогоос шалтгаалж тухайн бүс нутагт нийгмийн хяналтын механизм суларснаар гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх

<sup>30</sup> Shaw, Clifford R and McKay, Henry D. 1942. Juvenile Delinquency and Urban Areas. Chicago: The University of Chicago Press

<sup>31</sup> Wirth, Louis. 1931. "Culture Conflict and Delinquency I: Culture and Misconduct." Social Forces, Vol.9, No.4, pp.484-492

<sup>32</sup> Cloward, Richard A. and Lloyd E. Ohlin. 1966. Delinquency and Opportunity: A Theory of Delinquent Gangs. First Free Press Paperback Edition. New York. Free Press

<sup>33</sup> Shaw, Clifford R. 1930. The Jack Roller: A Delinquent Boy's Own Story. Chicago: University of Chicago Press

чадамжийг ч алдаж байдаг. Ингэснээр нийгмийн бүтэц өөрөө гэмт хэргийг бий болгож, гэмт хэрэг үйлдэгдэх нөхцлийг хялбаршуулсан механизм болдог гэж хэлж болно.

#### **4. Туршилт, судалгаа: Онол батлагдсан уу?**

Лонгмүүр, Яанг нар 1936 онд Бургессийн дэвшүүлсэн бүсчлэлд хуваагдсан хотын бүтцийг Калифорни мужийн Long Beach хотод хэрэгжүүлэн туршихад энэ загварчлал энэ хотод ч гэсэн батлагдаж байлаа. Гэмт хэрэг болон хотын бүтцийн хоорондох хамаарлыг судалсан судалгааны үр дүнд хотын хүн амын хөдөлгөөн нэмэгдэхэд гэмт хэргийн түвшин ч бас нэмэгдэж байсан нь тогтоогджээ.

Варнер ба Пийрс нар 1980 онд Бостоны 60 дүүрэгт цагдаагийн байгууллагад өгсөн дуудлага мэдээлэлд тулгуурлан нийгмийн эмх замбараагүйн онолыг туршихад санхүүгийн байдал, хүн амын хөдөлгөөн, хүн амын төвлөрөл, гэр бүлийн тогтворгүй байдал, үндэстний холимог байдал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан орон байрны хулгай, дээрэм, халдлага зэрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлох судалгаа хийжээ. Судалгааны үр дүнд тогтворгүй гэр бүл, хүн амын төвлөрөл, ядуу дорой, холимог үндэстэн ихтэй бүст гэмт хэргийн түвшин өндөр болохыг харуулсан ба ингэснээр онолыг бататгасан юм.

Сампсон ба Рауденбуш нар өмнө нь 1997 онд Сампсоны хийсэн судалгааг дахин 1999 онд нийгмийн хамтын үр ашиг гэх ойлголтыг Чикаго хотын нийт 23000 гаруй гудамж, 196 дүүрэг, 3500 хүн дунд дахин гүйцэтгэжээ. Судалгааны үр дүнд хамтын үр ашиг нь хот, дүүргийн ерөнхий онцлогтой салшгүй холбоотой бөгөөд хүчирхийлэл агуулсан гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тогтооход чухал нөлөөтэй болох нь тогтоогджээ.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар гэр хорооллын гудамжинд 17434 гэмт хэрэг үйлдэгдсэн гэж бүртгэгдсэн бол хотын төв болон бусад газар 28787 гэмт хэрэг үйлдэгдсэнээр бүртгэгдсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэрэгт 2019 байдлаар 196 хэрэгт 335 хүн холбогдон шалгагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт энэ төрлийн 172, хөдөө орон нутагт 24 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 65 нэгж буюу 33.2 хувиар, холбогдогч нарын тоо 77 нэгж буюу 22.9 хувиар өссөн байна. 2019 онд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 284 нь буюу 86.4 хувь нь 19-35 насны залуус байгаагаас 18 буюу 5.2 хувь нь 15-18 насны хүүхдүүд байна. 17 хүүхдээс 13 нь ерөнхий боловсролын дунд сургуулийн 10-12 дугаар ангийн хүүхдүүд байна. Нийт 335 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 48 нэгж буюу 14.2 хувь нь давтан үйлдсэн байна. Энэ онд бүртгэгдсэн нийт холбогдогчдын 49 хувийг 19-25 насныхан, 43 хувийг 26-35, долоон хувийг 36-45, үлдсэн нэг хувийг 46-55 насныхан эзэлж байна.<sup>34</sup>

Нийгмийн эмх замбараагүй байдал нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болохоос гадна хувь хүнд айдас хүйдэс төрүүлж байдаг. Энэ талаар маш олон эрдэм шинжилгээний бүтээл байдаг ба нийгмийн эмх замбараагүй байдал бүрдсэн орчинд хүн хэрхэн бүрэг болж буй, хувь хүн нийгмээс хэрхэн тусгаарлагдаж бусад хүмүүсээс хөндийрч байгааг илэрхийлсэн байдаг. Орчин тойрноосоо аюул заналхийлэл мэдэрдэг хүмүүс гэмт хэрэгт өртөмтгий байдаг. Энэ онцлогоороо нийгмийн эмх замбараагүй байдал нь хувь хүний бусад хүмүүстай харилцах, итгэх зэрэг байдлыг үгүй хийснээр тэдгээрийг гэмт хэрэгт өртөх эрсдлийг улам нэмэгдүүлж байдаг. Энэ талаар маш олон судалгаа байдаг ба нийгмийн эмх замбараагүй байдал гэмт хэргийн айдсын хооронд шууд хамаарал байдаг гэдгийг нотолдог.

#### **5. Онолын сул ба давуу талууд**

##### **5.1 Онолын давуу тал**

Чикагогийн үзэл баримтлал криминологийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан. Үүнийг хоёр хэсэгт хувааж үзэх боломжтой.

- Онолын
- Арга зүйн

Онолын үүднээс Чикаго үзэл баримтлал нь гэмт хэрэг, зөрчлийн экологи гэх ойлголтыг дэвшүүлж, гэмт явдал болон хүрээлэн байгаа орчны хамаарлыг судалсан судалгаанууд тухайн үед хүчирхэг байсан биологийн детерминизм болон сэтгэл зүй суурьтай гэмт хэргийн онолуудад няцаалт өгч, криминологид Куны тодорхойлсоноор нэгэн парадигм болсон юм.

<sup>34</sup> ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. “Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ”. 2020 оны 2 дугаар сарын 29

Чикагогийн үзэл баримтлал нь соёлын зөрчилдөөн, нийгмийн хяналт, бүлэглэл зэрэг асуудлаар дэвшүүлсэн хамаарлын хүрээ нь дараа дараагийн хяналтын онол, суралцахуйн онол, доод соёлын онол зэрэг онолын суурь болжээ.

Арга зүйн үүднээс Чикаго урсгал нь бодит судалгаа, техникээр социологи, криминологийн шинжлэх ухаанд диалектик, практикт батлагдаагүй онол, үзэл баримтлалын шинжтэй санаануудыг тэр чигт нь няцаасан. Экологи болон гэмт хэргийн харилцан хамаарлыг үндэслэн олж авсан мэдээллийг тоон статистик болгон анализ хийж судалгаа шинжилгээг шинэ түвшинд хүргэсэн. Үүнээс гадна амьдралын хэв маяг, феноменологи, этнографик судалгааг анх удаа судалгааны арга хэрэглэн гэмт явдлын шалтгаан нөхцөлтэй холбон хэрэглэжээ. Ийнхүү шинжлэх ухааны судалгааны арга зүйн бүхий л төрлийг нэгэн зэрэг хэрэглэж, олон ургалч болон холимог үзэл санааг нэгтгэн криминологи, социологи, онол зэргийг бодитоор хэрэгжүүлж өөрийгөө баталсан нь маш том дэвшил болсон юм.

## **5.2. Шүүмжлэлүүд ба онолын сул тал**

Соёлын зөрчилдөөнийг гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлоход ашиглах нь оновчгүй гэж зарим судлаачид үздэг. Аллпорт бол эдгээр социологичдын нэг юм. Аллпорт гэмт хэрэг, зөрчлийг зөвхөн соёлын зөрчилдөөнөөр тайлбарлах нь асуудлыг шийдэх бус илүү ойлгомжгүй байдалд хүргэнэ гэжээ. Түүний үзсэнээр зөрчилдөж байгаа нь соёлын ялгаа биш, бие хүмүүс юм. Хоёр өөр соёл нэг дор хамт байх нь эдгээр соёл зайлшгүй зөрчилдөнө гэсэн үг биш бөгөөд ямар ч асуудалгүй нэг дор өөр соёлууд байдаг нь үүнийг нотолж байгаа хэрэг юм.

### **Нийгмийн эмх замбараагүйн онолд түшиглэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам:**

Шав ба Маккэй нар Чикаго хот дахь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхийн тулд 1930-аад онд өөрсдийн боловсруулсан Чикагогийн бүсчлэлийн төсөл нэртэй судалгаа хийж, онолын хүрээнд дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагааны хүрээнд уламжлалт нийгмийн хяналтыг бий болгох, гэмт бүлэглэлүүдийн залуучуудад үзүүлэх нөлөөг багасгах замаар эдгээр залуучуудыг илүү нийгэмтэй ойртуулахыг зорьжээ. Ингэснээр нийгэм дэх эмх замбараагүй байдал, гэмт хэрэг, зөрчил үйлдэх хандлагаас урьдчилан сэргийлж, хүмүүсийг холбоо, клуб, дугуйлан зэрэг хамт олны оролцоог дэмжсэн үйл ажиллагааг идэвхижүүлжээ. Үүнээс гадна гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулж, мэргэжлийн хүмүүстэй нэг бүрчлэн уулзалт зохион байгуулах замаар шийдэлд хүрэх бүх арга замыг хангажээ.

Нийгмийн эмх замбараагүйн онолын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замын хамгийн эхэнд гэмт хэрэг, зөрчлийн шалтгааныг бий болгож байгаа бодит эмх замбараагүй байдалтай тэмцэх шаардлагатай юм. Аливаа нэгэн газар эмх цэгцгүй, эзэнгүй илтгэх хамгийн энгийн жишээ бол орчны замбараагүй байдал, баригдаж дууагүй барилга, бохир гудамж, хог новш, будаг нь ховхорсон хана гэх мэтийг дурдаж болно. Үүнээс үзвэл бодит эмх замбараагүй байдлыг үгүй болгох нь хамгийн эхний ажил юм. Үүний тулд хот, орчны тохижилтын ажилд анхаарал хандуулах, эзэнгүй барилга байгууламжийг сэргээн засварлах, гудамжны цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах шаардлагатай болно.

Үүний дараа нийгмийн эмх замбараагүй байдлын бас нэгэн шалтгаан болох уламжлалт олон нийтийн хяналтын механизмыг сэргээх, олон нийт дунд итгэл үнэмшил, үнэт зүйлийг сэргээх ажлыг зохион байгуулах хэрэгтэй юм. Ард иргэдийг нэг дор төвлөрүүлж, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхитэй зохион байгуулах, эв нэгдлийг эрхэмлэх, цагдаагийн байгууллага болон бусад төрийн байгууллагууд хамтрах нь үр дүнтэй юм. Олон нийтийн цагдаагийн тусламжтай иргэд болон цагдаагийн байгууллагын харилцааг дэмжих боломжтой. Бусад төрийн байгууллагууд гэдэг нь засаг захиргааны нэгжээс эхлээд иргэнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой бүх байгууллага юм. Ингэснээр төрөөс үзүүлж байгаа тусламж нь ард иргэдэд дэмжлэг болж, үүний зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулсан гэсэн үг юм.

Онолын хувьд гэмт хэргийн түвшин өндөр газруудын нийгэм, эдийн засгийн байдалд бодитой өөрчлөлт орохгүй л бол тодорхой үр дүнд хүрэхгүй юм. Энэ нь тухайн газар оршин суух иргэн бүр тодорхой өөр хэв маягийг хэвшүүлэхгүй бол ганц нэг хүн үүнд санаа зовоод нэмэргүй.

## Дүгнэлт

Хүн өөрөө нийгмийн салшгүй нэг хэсэг юм. Аливаа нийгмийнхээ хүрээллээс шалтгаалан соёл, үнэт зүйлийг өөртөө төлөвшүүлж, өөрийн хандлагаараа нийгмийн үнэт зүйлийг тодорхойлдог. Үүнээс үзвэл аж үйлдвэржилт болон аж үйлдвэржилттэй холбоотой хүн амын өсөлттэй зэрэгцэн холимог тогтолцоотой хот, мужууд, нэг нэгнээсээ эрс тэс ялгаатай соёлууд нэг дор төвлөрч, өмнөх тогтолцоог үгүй хийж, эмх замбараагүй байдлыг бий болгох шалтгаан болдог. Үүнээс үзвэл нийгмийн хамгийн жижиг нэгж гэр бүлээс эхлээд бүх нэгжүүдэд нийтлэг зөв буруу гэх ойлголт үгүй болох ба энэ эмх замбараагүй байдлыг бий болгон гэмт хэрэг, зөрчил үйлдэх хандлагыг нэмэгдүүлдэг байна.

Нийгмийн эмх замбараагүйн онол гэмт хэрэг, зөрчлийн талаар дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг, зөрчил нь олон нийтийн хяналтын механизм, үр нөлөө үгүй болсоноор үүсдэг.
2. Энэхүү хяналтын механизм үгүй болох үйл явц хурдацтай хотжилт, нүүдэл, аж үйлдвэржилтийн үр дүнд бий болдог.
3. Гэмт хэрэг зөрчил тухайн хотын өөр өөр хэсгүүдэд ялгаатай байдаг нь тохиолдол биш бөгөөд тодорхой зүй тогтолтой хамааралтай.
4. Нийгмийн эмх замбараагүй нөхцөл байдалтай газар гэмт этгээдүүд болон тэдний залгамж үеийг гэмт хэрэг, зөрчилд татах байдлаар байнгын хэв шинжийг бий болгодог.

Нийгмийн эмх замбараагүйн онолыг байгалийн шинжлэлийн биологи, амьтан судлал зэрэг шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг экологийн үзэл баримтлалтай адилтган хэрэглэдэг ба гэмт хэрэг үйлдэгдэх нь нийтийн хяналтын механизмын уналттай зэрэгцэн эмх замбараагүй байдалтай уялдан бий болдог нөхцөл байдал гэж үзэж болно.

Эйкэрсийн үзсэнээр Чикагогийн судалгааны үр дүнд гэмт этгээдүүдийн тархац тодорхой нэг тогтолцоотой холбоотой болохыг тайлбарлажээ. Гэмт хэргийн түвшин тухайн хотын төв хэсэгт амьдарч байгаа орлого багатай хэсэгт илүү өндөр байсан бол илүү чинээлэг амьдралтай хотын гаднах хэсэгт улам багассан байна.<sup>35</sup> Судалгаа хийсэн 30 жилийн хугацаанд энэ хэсгийн үндэс угсаа бараг тэр чигээрээ шинэчлэгдсэн хэдий ч хотын төвийн гэмт хэргийн өндөр түвшин хэвээрээ байсан юм. Энэ нь гэмт хэрэг, орчин хоёр салшгүй холбоотойн баталгаа юм.

Америкийн 1900-аад оны нийгмийг судлан дэвшүүлсэн энэ онол дэлхийн хэмжээнд үнэлэгдсэн юм. Хэдийгээр гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг газрууд маш олон ч бүгд Чикаго шиг төвлөрлийн бүсчлэлгүй байж болно. Нийгмийн эмх замбараагүйн онолоос мэдэж авах ёстой зүйл бол гэмт хэрэг, зөрчил нь орчинтой салшгүй холбоотой байдаг юм. Энэ хүрээнд криминологичид болон социологичид хамгийн эхлээд Чикаго үзэл баримтлалын дэвшүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн экологи гэх ойлголтод түшиглэн улс орныхоо өөр өөр хотуудад дээрх онол хэрэгжиж байгаа эсэхийг тогтоон дүн шинжилгээ хийх юм.

## Санал

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд олон нийтийн хяналтын механизм, үр нөлөөг дээшлүүлэх;
- Нийгмийн эмх замбараагүй нөхцөл байдалтай газар гэмт этгээдүүд болон тэдний залгамж үеийг гэмт хэрэг, зөрчилд татах байдлаар байнгын хэв шинжийг бий болгохоос урьдчилан сэргийлэх;
- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил, ёс суртахууны эсрэг зөрчлүүдийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, түгээх ажилд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулж, мэргэжлийн хүмүүстэй нэг бүрчлэн уулзалт зохион байгуулах.

## Ном зүй

- Shaw, Clifford R. 1930. *The Jack Roller: A Delinquent Boy's Own Story*. Chicago: University of Chicago Press

---

<sup>35</sup> Akers, Ronald L. 2000. *Criminological Theories: Introduction, Evaluation and Application*. Los Angeles, CA: Roxbury Publishing Company

- Wirth, Louis. 1931. "Culture Conflict and Delinquency I: Culture and Misconduct." *Social Forces*, Vol.9, No.4, pp.484-492
- Cressey, Paul Frederick. 1938. "Population Succession in Chicago: 1898-1930." *American Journal of Sociology*, Vol.44, No.1.pp.89-101
- Quinn, James A. 1940. "Burgess Zonal Hypothesis and its Critics." *American Sociological Review*. Vol.5, No.2. pp.210-218
- Shaw, Clifford R and McKay, Henry D. 1942. *Juvenile Delinquency and Urban Areas*. Chicago: The University of Chicago Press
- Cloward, Richard A. and Lloyd E. Ohlin. 1966. *Delinquency and Opportunity: A Theory of Delinquent Gangs*. First Free Press Paperback Edition. New York. Free Press
- Cordella, Peter and Siegel, Larry. 1996. *Readings in Contemporary Criminological Theory*. Boston: Northeastern University Press
- Akers, Ronald L. 2000. *Criminological Theories: Introduction, Evaluation and Application*. Los Angeles, CA: Roxbury Publishing Company
- Lichbach, Mark I. 2003. *Is Rational Choice Theory All of Social Science?* Ann Harbor: The University of Michigan Press
- ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ. 2020

## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ОНОЛЫН АСУУДАЛД

*Т.Мөнхдалай*

*Отгонтэнгэр их сургуулийн*

*Хууль зүйн сургуулийн ахлах багш*

**Товч агуулга:** “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад хууль хяналтын болон нутгийн захиргааны байгууллага, түүний албан тушаалтнуудаас хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлж, өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж ажиллах нь онолын болон практикийн ач холбогдолтой, үр дүнтэй ажил болох талаар дурдсан.

**Түлхүүр үгс:** Гэр бүл, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хууль тогтоомж, гэмт хэрэг, илрүүлэх, таслан зогсоох, шалгаж шийдвэрлэх, эртнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуульд тунхаглан тодорхойлогдсон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнчлэн, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх үүргээ биелүүлэхийн тулд гэмт хэрэгтэй хийх тэмцлийн талаар явуулж байгаа төрийн бодлого онцгой ач холбогдолтой.

Хүч хэрэглэсэн гэмт явдал нь нийгэм, төрийн өмнө тулгамдсан олон хурц асуудлыг байнга бий болгогдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа нь төрийн дотоод чиг үүрэгт хамаарал бүхий асуудлын нэг юм.

“Сайн хуульч гэмт хэрэг үйлдсэний төлөө шийтгэхийн оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавина”<sup>36</sup> хэмээсэн нь алив нэг гэмт хэргийг үйлдэхээс өмнө урьдчилан сэргийлэхэд цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр, зардал хэмнэсэн төр, олон нийт, ард иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд нийцсэн ач холбогдолтой арга хэмжээ болдог билээ.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн”<sup>37</sup> гэж хуульчилсан нь тодорхой төрлийн гэмт хэргийн үйлдэгдэн гарч буй шалтгаан, нөхцөлийг зөв тодорхойлж, тухайн гэмт хэргийг дахин давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хэргийн гаралтыг саармагжуулах, тогтворжуулах улмаар бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг зөв төлөвлөн биелэлт үр дүнг тооцон ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх болно.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг илрүүлэн арилгахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явдал чухал бөгөөд энэхүү арга хэмжээ нь шалтгаан нөхцөл бүрт нөлөөлж чадахаар, байнгын, тасралтгүй, иж бүрнээр зохион байгуулагдах ёстой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь шинжлэх ухаанд тулгуурласан, хуульд нийцсэн, бодитой, үндэслэлтэй, ашиг хэрэгцээтэй, дайчин давшингуй, байнгын байх нь үр дүнд хүрэх нэг нөхцөл мөн болохыг төр, засгийн болон хууль хяналт, олон нийтийн байгууллага бүр явуулж буй бодлого, үйл ажиллагаандаа баримтлан мөрдлөг болгон ажиллавал зохилтой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрийн болон хууль хяналтын байгууллагын чиг үүрэг, өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж байгаа арга, хэлбэрээр нь:

- Илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Таслан зогсоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Шалган шийдвэрлэж урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Рецидив /давтан/ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Эртнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Хууль тогтоомжийг боловсронгуй болгож урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэж ангилан үзэж болох юм.

Дээрхи урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар товч дурьдвал:

<sup>36</sup> Ш.Монтескы.Избранные произведения. Москва.1955. 231 дэх тал

<sup>37</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль. 3 дугаар зүйл. 3.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл №42. 2019 он

## **1. Илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Тооноос чанарт шилжих хөгжил дэвшлээр гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, дээшлүүлэхийг өнөөгийн нийгмийн амьдрал цагдаагийн байгууллага, түүний алба хаагч нараас зүй ёсоор шаардаж байна.

Илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буй субъектээр нь:

А. Эрүүгийн цагдаагийн мөрдөгч нараас гэмт хэргийг илрүүлж урьдчилан сэргийлэх ажиллагаа;

Б. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны мөрдөгч нараас гэмт хэргийг илрүүлж урьдчилан сэргийлэх ажиллагаа гэсэн 2 үндсэн хэсэгт хуваан ангилж болох юм.

А.Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар Эрүүгийн цагдаагийн мөрдөгч нар "... гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай, түүнчлэн, улс нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл авмагц гарч болох аюул хохирлыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус тусын чиг үүргийн дагуу шуурхай авах үүрэгтэй"<sup>38</sup> гэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь ихэнхи тохиолдолд гэр бүлийн хүрээнд нууцаар үйлдэгддэг тул Эрүүгийн цагдаагийн мөрдөгч нар нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн гэмт этгээдийг олж тогтоох, гэмт этгээд юу сэдэж төлөвлөж байгааг мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад урьдчилан мэдэж холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч чадсанаар гэмт хэргийн улмаас үүсэх хор аюулыг багасгах буюу таслан зогсоох нь гэмт хэргийг илрүүлж урьдчилан сэргийлэх ажиллагааны нэг хэсэг болдог.

Б.Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны мөрдөгч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах үүднээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх "Гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн ... –ийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн"<sup>39</sup> эдлүүлэх үүргийг хүлээдэг.

Мөрдөгч нар гэмт хэргийг илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох талаар прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд бие дааж шалган шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн үр дүн хариуцлагыг өөрөө хүлээдэг хариуцлагын тогтолцоотой байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гарсан газар, орон байранд хийх хэргийн газрын үзлэг, оролцогч нараас мэдүүлэг авах ажиллагааг зөв удирдан явуулах арга тактикт мөрдөгч нарыг сурган дадлагажуулж мэргэшүүлэх, хэргийн газраас ач холбогдол бүхий ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авах, хураан авсан нотлох баримтыг үнэлэхэд шинжлэх ухаан, техник, технологийн ололт амжилтыг бүрэн дүүрэн хэрэглэх, ашиглах нь хэрэг илрүүлэлтийн үр дүнг ахиулах, дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг сайжруулахад түлхэц болно гэдгийг анхаарч ажиллах нь чухал ач холбогдолтой.

2018 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 210, 2019 онд 207 хэрэг бүртгэгдсэн бөгөөд хэргийн гаралт өмнөх оноос 3 гэмт хэрэг буюу 1.4%-иар буурсан тоон үзүүлэлт<sup>40</sup> байгаа хэдий ч энэ нь нэг талаас дээрхи онуудад Эрүүгийн цагдаагийн болон Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах албаны мөрдөгч нараас бие даан илрүүлсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг байхгүй, зөвхөн хохирогч нарын гомдол мэдээллээр эрүүгийн хэрэг үүсгэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь мөрдөгч нараас хуулиар олгогдсон үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт харьцангуй буурсан нь урьдчилан сэргийлэх ажил сайн хийгдсэн гэж үзэж болох боловч нуугдмал хэлбэрээр үйлдэгдэж байгаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа хангалтгүй байгаад дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй.

## **2. Таслан зогсоож урьдчилан сэргийлэх ажиллагаа**

Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас гэмт хэрэг гарч болзошгүй газар орон, гудамж талбайг эргүүлийн цагдаагийн ажил үүрэг гүйцэтгэх маршрутын хяналтанд бүрэн хамруулах, дүрс бичлэг,

<sup>38</sup> Гүйцэтгэх ажлын тухай хууль.13 дугаар зүйл 13.3.2 дах хэсэг. //Төрийн мэдээлэл.№3, 1998

<sup>39</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.1.1 дүгээр зүйл 1.1.1 дэх хэсэг. //Төрийн мэдээлэл. №23, 2017

<sup>40</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2019 оны гэмт хэргийн мэдээ



дохиоллын хяналтанд авах нь гэмт хэрэг зөрчлийг үйлдэгдэж буй тухайн цаг мөчид таслан зогсоох, аливаа нэг захиргааны зөрчлийг нийгмийн хор аюул нь ихсэх, цаашид даамжран үргэлжлэхээс урьтаж зөрчилтийн шатанд нь илрүүлэн таслан зогсоож урьдчилан сэргийлэх нь ач холбогдолтой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэн гарч болзошгүй орон байр, бусад газрыг цагдаагийн болон олон нийтийн эргүүлийн маршрутын хяналтанд авах ажлыг зохион байгуулахдаа алба хаагч нарынхаа болон хүчирхийлэлд өртөгч иргэдийн аюулгүй байдлыг хангах, цагдаагийн ажилтны албан үүргээ гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, дадлыг харгалзан оновчтой хуваарилалт хийх нь зүйтэй. Түүнчлэн, аж ахуйн байгууллага, иргэдийн туслалцааг авах талаар **албан болон албан бус сургалтуудыг** зохион байгуулан иргэдийн дунд "Миний цагдаа намайг, биднийг хамгаална" гэсэн итгэл үнэмшлийг сэргээн, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, цагдаагийн ажилтны нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн шат дараалсан арга хэмжээг холбогдох байгууллага, албадаас зохион байгуулан хэрэгжүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой хувь нэмэр болох нь дамжиггүй.

Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны идэвхитэй, зохион байгуулалтын оновчтой үйл ажиллагаа нь үйлдэгдэн гарч байгаа гэмт хэрэг зөрчлийг цаг алдалгүй, халуун мөрөөр нь шуурхай мөрдөн илрүүлэх, цаашид олон гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх боломж нөхцлийг таслан зогсоосон урьдчилан сэргийлэх ажиллагааны нэг хэсэг болдог.

### **3. Шалган шийдвэрлэж урьдчилан сэргийлэх ажиллагаа**

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах нь Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үүрэг<sup>41</sup> байдаг.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны мөрдөгч нь иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авсан тэр цаг мөчөөс эхлэн эцэслэн шалгаж шийдвэрлэж дуусах бүхий л хугацааны туршид иргэдийг чирэгдүүлэхгүй<sup>42</sup>, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд ял завшуулахгүй, гэм буруугүй нэг ч иргэнийг хилсээр эрүүгийн хариуцлагад татахгүй байж цагаатгах, яллах болон хөнгөрүүлэх хүндрүүлэх нотлох баримтыг цуглуулах ажиллагаанд хууль ёсыг зөрчихгүй шуурхай ажиллаж гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэн гарсан шалтгаан нөхцлийг арилгуулахаар мөрдөгч, прокурор мэдэгдэл, шүүхээс магадлал бичин биелэлтэнд хяналт тавьж ажиллах нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэсэг байдаг. Мөн шүүхээс гаргаж буй шийдвэр шударга, зөв байх нь гэмт хэргийг таслан зогсоох, дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд хуулийг зөв таниулан ойлгуулахад ач холбогдолтой байх болно.

Цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын алба хаагчийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлыг дүгнэхдээ тоон үзүүлэлтээр бус хийсэн ажлын чанар, үр дүнг харгалзан үндэслэлтэйгээр дүгнэх нь зүйтэй. Тодруулбал, дээр дурдсан байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэхдээ орон нутгийн иргэдийн санал дүгнэлтийг харгалзан үздэг байх шаардлага зүй ёсоор тавигдана.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллага нь "Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах үүрэг хүлээнэ"<sup>43</sup> гэж заасан бөгөөд Шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын ажилтан нь "Нутгийн захиргааны байгууллага, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүрэгт хамаарах хуулийн этгээд, түүний албан тушаалтанд гэмт

<sup>41</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 29 дүгээр зүйл, 29.1 дэх хэсэг. //Төрийн мэдээлэл. №42. 2019

<sup>42</sup>"Гэмт хэргийн хохирогч" судалгаанд /ХЭҮТөв, НЦГазар, ШУА-ийн философи эрхийн хүрээлэн/ "Хуулийн байгууллагын ажилтнууд нь хохирогчдод хэрхэн хандаж харьцдагийг авч үзвэл: 62.9% нь эерэг үнэлгээ өгсөн хэдий ч 33.4% нь үл тоомсорлож, хайхрамжгүй хандсан, 15.3% нь ойлгож туслахыг боддоггүй, 13.9% нь буруутгаж гэмт хэрэгтэн мэт харьцсан, 10.5% нь зуучлагчийн байр сууринаас хандсан, 10.3% нь загнаж хатуу ширүүн хандсан, 6.9% нь мэдээлэл өгдөггүй, тохуурхсан, 1.3% нь ичээсэн гэсэн сөрөг үнэлгээг өгчээ. Хохирогч нартай хуулийн байгууллагын ажилтнууд зүй бус тааламжгүй харьцсан талаар: Хохирогчийн сэтгэл зүйг хайхардаггүй гэж-41%, Харилцааны соёлгүй гэж-40%, Мэргэжлийн ёс зүй, ёс суртахуунгүй /авилга авдаг/ гэж-25.3%, Хохирогчид туслах үүргээ ухамсарладаггүй гэж-23.2% нь дүгнэжээ.

<sup>43</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 29 дүгээр зүйл, 29.1.1 дэх хэсэг. //Төрийн мэдээлэл. №42. 2019

хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл болон түүнийг арилгах тодорхой арга хэмжээний талаар мэдэгдэл, зөвлөмж хүргүүлэх үүрэгтэй”<sup>44</sup> бөгөөд энэ талаар шүүх энгийн магадлал, прокурор, мэдэгдэл мөрдөн байцаах албаны мөрдөгч нар мэдэгдэл бичиж түүнийхээ биелэлтэд хяналт тавьж ажиллах, үүргээ биелүүлээгүй албан тушаалтан, хуулийн этгээдэд хариуцлага тооцох эрх зүйн хэм хэмжээний үндэслэлийг хуульчлан тогтоож<sup>45</sup> өгсөн.

Практикт гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг нутгийн захиргааны байгууллага, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүрэгт хамаарах хуулийн этгээд, түүний албан тушаалтанд даалгадаг ч шүүх, прокурор, мөрдөгч нь бичсэн магадлал, мэдэгдэл, түүний дагуу урьдчилан сэргийлэх тодорхой ажил зохион байгуулж, үр дүнгийн талаар хариу ирүүлсэн тоон үзүүлтэнд сэтгэл амрах бус хийж гүйцэтгэсэн ажлынх нь чанар, үр өгөөжид гол анхаарлаа хандуулах нь зүйд нийцнэ.

Мөн түүнчлэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдлийн дагуу орон нутгийн төрийн захиргааны болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах боломж, нөхцөлийг бүхий л талаар бүрдүүлэн идэвхи санаачлага гарган ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, Хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан биелэлт үр дүнг тооцох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах зэрэг ажлыг зохион байгуулах гэх мэт.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаанд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хамтын ажиллагаа чухал бөгөөд үйлдэгдэн гарсан гэмт хэргийг хуульд заасан анхны хугацаанд нь шуурхай, чанартай шалгаж нэг мөр шийдвэрлэх нь тухайн байгууллагын нэр хүндийн асуудал төдийгүй хууль ёсны зарчмыг ханган биелүүлж байгаа явдал мөн.

❖ Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг бие даасан хараат бус шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын хувьд өөрийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа хууль зөрчигдөхөд хүргэж болох үйлдлийг гаргуулахгүй байхад анхаарч, зөрчлийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж тогтоон таслан зогсоох арга хэмжээг мөрдөгч нартай хамтран хэрэгжүүлэх, тэдэнд даалгавар, шаардлага, зөвлөлгөө чиглэл өгч ажиллаж байна.

Прокурор эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуралдаанд яллах дүгнэлт үйлдэн төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцохдоо үйлдсэн гэмт хэргийн шинж байдал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдал, нөлөөлөл үзүүлэх албадлагын арга хэмжээ, хохирогчид учирсан хохирол, хор уршиг зэргийг прокурорын яллах дүгнэлтэнд тодорхой тусган хуульд заасан яллах үүргээ хэрэгжүүлж ажилладаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “Прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судлаж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавина”<sup>46</sup> гэж Прокурорын байгууллагын чиг үүргийг хуульчилсан байна.

❖ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шүүхийн байгууллагын үйл ажиллагаа шийдвэрлэх нөлөө үзүүлдэг бөгөөд Шүүх өөрийн үндсэн чиг үүрэг болох шүүх таслан ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа гаргаж буй шийдвэр нь шударга, зөв байх нь гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд хуулийг зөв тайлбарлан таниулж ойлгуулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнтэй хэлбэр юм.

Шүүхийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэр олон түмэнд ил тод байдаг учир Шүүхээс гэм буруутай хүн, хуулийн этгээдэд оногдуулж байгаа ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөл, хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, шүүгдэгчийн хувийн зан байдал болон бусад нөхцөл байдлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр зөв шийдвэр гаргах нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн хүмүүжилд болон олон нийтэд сургаж нөлөөлөл үзүүлдэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ болдог байна. Шүүхийн байгууллага гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг,

<sup>44</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 29 дүгээр зүйл. 29.1.10 дах хэсэг. //Төрийн мэдээлэл. №42. 2019

<sup>45</sup> Зөрчлийн тухай хууль. 5.9 дүгээр зүйл. 5.9.1.3 дах хэсэг. //Төрийн мэдээлэл №24. 2017

<sup>46</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 17 дугаар зүйл. //Төрийн мэдээлэл №, 2016

зөрчил, маргааныг хянан шийдвэрлэхдээ хэний ч нөлөөнд үл автан, хөндлөнгийн нөлөөлөл оролцоогүйгээр гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу бэхжүүлж хураан авсан нотлох баримтанд үндэслэн шийдвэр гаргах нь зүйд нийцнэ.

#### **4. Рецидив /давтан/ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа**

Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, хорих ял тэнсэгдсэн болон хорих ял хойшлогдсон хүмүүст тавих цагдаагийн байгууллагын хяналтыг эрс сайжруулах нь дахин давтан гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэсэг юм.

Төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын албан тушаалтан нараас хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, хорих ял тэнсэгдсэн болон хорих ял хойшлогдсон хүмүүсийг хүлээн авах, нийгэмшүүлэх асуудалд төдийлөн анхаарч үздэггүй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, итгэл даахгүй, найдваргүй хүн гэсэн үзэл бодол, хандлагаар хандан цааш түлхдэгээс сэтгэлийн хат нэмгэн зарим нэг нь дахин давтан гэмт хэрэг үйлдэж байгаа нь амьдралын үнэн билээ. Иймд ямар ч төрлийн гэмт хэрэг үйлдсэн байлаа хүн гэдэг үнэт капиталыг алдсан амьдралаа эргүүлэн олж авах, дахин давтан алдаа эндэгдэл гаргахгүй байхад чиглэсэн нөлөөллийн болон бусад ажлыг түүний оршин суугаа газрын нутгийн захиргааны байгууллага санаачлан зохион байгуулж сэтгэлийн урам, эдийн засгийн жижигхэн урамшуулал өгвөл хүн үйлдсэн хэрэг, алдсан алдаанаасаа жигшин дахин засарч хүмүүжих, иргэнших боломж нөхцөлийг олгох болно. Түүнчлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний ажилтан нараас ялтанг хүмүүжүүлэх, давтан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн ажлын арга барилдаа өөрчлөлт гаргах, улмаар хорих ял эдлэж байгаа ялтан ял эдлэж байх үедээ болон оргон зайлахдаа дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой цогц арга хэмжээг зохион явуулах шаардлагатай байна.

#### **5. Эртнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Гэмт хэргийг эртнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь дор дурьдсан төрөлтэй байна. Үүнд:

*а. Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ*

*б. Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ*

*в. Урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ*

*г. Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээ*<sup>47</sup> гэж хуваан үзэж болно.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төр, нийгэм-эрх зүй, нийгмийн ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагын зөв бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга ажиллагаа туйлын чухал юм.

Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, тодорхой бүлэг хүмүүст чиглэгдсэн урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг зохион байгуулахад хамрагдах хүрээ, оролцох субъектыг оновчтой тодорхойлж тэднийг бүрэн хамруулж оролцуулах нь амжилтын үндэс болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг зохион байгуулахдаа үйлдэгдэн гарсан гэмт хэргийн төрөл, шалтгаан нөхцөл, гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон оролцоо зэргийг харгалзан ялгамжтай авч үзэх нь чухал бөгөөд энэхүү арга хэмжээ нь цаг үетэйгээ нийцсэн, бусдад нөлөөлөл үзүүлж чадахаар зохион байгуулах нь иргэдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хэрэгт холбогдохоос хамгаалах үр дүнтэй ажил болно. Тухайлбал: Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн албан болон албан бус сургалтыг оролцогч нарын мэдлэг, боловсролд тохируулан ялгавартайгаар, тодорхой үе шаттайгаар тасралтгүй зохион явуулах замаар аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх боломжтой.

Тодорхой нэг хүн гэмт хэрэг үйлдэх, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн хүний хувийн зан байдал, гэр бүл, найз нөхдийн орчин нөлөөг харгалзан тэр нөхцөл байдалд тохирсон нөлөөлөл, хүмүүжлийн чанартай арга хэмжээг сонгон авч хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй зохион явууласнаар үр дүнд хүрэх болно.

Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээ нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн гэмт зан үйл, буруу тогтсон дадал зуршилд нь соён гэгээрүүлэх замаар нөлөөлөл үзүүлэх үйл явдал юм.

<sup>47</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 6 дүгээр зүйл. 6.1.4 дэх хэсэг. //Төрийн мэдээлэл №42. 2019

## **6.Хууль тогтоомжийг боловсронгуй болгож урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Улс орон хөгжихийн хэрээр, нийгмийн хөгжлийн шаардлагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал нь нийгмийн хэрэгцээ, шаардлага, захиалгаар тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц бөгөөд энэ нь зөвхөн хуулийг шинээр батлах, зохих нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн найруулснаар хангагдчихдаг асуудал төдий бус нэгэнт батлагдсан хуулийг зөв ойлгож, тайлбарлан амьдралд хэрэгжүүлэх, онол болон практикийн уялдаа холбоо, харилцан хамаарлыг зөв, шударгаар хангах явдал билээ. Өөрөөр хэлбэл, батлагдан гарсан аливаа хуулийн онол, практик хэрэглээ нь амьдралтай нийцсэн, шинэ онол, үзэл баримтлал дэвшүүлсэн нь үндэснийхээ өв соёл, уламжлалыг хадгалсан хуулийг хэрэглэх практик ажиллагаа нь бусад салбар хууль эрх зүйтэй харилцан шүтэлцэж уялдсан тохиолдолд уг хууль хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Үүнийгээ бид сайн хууль батлагдлаа гэж ярьдаг.

Энэ тухай криминологийн сонгодог сургаалыг үндэслэгч Чезаре Беккариа өөрийн бүтээлдээ “Хуулийг хүмүүс уншаад шууд ойлгохоор энгийн ойлгомжтой бичих”<sup>48</sup> хэрэгтэй гэж тэмдэглэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнг нь сайжруулах талаар Улсын их хурал, хууль хяналтын болон орон нутгийн захиргааны байгууллагаас олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь “ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай “Монгол Улсын хуулийг шинэчлэн батлаж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд холбогдох зүйл заалтыг шинээр нэмж хуульчилсан явдал юм.

Гэвч хуулийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байгаагийн гол шалтгаан нь нэг талаас хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд эргэлзээ төрүүлсэн, хоёрдмол утга, агуулгатай, хууль үйлчлэх хоорондын уялдаа холбоо тааруу, хуулийн хийдэл байгаа, нөгөө талаас алба хаагч, ажилтнуудын мэдлэг, чадвар, санаачлага сул байгаа явдал нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй “сайн” зохион байгуулахад хүндрэл бэрхшээл учруулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд олон нийтийн оролцоо чухал бөгөөд тэдний хүч туслалцааг авах ажлыг сайтар зохион байгуулахад Цагдаагийн байгууллага, олон нийттэй харилцах алба, олон нийтийн байцаагч нарын идэвхи санаачлага, хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн төдийлөн харагдахгүй, олон нийтэд хүрч мэдрэгдэхгүй байгаад шүүмжлэлтэй хандаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи, санаачлагатай оролцсон иргэдийг урамшуулах, урамшууллын олон хэлбэрийг сайн ашиглах хэрэгтэй.

Цагдаагийн алба, ажилтнуудаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, халдлагад өртсөн хүнд хууль зүйн болон бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх, хамгаалалтанд авах, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг судлан дүн шинжилгээ хийж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, арга замыг нь тодорхойлон заасан аргачлал, зөвлөмжийг боловсруулан цагдаагийн болон нутгийн захиргааны байгууллагын алба хаагч нараар судлуулан хэрэгжүүлдэг, улмаар тэднийг мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион явуулах шаардлагатай байна.

Цагдаа, прокурор, шүүхийн байгууллага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлыг нь дүгнэхдээ тоон үзүүлэлтээр бус хийсэн ажлын чанар, үр дүнг тооцож олон нийтийн сэтгэл ханамж, санал хүсэлтийг харгалзан үнэлэх нь ач холбогдолтой болно.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг зөв тодорхойлж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах, уг гэмт хэргийн талаархи дэлгэрэнгүй судалгаа, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх зэрэг ажлыг хариуцсан “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” албыг Цагдаагийн газар, хэлтсийн дэргэд байгуулах, ажилтнуудын орон тоо, үйл ажиллагааны чиглэлийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан, ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх шаардлага бий болоод байна.

Эцэст нь дурдахад “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг” сайтар зохион байгуулж ажиллахад энэ чиглэлээр мэргэшсэн байцаагч, мөрдөгч, прокурор, шүүгчийг бэлтгэж, тэдний хүч туслалцааг авч ажилласнаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчил буурах нэг нөхцөл бүрдэнэ.

<sup>48</sup>Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай./Г.Эрдэнэбатын орчуулга/. УБ. 2007. 62 дах тал

## ДАЛД ЭДИЙН ЗАСАГ БА ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМААРЛЫН ОНОЛЫН АСУУДАЛ

Ү.Анхбаяр

*Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн  
Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч,  
Дотоод хэргийн их сургуулийн магистрант*

**Товч агуулга:** Далд эдийн засгийн ойлголт, шинж, түүнийг эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл, хор уршгийг судалж, судалгааны үр дүнд үндэслэн түүнтэй тэмцэх талаарх санал-зөвлөмж боловсруулсан.

**Түлхүүр үгс:** Эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдал, аюулгүй байдал, далд буюу сүүдрийн эдийн засаг.

### Удиртгал

Монгол Улс төдийгүй дэлхийн нийтийн эдийн засгийн аюулгүй байдал нөлөөлж буй далд (сүүдрийн, албан бус, парралель) эдийн засгийн тухай ойлголт, түүнийг бүрдүүлэгч төрлүүд, өсөлт, ажиллах хүчин, албан эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн талаар зарим жишээн дээр товч өгүүлэхийн зэрэгцээ санал-зөвлөмж боловсрууллаа. Түүний хажуугаар судлаачдын хийсэн ажил дээр үндэслэн өөрийн улсын далд эдийг засгийн бүрдүүлэгч хүчин зүйлүүд, тэдгээрийн хэмжээг энгийн аргаар тодорхойлж, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохыг зорилгоо. Далд эдийн засгийн талаар нарийн тодорхой мэдээлэл, албан ёсны баримтыг оруулахад хэцүү байгаа нь уг асуудал хувь хүний сонирхолруу хэт давуу байдалтай орж, нийтэд мэдэгдэхгүй далд хэвээр байхыг хүсэж байгаатай нягт холбоотой гэж үзэж болохоор байна.<sup>49</sup>

Судлаачид далд эдийн засгийг өөр өөрийн үзлээр тайлбарласан байдаг бөгөөд нарийн тоо баримтыг гаргахын тулд олон талт судалгаанд тулгуурлах нь чухал байна. Далд эдийн засаг нь хувийн сонирхолд орсон гэдэг нь хувь хүн ямар нэгэн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй такси үйлчилгээ үзүүлэх, сантехникч нь бусдын эвдэрсэн усны хоолойг засаж өгөөд хувьдаа төлбөр мөнгийг авах, хувь хүмүүс гар дээрээс худалдаа наймаа эрхлэх зэрэг энгийн мэт жишээнээс авахуулаад Эрүүгийн хуульд заасан хулгай, дээрэм, залилах зэрэг гэмт хэргийг үйлдэж олсон мөнгө, эд зүйлээс гадна хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, зэвсгийн наймаа, бэлгийн мөлжлөг, хүн худалдах, хээл хахууль, хилээр хууль бусаар бараа, эд зүйл нэвтрүүлэх, зэрэг үндэстэн дамнасан гэмт хэргийн үйлдлүүд бүрийн цаана аливаа төрийн хяналтад үл хамаарах далд буюу сүүдрийн эдийн засаг нуугдаж байдаг.

Судлаачдын үзэж байгаагаар, дээрх үйл ажиллагаа нь дэлхий даяар жилд нэг триллион орчим америк доллараар хэмжигддэг бөгөөд татварын байцаагч, засгийн газрын эрх мэдэлтнүүдийн нүдэнд өртөхгүй өнгөрдөг. Гэмт хэргийн болон далд эдийн засгийн үйл ажиллагаа нь урт хугацааны замыг туулж, өнөөгийн байдлаар дэлхий дахинд улам бүр нягт болж, эрчимжсээр байна. Иймээс түүний үйл ажиллагаа болон өсөлтөд бүхий л хэлбэрээр хяналт тавихгүй бол дараах ноцтой байдалд хүргэх болно. Үүнд:

- Далд буюу сүүдрийн эдийн засгийн өсөлт нь ажилгүйчүүдийн тоо, албан ёсны ажиллах хүчин, орлого, хэрэглээ гэх мэт албан статистикийн уяалдаа холбоог алдагдуулдаг байна. Иймээс бодлогын арга хэмжээ явуулах, эдийн засгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ хоорондын уялдаа холбоо, хамаарал нь алдагдсан статистик дээр суурилах юм бол бодит бус буруу үр дагаварт хүргэх магадлалтай.<sup>50</sup>
- Далд эдийн засгийн өсөлт нь хор хөнөөлтэй үе мөчлөгийг бий болгодог. Сүүдрийн буюу далд эдийн засагт явагдаж байгаа үйл ажиллагаа нь төрд татвар төлөх байдлыг багасгадаг бөгөөд төсвийн орлогыг буруулдаг. Татварын суурь бааз түүнээс татвар цуглуулалтын хэмжээ багасаж эхэлбэл Засгийн газар татварынхаа хэмжээг нэмэгдүүлнэ. Энэ нь сүүдрийн буюу далд эдийн засгийн цаашдын идэвхижилтийг улам бүр нэмэгдүүлж, төсвийн орлогыг сулруулдаг. Өөрөөр хэлбэл сүүдрийн эдийн засагт хуримтлагдсан орлогын гуравны хоёр хувь нь л гэхэд албан эдийн засгийн үзүүлэлтэд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлэхээр байдаг байна.<sup>2</sup>
- Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргүүд, цагаан захтнууд буюу авлига, албан тушаалын гэмт хэргүүдийн нөлөө улам бүр идэвхижиж, дэлхий нийтийн

<sup>49</sup> МБСГ-ын эдийн засагч Д.Энхзаяа “Сүүдрийн эдийн засаг” 2012

<sup>50</sup> www.mongolbank.mn/ МБСГ-ын эдийн засагч Д.Энхзаяа “Сүүдрийн эдийн засаг” 2012

анхаарлыг татаж, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх үндэс болохын сацуу улс орны эдийн засаг, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч болзошгүй байна.

Энэхүү илтгэлээр далд эдийн засгийг бүрдүүлэгч хүчин зүйлүүд, тэдгээрийн үзүүлэх нөлөөг таниулахыг зорьсон болно.

### **Далд эдийн засгийн ойлголт, үндсэн шинж**

Далд буюу сүүдрийн эдийн засгийн талаарх тодорхойлолтуудыг янз бүрийн хэлбэрээр эдийн засгийн ном хэвлэл, сурах бичгүүдэд дурдагдсан байдаг. Зарим тохиолдолд хоёр дахь эдийн засаг эсвэл албан бус эдийн засаг гэж нэрлэх нь ч бий. Далд эдийн засгийг Англи хэл дээр shadow economy, second economy, unofficial economy, informal economy, Орос хэл дээр теневая экономика гэдэг нь “Далд буюу сүүдрийн эдийн засаг” ба албан ёсны бүртгэлд тооцогддоггүй эдийн засгийн үйл ажиллагаа гэж үздэг, энэ нь улс орны үндэсний нийт бүтээгдэхүүнд орж тооцогддоггүй гэсэн тодорхойлолт юм.<sup>51</sup> Далд буюу сүүдрийн эдийн засаг хэмээх үг нь эдийн засгийн шинжлэх ухаанд 1930 оноос эрчимтэйгээр нэвтэрсэн ба АНУ-ын эрдэмтэн эдийн засагч П.Гупман уг тодорхойлолтыг гаргасан байна. Төрийн хяналтад үл хамаарах эдийн засгийн үйл ажиллагааны төрөл буюу эдийн засгийн зүй бус, хууль тогтоомжоор хориглосон, тооцож үл болох бараа, үйлчилгээний нийлүүлэлт. Аливаа дүрэм журам, хуулийн хариуцлагаас зайлсхийхийн тулд иргэн, ААН нь эрхэлж буй үйл ажиллагаагаа үнэн бодитой мэдээлэхгүй, албан ёсны эдийн засгийн бүртгэлээс орхигдож, далд хэлбэрт үйл ажиллагаа явагдаж байдаг.

Албан тушаал, авлига, хүний наймаа, хар тамхи мансууруулах бодисын хууль бус эргэлт, бүхий л төрлийн хууль бус худалдаа, бусад төрлийн гэмт хэрэг үйлдлээс шууд болон шууд бусаар олж авсан эд хөрөнгө, эдийн засгийн давуу байдлаас гадна улс орны татварын алдаатай бодлого, түүний дарамт, нийгмийн даатгалын өндөр шимтгэл, иргэдээс банкны системд үл итгэх байдал зэргээс далд эдийн засгийн өсөлт нэмэгдэж байна. Хууль бус үйл ажиллагаанаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн бараа үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон мэдээлэгдээгүй орлогуудыг /мөнгөн болон бартерийн хэлцлүүд зэрэг/ оруулан ойлгоно. Далд эдийн засаг нь зарим талаар албан эдийн засгийн бүх үйл ажиллагааг агуулдагийг хувьд татварын газарт мэдээллээ өгч, татвар төлөгч байх ёстой. Гэвч түүнийг нарийн тодорхойлоход төвөгтэй учир татвар төлөлт болон дүрэм, журам өөрчлөгдөх бүрт цаг үргэлж харилцан уялдаатайгаар хөгжин өөрчлөгдөж байдаг.

ОХУ-ын далд эдийн засгийн хэмжээ нь 1991 онд ДНБ-ийн 10-11, 1997 онд 27, өнөөгийн байдлаар 50 хувьтай тус тус тэнцэх болсон талаар судлаачид тооцон гаргасан байдаг. Харин АНУ-д 700 тэрбум, Итали Улсад 310 тэрбум, ХБНГУ-д 300 тэрбум, Англи Улсад 190 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө албан эдийн засгаас гадуур өнгөрдөг гэж үзсэн байдаг бол Монгол Улстай ижил хөгжилтэй орнуудын хувьд дээрх хэмжээ нь ДНБ-ийн 40-50 хувьтай тэнцдэг гэж үзжээ.<sup>52</sup>

Монгол Улс дахь далд эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс:

1. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой цагаан захтнуудын хууль бус орлого;
2. Зах худалдааны төвүүдэд арилжаа хийж буй жижиг бизнес эрхлэгчид, өрхийн болон хувиараа бизнес эрхлэгчид, албан бус секторынхны олсон орлого /Гаалийн болон ХХОАТ төлдөггүй/;
3. Эрэлт хэрэгцээ бүхий бараа, үйлчилгээг нэг гараас нөгөөд дамжуулан үнийг өсгөж, худалдан борлуулдаг “Ченж” гэгдэх худалдаа эрхлэгчдийн олсон орлого;
4. Хүний наймаа, бэлгийн мөлжлөг, хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн наймаа болон бусад төрлийн гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлого;
5. Мөнгө хүүлэгчид буюу гар дээрээс барьцаатай болон барьцаагүй хэлбэрээр бусдад хүүтэй мөнгө зээлж, ашиг олдог хүмүүсийн олсон орлого;
6. Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоодын дүрмийн санд ороогүй, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээс гадуур үйл ажиллагаандаа оруулж буй мөнгө;
7. ААН, иргэдийн татварын байгууллагад хуулийн дагуу тайлагнаагүй, татвар ногдуулах төлөхөөс зайлсхийсэн орлого /орлогын, нэмэгдсэн өртөгийн болон бусад татвараас зайлсхийх/;

<sup>51</sup> Н.Амар “Далд эдийн засгийн хэмжээ, өсөлт, нөлөө” 2002 он.

<sup>52</sup> Н.Амар “Далд эдийн засгийн хэмжээ, өсөлт, нөлөө” 2002 он.

8. Банкны системд үл итгэх хүмүүсийн гар дээрээ хадгалж байгаа мөнгө зэрэг нь Монгол Улс дахь далд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байгаа гэж үзэж байна.

Орлого өндөртэй хөгжингүй орнуудад сүүдрийн эдийн засаг нь өргөн хүрээг хамарч, сүүдрийн эдийн засаг дахь үйл ажиллагаа, оролцоо нэмэгдэхийн хэрээр дэлхийн эдийн засаг хямралд өртөж байгааг хүлээн зөвшөөрөөд байна. Тэдгээр улсуудын ихэнх нь дээрх асуудалд анхаарч хууль сахиулахад чиглэсэн бүтцийн болон бодлогын дэлгэрэнгүй стратеги боловсруулаад байна. Одоогийн хэрэгжүүлж байгаа хууль сахиулах хөтөлбөрийг сайжруулах нь нөлөөлөл багатай учраас татварын байгууллагаас сүүдрийн эдийн засгийн эрсдэлийг бууруулах, түүнийг ядаж хяналтын түвшинд барьж байх шинэчилсэн стратеги бүхий хувилбарыг боловсруулах шаардлагатай. Зарим улсуудад сүүлийн үед хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь зах зээл дээрх бэлэн мөнгөөр хийгдэж байгаа аливаа хэлцэл, гүйлгээг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч байна. Төлбөрийн карт, утсан болон цахим гүйлгээ хийх төлбөр гүйцэтгэх шинэ арга, хэрэгсэл нэвтэрсэн боловч бэлэн мөнгөөр хийгдэж байгаа гүйлгээ эдийн засаг өндөр хөгжсөн улс орнуудад ч байсаар байгаа юм.<sup>53</sup>

Өндөр хөгжилтэй орнуудад ч далд эдийн засаг өргөн хүрээг хамарч эдийн засгийн хямрал, татварын орлогод муу нөлөөлдөг болохыг хүлээн зөвшөөрөөд байна. Австралийн төв банкнаас хийсэн судалгаагаар тухайн улсад нийт төлбөр тооцооны 70 гаруй хувь нь бэлэн мөнгөөр хийгдэж байна гэжээ. Судалгаанаас харахад энэхүү төлбөр нийт хэлцлийн 38 хувийг эзэлж байгаа ба үнэ цэнэ багатай худалдан авалтад бэлэн мөнгө төлбөрийн гол хэрэгсэл болж байгааг харуулжээ.<sup>54</sup> Гэтэл бэлэн мөнгөөр хийгдсэн арилжаанд татварын байгууллагаас хяналт тавих, тодорхойлоход хамгийн хүндрэлтэй байдаг. Тиймээс татварын байгууллага нь банк, санхүүгийн байгууллагатай нягт холбоотой хамтран ажиллаж, олон нийтийн бэлэн мөнгөөр хийгдэх төлбөр тооцооны эргэлтийг бууруулж, төлбөрийн бусад хэрэгсэл хувилбаруудыг санал болгон дэмжин хөгжүүлэх шаардлагатай юм.

#### **Эдийн засгийн аюулгүй байдалд далд эдийн засгийн үзүүлэх нөлөө**

Эдийн засаг нь шинжлэх ухааны бие даасан салбар бөгөөд онолын болон хавсарга байдлаар судлагдаж байна. Онолын эдийн засгийг хүн, нийгэмт хязгаарлагдмал нөөц ашиглах аргыг, хэрхэн ашиглаж байгааг судлах эдийн засгийн онол гэж нэрлэдэг. Хавсарга эдийн засаг гэдэг нь эдийн засгийн тогтолцооны тусгаар элементүүдийн үйл ажиллагааг хангахын тулд эдийн засгийн онолоор бий болгосон санал, хууль, зүй тогтолын хэрэгжих боломжийг судалдаг ухаан мөн.<sup>54</sup>

Иймээс эдийн засгийн асуудлыг авч үзэхдээ онолын болон практик асуудлыг харилцан хамааралтайгаар авч үзэх нь чухал. Монгол Улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “Эдийн засгийн аюулгүй байдал”, “Дотоод аюулгүй байдал”, “Хүний аюулгүй байдал”, “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “Мэдээллийн аюулгүй байдал” харилцан уяалдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна гэж тодорхойлсон байна.<sup>55</sup> Г.Вечканов дээрх асуудлаас онцлон улс орны эдийн засгийн аюулгүй байдал, түүний тогтвортой хөгжил нь аюулгүй байдлын бусад салбарын үндсэн тулгуур нь болно гэж үзсэн байдаг. Эдийн засгийн аюулгүй байдалд эдийн засгийн суурь салбаруудын тогтвортой хөгжил, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, хөрөнгө оруулалтын оновчтой хувилбарууд, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, шинжлэх ухаан технологи, инновацийн идэвхитэй байдал, улсын мөнгө санхүүгийн бодлого, зохицуулалт, экспорт, импортын зохистой харьцаа зэргийг оруулан ойлгож болно<sup>7</sup> гэж үзсэн байна. Иймээс эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь улс орны үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг юм.

Сүүдрийн буюу далд эдийн засгийн үр дагаврын улмаас ихэнх улс орнуудад боломжит татварын орлогын алдагдал нийт татварын зөрүү /бодит ба боломжит татварын орлогын хоорондын зөрүү гэх мэт/-ний ихэнх хувийг эзэлж байдаг. Далд эдийн засаг гэсэн ойлголт нь маш өргөн хүрээтэй, олон янз байдаг боловч ерөнхийдөө татварын тогтолцооноос гадна бизнесийн үйл ажиллагаа явуулах, бүртгэлтэй ААН-д татвар болон Нийгмийн даатгал төлөхөөс зайлсхийж, нуун дарагдуулах эсхүл хэрэглэгчийн эрх ашиг болон аюулгүй ажиллах нөхцөлтэй холбоотой хууль эрх зүйн зардлаас зайлсхийхийг хэлдэг. Заримдаа ийм хэлцэл, үйл ажиллагаануудыг бүгдийг биш ч гэсэн хэсэгчилсэн байдлаар орлого дарагдуулж, бодит төлөх ёстой татварын хэмжээнээс хамаагүй бага орлогыг татварын байгууллагад тайлагнадаг ба мөн

<sup>53</sup> <http://www.test.monicipa.mn/> Фридрих Шнайдер “Сүүдрийн эдийн засаг”.

<sup>54</sup> Б.Юмаажав, Т.Мөнх-Оргил, Д.Мөнхбат “Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй зарим асуудал” 2018

<sup>55</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

зарим тохиолдолд тухайн бизнес үйл ажиллагаа, хэлцлийг огт тайлагнадаггүйн дээр татвараас нуух зорилгоор төлбөрийг бэлэн мөнгөөр хийх тохиолдлууд цөөнгүй.<sup>56</sup>

Үүний нэг жишээ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-үүд нь тусгай зөвшөөрөл, эрхийг бусдад худалдах үйл ажиллагаагаа бэлэглэлийн гэрээгээр халхавчлан хийх явдлыг дурдаж болох юм. Статистикийн баримтаар харахад 2000 оноос өмнө манай улсад ийм хэлбэрийн эдийн засгийн эзлэх хувь их байсан нь албан ёсны бүртгэлтэй ажлын байр хомс, нийгмийн даатгалын систем бэхжээгүй байсантай холбоотой. Тухайн үед Монгол Улсад дээрх үзүүлэлт нь насанд хүрсэн хүн амын 40 орчим хувьтай тэнцдэг байжээ. Ер нь далд эдийн засгийг бий болгодог ажилгүй, тогтмол орлогогүй иргэд, татвар төлөхөөс зайлсхийгчид, хууль бус бизнесээр хөлжигчид нь 1990-2000 онд “гаарсан” гэж эдийн засагчид үздэг. Тухайлбал “Ганзагын наймаа” буюу хувиараа худалдаа эрхлэгчид, дамын наймаа ид цэцэглэж байх үед ажилгүй иргэдийн тоо 300 мянга хол давсан. Харин улсад бүртгэлтэй бизнесийн цөөн хэдхэн компани, төрийн байгууллагуудаас цалин авч, татвар, даатгал төлдөг цөөн хүмүүс байсан.

Улсын төсвийн орлого тэрбум төгрөг хүрдэггүй байсан бөгөөд 1991-1997 онд ганзагын наймаачдын гарт 800 тэрбум гаруй төгрөг эргэлддэг байсан гэж үздэг.<sup>57</sup> Харин одоогийн байдлаар 12 их наяд орчим төгрөг албан эдийн засгаас далд байна гэж үзэж байгаа. Далд эдийн засгийн өсөлтөд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой нуугдмал хөрөнгө орлого, зах худалдааны төвүүдэд арилжаа хийж буй жижиг бизнес эрхлэгчдээс гадна өрхийн болон бусад байдлаар ажил, үйлчилгээ явуулдаг албан бус секторынхны олсон орлого, бүхий л төрлийн гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлого, ААН, иргэдийн татварын байгууллагад хуулийн дагуу тайлагнаагүй, татвар ногдуулах төлөхөөс зайлсхийсэн орлогоос гадна банк санхүүгийн системд үл итгэгч хүмүүсийн гар дээр хадгалагдаж байгаа мөнгөнүүд нөлөөлж, нэмэгдүүлж байдаг. Далд эдийн засгийг бүрдүүлэгч дээрх байдлууд улам бүр идэвхижсэнээр улс орны эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлж, төсвийн хүчин чадлыг сулруулж байдаг юм. Үүний хажуугаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэг, түүнийг үйлдэгчдийн үйл ажиллагааг санхүүжүүлэгч нь болж байдаг ба эцэстээ энэ далд хэлбэрт байгаа мөнгийг ил гаргахын тулд мөнгө угаах гэмт хэрэг зайлшгүй үйлдэгддэг. Монгол Улс нь мөнгө угаах гэмт хэрэгтэй хангалттай тэмцэж чадаагүй, ФАТФ-аас өгсөн зөвлөмжийг зохих ёсоор биелүүлээгүй гэсэн шалтгаанаар “Саарал жагсаалт”-д ороод байгаа нь сүүдрийн эдийн засаг гэх зүйлийн эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөний тодорхой илрэл юм.

Далд эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нэг гол хүчин зүйл болох авлига, хээл хахуулийн улмаас жил бүр дэлхийн эдийн 2 их наяд ам.долларын хохирол учирч байдаг гэх судалгаа байдаг ба энэ нь ядууралтай тэмцэх, ажлын байр бий болгох, байгаль орчныг хамгаалахад зарцуулж болох их хэмжээний мөнгө гэдгийг ажиглагчид онцолж байна. Авлига зарцуулсан мөнгөний хэмжээ дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувьтай тэнцэж байгаа судалгааг ОУВС-аас гаргасан байна. Авлига нь Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг бууруулахаас гадна гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс төрийн алба хаагчид нь шударгаар ажилладаг улс орнуудыг хайдаг. Авлига, хээл хахууль нь банкны тогтолцоог сулруулж, хүмүүсийн санхүүгийн зах зээлээс хөндийрүүлэхэд нөлөөлдөг байна. “Далд эдийн засагт орох нь авилгалд автах зам бөгөөд үйлдвэрүүд зарим тохиолдолд мэргэжилтнүүдийг хахуульддаг нь албан ёсны шийдвэрээс зайлсхийхийн тулд аж ээ” хэмээн<sup>58</sup> Роүз Аккермен тэмдэглэсэн байдаг.

Далд эдийн засаг нь эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг судлахын тулд зарим нэгэн судалгааг макро эдийн засгийн загварт нэгтгэн судалдаг байх ба Хюстон далд эдийн засгийн өсөлтийн судалгааг дүгнэхдээ нэг талаас үнийн нөлөөгөөр татвар бүрдүүлэлт болон зохицуулагч бодлогыг хэрэгжүүлнэ, нөгөө талаас далд эдийн засаг оршин байснаар санхүү болон мөнгөний сэргээх нөлөө үзүүлэх инфляцийн үр нөлөө өсгөх магадлалтай гэжээ. Адам, Гинбург нар далд эдийн засгийн урьдчилсан нөхцөлд анхаарлаа хандуулж байсан. Тэд далд эдийн болон эдийн засгийн хооронд эерэг холбоо байгааг илрүүлсэн ба инфляцийн уналтын бодлого нь албан болон албан бус эдийн засгийн хувьд эерэг нөлөө үзүүлдэгийг дүгнэн баталжээ.<sup>59</sup> АНУ-ын шинжээч Финчтенфаумны 1989 оны судалгаагаар АНУ-ын үр бүтээлийн удаашрал 1970-1989 онд их өссөн, АНУ далд эдийн засгийн хурдацтай хөгжлийн ачаар

<sup>56</sup> <http://www.test.monica.mn/> Фридрих Шнайдер “Сүүдрийн эдийн засаг”

<sup>57</sup> Н.Амар “Далд эдийн засгийн хэмжээ, өсөлт, нөлөө” 2002 он.

<sup>58</sup> <http://www.test.monica.mn/> Фридрих Шнайдер “Сүүдрийн эдийн засаг”.

<sup>59</sup> <http://www.test.monica.mn/> Фридрих Шнайдер “Сүүдрийн эдийн засаг”.



орлогын бууралт болоогүй гэж үзсэн байгаа нь сүүдрийн буюу далд эдийн засаг нь эдийн засгийн аюулгүй байдалд дан сөрөг нөлөө үзүүлдэггүй болохыг харуулж байна.

### **Дүгнэлт**

Далд эдийн засгийн өсөлт нь улсын бараа үйлчилгээний чанар болон тоо хэмжээ буурч, улмаар улсын орлого багассаны үр дүнд бий болдог гэж өмнө нь дурдаж байсан. Гэвч ихэнх тохиолдолд пүүс компани болох иргэдэд ногдуулж буй татварын түвшний өсөлт, улсын бараа, үйлчилгээний (засгийн газрын мэдэлд байгаа зам, эмнэлэг гэх мэт) чанар ба зохион байгуулалт муудсантай уялдаж бий болдог байна. Нөгөө талаар сүүдрийн эдийн засагт бий болсон орлогын гуравны хоёр нь түргэн хугацаанд албан эдийн засагт зарцуулагддаг байна. Энэ нь албан эдийн засагт эерэг байдлаар нэмэр болж өсөлтийг нэмэгдүүлэх талтай. Иймээс сүүдрийн эдийн засгийн өсөлт нь бүх зүйлд нөлөө үзүүлж чадна. Гэвч энэ нөлөө нь ихэнхдээ эерэг, эсхүл сөрөг байна уу гэдгийг үнэлж, дүгнэхэд хэцүү. Засгийн газар далд эдийн засгийг хянахын тулд хууль тогтоомжийг гаргаж чадна.<sup>60</sup> Татварын түвшин өндөр, бага хэмжээний далд эдийн засагтай улсын хувьд хууль, журмыг сайн дагаж мөрдсөний үр дүнд татварын түвшинг бууруулж чаддаг талаар судлаачид баталсан байдаг ба түүнд цөөн тооны хууль журмуудыг хэрэгжүүлэх нь чухал байдгийг онцолжээ. Мөн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь далд эдийн засгийн өсөлтийг хязгаарлах, бууруулах үндэс болдог гэж үзэж байна. Үүнд.

Далд эдийн засгийн хэмжээ болон өсөлтийг удирдаж буй гол хүчин зүйлс нь татварын дарамт, нийгмийн хамгааллын төлбөрүүд болон Засгийн газар, улсаас зохицуулах үйл ажиллагаа хууль эрх зүйн орчин нь оновчтой биш, хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэхгүй байх зэрэг нь далд эдийн засгийн үйл ажиллагааг өөхшүүлж байдаг бөгөөд олон орны туршлагаас харахад авилга болон далд эдийн засагтай холбогдох үйл ажиллагааг хянах хууль, дүрэм, журмуудыг хэрэгжүүлэх нь чухал байдгийг онцолжээ. Мөн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь далд эдийн засгийн өсөлтийг хязгаарлах, бууруулах үндэс болдог гэж үзэж байна. Үүнд.

- Татварын түвшинг бууруулах нь сүүдрийн эдийн засгийг багасгах гол хүчин зүйл биш боловч түүнийг тогтворжуулах сайн талтай.
- Шууд татварыг шууд бус татвараар орлуулж, татварын бааз суурийг аль болох өргөтгөж, тэдгээрт ногдох татварын хэмжээг багасгаж, мөн зайлшгүй болгох.
- Татвараас зайлсхийсан үйлдэл давтагдсан субъектэд татвар, санхүүгийн шалгалтыг явуулж, гарсан зөрчилд өндөр торгууль ногдуулах.
- Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэлд оногдуулах ялын бодлогыг өндөрсгөх, нэн ялангуяа хууль бус орлого, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгө зэргийг хурааж, улсын орлого болгодог хууль эрх зүйн зохицуулалттай байх;
- Засгийн газраас далд эдийн засгийн үйл ажиллагааг хуульчлахад онцгой анхаарах, тухайлбал албан бус секторын үйл ажиллагааг хуульчлах.
- Авилгад автах явдлыг багасгахын тулд эдийн засгийн өрсөлдөөнийг бий болгох, пүүс компаниудыг далд эдийн засгаас албан эдийн засаг руу шилжүүлэхийн тулд шинэтгэл хийх шаардлагатай.
- Засгийн газрын зүгээс хууль, журмынхаа тоог өсгөхөөс илүүтэйгээр тэдгээрийг хамгийн доод түвшинд ч гэсэн хатуу чанд дагаж мөрдөхийг хуульчлах нь илүү ач холбогдолтой гэж үзэж байна.

### **Ном зүй**

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл
2. МБСГ-ын эдийн засагч Д.Энхзаяа “Сүүдрийн эдийн засаг” 2012
3. Н.Амар “Далд эдийн засгийн хэмжээ, өсөлт, нөлөө” 2002
4. <http://www.iltod.gov.mn/> ОУВС Баррий Рассел “Сүүдрийн эдийн засгийг удирдах” 2010 он.
5. Б.Юмаажав, Т.Мөнх-Оргил, Д.Мөнхбат “Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй зарим асуудал” 2018 он,
6. О.Лхагвацэрэн “Дэлхийн орнуудын далд эдийн засаг” 2008
7. Мандах бүртгэл дээд сургууль Г.Өсөхбаяр “Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээ ба өсөлт” 2015
8. Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо “Далд эдийн засгийг тооцох судалгааны нэгдсэн тайлан-2010”
9. <http://www.test.monicsra.mn/> Фридрих Шнайдер “Сүүдрийн эдийн засаг”

<sup>60</sup> <http://www.iltod.gov.mn/> ОУВС Баррий Рассел “Сүүдрийн эдийн засгийг удирдах” 2010 он.

## ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Э.Оюунтулхүүр

*Шихихутуг хууль зүйн их сургуулийн магистрант*

**Товч агуулга:** Дэлхий нийтээрээ эрх тэгш байдлыг энх тайван, аюулгүй байдлын суурь хэмээн үзэж, жендэрийн тэгш байдал буюу эрэгтэй эмэгтэй хүмүүс нийгэм болон гэр бүлдээ тэгш оролцоотой байж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж, түүнийхээ үр шимээс тэгш хүртэх боломж нөхцөлөөр хангагдахыг тэргүүлэх чиглэл болгосонтой холбогдуулан манай улс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэртэй бус байдлаас үүдэлтэй жендэрт суурилсан хүчирхийлэл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх тухай тулгамдаж буй шинэ төрлийн энэхүү ойлголтын суурь зохицуулалт, бодлого төлөвлөлтийг нарийн судалгаанд суурилсан байдлаар үндэсний хэмжээнд төлөвлөн урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлагатай томоохон асуудлуудын нэг болоод байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал нь дан ганц эмэгтэйчүүдийн асуудал биш бөгөөд тухайн улс орны эдийн засаг нийгмийн амьдралд аль жендер давамгайлж байгаагаас шалтгаалдаг ойлголт юм. Жендэрт суурилсан хүчирхийллийг төгсгөл болгоход цогц бодлого боловсруулж, шинэчлэл явуулах шаардлагатай. Энэхүү өгүүлэлээр жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн шалтгаан нөхцөл, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, жендэрээс үүдэлтэй гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж, хуулийг цаашид боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорив.

**Түлхүүр үг:** Жендер, хүчирхийлэл, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомж

### Удиртгал

Олон улсын аль ч улс оронд жендэрийн тэгш эрхийн асуудал нь соёл уламжлалын тэмцэлтэй тулгаралгүй хэрэгжсэн түүх төдийлэн байхгүй. Тухайлбал, Латин Америкийн эмэгтэйчүүд жендэрт суурилсан хүчирхийллийг нийгэмд ил гарган тавьж, түүнийг шийдвэрлэх хуулийг баталж чадсан байдаг хэдий ч хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарсаар байна. Сүүлийн үед аль ч улс орны хувьд хүний эрх чөлөө тэр дундаа жендэрийн асуудал нь эдийн засаг, нийгэм соёл, улс төрийн амьдралд оролцор оролцоог нэмэгдүүлэх өөрчлөлт гаргахыг нийгэм өөрөө шаардаж байна. Түүнчлэн, Монгол улс нь олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсноор дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага зүй ёсоор бий болж байна.

Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн оролцоо, нийгэмд эзлэх байр суурь нь нийгмийн байгуулал, соёлын нөлөө, хэвшмэл ойлголт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан эмэгтэйчүүд нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж, түүнийхээ үр шимийг тэгш хүртэх боломж хязгаарлагдмал байгаагаас үүдэлтэйгээр аливаа төрлийн хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч болсоор байна. Хохирогчийн төлөв байдлаас үзэхэд эмэгтэйчүүд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх нь давамгайл байдаг байна. Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн төрөл хэлбэр дотроос гэр бүлийн хүчирхийлэл нь хамгийн түгээмэл тохиолддог боловч хамгийн цөөн мэдээлэгддэг гэмт хэрэг юм.<sup>61</sup>

Жендэрийн тэгш байдлын тухай хуульд зааснаар жендэрт суурилсан хүчирхийллийн илрэх хэлбэрийг бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол гэж толорхойлсон байдаг.

Манай улсын түүхэн эх сурвалжаас авч үзвэл жендэр, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй гэж заасан боловч төдийлөн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байдаг.

• 1924 оны Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 11 дүгээрт "...тус улсын харъяат ард түмэн угсаа, шашин, эрэгтэй эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино..."<sup>62</sup>, хэмээн заасан байдаг.

• 1940 оны Үндсэн хуулийн 80 дугаар зүйлд "...БНМАУ-ын дотор эмэгтэйчүүд нь аж ахуй улсын ба соёл боловсрол, улс төр, олон нийтийн бүхий л ажил хэрэгт эрэгтэй хүний нэгэн адил, ажил хөдөлмөрийн бололцоог олгох, ...хөлс хэрэглэлийг бүрэн дүүрэн олгох явдлаар хангагдана. Эмэгтэйчүүдийг богтлон өгөх, насанд хүрээгүй эмэгтэйчүүдийг эхнэр болгон өгөх

<sup>61</sup> "Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь" онол, практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2018

<sup>62</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1924

буюу авах, олон эхнэртэй байх явдал, ... ахуй улсын ба соёл боловсрол улс төр олон нийтийн ажил дор оролцож явдал, саадыг учруулах зэргээр ямар нэгэн байдлаар эмэгтэйчүүдийг боолчлолын байдлаас ангижруулан гаргах ба тэгш эрхтэй болгох явдалд саадыг учруулвал хуулиар цээрлүүлэн шийтгэнэ<sup>63</sup>” гэж анх удаа эмэгтэйчүүдийн эрхийн асуудлын хамгаалалтын системийг Үндсэн хууль буюу суурь хуулиар зохицуулж байсан байна.

- 1960 оны Үндсэн хуульд “...БНМАУ-ын эмэгтэйчүүд нь төр аж ахуй, нийгэм, улс төр, соёлын бүх салбарт эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх эдэлнэ... эмэгтэйчүүд эрхээ эдлэхэд нь ямар нэгэн саад тотгор учруулахыг хуулиар хориглоно”<sup>64</sup> гэж заасан байна.

- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна”<sup>65</sup>

- Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Эрэгтэй эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг жендэрийн эрх тэгш байдал<sup>66</sup> хэмээн суурь зохицуулалтыг бий болгосон. Гэвч хуулийн хэрэгжилт дутуу дулимаг байгаатай холбогдон жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл байсаар байгаа учраас тус гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, эрх зүйн зохицуулалтын эргэлзээтэй асуудлыг тусгайлан авч үзэв.

Энэхүү сэдвийг судлахдаа шинжлэх ухааны танин мэдэхүйн ерөнхий ба тусгай аргуудыг бүрэн хэрэглэхийг эрмэлзсэн болно. Анализ болон синтез, тоон болон чанарын судалгааны аргуудыг хууль тогтоомж болон үндэсний хэмжээний судалгааны тайлан, олон улсын жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сайн туршлагад харьцуулалт хийхдээ ашигласан болно.

#### **I. Жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн ойлголт, шалтгаан, нөхцөл**

Жендэр хэмээх ойлголт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ.<sup>67</sup> Жендэр хэмээх ойлголтыг судлахын тулд жендэр ба хүйс гэсэн ойлголтуудын шинж чанар, ялгааг танин мэдэх шаардлагатай болдог.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс биологийн талаасаа харилцан адилгүй байдаг. Ялгаатай шинж тэмдгүүд нь төрөлхийн байх бөгөөд энэ нь бүх хүн төрөлхтөнд хамааралтай. Хүйс нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондох биологийн ялгааг тодруулдаг бол Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн зан төлөвийг тодорхойлдог соёлын онцлог шинж чанаруудын нэгдэл бөгөөд тэдгээрийн хоорондох харилцаа юм. Тиймээс жендэр нь эрэгтэй эсхүл эмэгтэй хүмүүст ганцхан хамааралтай биш, харин тэдний хоорондох харилцаа болон аль аль хүйсэд холбоотой. Анги давхарга, арьсны өнгө, угсаа гарал зэрэг ойлголтуудтай адил жендэр нь нийгмийн үйл явцыг ойлгох шинжилгээ судалгааны нэг арга хэрэгсэл юм. Жендэр нь цаг хугацаа, орон зайг даган өөрчлөгдөж байдаг.<sup>68</sup> Эрэгтэй эмэгтэй хүмүүс нийгэмд болон хувийн амьдарлынхаа хүрээнд эн тэнцүү үнэлэгдэж, эрх мэдэл оролцооныхоо хувьд ижил түвшинд байхыг жендэрийн тэгш байдал гэж ойлгож болох боловч орчин үед олон улсын чиг хандлага тэгш байдлыг аюулгүй байдлын суурь хэмээн үзэж, жендэрийн тэгш байдлыг эрэгтэй эмэгтэй хүмүүст ялгаагүй хандах биш харин хүйсийн ялгаатай хэрэгцээнд тохирсон бодлого төлөвлөлт үйл ажиллагаа явуулахыг ойлгож байна. Ингэснээр тэдний эдлэх боломж нь тэгш, нийгэм гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх нөхцөл бололцоог бүрдүүлэх юм. Манай улсын хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг Засгийн газраас онцгой анхааран Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг санаачлан, УИХ-аас тус хуулийг 2011 онд баталснаар Монгол улс энэ төрлийн харилцааг зохицуулсан тусгайлсан хуультай азийн цөөхөн орны нэг болсон байна. Тус хуульд

<sup>63</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1940

<sup>64</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1960

<sup>65</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

<sup>66</sup> Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2

<sup>67</sup> Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1

<sup>68</sup> Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь. Сургагч багш нарт зориулсан гарын авлага. 2014 он

жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим болон механизмийг нарийн тодорхой заасан. Эрэгтэй эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах дараах төрлийн тусгай арга хэмжээ авахаар тогтоосон байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь үнэн хэрэгтээ зорилго биш хүний хөгжил, нийгмийн хөгжлийг хангах, шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтыг арилгах үндсэн арга зам гэдгийг ойлгох шаардлагатай байна.

Жендэрийн хэвшмэл үзэл гэдэг нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэйхүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт хандлага юм. Түүнчлэн жендэр нь эрэгтэй эмэгтэй хүний үүрэг, хариуцлагыг мөн тэдний хувьд зөв зүйтэй хэмээн тооцогдох зан үйл, юу хийж болох, юу хийж болохгүйг тодорхойлсон ойлголт юм. Жендэрийн хэвшмэл байдал нь голдуу эрэгтэйчүүдийн эрх мэдлийг дэвэргэн эмэгтэйчүүдийг сул дорой дорд гэж үзэх үзлийг нэмэгдүүлж, улмаар эмэгтэй буюу хүйсийн байдлаасаа болж жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх асуудал улам бүр нэмэгдсээр байна. Тухайлбал Монгол улсын хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол шийдвэр гаргах түвшинд ажиллахгүй байгаа бөгөөд гүйцэтгэх түвшинд ажиллахгүй байгаа бөгөөд гүйцэтгэх түвшинд эмэгтэй албан хаагчдын тоо өндөр үзүүлэлттэй байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт нь Монгол улсын нийгэмд бүрэн тогтоогүй, эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондын хүйсийн ялгаатай болон эрх тэгш бус байдлаас шалтгаалсан хүчирхийллийг зөвхөн эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл гэсэн утгаар ойлгох нь нийтлэг байна. Гэтэл түүнд эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна эрэгтэйчүүд өртдөг бөгөөд энэ талын хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнээс гадна ажлын байр, сургууль, гудамж талбай, олон нийтийн газар болон орон нутаг төрийн бодлого үйл ажиллагааны үр дагаврын улмаас гарч байна. Жендэрт суурилсан хүчирхийллийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэмээн явцуу ойлгогдоос эмэгтэйчүүд хохирогч эрэгтэйчүүд хүчирхийлэгч хэмээн ерөхийлөх хандлага түгээмэл байдаг. Тийм учраас хууль сахиулах болон гүйцэтгэх чиг үүргийн институтын бодлого тодорхойлогч бодлогын түвшинд ажиллаж буй албан хаагчдын дунд байгаа нь энэ асуудлыг судлагдахуун болгон судлах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг зүй ёсоор харуулж байна. Мөн “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” /ЭЯГБХУТК/ конвенцийн 1-р зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг гэр бүлийн болон нийгмийн хүрээнд гарснаас үл хамааран эмэгтэйчүүдэд бэлгийн, эсвэл сэтгэл санааны болон аливаа дарамт учруулсан, эсвэл учруулж болзошгүй, айлган сүрдүүлэх, албадлага хэрэглэх, эсвэл дур зогоороо эрх чөлөөг нь боогдуулах зэрэг жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн аливаа үйлдэл<sup>69</sup> хэмээн тодорхойлжээ. “Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцийн 2 дугаар зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн, бие мах бодийн, сэтгэл санааны хүчирхийлэлд:

- Гэр бүлийн хүрээнд – Зодох, бэлгийн замаар хүүхдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтэнийг зэрэмдэглэх, бэлгийн хүчирхийлэл;
- Нийгмийн хүрээнд – Бэлгийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт, доромжлол, хил дамнуулан худалдаалах, хүчээр биеийг нь үнэлүүлэх;
- Төрийн хүрээнд – Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль нь чанаргүй боловсруулагдсан, эсвэл хэрэгждэггүй, хууль сахиулах байгууллага нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэрэглэдэг, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хамгаалах, анагаах байр байхгүй урьдчилан сэргийлэх ба шийтгэх арга хэмжээ авдаггүй, жендэрийн тэгш бус харилцааг гүнзгийрүүлсэн үйлдлүүд<sup>70</sup> хэмээн тодорхойлсон байна. Түүнчлэн төрөөс эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэх, боловсрох бололцоо, оролцоогоор хангах, нийгмийн үйлчилгээнд хамруулах талаар хийж буй эс үйлдэл нь жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн хэлбэр мөн.

“Хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх ялгаатай байдлаас үүдсэн, тухайн хүний хүслийн эсрэг хийж буй аливаа гэмт үйлдэл хэмээн тодорхойлоод “Жендэрт суурилсан хүчирхийлэл нь ийнхүү нийгмээс тогтоосон ялгаатай байдлаас үүдэлтэй тул ийм хүчирхийлэлд бэлгийн хүчирхийлэл хамаарах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлахгүй. Хохирогчийн ихэнх нь бүх насны эмэгтэйчүүд, охид байдаг боловч эрэгтэйчүүд, хөвгүүд мөн адил шууд болон шууд бус хохирогч байж болно. Энэхүү хүчирхийллийн улмаас бие махбодийн болон сэтгэл санааны хохирол аль алийг нь амсах бөгөөд хохирогчид, тэдгээрийн хүрээлэн байгаа орчныхонд удаан хугацааны сөрөг үр дагавартай” гэж тодорхойлсон байдаг.

<sup>69</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол. 1993 он

<sup>70</sup> 1979 оны Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

## II. Жөндэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт

Монгол улс олон улсын хүний эрхийн суурь зарчим, стандартуудыг хангахыг бүрэн дэмждэг бөгөөд эмэгтэйчүүдийн эрх, жөндөрийн тэгш эрх байдлыг хангах зорилт бүхий дараах олон улсын гэрээ, хэлцлүүдэд гарын үсэг зурж, нэгдэн орсон байдаг.

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай олон улсын конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн орчин нөхцөлийг дээшлүүлэх тухай конвенц
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенц
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэ, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
- Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай ОУХБ-ын конвенц
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
- Боловсролын салбар дахь алагчлах үзлийн эсрэн конвенц
- Амаржсан эхийн эрхийг хамгаалах ОУХБ-ын 103 дугаар конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, 190 дүгээр зөвлөмж
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн конвенцид оруулах нэмэх протокол

Монгол улсын жөндөрийн эрх тэгш байдлын үнэлгээнд Швейцарийн хөгжлийн агентлаг, IRIM судалгааны хүрээлэн 1990-ээд оноос Монгол улс, эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын олон чухал гэрээ, хэлцэлд гарын үсэг зурж, нэгдэн орсон боловч “Үндэсний хууль эрх зүйн орчин нь хүний эрхийг хамгаалах олон улсын гэрээ хэлцлийн агуулгатай нийцэж буй эсэх Экспертийн үнэлгээ” авч эдгээр олон улсын гэрээ хэлцлийг улам чанартай мөрдөх шаардлагатай гэсэн зөвлөмжийг өгсөн байна. Мөн энэхүү зөвлөмжөөр “Монгол улс нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр олон улсын гэрээнд нэгдэн орсон нь чухал алхам боловч одоо мөрдөгдөж байгаа дотоодын хууль тогтоомж нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрх, нэр хүндийг хамгаалах талаар дутагдалтай байгаа нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учруулж, зөрчилтэй байдлыг үүсгэж байна”<sup>71</sup> хэмээн дүгнэсэн байдаг.

Монгол Улс дараах хуулиудад жөндөрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Иргэний хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- УИХ-ын сонгуулийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Улс төрийн намуудын тухай хууль. Түүнчлэн, жөндөрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон бодлогын баримт бичгүүд цөөнгүй байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгээс 1979 онд эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг баталсан. 1989 онд эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг арилгах хорооноос эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх 12 дугаар зөвлөмжийг гаргасан. Тус зөвлөмжид оролцогч улсуудыг гэр бүлийн хүрээнд, ажлын байран дээр эсвэл нийгмийн аль нэг хэсэгт болж буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлээс

<sup>71</sup> НҮБХХ, Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2011 он.

хамгаалахыг конвенцийн 2,5,11,12 болон 16 дугаар зүйлээр зохицуулан тайлбарласан байна. Олон улсын хэмжээнд нийцүүлэн жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэж буй арга туршлагаас дурьдвал:

Польш – Мэргэжилтнүүдэд зориулсан тусгай сургалт, мониторингийн тогтолцоог бүрдүүлсэн байна. Тусгай сургалт нь салбар хоорондын багуудын хамтын ажиллагаан дээр түшиглэж орон нутагт гэр бүлийн хүчирхийллээс нь урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж тэднийг сургаж дадлагажуулах болон хүчирхийлэл үйлдэгч нарт зориулсан сургалтын хөтөлбөр, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээ болон асуудалтай гэр бүлтэй ажиллах чиглэлээр зохион байгуулдаг байна.

Словень – Хүчирхийлэлд өртсөн хувь хүмүүст дэмжлэг үзүүлдэг бөгөөд хүчирхийлэлгүй харилцаа нийгэмлэг эсвэл сайн дурын ажилтнууд хүчирхийлэлд өртсөн хүмүүстэй зөвлөх байдлаар ажилладаг байна. Тус зөвлөх нь хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчид өдөрт 1 цагаас 1 цаг 30 минут дэмжлэг үзүүлэх уулзалтыг тогтмол зохион байгуулдаг байна.<sup>72</sup> Ихэнх улс орнуудад эмэгтэйчүүд төрийн үйл ажиллагаанд оролцох эрхгүй байдаг бөгөөд, квотын хязгаарлалтын систем нь ардчиллын сонголттой улс оронд хамгийн үр дүнтэй гэдэг нь зарим улс орнуудын туршлагаас харагдаж байна. Энэхүү жендэрийн квотын систем нь тухайн улс орны парламентын суудлын 30-40%-ийг эмэгтэйчүүд эзэлсэн байхыг зорилгоо болгодог. Хязгаарлалтын бодлого, систем нь улс төрч эмэгтэйчүүдийг тухайн улс орны улс төрийн процесс болон улс төрийн соёлд чухал нөлөө үзүүлдэг байна.<sup>73</sup> Жендэрийн тэгш эрхийг бодитойгоор хэрэгжүүлж буй улс орнуудын парламентын доод танхимд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр түвшинд байна.

### **III. Жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлон тогтоосон ерөний хэм хэмжээ бүхий хууль бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль байдаг. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд төрөөс явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийг татан оролцуулах, улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулахаар хуульчилсан. Манай улсын хувьд гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд үзүүлэх цогц үйлчилгээ дэмжлэг дутмаг бөгөөд энэ нь эргээд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл болж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд зааснаас гадна бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа дээрх олон чиг хандлагатай уялдуулан зохион байгуулах шаардлагатай байна. Мөн түүнчлэн гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах ажлыг тодорхой бодитой хийх хэрэгцээ шаардлага байсаар байна. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт бууран хандлагатай байгаа хэдий ч шинж чанарын хувьд улам бүр харгис, хэрцгий шинжтэй болж онц хүнд гэмт хэргийн тоо нэмэгдэж байна. Иймд тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгааныг бодитой тогтоосноор түүний мөн чанарыг нь илрүүлэх, арилгах арга замыг тодорхойлоход илүү ач холбогдолтой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухайн гэмт явдлын шалтгаан, гэмт хэрэг үйлдэгчийн хувийн шинж байдал, хохирогч, гадаадын бусад орнуудын туршлага гэх мэт зүйлүүдийг анхааран авч үзэх нь чухал ач холбогдолтой бөгөөд аливаа гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн шилдэг арга нь тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм. Мөн түүнчлэн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, төвшин, түүний хэрэгжилтийг хангах нийгэм эдийн засаг, эрх зүйн орчин, урьдчилан сэргийлэх субъектуудын тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагааны маеханизм, урьдчилан сэргийлэх хэлбэр, арга зүйг зөв оновчтой сонгох шаардлагатай байна.

Манай улсад 2016-2018 оны байдлаар эмэгтэйчүүд хохирогч болдог төрлийн гэмт хэрэг нь өмнөх онуудаас өссөн байгааг үндэсний статистикийн газраас мэдээллэсэн. Ерөнхий боловсролын дунд сургуулийн 7 дугаар ангиас эхлэн эмэгтэйчүүд жендэрт суурилсан хүчирхийлэл, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж эхэлдэг төдийгүй хамгийн идэвхитэй үе нь их дээд сургуулийн оюутан байх үе, түүний дараа ажил хөдөлмөр эрхлэх, гэр бүл болсны дараах үеүд байдаг байна. Монгол улсын хэмжээнд сүүлийн 10 жилд гэмт хэрэг үйлдсэн нийт хүний 42 хувь нь 18-35 насны залуучууд байсан бол гэмт хэрэгт хохирсон иргэдийн 48 хувь нь

<sup>72</sup> С.Цэрэндорж. Жендэр ба хүний эрх. УБ., 2018. 30 дахь тал

<sup>73</sup> Улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийн оролцоо. УБ., 2004. 21 дэх тал

тухайн насны хүмүүс байна.<sup>74</sup> Үүнээс үзэхэд, жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн насны субъектүүдэд чиглэсэн байдлаар зохион байгуулах нь үр дүнтэй гэж бөгөөд Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж иргэдэд ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг байх нь зүйтэй гэж үзэж байна.

### Дүгнэлт

Дэлхий нийтээрээ тэгш байдлыг энх тайван, аюулгүй байдлын суурь хэмээн үзэж байгаа өнөөгийн нийгэмд жендэрт суурилсан хүчирхийлэл, гэмт хэрэг түүнээс уртдчилан сэргийлэх асуудал нь өнөөгийн нийгмийн тулгамдаж буй томоохон асуудлын нэг юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэртэй бус байдлаас үүдэлтэйгээр нас, хүйс, хүч чадлаа ашиглан үйлддэг хүчирхийлэл буюу гэмт хэрэг юм. Энэ төрлийн гэмт хэрэг, хүчирхийллийг таслан зогсоох шийдлийг олохтой холбогдуулан дүгнэвэл:

- Жендэрийн тухай ойлголтыг ерөнхийд нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний байгаа орчиндоо эзлэх байр суурь гэж ойлгоно. Харин жендэрт суурилсан хүчирхийлэл гэдгийг эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэртэй бус байдлаас үүдэлтэйгээр нас, хүйс, хүч чадлаа ашиглан үйлддэг хүчирхийлэл хэмээн тодорхойлж байна. Дээрх төрлийн хүчирхийлэл нь улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа 32 сая гаруй гэмт хэргийн 3/1 хувийг эзэлж байна. Энэхүү өгүүлэлээр жендэрийн хязгаарлалт болон жендэр хэмээх ойлголт хандлага, жендэрт суурилсан хүчирхийлэл болон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа олон улсын туршлагауудыг харьцуулан судлахад европын болон төв азийн бусад орнууд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд сургуулийн өмнөх боловсролоос эхлэн хүний эрх, хүний эрхэм чанар болон жендэрийн ойлголт, мэдрэмжийг ойлгох асуудлыг боловсролын тогтолцоогоор дамжуулан хийж хэрэгжүүлж байна.
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар жендэрт суурилсан хүчирхийллийн илрэх хэлбэрийг бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол гэж тодорхойлсонтой холбогдуулан үндэсний хэмжээний судалгааг Үндэсний статистикийн газраас олон улсын аргачлалын дагуу хийсэн байна.<sup>75</sup> Тус судалгаагаар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь хүчирхийллийн хэлбэрийг гарган ирсэн байх бөгөөд тус судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 57.9% нь хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн талаарх дүгнэлтийг гаргасан байна. Тодорхой төрлийн гэмт хэрэгт хохирсон хүмүүсээс дөнгөж 31.3% нь цагдаад, хуулийн байгууллагад мэдэгдэж байгаа нь нэг талаас нийт гэмт хэргийн 68.7% нь нуугдмал байгааг илэрхийлж байгаа бол нуугдмал байх хамгийн өндөр магадлалтай гэмт хэргүүд нь бэлгийн мөлжлөг, хүчиндэх гэмт хэрэг ордог.<sup>76</sup> Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүдийн 36% нь найз нөхөд, 8.3% нь цагдаад мэдэгдсэн байна. Энэ төрлийн хүчирхийлэл гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг тул хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд эрх бүхий байгууллагад ханддаг, хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалж чаддаг, хүчирхийллийг үл тэвчдэг болгохын тулд иргэдэд энэ төрлийн боловсролыг олгох нэн шаардлагатай.
- Манай улсын хувьд жендэрт суурилсан хүчирхийлэл болон тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ерөнхий болон тусгай, нэг бүрчилсэн гэсэн уламжлалт аргаас илүүтэйгээр олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн загвар болох нийгмийн хөгжилд суурилсан болон олон нийтийн оролцоонд тулгуурласан хэлбэрээр зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэж байна. Энэхүү аргуудад тулгуурлан боловсролын тогтолцоонд өөрчлөлт хийх замаар гэр бүл, бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулж урт хугацааны болон богино хугацааны сургалтыг ерөнхий боловсролын сургуулиас эхлэн их дээд сургууль, төрийн албан хаагчид болон мэргэжлийн чиг үүргийн байгууллагын албан хаагчид, иргэдэд тохирсон байдлаар сургалтын хөтөлбөр бий болгон системтэйгээр зохион байгуулах шаардлагатай.

<sup>74</sup> Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном. 2017 он. УБ хот.

<sup>75</sup> Үндэсний статистикийн газар. Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан. 2017 он. УБ

<sup>76</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. УБ., 2017. 22 дахь тал

## Ном зүй

Нэг.Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1924
- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1940
- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1960
- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2011. №8

Хоёр.Олон улсын гэрээ, конвенц

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

Гурав.Ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл

- С.Цэрэндорж. С. Жендэр ба хүний эрх. УБ., 2018
- Монголын криминологичдын холбоо. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. УБ., 2017
- “Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь” /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/. УБ., 2014
- Үндэсний статистикийн газар. “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан”. УБ., 2017
- “Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь” онол, практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2018
- “Улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийн оролцоо”. УБ., 2004



# ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗҮЙЛ ХУДАЛДАХ ҮЙЛДЭЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Г.Гантөмөр  
ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,  
хууль зүйн доктор (Ph.D), профессор

### Оршил

Дэлхий нийтийн болон үндэсний хэмжээнд хүүхэд хамгаалалын асуудал чухлаар тавигдаж байгаа өнөө үед Монгол Улсад хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг хянан шийдвэрлэх тусгай тогтолцоо буюу “*jibevenall justice*”-г шинээр бий болгох, тэдний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн төрөл, хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангид насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээнүүдийг нэгтгэн тусгайлан бүлэг болгосон, тусгай ангид Хүүхдийн эсрэг гэмт хэргийг 2002 оны Эрүүгийн хуульд байсан “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”-ийн бүлгээс авч бие даасан бүлэгт хуульчилсан зэрэг шинэлэг өөрчлөлт орсон нь энэ чиглэлээр хийсэн чухам алхам болсон.

Хүүхдийн эсрэг хууль бус үйлдлийн нэг нь насанд хүрээгүй хүмүүсийг ууж согтуурахад татан оролцуулах, согтууруулах ундааны зүйл өгөх, тэдний дэргэд архидан согтуурах, согтууруулах ундааны зүйл худалдан борлуулах явдал бөгөөд эдгээр хууль бус үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид хуульчилсан байдаг. Тухайлбал, насанд хүрээгүй хүнийг байнга ууж согтуурахад татан оролцуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцон, Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйлд, насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах, түүгээр үйлчилсэн бол зөрчилд хамааруулан Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 6.5.11.5-д, хүүхдийн дэргэд ууж согтуурсан бол мөн хуулийн 6.20 дугаар зүйлийн 6.20.9-д тус тус заасан байдаг.

Архидан согтуурахын эсрэг чиглэсэн үйл ажиллагаа нь архины хэрэглээг зохистой хэмжээнд байлгах, архигүй орчинг бий болгох, согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, архидан согтуурах болон түүнд үндэслэн гардаг хууль бус үйлдлүүдээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, эрх зүйн болон соён гэгээрүүлэх зэрэг олон талт арга хэмжээнүүдээс тогтоно.

Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хамгийн оновчтой, үр дүнтэй эрх зүйн арга хэмжээ нь согтууруулах ундааг үйлдвэрлэх, борлуулах, худалдах, түүгээр үйлчлэхэд газар орон, цаг, хүйс, насны хязгаарыг тогтоох явдал юм. Тухайлбал, согтууруулах ундааг хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэх насны доод хязгаарыг тогтоон, түүнийг зөрчвөл зохих хууль зүйн хариуцлага хүлээлгэх жишиг дэлхий нийтийн хэмжээнд нэгэнт тогтож, тэр нь ч үр дүнгээ өгч байна.

Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдахтай тэмцэх нь хүүхдийг архи хэмээгч хорт ундаанаас хол байлгах, архийг үл тэвчих хүмүүжил олгох, хүүхэд байгаа орчинг архигүй орчин болгох, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, бие махбодь, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад чухал нөлөөтэй, үр дүнтэй арга юм.

### Үндсэн хэсэг

Бид энэ өгүүлэлдээ насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг гадаад орнуудын хууль тогтоомжид хэрхэн хуульчилсныг харьцуулсан эрх зүйн хүрээнд авч үзэх болно.

Гадаад орнуудад насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байдлыг харьцуулан судлах нь зөвхөн танин мэдэхүйн төдий бус, энэ төрлийн хууль бус үйлдэлтэй тэмцэж буй гадаад орнуудын төрийн эрүүгийн бодлого, чиг хандлага, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо, тэдгээрийн онцлог, үр дүнг тодорхойлж, сайн туршлагыг судлах, суралцах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

Гадаадын орнуудын холбогдох хууль тогтоомж, тэдгээрт согтууруулах ундааны зүйл худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон насыг хэрхэн тогтоосон, уг хоригийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хэрхэн хуульчилсан байдлыг харьцуулан судлахад улс орнуудыг дараахь 2 төрөлд ангилж болохоор байна.

Энэ нь:

1-рт: Уг үйлдлийг зөрчилд тооцон захиргааны хариуцлага хүлээлгэдэг орнууд,

2-рт: Уг үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг орнууд юм.

### **1.Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг зөрчилд тооцож захиргааны хариуцлага хүлээлгэдэг улсууд:<sup>77</sup>**

**БНХАУ:** Манай урд хөрш БНХАУ-д насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг зөрчилд тооцож, 2012 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай хууль”-иар хариуцлага хүлээлгэдэг. Тус хуулийн 37 дугаар зүйлд “...Насанд хүрээгүй хүмүүст тамхи, согтууруулах ундаа зарахыг хориглоно. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, ажилтан нь насанд хүрээгүй хүмүүст тамхи, согтууруулах ундаа зарахгүй байх тэмдэгийг тогтоосон газарт байрлуулна. Хэрэв насанд хүрсэн хүн мөн эсэхийг тодорхойлоход хэцүү бол тэднээс иргэний үнэмлэхээ гаргаж өгөхийг шаардах хэрэгтэй. Бага, дунд сургууль, цэцэрлэг зэрэг хүүхдийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг анги, дотуур байр, өрөө тасалгаа, бусад газарт хэн ч тамхи татаж, архи ууж болохгүй...”, 67 дугаар зүйлд “...Хэрэв насанд хүрээгүй хүмүүст тамхи, согтууруулах ундаа зарах, эсвэл насанд хүрээгүй хүмүүст тамхи, согтууруулах ундаа зарахгүй гэсэн тэмдэг тавиагүй бол эрх бүхий байгууллага хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулна...” гэж заасан байна.<sup>78</sup>

**БНСУ:** Тус улсад бидний судалж буй үйлдлийг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр батлагдан, 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр шинэчилэн найруулсан “Хүүхэд хамгааллын тухай” хуулиар зорицуулдаг. Уг хуулийн зорилго нь хүүхдийн бие бялдар, сэтгэхүйн байдалд хохирол учруулж болохуйц үйлдвэрлэл, үйлчилгээ, мэдээ, мэдээлэл, хөдөлмөр эхлэлт болон аюултай орчин, нөхцөлөөс тэднийг хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааны чиглэл, эрх зүйн орчинг тодорхойлоход оршино.

Тус хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Хүүхэд” гэдэгт 19 насанд хүрээгүй хүнийг ойлгодог. Мөн уг хуулийн 2 дугаар бүлгийн 4 дэх хэсэгт хүүхдэд хэрэглүүлэх болон үйлчлэхийг хориглосон бодисуудыг дараахь 2 төрөлд ангилна. Энэ нь: 1)Сэтгэцэд нөлөөлөх бодис, 2)Эрүүл мэндэд нөлөөлөх бодис болно.

“Эрүүл мэндэд нөлөөлөх бодис” гэдэгт Солонгос Улсын Татварын тухай хуульд заасан согтууруулах ундааны бүх зүйлийг /архи, пиво, ликор түүнтэй адилтгах зүйл / хамаарна.

“Хүүхэд хамгааллын тухай” хуулийн 4 дүгээр бүлэгт хүүхдийн сэтгэц болон биеийн эрүүл мэндэд хортой бодисыг эмнлэгийн болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хяналтан доор худалдаалах, үйлчлэхээс бусад тохиолдолд худалдахыг хориглосон байдаг ба 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...энэ хуулиар тодорхойлсон согтууруулах ундааны зүйлийг 19 насанд хүрээгүй хүнд худалдаалахыг хориглоно...”, Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “...насанд хүрээгүй хүн гэсэн сэжиг төрсөн тохиолдолд худалдаа, үйлчилгээний байгууллага, ажилтан бичиг баримтыг нь шалгасны үндсэн дээр худалдаалах эсхүл үйлчилж болно...”, 7.1 дэх хэсэгт “...Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг байгуулагад 19 насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглоно...” гэж хуульчилсаны зэрэгцээ зөрчсөн тохиолдолд тус хуулийн 59 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар “...28 дугаар зүйлд заасан журмыг зөрчиж үйлчилсэн, худалдсан, хөдөлмөр эрхлүүлсэн бол баривчлах эсхүл 20 сая хүртэлх воноор торгоно...”<sup>79</sup>

**Япон:** Тайшогийн 11 дүгээр оны хууль №20 буюу 1922 оны “Насанд хүрээгүй хүүхдийн согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох тухай” хуулиар насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...20 ба түүнээс доош насны этгээд нь архи, бусад согтууруулах ундаа уухыг хориглоно...”, 2 дахь хэсэгт “...Насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх эсвэл түүний асран хамгаалагч нь насанд хүрээгүй хүүхдийг согтууруулах ундаа хэрэглэснийг мэдсэн бол түүнийг хянах үүрэгтэй...”, 3 дахь хэсэгт “...Архи, согтууруулах ундаа зарж борлуулдаг буюу нийлүүлдэг бизнес эрхлэгч нь 20 ба түүнээс доош насны хүүхдэд архи, бусад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно...”, 4 дэх хэсэгт “...Архи, бусад согтууруулах

<sup>77</sup> Нэгдэх ангилалын оронд Монгол улс хамаардаг. Г.Г

<sup>78</sup> 中华人民共和国未成年人保护法(2012修正)

<sup>79</sup> htr //www.law.go.kr // Бүгд Найрамдах Солонгос улсын хууль тогтоомж мэдээллийн нэгдсэн төв.

ундаа зарж борлуулдаг буюу нийлүүлдэг бизнес эрхлэгч нь 20 ба түүнээс доош насны хүүхдийг согтууруулах ундаа уухаас сэргийлж насыг лавлах болон бусад холбогдох арга хэмжээ авах үүрэгтэй...”, мөн хуулийн 2 дугаар зүйлд “...20 ба түүнээс доош насны хүн нь архи, бусад согтууруулах жндааг уух зорилгоор хадгалсан, авч яваа бол архи согтууруулах ундаа, түүний багаж хэрэгслийг захиргааны арга хэмжээ авч хураан авах эсвэл устгах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч болно...” гэжээ.

Судалж буй үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг 3 дугаар зүйлд “... 1.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн хүн 500.000 хүртэл иенийн торгууль ногдуулна...”, “... 2. 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн этгээдэд 10.000 хүртэл иенийн торгууль ногдуулна...”, 4 дүгээр зүйлд “...Хуулийн этгээдийн төлөөлөгч эсвэл хуулийн этгээд нь өмнөх зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн тохиолдолд тухайн төлөөлөгч, ажилтан, бусад ажилтанд ижил хариуцлага ногдуулна...”<sup>80</sup> гэж заасан байна.

**Узбекистан:** 2011 оны 10 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “*Согтууруулах ундаа болон тамхины хэрэглээг хязгаарлах тухай*” хуулиар /№ ЗРУ – 302/ согтууруулах ундааны зүйл, тамхийг хэрэглэх, үйлдвэрлэх борлуулах, худалдах, үйлчлэх, хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ба тус хуулийн 13 дугаар зүйлд зааснаар 20 нас хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл болон тамхийг худалдахыг хориглох ба зөрчсөн тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэж торгох эсхүл баривчлах шийтгэл ногдуулна<sup>81</sup>.

**2.Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг орнууд:**

**а. Ром-Германы эрх зүйн бүлийн орнууд:**

**ОХУ:** Манай хойд хөршид 1990 оноос хойш насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдаалах үйлдлийг зөрчилд тооцож, Захиргааны хариуцлагын хуулиар шийтгэдэг байв. Харин 2011 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн Холбооны хуулиар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ үйлдлийг удаа дараа үйлдсэн бол гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуулийн 151.1 дүгээр зүйлд хуульчилжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 151.1 дүгээр зүйлд “...Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйлийг нийтийн худалдаагаар удаа дараа худалдсан бол 80.000 рублиэр, эсхүл шүүгдэгчийн 6 сар хүртэлх цалин, эсхүл мөн хугацааны орлогоор торгох, эсхүл 1 жилээс 3 жил хүртэл хугацаагаар тодорхой үйл ажиллагаа явуулах, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасч засан хүмүүжүүлэх ял оногдуулна...”<sup>82</sup> гэж заасан байна.

ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 14.16 дугаар зүйлийн 2.1-д “...Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйлийг нийтийн худалдаагаар худалдсан нь гэмт хэргийн шинжгүй бол /анх удаа үйлдсэн бол Г.Г/ иргэнийг 30000-50000 рублиэр торгох, албан тушаалтныг 100.000-200.000 рублиэр, хуулийн этгээдийг 300.000-500.000 рублиэр торгоно.”<sup>83</sup>

Үүнтэй ижил зохицуулалт **Беларусь, Казакстан** Улсын Эрүүгийн хуульд бий.

**Турк:** Бүгд Найрамдах Турк Улс 2013 он хүртэл насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах үйлдлийг “*Согтууруулах ундаа, түүнийг хэрэглэх тухай*” хуулиар зохицуулж байсан, 2013 оноос гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон. Тус улсын Эрүүгийн хуульд тухайн хэргийг “*Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг*”-ийн төрөлд хамааруулдаг ба “*Хүний эрүүл мэндэд аюултай бодис нийлүүлэх*” гэсэн 194 дүгээр зүйлд “...*Хүүхэд, сэтгэцийн өвчтэй хүн, дэгдэмхий бодис хэрэглэдэг хүмүүст тэдгээрийн эрүүл мэндэд хортой бодис зарсан буюу бэлэглэсэн хүнийг зургаан сараас нэг жил хүртэл хорих ял шийтгэнэ...*”<sup>84</sup> гэж заажээ. “Хүүхэд” гэдэгт 18 нас хүртэлх насны хүнийг, “Хүний эрүүл мэндэд аюултай бодис” гэдэгт архи, тамхи, хүүхдийн болон уг зүйлийн диспозицид заасан хүмүүсийн эрүүл мэндэд аюултай химийн хорт бодис, дэгдэмхий бодис /балин, хөргөлтийн шингэн, ахуйн хэрэглээний газ, цавуу, ацетон гэх мэт/ тус тус ойлгодог.

**Швейцари:** Тус улсын 1937 оны Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлд -...16 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл болон 1951 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн

<sup>80</sup> // [https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawid=211AC0000000020](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawid=211AC0000000020)

<sup>81</sup> статья 13 в редакции Закона Республики Узбекистан от 14 ноября 2019 года № ЗРУ-584 —

Национальная база данных законодательства, 15.11.2019 г., № 03/19/584/4025)

<sup>82</sup> Уголовный кодекс РФ. (с изменениями на 18 февраля 2020 года) М. изд. Проспект 2020 год

<sup>83</sup> Закон об административных правонарушениях РФ. М. Изд Зерцало. 2020 год

<sup>84</sup> Уголовный кодекс Турции Пер с турецкого Н.Сафарова и Н.Бабаевой. науч. ред. Н.Сафарова и Х.Аджурь СПб. Изд. Юридический Центр Пресс. 2011 г. стр 141

“Мансууруулах бодисын тухай” холбооны хуульд заасан хүүхдийн эрүүл мэндэд гэм хор учруулж болохуйц эм бэлдмэл, бодисыг өгсөн бол хорих буюу торгох ял оногдуулна...”<sup>85</sup> гэж хуульчилсан нь судалгааны хувьд анхаарал татна. Уг зүйлийн онцлог нь халдлагын зүйлийг зөвхөн согтууруулах ундаа бус хүүхдийн эрүүл мэндэд хор хохирол учруулж болох бусад эм бэлдмэл, бодис байхаар заасан нь Турк улсынхтай ижил, мөн объектив талыг зөвхөн дээрх зүйлүүдийг худалдах бус, насанд хүрээгүй хүнд **өгсөн** үйлдэл байхаар илүү өргөн утгаар хуульчилсан, “өгсөн” гэдэгт борлуулах, худалдах, үйлчлэх, үнэгүй өгөх зэрэг үйлдүүд бүгд багтаж байгаа явдал болно.

**Серби:** Тус улсын Эрүүгийн хуулийн 132 дугаар зүйлд зааснаар насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Уг гэмт хэрэг Эрүүгийн хуулийн “Хүн амын эрүүл мэндийн болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг”-ийн бүлэгт хамаарах ба “...Ресторан, бар болон бусад худалдаа, үйлчилгээний байгууллагад 16 насанд хүрээгүй хүнд архи, бусад хатуулаг өндөртэй согтууруулах ундаа, хатуулаг ихгүй боловч тодорхой хэмжээнд хэмжээнд хэрэглэсэн тохиолдолд согтууралд хүргэх ундааг худалдсан, түүгээр үйлчилсэн бол торгох, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...”<sup>86</sup>.

**Болгар:** Болгар Улсын Эрүүгийн хуулийн “Гэр бүл, хүүхэд залуучуудын эсрэг гэмт хэрэг” гэсэн 4 дүгээр хэсгийн “Хүүхэд залуучуудын эсрэг гэмт хэрэг” гэсэн 2 дугаар бүлгийн 196 дугаар зүйлийн 2 дахь заалтад “...16 насанд хүрээгүй хүнд эсвэл хэрэг хариуцах чадваргүй хүнд өөрт нь хэрэглүүлэхээр согтууруулах ундааны зүйлийг худалдсан бол 1000 хүртэл левээр торгох, эсхүл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ. Хэрэв энэ үйлдлийг удаа дараа үйлдсэн бол 3000 хүртэл левээр торгох, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...”<sup>87</sup> гэж заажээ.

**Польш:** Тус улсын 2007 оны Эрүүгийн хуулийн “Гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг” гэсэн 26 дугаар бүлгийн 208 дугаар зүйлд “... бага насны хүүхдэд согтууруулах ундааны зүйл өгч, эсвэл түүнд согтууруулах ундааны зүйл олж авах, хэрэглэхэд тусалсан, эсхүл согтууруулах ундааны зүйл хэрэглэхэд өдөөн түлхэх замаар согтуурлын байдалд оруулсан бол торгох эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...” гэж энэ хэргийн объектив талыг заасан ба үүнд бага насны хүүхдэд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэл хамаарна. Мөн “бага насны хүүхэд” гэдэгт уг хуулийн 210, 211 дүгээр зүйлд зааснаар 15 хүртэлх насны хүнийг ойлгоно.<sup>88</sup>

**Голланд:** Голланд Улсын Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлгийн 252 дугаар зүйлд бидний судалж буй гэмт хэргийг дараах шинжтэйгээр хуульчилжээ. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “...16 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан, өгч согтуурлын байдалд хүргэсэн бол 9 сар хүртэл хугацаагаар хорих эсхүл 3 дугаар зэргийн торгууль ногдуулна...” хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “... энэ үйлдлийн улмаас насанд хүрээгүй хүний бие махбодид хүнд гэмтэл учирсан бол 6 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл 4 дугаар зэргийн торгууль ногдуулна...”<sup>89</sup>, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “...энэ үйлдлийн улмаас насанд хүрээгүй хүний амь нас хохирсон бол 9 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл 5 дугаар зэргийн торгууль ногдуулна...”<sup>89</sup> гэж заасан байдаг.

Голланд Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 23 дугаар зүйлд торгох ялыг 6 зэрэгтэй байхаар заасан ба 1 дугаар зэргийн торгууль - 500 гульден, 2 дугаар зэргийн торгууль - 5.000 гульден, 3 дугаар зэргийн торгууль - 10.000 гульден, 4 дугаар зэргийн торгууль - 25.000 гульден, 5 дугаар зэргийн торгууль - 100.000 гульден, 6 дугаар зэргийн торгууль - 1 сая гульден байдаг.<sup>90</sup>

**Израиль:** Израиль Улсын Эрүүгийн эрх зүйн тухай хуулийн 193 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэхийг дэмжсэн, өдөөн түлхсэн бол 3 сар хүртэл хугацаагаар хорино...”, 2 дахь хэсэгт “...18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдсан бол 6 сар хүртэл хугацаагаар хорино...”, 3 дахь хэсэгт “...Олон нийтийн газар,

<sup>85</sup> Уголовный кодекс Швейцарии перевод с немецкого А.В.Серебренниковой. М.МГУ. 2001 год. стр 139

<sup>86</sup> Уголовный кодекс Республики Сербия. Пер с англ С.П.Карибова. науч. ред. Ю.А.Кашубы. СПб. Изд. Юридический Центр Пресс. 2009 г стр 138

<sup>87</sup> Уголовный кодекс Болгарии. Перевод с болгарского Д.В.Милушева, науч. ред. А.М.Лукашев и И.И.Айдаров. Спб. Изд. Юридический Центр Пресс. 2001 г стр 139

<sup>88</sup> Уголовный кодекс Польши. Перевод с польского Д.А.Барилловича. науч. ред. А.И.Лукашева. Спб. Изд. Юридический Центр Пресс. 2001 г стр 153-154

<sup>89</sup> Уголовный кодекс Голландии. Перевод с английского И.В.Мироновой, науч. ред. Б.В.Волженкин. Спб. изд. Юридический Центр Пресс. 2001 г. стр 363-364

<sup>90</sup> Уголовный кодекс Голландии. Перевод с английского И.В.Мироновой, науч. ред. Б.В.Волженкин. Спб. изд. Юридический Центр Пресс. 2001 г. стр 139-140

эсхүл насанд хүрээгүй хүний эцэг эх, асран хамгаалагч байхгүйд эсхүл тэдний зөвшөөрөлгүйгээр 18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдан авч өгсөн бол 6 сар хүртэл хугацаагаар хорино..."<sup>91</sup> гэж заажээ.

#### **б. Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнууд:**

Англо-Саксоны эрх зүйн бүлийн ихэнх орнуудад насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог ч эрх зүйн орчин нь өөр өөр байдаг, зарим оронд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэж байхад, зарим улсад эрүүгийн хуулиар бус эрүүгийн эрх зүйн шинжтэй хуульд буюу эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ агуулсан ердийн хуульд хуульчилсан байдаг онцлогтой.

**Англи:** 2003 онд батлагдсан *"Лицензийн тухай"* хуульд судалж буй хэргийг хуульчилсан ба уг хуулийн 146 дугаар зүйлд зааснаар хувь хүн эсвэл хуулийн этгээд /ресторан, бар, клуб, дэлгүүр, бусад худалдаа, үйлчилгээний газар Г.Г/ 18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан бол 5.000 хүртэл фунт стерлингээр торгодог, энэ үйлдлийг 3 сарын дотор хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн бол 10.000 хүртэл фунт стерлингээр торгодог.<sup>92</sup>

**АНУ:** АНУ-ын бүх муж улсуудад 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог. 1984 онд АНУ-ын Конгрессоос *"Согтууруулах ундаа хэрэглэх насыг тогтоох тухай"* хуулийг /National Minimum Drinking Age Act (23 USC § 158) / баталсан бөгөөд бүх муж улсуудыг согтууруулах ундаа хэрэглэх, худалдах насыг 21 насаар тогтоох шаардлага тавьж хэрэв энэ шаардлагыг биелүүлэхгүй бол холбооны засмал зам ашигласны төлбөрийн 10 хувийг муж улсуудад үлдээхийг зогсоохыг мэдэгдсэний дүнд 1986 он гэхэд 50 муж улс холбооны нэг тойрог бүгд 21 насаар тогтоосон юм.<sup>93</sup>

Мичиган муж улсын хууль тогтоомжийн эмхэтгэлийн *"Насанд хүрээгүй хүн"* гэсэн 23 дугаар бүлгийн *"21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдахгүй байх"* гэсэн 5 дугаар бүлгийн 33.5.1-р зүйлд "... 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдахыг хориглоно. 21 насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж эсвэл 21 нас хүрсэн эсэхийг сайн лавлаж тогтоолгүйгээр согтууруулах ундааны зүйл худалдсан бол мисдиминор ангилалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзнэ..."<sup>94</sup> гэж хуульчилжээ.

Флорида муж улсын хуулиар насанд хүрсэн хүн 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах, бэлэглэх, өгөх, эсвэл худалдаа, үйлчилгээний газар тэдэнд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг зөвшөөрөхийг хориглох ба зөрчсөн үйлдлийг хоёрдугаар зэрэглэлийн мисдиминорт тооцож 60 хүртэл хоногоор хорих, эсхүл 500 хүртэл доллароор торгохоор, хэрэв энэ үйлдүүдийг 1 жилийн дотор 2 буюу түүнээс дээш удаа үйлдсэн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл 1000 хүртэл доллароор торгохоор заасан байдаг.<sup>95</sup>

Оклахома муж улсын Үндсэн хуулийн 28 дугаар хэсгийн § 5-д зааснаар 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан, бэлэглэсэн, бусад байдлаар өгсөн бол гэмт хэрэгт тооцон торгох, энэ үйлдлийг дахин үйлдсэн бол согтууруулах ундааны зүйл борлуулах эрхийг /лицензийг/ хураадаг байна.<sup>96</sup>

АНУ-ын насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдахтай холбоотой хууль тогтоомжийн онцлог нь зөвхөн худалдсан төдийгүй худалдан авсан насанд хүрээгүй хүнд хариуцлага хүлээлгэдэг явдал болно. Тухайлбал, Оклахома муж улсын хуулиар согтууруулах ундааны зүйл худалдан авах зорилгоор насанд хүрээгүй хүн согтууруулах ундааны зүйл худалдан авах зорилгоор өөрийн насыг буруу мэдээлсэн, худал хэлсэн, иргэний бичиг

<sup>91</sup> Закон об уголовном праве Израйля. Перевод с иврита М.Дортмана. науч ред. Н.И.Мацнев. Спб. изд. Юридический Центр Пресс. 2005 г. стр 200-201

<sup>92</sup> Е.А.Герасимова. Уголовно-правовое проитводействие розничной продаже несовершеннолетним алкогольной продукции. Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. Саратов. 2015. стр 69

<sup>93</sup> Е.А.Герасимова. Уголовно-правовое проитводействие розничной продаже несовершеннолетним алкогольной продукции. Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. Саратов. 2015. стр 69

<sup>94</sup> Понкин И.В. Зарубежные законы и документы о формировании и защите общественной нравственности и нравственности несовершеннолетних / Приложение к проекту Концепции государственной политики формирования и защиты нравственности детей в Российской Федерации. М., 2008. С. 197.

<sup>95</sup> Е.А.Герасимова. Уголовно-правовое проитводействие розничной продаже несовершеннолетним алкогольной продукции. Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. Саратов. 2015. стр 67

<sup>96</sup> Oklahoma constitution: Article XXVIII: ALCOHOLIC BEVERAGE LAWS AND ENFORCEMENT. [Электронный ресурс]. URL: <http://oklegal.onenet.net/okcon/XXVIII.html>

баримтыг хуурамчаар үйлдсэн, зассан, бусад аргаар хууран мэхэлсэн бол зөрчилд тооцон 30 хоног хүртэл нийгэмд тустай ажил хийлгэх, эсхүл 300 хүртэл доллараар торгох шийтгэл ногдуулдаг.<sup>97</sup>

Нью-Джерси муж улсын хуулиар 21 насанд хүрээгүй хүн согтууруулах ундаа худалдан авсан, биедээ авч явсан, гудамж талбай, олон нийтийн газар, сургууль, эсвэл тээврийн хэрэгсэл дотор хэрэглэсэн бол 500 хүртэл доллароор торгох, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараар хасах шийтгэл ногдуулна.<sup>98</sup>

АНУ-ын зарим муж улсууд судалж буй гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа хуульчилсан нь бий. Тухайлбал, Кентукки муж улсын Эрүүгийн хуулийн “Гэр бүлийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгийн 070 дугаар зүйлд зааснаар зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний байгууллагад насанд хүрээгүй хүн гэдгийг нь мэдсээр байж согтууруулах ундааны зүйл худалдсан, бэлэглэсэн, худалдан авч өгсөн бол насанд хүрээгүй хүнтэй хууль бус хэлцэл хийсэн бол 3 зэргийн мисдиминор үйлдсэн гэм буруутайд тооцож 500-2000 доллараар торгох эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорино<sup>99</sup>. Хэрэв худалдагч, худалдааны байгууллага хохирогчийн дүр төрх, гадаад байдал, үг хэл, бусад байдлыг буруугаар ойлгож андуурсны улмаас, эсвэл насанд хүрээгүй этгээд бичиг баримт хуурамчаар үйлдсэн, өөрчилж зассан, бусад байдлаар хуурч мэхэлсэний улмаас түүнд согтууруулах ундааны зүйл худалдсан болохоо нотолж чадвал хариуцлага хүлээдэггүй байна.

**Канад:** Тус улсад 1996 оны “Согтууруулах ундааны эргэлтэнд хяналт тавих тухай” хууль үйлчилдэг ба 33 дугаар зүйлд насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан, бэлэглэсэн, бусад байдлаар өгсөн, эсвэл өөрийн байр, эзэмшил газар насанд хүрээгүй хүнийг ууж согтууруулах зорилгоор согтууруулах ундааны зүйл хадгалсан, ууж согтуурах боломж олгосон бол гэмт хэрэг гэж үзэж 500-гаас дээш доллароор торгох, согтууруулах ундаа тусгайлан борлуулдаг, түүгээр үйлчилдэг газар /архи, виныны дэлгүүр, клуб, бар, ресторанд/ насанд хүрээгүй хүнийг байлгасан үйлдлийг зөрчилд тооцон 100 хүртэл доллароор торгохоор заасан байна.<sup>100</sup>

#### **в. Мусульманы шашины эрх зүйн бүлийн орнууд:**

Мусульманы шашинтай орнуудын хувьд судалж буй асуудал нь өөрийн гэсэн онцлогтой, мусульманы шашинд согтууруулах ундаа хэрэглэхэд насны хязгаар байхгүй, бүх хүйс, насны мусульман шашин шүтдэг бүх хүнд хориотой, Аллах бурханы сургаалийн эмхэтгэл болох Коран сударт заасан хүнд гэмт хэрэг мөн.

Мусульман шашинтай хүн согтууруулах уусан хүнд оногдуулах ял нь мусульманы эрх зүйн өөр нэг эх сурвалж болох Суннад шууд заагдсан, 80 удаа ташуурдах ял шийтгэх заалт бий. **Саудын Арави** Улс нь одоог хүртэл төрөлжүүлж нэгтгэсэн Эрүүгийн хууль байхгүй цөөн орны нэг бөгөөд тус улсад дээрх шашины эх сурвалжийг үндэслэн 80 удаа ташуурдах ял оногдуулахаар заасан байна. **Кувейт** Улсын 1960 оны, **Бахрейн** Улсын 1976 оны, **Афганистан** Улсын 1976 оны Эрүүгийн хуулиар дээрхтэй адил ял хэрэглэдэг.<sup>101</sup>

**Ливи** Улсад 1976 оноос “Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын тухай” хууль үйчилж байгаа ба мусульман шашинтан согтууруулах ундааны зүйл хэрэглэвэл 40 удаа ташуураар жанчих, энэ үйлдлийг мусульман шашинтан бус хүн үйлдвэл торгох болон богино хугацааны хорих ялаар шийтгэхээр<sup>102</sup> ялгавартай байдлаар хуульчилсан нь анхаарал татаж байна.

**Иран** Улсын “Эрүүгийн ялын тухай” хуулийн 2 дугаар хэсгийн 6 бүлгийн 165 дугаар зүйлд согтууруулах ундаа хэрэглэсэн /масхар/ тохиолдолд согтууруулах ундааны төрөл, хэрэглэсэн хэмжээ, согтуурлын зэрэг хамаарахгүйгээр ял шийтгэнэ, 174-р зүйлд хүйс

<sup>97</sup> См.: Oklahoma constitution: Article XXVIII: ALCOHOLIC BEVERAGE LAWS AND ENFORCEMENT. [Электронный ресурс]. URL: <http://oklegal.onenet.net/okcon/XXVIII.htm>

<sup>98</sup> New Jersey Statutes - Title 2C The New Jersey Code of Criminal Justice - 2C:33-15 Possession, consumption of alcoholic beverages by persons under legal age; penalty. [Электронный ресурс]. URL: <http://law.onecle.com/new-jersey/2c-the-new-jersey-code-of-criminal-justice/33-15.html>

<sup>99</sup> Е.А.Герасимова. Уголовно-правовое противодействие розничной продаже несовершеннолетним алкогольной продукции. Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. Саратов. 2015. стр 71

<sup>100</sup> Е.А.Герасимова. Уголовно-правовое противодействие розничной продаже несовершеннолетним алкогольной продукции. Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. Саратов. 2015. стр 72

<sup>101</sup> Г.Ф.Елаян. Основы мусульманского уголовного права. Учебное пособие.г.Махачкала. 2002 год. стр 63.

<sup>102</sup> Правовые системы мира. Энциклопедический справочник под ред А.Я.Сухарева.М.2003 год. стр 446

хамаарахгүйгээр 80 удаа ташуурдах ял оногдуулахаар заасан байна.<sup>103</sup> Харин уг хуулийн 175 дугаар зүйлд зааснаар согтууруулах ундааны зүйлийг хууль бусаар үйлдвэрлэсэн, бэлтгэсэн, тэвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>104</sup>

### Дүгнэлт

Гадаад орнуудад насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байдлыг өөр өөр эрх зүйн бүлийн төлөөлөл болгон 30 гаруй орны эрүүгийн болон бусад хууль тогтоомжийг харьцуулан судлахад дараахь дүгнэлт хийж болохоор байна. Үүнд:

- Гадаад орнуудад насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлага улс орон болгоны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрх зүйн соёл, зан заншил, уламжлал, шашин шүтлэг, согтууруулах ундаанд хандах уламжлалт хандлага, согтууруулах ундааны хэрэглээ, соёл зэргээс хамааран харилцан адилгүй хуульчилжээ.
- Гэхдээ ХХ зууны 70-аад оноос эхлэн насанд хүрээгүй хүнийг архи, тамхи, бусад хорт бодисын нөлөөллөөс хамгаалах үндэсний нэгдсэн тогтолцоог бий болгон, дэлхий нийтэд явагдаж буй даяарчлын үйл явц, эрх зүйн интеграцлалын нөлөөгөөр ойртон нягтарч, нэгдсэн нэг стандарт, жишигт шилжиж байгаа нь сүүлийн жилүүдэд тодорхой улс орнуудын эрүүгийн болон бусад хууль тогтоомжид насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдэлтэй холбоотой орж байгаа нэмэлт, өөрчлөлтөөс харагдаж байна.
- ХХI зууны эхний арван жилээс улс орнууд насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах үйлдлийг шууд гэмт хэрэгт тооцох, эсвэл урьд нь зөрчилд тооцож байсан орнууд уг үйлдлийг удаа дараа үйлдсэн, эсвэл урьд нь захиргааны арга хэмжээ авагдсаны дараа 3 сараас 1 жилийн дотор дахин үйлдвэл гэмт хэрэгт тооцох /*praecedentialis – административная преюдиция хийх Г.Г*/ явдал түгээмэл болж, уг үйлдлийг зөрчилд тооцон захиргааны шийтгэл ногдуулдаг орнуудын тоо цөөрөх төлөв ажиглагдаж байна.
- Гадаадын орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжид согтууруулах ундааны зүйл худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох насны доод хязгаарыг 15-16 насаар тогтоож байсан боловч сүүлийн жилүүдэд түүнийг 18, бүр цаашилбал 20-21 насаар тогтоох дэлхий нийтийн чиг хандлага бий болж байна.
- Сүүлийн жилүүдэд гадаадын орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжид насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах, түүгээр үйлчлэхийг зөвхөн хориглох бус, хуурч мэхлэх аргаар согтууруулах ундаа худалдан авсан, сургууль олон нийтийн газар хэрэглэсэн, ууж согтуурсан насанд хүрээгүй хүнд өөрт нь хариуцлага хүлээлгэх, худалдан авах үйлдэлд нь тусалсан дэмжлэг үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг газруудад 21 насанд хүрээгүй хүнийг ажилд авахгүй байх, авсан бол хариуцлага хүлээлгэх зэргээр хамрах хүрээг өртгөтгөх замаар насанд хүрээгүй хүнийг согтууруулах ундаа хэрэглэхээс урьдчилсан сэргийлэхэд чиглэгдсэн эрх зүйн арга хэмжээг шинээр авах болжээ.
- Монгол Улсын архидан согтууруулахтай тэмцэх эрх зүйн орчин, архидан согтууруулахтай холбоотой үйлдлүүд, түүний дотор насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах, түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан зохицуулалт дэлхийн нийтийн жишиг, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалттай үндсэндээ нийцэж байна.

### Санал

Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдсан, түүгээр үйлчилсэн зөрчлийг удаа дараа үйлдсэн бол гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх /административная преюдиция хийх/ зохицуулалтыг Эрүүгийн хуульд оруулах нь зүйтэй байна.

<sup>103</sup> Закон об исламских уголовных наказаниях Исламской Республики Иран. Перевод с персидского М.С.Палевани, науч.ред А.М.Ахани. Спб. изд. Юридический Центр Пресс. 2008 г. стр 102

<sup>104</sup> Закон об исламских уголовных наказаниях Исламской Республики Иран. Перевод с персидского М.С.Палевани, науч.ред А.М.Ахани. Спб. изд. Юридический Центр Пресс. 2008 г. стр 106

## ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА

Н.Одонтуул

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн  
Ерөнхий шүүгч, Дотоод хэргийн их сургуулийн докторант

**Товч агуулга:** Эрүүгийн хариуцлагын нэг төрөл болох эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

**Түлхүүр үг:** Эрүүгийн хариуцлага, албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хэрэг хариуцах чадваргүй байдал, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт.

### Удиртгал

2015 оны Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэх үндэслэл журмын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан. Дээрх хуулиуд хэрэгжих явцад эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй, шүүхээс нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй асуудал цөөнгүй гарах болсон.

Энэхүү судалгааны ажлын дүгнэлт санал нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол-эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл, уг арга хэмжээг хэрэглэж буй өнөөгийн байдал, 2014-2019 онд анхан шатны шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн 34 шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийсэн судалгааны үр дүнд үндэслэгдсэн болно.

#### 1. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж ирсэн уламжлал

Эрүүгийн хариуцлага гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ бөгөөд энэ нь хуулиар тогтоосон ял, албадлагын арга хэмжээнээс бүрддэг.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлагын хүрээнд шүүхээс хэрэглэдэг Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Энэ арга хэмжээг дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэглэдэг бөгөөд Монгол Улсын 1926, 1929, 1942 оны Эрүүгийн хуульд гагцхүү эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох талаас тодорхойлж ирсэн бол 1961 оны Эрүүгийн хуульд ухаан санаа нь эрүүл бус этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй, мөн эмнэлгийн чанартай арга хэмжээг хэрэглэх үндэслэл, арга, өөрчлөх, зогсоох, хэргийг сэргээх үндэслэл, хэргийн хугацаа тоолох талаар тодорхой бүлэг, зүйл, хэсэгт тусгайлан авч үзсэн олон талын ач холбогдолтой зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл, ял ба албадлагын арга хэмжээг тусгайлан салгаж, эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, хэдийд хэрхэн аль үе шатанд хэрэглэх талаар оновчтой тодорхойлох боломжтой болсон.<sup>105</sup>

Харин 2002 оны Эрүүгийн хуульд энэ арга хэмжээг эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнд хамааруулаад энэ арга хэмжээний ойлголт төрөл, түүнийг оногдуулах, өөрчлөх зогсоох, хугацааг тоолох журмыг нарийвчлан хуульчилсан.

#### 2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний ойлголт, мөн чанар

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна”<sup>106</sup> гэж заасан. Тиймээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх гол үндэслэлийн нэг нь тухайн этгээдийн хэрэг хариуцах чадвартай холбоотой бөгөөд энэ асуудлыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд олон талаас нь судалж иржээ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын мөн чанартай холбогддог.

<sup>105</sup> С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол” II боть. УБ., 2014. 62 дахь тал

<sup>106</sup> Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл, УБ, 2016 №7



2015 оны Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”<sup>107</sup>, “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно.”<sup>108</sup> гэж тус тус заасан.<sup>109</sup> Мөн энэ хуульд гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд ял оногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр<sup>110</sup>, мөн гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүх түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний дараа ял оногдуулахаар<sup>111</sup> тус тус хуульчилсан. Түүнчлэн, Эрүүгийн хуульд<sup>112</sup> зааснаар согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн *согтуурах, мансуурах донтох эмгэгтэй* болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл нь хэрэг хариуцах чадваргүй байдал юм. Хэрэг хариуцах чадваргүй байдлыг эмнэлгийн буюу биологийн, хууль зүйн буюу сэтгэл зүйн гэсэн хоёр шалгуураар шалгаж шийдвэрлэх бөгөөд энэ хоёр шалгуурыг нэгэн зэрэг нэг хүнд илэрсэн тохиолдолд тухайн этгээдийг хэрэг хариуцах чадваргүй гэж үзнэ.<sup>113</sup> Хэрэг хариуцах чадваргүй байдлыг эмнэлгийн /биологи/ болон хууль зүйн шалгуураар тодорхойлдог.

*Эмнэлгийн буюу биологийн* шалгуурт: Эрүүгийн хуульд<sup>114</sup> заасан сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдол буюу хүний сэтгэцийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж сарниулдаг архаг өвчнүүд хамаарна. Энэ шалгуур сэтгэцийн олон янзын эмгэг өөрчлөлтүүдийг өөртөө багтаасан, нэгтгэн дүгнэгдсэн дараах 4 бүлэг шинж байдлуудаас бүрддэг.<sup>115</sup> Үүнд:

- Сэтгэл мэдрэлийн архаг өвчнүүд;
- Сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааг түр сарнихад хүргэсэн сэтгэцийн үйл ажиллагааны түр зуурын эмгэг өөрчлөлтүүд;
- Ухаан сулралт;
- Сэтгэл мэдрэлийн бусад эмгэг байдлууд.

*Сэтгэцийн буюу сэтгэл мэдрэлийн архаг өвчнүүдэд* тасралтгүй даамжрах явцтай сэтгэцийн эмгэг өөрчлөлтөд хүргэж байгаа шизофрени, эпилепси, даамжрах саа, өтлөлтийн үеийн солиорол мэтийн архаг өвчнүүд, мөн өвчин нь үе үе дахиж /хөдөлж/ сэтгэцийн гүнзгий эмгэг өөрчлөлтөд хүргэж байгаа шизофрени, өтлөлтийн өмнөх үеийн солиорол зэрэг үечлэн даамжрах явцтай өвчнүүд, өвчний хурц үе өнгөрсний дараа сэтгэцийн тогтвортой гүнзгий эмгэг байдлыг үлдээсэн тархины органик өвчнүүд хамаардаг. Өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг өвчинд эмчлэгдэх боломжгүй болсон байдлыг ойлгоно.<sup>116</sup>

*Сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааг түр сарнихад хүргэсэн сэтгэцийн үйл ажиллагааны түр зуурын эмгэг өөрчлөлтүүдэд* сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааг түр сарнихад хүргэдэг гэнэт эхэлдэг, богино хугацаатай үргэлжилдэг, эхэлсэн шигээ гэнэт арилдаг, клиникийн хувьд үлдэц согог өгөлгүй бүрэн эдгэрдэг, янз бүрийн шинж тэмдгээр илэрдэг, янз янзын шалтгаантай сэтгэцийн эмгэг байдлуудыг хамааруулан авч үздэг. Үүнд дараах сэтгэц эмгэгийн шинжүүд хамаарна. Хордлого, халдвар, бие махбодын өвчний шалтгаант шинж тэмдгийн солиорлууд, эмгэг согтолт, сэтгэлийн эмгэг цочирдол, эмгэг нойрмог байдлууд, сэтгэлийн шалтгаант хурц солиорол нэртэй түр зуурын солиорлуудыг өөртөө багтаасан онцгой байдлууд, гадна төрөлт хүчин зүйлээр сэдэгдэн үүсдэг, ихэнх тохиолдолд ухаан балартах байдлаар клиник нь илэрдэг гадна төрөлтөд органик солиорлууд, завсрын тархины эмгэгээр нөхцөлдөн үүсдэг, ухаан баларталт ба хөдөлгөөний хүрээний өөрчлөлтөөр клиник нь илэрдэг пароксизм өөрчлөлтүүд.

*Сэтгэцийн үйл ажиллагаа түр сарнисан гэдэгт* сэтгэцийн хэвийн байдалд буцаж орох сэтгэцийн түр зуурын солиорол буюу өөрөөр хэлбэл эдгэрч болох байдлыг ойлгоно. Тухайлбал, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагаа түр сарнихад хүргэдэг сэтгэцийн үйл ажиллагааны түр зуурын эмгэг өөрчлөлтүүдэд гэнэт эхэлдэг, богино хугацаатай үргэлжилдэг,

<sup>107</sup> Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

<sup>108</sup> Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>109</sup> Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл, УБ, 2016. №7

<sup>110</sup> Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

<sup>111</sup> Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

<sup>112</sup> Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

<sup>113</sup> Улсын Дээд Шүүх, Ханнс-Зайделийн сан. “Эрүүгийн эрх зүй-2013”. УБ., 2013, 78 дахь тал

<sup>114</sup> Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйл

<sup>115</sup> С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба. “Шүүхийн сэтгэц гэм судлал”. УБ., 1990. 23 дахь тал

<sup>116</sup> Л.Эрдэнэбаяр. “Шүүхийн сэтгэц эмгэг судлалын лекцүүд”. УБ., 2005. 300 дахь тал

эхэлсэн шигээ гэнэт арилдаг, клиникийн хувьд үлдэц согог өгөлгүй бүрэн эдгэрдэг, янз бүрийн шинж тэмдгээр илэрдэг, янз янзын шалтгаантай сэтгэцийн эмгэг байдлуудыг хамааруулан авч үздэг.

*Ухаан сулралт* гэж оюун ухааны танин мэдэх үйл ажиллагааг цогцлон бүрдүүлэгч элементүүд болох сэтгэхүй, хэл яриа, ой, анхаарал зэрэг сэтгэцийн үзэгдлүүдийн ажиллах чадвар дутуу хөгжих, эсвэл суларч муудах буюу алдагдахыг хэлнэ. Ухаан сулралт нь төрөлхийн ба олдмол шинж чанартай байж болно. Төрөлхийн ухаан сулралтыг оюуны хомсдол, олдмол ухаан сулралтыг тэнэгрэл гэж тус тусад нь нэрлэдэг.<sup>117</sup> Төрөлхийн ухаан сулралтыг дотор нь дүйнгэ тэнэг, мангуу тэнэг, усан тэнэг, олдмол ухаан сулралтыг дотор нь хэсэгчлэгдсэн тэнэгрэл, ерөнхий тэнэгрэл гэж ангилан үздэг.

Ухаан сулралтын хүнд, хөнгөн зэргээс хамааран хэрэг хариуцах эсэх нь үнэлэгддэг. Усан тэнэг, мангуу тэнэг ба ерөнхий тэнэгрэлийн байдалтай өвчтнүүд хийсэн хэргээ хариуцах чадваргүй байхад хөнгөн зэргийн дүйнгэ тэнэг ба хэсэгчлэгдсэн тэнэгрэлийн байдалтай өвчтөнүүд үйлдсэн хэргээ хариуцах чадвартай байж болно.<sup>118</sup>

*Сэтгэл мэдрэлийн бусад өвчнүүдэд* хүнд хэлбэрийн даамжирч ээнэгшил алдагдсан эмгэг төрх, хүнд зэргийн бие сэтгэцийн дутуу хөгжил /инфантилизм/, ужиг явцтай неврозыг хамааруулан авч үздэг.

Хэрэг хариуцах чадваргүй байдлын хууль зүйн шалгуур нь дээрхи сэтгэцийн өвчин, эмгэгийн улмаас хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн хувьд өөрийн үйлдлийг ухамсарлах, үйлдлээ удирдах жолоодох чадваргүй байдлыг хэлнэ.<sup>119</sup>

Хэрэг хариуцах чадваргүй байдлын хууль зүйн буюу *сэтгэл зүйн шалгуурыг* хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч тогтоох бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд<sup>120</sup> зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж түүний сэтгэцийн байдлыг тодорхойлохоор заавал шинжилгээ хийлгэнэ.<sup>121</sup> Ингэхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч сэтгэц эмгэг судлалын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн хэргийн нөхцөл байдал, бусад нотлох баримтыг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадвартай эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

**Хэрэг хариуцах чадваргүй байдлын хууль зүйн шалгуур нь** оюун санааны болон хүсэл зоригийн гэсэн хоёр шинжтэй байдаг.<sup>122</sup> Гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн архаг өвчин, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, оюун ухааны хомсдол, өөр бусад хүнд өвчтэйн улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинжийг ойлгож мэдэхгүй, ухаарахгүй байгаа бодит байдал нь хууль зүйн шалгуурын оюун санааны шинж юм.

Харин өөрийн үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй гэдэг нь бий болсон тухайн нөхцөлд хийж болох үйл ажиллагааны олон хувилбаруудаас аль зөв, оновчтойг сонгон авч хэрэгжүүлэх боломжгүй байдал нь хууль зүйн шалгуурын хүсэл зоригийн шинж юм. Оюун санаа, хүсэл зоригийн шинжүүд хоёулаа тогтоогдсон тохиолдолд хэрэг хариуцах чадваргүй байдлын хууль зүйн шалгуур болно.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэргийг шүүхээр шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсон этгээд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ /эмчилгээ/-ний үр дүнд эдгэрсэн тохиолдолд үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулах асуудлыг шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

### **3. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж буй байдал**

2015 оны Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйл болон 7.4 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй хүнд энэ хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч буй байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар судлан үзлээ.

Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 5 жилд 47245 эрүүгийн хэрэг хүлээн авч, 3638 хэргийг мөрдөн байцаалтад буцааж, 40283 эрүүгийн хэргийг

<sup>117</sup> С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба, “Шүүхийн сэтгэц гэм судлал”, УБ., 1990, 24 дэх тал

<sup>118</sup> С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба, “Шүүхийн сэтгэц гэм судлал”, УБ., 1990, 25 дахь тал

<sup>119</sup> Г.Гантөмөр. “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ., 2011. 36 дахь тал

<sup>120</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг

<sup>121</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23

<sup>122</sup> Монгол Улсын Дээд Шүүх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010. 82 дахь тал

хянан шийдвэрлэж, 47405 хүнийг гэм буруутайд тооцож, 12461 хүнд хорих ял оногдуулах болон оногдуулахгүйгээр тэнсэж, 43825 хүнд ял шийтгэл оногдуулжээ.<sup>123</sup>

Хүснэгт №1 Ял оногдуулсан байдал 2014-2008 он

Он	Шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэрэг	Гэм буруутайд тооцсон нийт хүн	Хорих ял оногдуулах болон оногдуулахгүйгээр тэнссэн	Ял шийтгэгдсэн нийт хүн
2014	6375	8178	3396	8178
2015	6756	7696	3197	7696
2016	5762	6566	2866	6566
2017	8839	10040	962	9019
2018	12551	14925	2040	12366
Нийт	<b>40283</b>	<b>47405</b>	<b>12461</b>	<b>43825</b>

Анхан шатны шүүх сүүлийн 5 жилийн хугацаанд 11076 хүн, хуулийн этгээдийг торгох ялаар, 24989 хүнийг хорих ялаар, 1520 хүнийг албадан ажил хийлгэх ялаар, 2393 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар тус тус шийтгэж, 3332 хүнд баривчлах, 609 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, 65 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэсэн байна.<sup>124</sup> (Хүснэгт №2)

Хүснэгт №2 Ял, албадлагын арга хэмжээний төрөл

№	Ялын төрөл	Он				
		2014	2015	2016	2017	2018
1	Торгох	285	370	216	2768	7437
2	Албадан ажил хийлгэх	442	463	376	239	-
3	Баривчлах	1053	957	733	581	8
4	Хорих	6277	5757	5114	4596	3245
5	Нийтэд тустай ажил хийлгэх	-	-	-	710	1683
6	Зорчих эрхийг хязгаарлах	-	-	-	-	-
7	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	110	132	117	123	127
8	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ	<b>11</b>	<b>16</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>23</b>

Дээрх судалгаанаас үзэхэд, сүүлийн 5 жилд анхан шатны шүүх нийт шийдвэрлэсэн 40283 эрүүгийн хэрэгт 47405 хүнийг гэм буруутайд тооцож, үүнээс 65 буюу 0.13 хувьд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэлгүй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан нь нийт ял шийтгэгдсэн этгээдүүдтэй харьцуулахад маш бага тоо юм.

Харин 2017 онд 5 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь 2018 онд 23 болж өссөн дүнтэй байна. Энэ нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой юм.

#### 4.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд тулгамдаж буй асуудал

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж байгаа шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах тулгамдсан асуудал байна.

Нэг. Анхан шатны шүүх сэтгэцийн эмгэгтэй хүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүгдэгчийг хууль ёсны төлөөлөгчтэй оролцуулалгүй хэргийг хянан шийдвэрлэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт “хохирогч нас барсан, эсхүл сэтгэцийн, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, эхнэр, нөхөр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг” хууль ёсны төлөөлөгчөөр мөрдөгч, прокурор

<sup>123</sup> Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тайлан. УБ., 2014-2018

<sup>124</sup> Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тайлан. УБ., 2014-2018

тогтооно гэж заасан. Гэтэл гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хэлэлцэх шүүх хуралдаанд түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй тохиолдол багагүй хувийг эзэлж байна. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй” шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулахаар заасан. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 2-т “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон хүнд холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхдээ улсын яллагч, өмгөөлөгчийг оролцуулахаар хуульчилсан.

#### **Тохиолдол-1**

*Шүүгдэгч О нь үлдэц шизофрени, хий үзэгдэл дэмийрлийн хам шинж сэтгэцийн эмгэгтэй байхдаа 2019.5.12-ны өдөр ... төрсөн эх 68 настай Л-ийн толгой, нүүрэн тус газар олон удаа заазуурдаж, цээж, нуруу, гар хэсэгт олон удаа зүсэж, хутгалж онц харгис хэрцгийгээр, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс О-д 8 жилийн хугацаагаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж Сэтгэцийн Эрүүл мэндийн Үндэсний төвийн тусгай тасагт эмчлүүлэхээр тогтоосон. Шүүх хуралдаанд түүний хууль ёсны төлөөлөгч оролцоогүй, өмгөөлөгч оролцсон байна.*

*Эх сурвалж: Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019 оны 10 дугаар сарын 02-ны №1036 шийтгэх тогтоол,*

Цаашид Сэтгэцийн Эрүүл мэндийн тухай хууль болон Гэр бүлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах ажиллагаанд сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчийг урьдчилан тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байх шаардлагатай.

Хоёр. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7-д “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж заажээ. Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж буй шийдвэрийг авч үзвэл шүүх Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтыг үндэслэн сэтгэцийн эмгэгтэй хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг 1 сараас 8 жил хүртэл хугацаагаар хэрэглэсэн байна.<sup>125</sup>

Судалгаанаас үзэхэд, шүүхээс тогтоосон хугацаа дуусгавар болсон хэдий ч тухайн этгээдийн сэтгэцийн байдал засрал сайжрал олоогүй тохиолдолд шүүхийн шийдвэргүйгээр эмнэлгийн байгууллагад уг этгээдийг үргэлжлүүлэн эмчилсээр байна.

#### **Тохиолдол-2**

*Шүүгдэгч О нь сэтгэцийн шизоффертив эмгэгийн холимог хэлбэр, дэмийрэл өвчтэй байх үедээ 2017.11.14-ний өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Сэтгэцийн эмнэлэгт ажил үүргээ гүйцэтгэж байсан сувилагч О-г шалтгаангүйгээр цохиж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс О-д эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, Сэтгэцийн Эрүүл мэндийн Үндэсний төвд 2 сарын хугацаагаар эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.*<sup>126</sup>

<sup>125</sup> Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019 оны 9 дүгээр сарын 16-ны №1000 шийтгэх тогтоол, Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 11 дүгээр сарын 02-ны №206 шийтгэх тогтоол, Өвөрхангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн №152 шийтгэх тогтоол, мөн шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 30-ны №87 шийтгэх тогтоол,

Өвөрхангай аймаг Хархорин сум дахь Сум дундын шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны №39 шийтгэх тогтоол, Архангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 19-ний №189 шийтгэх тогтоол, Өвөрхангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 7 дугаар сарын 06-ны №128 шийтгэх тогтоол, мөн шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 30-ны №87 шийтгэх тогтоол.

<sup>126</sup> Дархан-Уул аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 12 дугаар сарын 28-ны №02 шийтгэх тогтоол, Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх 2018 оны 8 дугаар сарын 02-ны №76 шийтгэх тогтоол, Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 оны 6 дугаар сарын 26-ны №147 шийтгэх тогтоол,

Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно гэж заасан хэдий ч практикт сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдийн сэтгэцийн эмгэг хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлтээр урьдчилан тогтоох боломжгүй талаар шинжээч эмч нар тайлбарладаг. Судалгаанаас харахад цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн хэлэлцүүлэгт оролцож хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хугацааг тогтоосон, зарим тохиолдолд шүүхийн шийдвэрт огт хугацаа заагаагүй байна. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 7-д эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэнэ гэж заасан боловч юуг үндэслэн, ямар хугацаагаар сунгах эсэх нь тодорхойгүй, хүндрэлтэй байна. Тухайлбал, тухайн этгээдийг эмчлэх хугацааг шийтгэх тогтоолд заасан байх боловч уг тогтоосон хугацаанд тухайн этгээдийн сэтгэцийн байдал засрал сайжрал олоогүй, эдгэрээгүй тохиолдолд дахин ямар хугацаа тогтоож сунгах нь ойлгомжгүй байна.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т “Шүүх гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй нь тогтоогдсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахаар байвал эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлэх шийдвэр гаргана.” 7-д “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад прокурор хяналт тавьж, уг арга хэмжээг зогсоох, хугацааг сунгах, тухайн шүүгдэгч эдгэрсэн нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж тус тус заасан.

Шүүхийн практикаас үзэхэд, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засрал сайжрал олсон, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нар өөрийн асрамжид авахаар хүсэлт гаргасан тохиолдолд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн уг арга хэмжээг зогсоож, албадан эмчлэгдэж буй этгээдийг асран хамгаалагчид халамжлуулахаар шийдвэрлэж байна.

### **Тохиолдол-3**

*Шүүгдэгч А нь 2018.3.3-ны өдөр төрсөн эцэг Ө-г хутгалж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, Сэтгэцийн эмгэг судлалын тусгай тасагт 1 жилийн хугацаагаар эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.<sup>127</sup> Прокуророос А-ийн өвчний байдал болон эрүүл мэндийн байдал нь засарч сайжирсан, сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засралын байдалд орсон болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон, уг арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн үндэслэлээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох тухай дүгнэлт үйлдэн ирүүлснийг шүүх хүлээн авч, А-д авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоож, түүнийг асран хамгаалагч, эх Ц-д халамжлуулах, А-г сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын хяналтад байлгахыг Ц-д даалгаж шийдвэрлэсэн.<sup>128</sup>*

Шүүх хэрэг хариуцах чадваргүй байдал арилаагүй боловч сэтгэцийн байдал засарч сайжирсан, түүнийг асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүд нь асрамжиндаа авах хүсэлт гаргасан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоож, асран хамгаалагчийн асрамжид шилжүүлэн өгч Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн “...сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно.” гэснийг төсөөтэй хэрэглэж байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох үндэслэл журмыг нарийвчлан тогтоох шаардлага бий болж байна.

<sup>127</sup> Дархан-Уул аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 12 дугаар сарын 28-ны №02 шийтгэх тогтоол, Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх 2018 оны 8 дугаар сарын 02-ны №76 шийтгэх тогтоол, Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 оны 6 дугаар сарын 26-ны №147 шийтгэх тогтоол,

<sup>128</sup> Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019.11.29-ний №361 захирамж.

Дөрөв. Монгол Улсын хэмжээнд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” хэрэглэхээр шийдвэрлэсэн этгээдийг Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төвд албадан эмчилж байгаа бөгөөд 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дугаар зүйлд “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг... шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн **190 дүгээр зүйлийн 190.1-д** “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.” гэж тус тус заасан.

Харин дээрхи хуулиудад 2002 оны Эрүүгийн хуульд тусгагдсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзаж ямар төрлийн эмнэлэгт эмчлэх зохицуулалт орхигдсон байна. Дээрх байдлаас шалтгаалан анхан шатны шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дэглэмийг тогтоохдоо Эрүүгийн хуульд заагаагүй нэр томъёог хэрэглэж байна. Тухайлбал, шүүх шийтгэх тогтоолдоо “Донтох эмгэгийн клиник”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлийн тасаг”, “Шүүх сэтгэц эмгэг судлалын энгийн клиник”, “Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний ердийн тасаг”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлтэй тасаг” гэж тус тус бичжээ. Мөн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ердийн тасагт, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай тасагт албадан эмчлэхээр заасан байх боловч энэ тухай үндэслэлээ шийдвэртээ бичээгүй.

#### **Тохиолдол -4**

*Шүүгдэгч Ч нь согтуурсан үедээ 2018.2.12-ны өдөр иргэн Б-г толгойн тус газар нь модоор цохиж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс түүнд сэтгэл заслын эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлтэй тасагт” 6 сарын хугацаагаар хэрэглэхээр эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.<sup>129</sup>*

2002 оны Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн *этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан* албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно”, мөн зүйлийн 2, 3 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгахаар хуульчилж байсан нь оновчтой зохицуулалт юм. Тиймээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг юуг үндэслэн тогтоохыг хуульчилж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах нь хууль ёсны зарчмын агуулгад нийцнэ.

Тав. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд холбогдсон этгээдэд мөн хуулийн 2.3 дугаар 2 дахь хэсэгт заасан “Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно”, мөн хуулийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэсэн зохицуулалтыг үндэслэн шүүх зөрчилд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэжээ.

#### **Тохиолдол- 5**

*Зөрчилд холбогдогч З нь 2019.1.22-ны өдөр Баянгол дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэн Н-ийн халааснаас “Эл Жи Экс” загварын гар утсыг, нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар хулгайлан авч 180.000 төгрөгийн хохирол учруулсан зөрчил гаргажээ. Шүүх Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 3-т зааснаар зөрчилд холбогдогч З-д шийтгэл ногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай*

<sup>129</sup> Өвөрхангай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018.5.30-ны №87 шийтгэх тогтоол.

*албадлагын арга хэмжээ авч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн энгийн тасагт эмчлэхээр шийдвэрлэсэн.*<sup>130</sup>

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон яллагдагч, шүүгдэгчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно” гэж заажээ.

Дээрх зохицуулалтаас харахад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэгт заасан журмыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, шүүгдэгчид хэрэглэхээр заасан бөгөөд зөрчил шалган шийдвэрлэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг удирдлага болгох боломжгүй. Тиймээс зөрчлийн шинжтэй үйлдэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг хуульчлах шаардлагатай.

### **Дүгнэлт**

1. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, журмыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан боловч шүүхийн практикт дээрх хуулиудад заасан зохицуулалтыг хэрэглэхэд хүндрэл учирч байна. Тухайлбал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн дэглэм, хугацааг тодорхой заагаагүй, уг арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй эсхүл сунгах тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, зөрчлийн тухай хуульд заасан эмнэлгийн чанартай арга хэмжээг хэрэглэхэд ямар журам баримтлах зэрэгт хүндрэл гарч байна.
2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж хуульчилсан боловч анхан шатны шүүхүүд согтуурах, мансуурах донтох эмгэгтэй ял шийтгэгдсэн хүнд энэ арга хэмжээг хэрэглэн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төвд хүргүүлэх талаар практик тогтоогүй байгаа нь судалгаанаас дүгнэгдэж байна.
3. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулна гэсэн заалт шүүхийн практикт хэрэгждэггүй байна. Судалгаанаас үзэхэд Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилж, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байгаа нь анхаарал татаж байна.
4. Түүнчлэн хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан этгээдэд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох, ял оногдуулах асуудлыг шүүх нэг дор шийдвэрлэх боломжгүй бөгөөд хэрхэн ял оногдуулах нь тодорхойгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.
5. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно<sup>131</sup> гэж заасны дагуу шүүх хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын ямар эсрэг эмчилгээ хийлгэхийг ихэнх тохиолдолд шийдвэртээ дурдаагүй орхисон зэрэг процессын алдаа гарч байна.

### **Санал**

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

<sup>130</sup>130 Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019.4.1-ний 271 дүгээр шийтгэвэр

<sup>131</sup>131 Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг

1. Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй байгаа алдааг засч, цаашид Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон Гэр бүлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчийг урьдчилан тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байх.
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан үндэслэл ямар хугацаанд арилах боломжтой эсэх талаар эмнэлгийн байгууллага дүгнэлт гаргаж чадахгүй байгаа, эсхүл эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан эмчлэгдэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тухайн хүнийг хэрхэх шийдвэрлэх асуудлыг тодорхой хуульчлах.
3. Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсний дараа уг этгээдийн сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засрал сайжрал олсон болох нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, хууль ёсны төлөөлөгч болон асран хамгаалагч нар асрамжид авах хүсэлт гаргасан тохиолдолд эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг арга хэмжээг зогсоож, албадан эмчлэгдэж буй этгээдийг асран хамгаалагчид халамжлуулахаар шийдвэрлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой хуульчлах.
4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7-д ...дэглэм... гэснийг хасч, уг зүйлд "...тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно." гэсэн өөрчлөлт оруулж хуульчлах.
5. Шүүхийн шийдвэрт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тусгай тасаг буюу "Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиник", энгийн буюу ердийн тасаг болох "Сэтгэцийн эмгэг судлалын 2, 3, 4, 5, 6 дугаар клиник" гэж, мөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын ямар эсрэг эмчилгээ хийлгэхийг тусган зааж байх.
6. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан шүүхийн тогтоолд сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг эмчилгээний аль нь болохыг тодорхой зааж байх.
7. Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж хуульчилсныг цаашид хэрэгжүүлж практик тогтоох зэрэг болно.

### **Ашигласан материал**

Нэг.Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №01
- Гэр бүлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1999. №30
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. УБ., 2013. №3
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24
- "Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам" Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А/240, А/369 дүгээр хамтарсан тушаал

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл, эмхэтгэл

- Монгол Улсын Дээд Шүүх, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар, УБ, 2003
- С.Жанцан. "Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургааль/" II боть. УБ., 2014
- Л.Эрдэнэбаяр. "Шүүхийн сэтгэц эмгэг судлалын лекцүүд". УБ., 2005
- С.Бямбасүрэн, Ш.Дорждамба. "Шүүхийн сэтгэц гэм судлал" УБ.,1990
- ХЗДХЯ, ШТДГГ, ХСИС, ШУТСан. "Албадлагын арга хэмжээнд тавих хяналтын тогтолцоо: хэрэгжилт, чиг хандлага" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2018
- Шүүхийн Ерөнхий Зөвлөл, "Монгол Улсын Шүүхийн тайлан 2014-2018". УБ., 2019



## ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

Г.Билгүүн

Дотоод хэргийн их сургуулийн докторант

**Товч агуулга:** Гэмт хэрэгтэй хийх тэмцлийн олон улсын хамтын ажиллагаа нь улс орнуудын олон улсын эрх зүйн хүрээнд хамаарах хамтын ажиллагааны нэг хэсэг юм. Энэ нь юуны өмнө гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх болон эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хэрэгцээ шаардлагатай холбоотой байдаг. Энэхүү өгүүллээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны үүсэл, хөгжил, чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон.

**Түлхүүр үг:** Эрх зүйн харилцан туслалцаа, олон улсын хамтын ажиллагаа, гэмт хэрэг.

Зуу гаруй жилийн өмнө Ф.Ф.Мартенс "...гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх үйл ажиллагаанд олон улсын эрүүгийн эрх зүйн бүх ашиг сонирхол төвлөрдөг..."<sup>132</sup> хэмээн тэмдэглэж байв. Олон улсын эрх зүйн салбарын орчин үеийн төлөөлөл болох ОХУ-ын эрдэмтэн В.П.Пановын үзэж байгаагаар "...гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөх яг тэр мөчид олон улсын эрх зүйн эхлэл тавигддаг..."<sup>133</sup>, И.И.Лукашук, А.В.Наумов нар "...гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орнууд хэрэгтнийг шилжүүлэн өгөхөд харилцан туслалцаа үзүүлэх эртний хэлбэр нь олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд хамрагдана..."<sup>134</sup> гэж эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны үүслийн талаар өөрсдийн бүтээл туурвилдаа авч үзсэн байна.

Гэмт хэрэг нь эртний үеэс эхэлж өр төлөөс ба гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх шаардлагыг араасаа дагуулж, харин үүнийг нь биелүүлэхээс татгалзахад өшөө авах буюу "casus belli"<sup>135</sup> үйлчилж байжээ.<sup>136</sup> Тухайлбал, өнөөгийн Израильчууд Израилева хотоос ирсэн эмэгтэйчүүдийг хүчирхийлж, амь насыг нь хохироосон үйлдэлд Египетийн Гиза хотын оршин суугчдыг шилжүүлэн өгөхийг шаардаж байжээ. Гэм буруутнуудыг шийтгэх ба шилжүүлэн өгөхөөс татгалзсаны улмаас дайн дэгдээж, Вениаминовийн үеийг устахад хүргэсэн байна.<sup>137</sup> Эртний улс орнууд боолуудын бослогыг дарахад, түүнчлэн, эзнээсээ болон нутгаасаа зугтаагсдыг шилжүүлэн өгөхөд хоорондоо харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулж байжээ.<sup>138</sup>

Дээрх агуулга бүхий гэрээг Египетийн фараон Рамсес II, Хеттийн хаан Хеттушил III (ойролцоогоор манай эриний өмнөх 1278 он, өөр нэг баримтаар 1296 он гэсэн байдаг) нар хийсэн байна.<sup>139</sup> Энэхүү гэрээ нь тухайн үедээ олон улсын захидал харилцаанд үйлчилж байсан Вавилоний шаантагт бичгээр боловсруулсан эх хувийн орчуулгын хуулбар байсан. Тухайн гэрээ нь олон улсын эрх зүйн шинжтэй уламжлагдан хадгалагдсан баримт бичгийн эртний түүхэн эх сурвалж бөгөөд олон улсын эрх зүйн харилцаа болон хэрэгтэн шилжүүлэн өгөх эрх зүйн үүсэл болохыг харуулсан түүхэн нотолгоо юм. Эх сурвалжид бичсэнээр: 15 жил гаруй үргэлжилсэн урт хугацааны дайн байлдаанд туйлдсан хоёр тал болон дайнаас үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэн Хеттийн дайчдын дунд бослого гарсан шалтгаанаар дайн хийж буй хоёр хаан найрамдалт харилцаа тогтоож, бие биедээ туслах, Ази дахь эзэлсэн улс орнуудаа тогтоон барих, улс төрийн оргодлуудыг бие биедээ шилжүүлэн өгөхөөр үүрэг хүлээсэн байна. Тухайлбал, "...Хэрвээ Рамсес бослого гаргалаа хэмээн өөрийн харьяат боолуудад уурсах юм бол тэднийг номхотгохоор явна, мөн ингэхэд Хеттийн хаан хамтран ажиллах болно. Хэрвээ Египетийн газар нутгаас нэг эсвэл хоёр гурван хүн Хеттийн орны агуу Ванд очихоор оргон зугтвал Хеттийн орны аугаа ван барьж аван, Египетийн их эзэн II Рамсес-д албадан тушаана, тэд тушаах хүмүүсийн эд хөрөнгө, эхнэр, хүүхэд болон зарц нарын бүрэн

<sup>132</sup> Мартенс Ф.Ф. Современное международное право цивилизованных народов: В 2 т. — СПб., 1900. — Т. 2

<sup>133</sup> Панов В.П. Международное уголовное право. — М., 1997.

<sup>134</sup> Лукашук И.И., Наумов А.В. Выдача обвиняемых и осужденных в международном уголовном праве. — М., 1998.

<sup>135</sup> Дайн зарлах гэдэгтэй утга нэг үг.

<sup>136</sup> Мартенс Ф.Ф. Современное международное право цивилизованных народов: В 2 т. — СПб., 1900. — Т. 2. С 384

<sup>137</sup> Библия. Книга судей. Гл. XV, ст. 9; Гл. XX, ст. 13]

<sup>138</sup> Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974. С. 11–18

<sup>139</sup> Арцибасов И.Н. Международное право. Законы и обычаи войны. — М., 1975.

бүтэн байдлыг хариуцаж, тэднийг хааны нэрийн өмнөөс шийтгэхгүй, нүд, чих, бие эрхтнийг гэмтээхгүй хохиролгүй буцаана...”<sup>140</sup> гэж тусгасан байна.

Үүнээс үзвэл, шилжүүлэн өгөх ёстой этгээдийг – гэмт хэрэг үйлдсэн хүмүүс гэж шууд үзэхгүйгээр, буцааж өгөх ёстой хүмүүс нь өөр хэн нэгний харьяат болохын тулд эзнээсээ болон нутгаасаа зугтсан байх нөхцөлийг харуулж байна. Энэ нь олон улсын эрх зүй бүрэлдэн тогтож, үүсэх үеийг харуулж, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх бус, харин энгийн харьяатууд эсвэл улс төрийг эсэргүүцэгч буюу оргодлуудыг буцаах тухай бичигдэн тэмдэглэгдсэн байна.

Мөн эрт дээр үеэс ХҮИ зууны эцэс хүртэл шилжүүлэн өгөх нь нэлээд ховор тохиолдол болохын хувьд үндсэндээ улс төрийн эсэргүүцэгчид болон тэрс үзэлтэн оргон зайлагчдын харилцаанд гардаг байсныг А.И.Бойцов баталсан.<sup>141</sup> Зарим судлаачид Рамсес ба Хеттушилийн гэрээг гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх хүрээнд үл хамаарна гэж тэмдэглэсэн байна.<sup>142</sup>

Бидэнд мэдэгдэж байгаа олон улсын эрх зүйн түүхэнд хамаарах энэхүү эртний дурсгал бичиг нь эртний Дорно, Грек, Римийн улсуудад гэрээний загвар нь болж өгсөн байна. Эртний Афинчууд Македоны хаан Филиппэд түүний амь насанд халдахаар тангарагласан бүх этгээдийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн, харин Ахейчүүд тэдний нэг тосгонд халдлага үйлдсэн иргэдийг шилжүүлэн өгөхгүй бол Спартаас холбоогоо тасална хэмээн сүрдүүлж байжээ. Лакедемонянууд алуурчныг өгөхөөс татгалзсаны төлөө Мессинүүдэд дайн зарласан бол Лукул – Митридатыг өгөхөөс татгалзсаны төлөө Тегеранд дайн зарласан. Түүнчлэн, оргодол боолуудын асуудлыг шийдвэрлэх харилцаанд шилжүүлэн өгөх эрхийг хэрэглэсэн тохиолдол тэмдэглэгдэн үлдсэн байна.<sup>143</sup>

Эртний Римийн түүхэнд улс оронд нь халдсан Фабияг шилжүүлэн өгөхийг шаардсан Галлууд, Аннибалын хувьд Римчүүд мөн адил шаардлага тавьж байсан, мөн Катонууд шударга бус дайн эхэлснийх нь төлөө Цезарийг Германд хүлээлгэн өгөхийг тулгаж байсан байна.<sup>144</sup> Эхний хаан Ромулийн үед Римчүүд Сабиняны эмэгтэйчүүдийг хулгайлдаг байсан. Тэд Рим рүү элч илгээн, эмэгтэйчүүдийг буцааж, хулгайлсан этгээдүүдийг шийтгэхийн тулд тэднийг шилжүүлэн өгөхийг шаардсан байна. Энэ шаардлагуудын алийг нь ч биелүүлээгүйн улмаас удалгүй дайн эхэлсэн талаар тэмдэглэгдэн үлджээ.

Бурхны хамгаалалт дор байдаг гадаадын элч нарын эсрэг гэмт хэрэг хүндэд тооцогддог байсан бөгөөд энэ нь шашны гэмт хэрэг мэтээр тооцогдож, буруутанд алах ял оноодог байсан. Буруутныг шилжүүлэн өгөхдөө шийтгүүлэхээр (ad supplisium<sup>145</sup>) гэж тусгайлан заадаг байсан байна. Ийм байдлаар Карфагенд - Луций Муниций, Луций Манлий гэдэг хоёр Рим хүнийг шилжүүлэн өгчээ. Рим дэх тусгай шүүх тухайн Римийн иргэнийг гадаад улсад шилжүүлэн өгөх эсэхийг шийдвэрлэдэг байжээ.

Дундад зууны шилжүүлэн өгөх эрх зүй Каролингийн хаадын Франкийн эрин үеэс өөрийн хөгжлөө эхэлсэн. 797 онд аугаа их Карлын үед гэмт хэрэг үйлдэж, алах ял сонссон этгээдийг шилжүүлэн өгөх эхний эрх зүйн зохицуулалтыг агуулсан гэрээ хийгдэж байжээ. Энэхүү гэрээний 10 дугаар зүйлд: “...хэрвээ Саксоны хуулиар алах ял заагдсан гэмт хэрэгтний нэг нь эрхэмсэг хаанаас орогнол гуйсан бол түүнийг шийтгүүлэхээр шилжүүлэн өгөх, эсвэл Саксончуудын зөвшөөрлөөр гэмт хэрэгтнийг эхнэр, гэр бүл, түүнд байх ёстой бүх зүйлийн хамт өөрийн орны хил хязгаараас, өөрийн хаант улсын хил хязгаар дотор эсвэл түүний хүсэж байгаа хил рүү явуулах, ингэснээр Саксончууд түүнийг үхсэнд тооцно...”<sup>146</sup> гэжээ.

Византийтай хийсэн Эртний Русийн гэрээнүүд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээг нэлээд тэлсэн. Тэдгээрт Византийн нутаг дэвсгэрт орос хүмүүс үйлдэж болох гэмт хэргийнхээ төлөө шийтгэл хүлээх ёстой, харин Грекчүүд Оросын нутаг дэвсгэр дээр мөн адил гэдгийг заасан байдаг. 911 онд Грекүүдтэй байгуулсан ван Олегийн гэрээнд: Алах, дээрэмдэх, эд хөрөнгө хулгайлах, биед гэмтэл учруулах зэрэг гэмт хэрэг үйлдсэний төлөө эрүүгийн хариуцлагад татах хамтын үүргийн тухай тэмдэглэгдсэн байна. Гэрээний 14 дүгээр зүйлд анх удаа гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх зарчмыг тодорхойлсон. Үүнд: “Худалдаа наймаа хийгч Руссууд, Грекэд ямар нэг шалтгаанаар ирэгсэд, тэнд амьдрагсдын дунд гэмт хэрэгтэн байх

<sup>140</sup> История дипломатии: В 3 т. — М., 1959. — Т. 1. С. 15

<sup>141</sup> Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: Юридический центр Пресс, 2004. 9 дэх тал

<sup>142</sup> Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974. 13 дахь тал., Симсон Э. О невыдаче собственных подданных. Международно-правовое исследование. — СПб., 1892. 14 дэх тал

<sup>143</sup> Никольский Д.П. О выдаче преступников по началам между народного права. — СПб., 1884. С. 44–49

<sup>144</sup> Грабарь В.Э. Римское право в истории международных правовых учений. — Юрьев, 1901. С. 48

<sup>145</sup> Өршөөлгүй алах ял

<sup>146</sup> Симсон Э. О невыдаче собственных подданных. Международно-правовое исследование. — СПб., 1892. С. 43

аваас Русьд буцаагдах ёстой. Энэ талаар Руссууд Христийн хаанд гомдол гаргавал түүнийг Русь руу хүчээр буцаана гэжээ. ОХУ-ын эрх зүйн түүх судлаач М.Ф.Владимирский – Будановын үзэж байгаагаар, хоёр талд шилжүүлэн өгөх иймэрхүү процессын хувьд буруутай этгээд дээр шүүлт явагдсаны дараа л цусан өшөө авахуулахаар Оросуудад шилжүүлэн өгдөг байсан<sup>147</sup> гэж үзсэн байна. Русууд өөрсдийн овог нэгтнүүдээ Грекүүдэд шилжүүлэн өгөхдөө буруутайгаа хүлээснийх нь дараа, тэнд алах ялыг нь гүйцэтгүүлэхээр өгдөг байжээ.

Шилжүүлэн өгөх хүрээнд хамаарах хөгжлийн дараагийн үе шатанд гэмт хэрэгтнийг өгөх нь шүүхийн ба эрх зүйн туслалцаанд хамаарахгүй, харин залхаан цээрлүүлэх ажиллагаа гэж үзэж байсан.

Дундад зууны үеийн олон улсын зан заншил ба гэрээнүүд өөрийн Эрүүгийн хуулийг бусад улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхийг төр засагтаа хориглодог байжээ. Энэ үед хүлээн авсан нутаг дэвсгэр дээр шийтгэл хүлээх гэмт хэрэг үйлдсэн дипломатуудын халдашгүй дархан эрх олгох олон улсын заншил хэлбэржин тогтнож эхэлсэн. Улс төрийн үзэл бодлоосоо мөрдөгдөн хавчигдаж байгаа этгээдийг төр засагт нь хүлээлгэн өгөхгүй байх, орогнох эрхийн хууль үүссэнээр, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх эрхийн агуулгад чанарын өөрчлөлт гарсан байна. Шилжүүлэн өгөхийг зөвшөөрөхгүй газар нь тодорхой шашин шүтлэгийн газрууд буюу сүм, хийдүүд болсон. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөхөд гарсан бас нэг саад нь феодалын нийгэмтэй улс орнуудад эх оронд нь зөвшөөрөлгүй орж ирсэн бүх гадаадын иргэдийг хамжлагаа болгодог зан заншил ч оршин тогтнож байлаа. Үүнтэй холбоотойгоор шилжүүлэн өгөх нь урьдын адил гэмт хэрэгтнүүдийг бус харин улс төрийн эсэргүүцэгчдийг дарах үндсэн хэлбэр байжээ. Жишээ нь: Дундад зууны эхэн үеийн гэрээнүүдийн нэг болох 1174 онд Английн хаан Генрих II, Шотландын хаан Вильгельм хоёрын хийсэн хэлэлцэн тохирч байгаа талууд бие биедээ улс төрийн гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх үүрэг хүлээсэн олон улсын гэрээ байсан.

Дундад зууны үеийн шилжүүлэн өгөх зөвшилцлийн гэрээнүүдийн тоонд 1242 онд Голландын ван Вильгельм II ба Брабантын гүн Генри II гэрээ, 1303 оны Английн хаан Эдуард III ба Францын хаан Филиппийн хоорондын гэрээ, 1376 оны хаан Карл V ба Савуа гүн хоёрын хоорондын гэрээ, 1497 оны Фламандууд Англичуудтай хийсэн гэрээ, 1661 онд Дани ба Англи улсын гэрээ зэрэг орно.

Дундад зууны эцсээр гучин жилийн дайны дараа /1618-1648/ Вестфалийн энх тайвны гэрээ баталсны үр дүнд олон улсын эрх зүйн хөгжил идэвхжих материалын ба оюун санааны урьдчилсан нөхцөл байдал үүсэн бий болсон байна. К.Иглтон "...Вестфалийн найрамдлын үеэс олон улсын эрх зүйн зөрчлийн төлөөх хариуцлагын зарчим, ёс суртахууны манантай талбайгаа орхиж, олон улсын эрх зүйн практикаар бэлтгэсэн хөрсөн дээр буусан..." тэмдэглэсэн байна.<sup>148</sup>

1718-1830 онд гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөх тухай олон улсын эрх зүйд хамаарах баримт бичгийн /гэрээ/ үндсэн хэсэг нь газар зүйн хувьд хөрш орнуудын хүлээх үүргээр холбогдохын зэрэгцээ хууль хяналтын байгууллагуудаас оргон зайлсан этгээдийг баривчлахад бие биедээ туслах бодит шалтгаанд үндэслэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх харилцааг зохицуулах шаардлага бий болж эхэлсэн.

Шилжүүлэн өгөх харилцаа нь өнөө үед ч улс төр, хөрш орон, төрөл садан, холбоотны харилцаанд үндэслэгдэн, тодорхой болзолтойгоор зохицуулагдаж байна. Иймээс шилжүүлэн өгөх тухай эрх зүйн зохицуулалт нь ихэнхдээ олон улсын хамтын гэрээн дээр үндэслэгддэг.

Эрүүгийн гэмт хэрэг мөрдөх асуудлаарх улс орнуудын хамтын ажиллагаа нь олон нийтийг хамарсан нэг улсаас нөгөө улс руу хийх хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор хөгжиж эхэлсэн. Тухайлбал, Европд үйлдвэржилтийн процесс явагдаж, тээврийн хэрэгслийн шинэ төрлүүд гарч ирсэнтэй холбоотойгоор төмөр зам дагуу дээрэмчидтэй тэмцэхэд асуудал үүсгэсэн байна.<sup>149</sup> 1791 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн Францын хуульд анх удаагаа "шилжүүлэн өгөх" гэдэг нэр томъёог хэрэглэсэн (Францаар: extradition, латинаар :ex –гаднаас, tradio – шилжүүлэх). Энэ хуулиар шилжүүлэн өгөх ажиллагааны тусгайлсан асуудлуудаар дүрэм тогтоож, XVIII зууны сүүл гэхэд Франц хэл өөрөө шилжүүлэн өгөх асуудлаарх дипломат захидал харилцааны ажлын хэл болсон.

XIX зуунд гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөх олон талд зөвшилцлүүдийн тоо улам өсөхийн зэрэгцээ Европын болон Америк тивийн олон улсууд бие биетэйгээ болон газар зүйн хувьд алслагдсан орнуудтай ч гэрээ хийж эхэлсэн. Гэмт хэрэгтнүүдийг хүлээлгэн өгөх Англи, Франц,

<sup>147</sup> Владимирский-Буданов М.Ф. Обзор истории русского права. — Ростов н/Д., 1995. С. 308–309

<sup>148</sup> Eagleton C. The Responsibility of States in International Law. — N.Y., 1928. P. 6

<sup>149</sup> Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: Юридический центр Пресс, 2004. С. 9–22

Испани, Нидерланд улсуудын хоорондын Амьений гэрээ 1802 онд байгуулагдаж, уг гэрээний 20 дугаар зүйлд аллага, санаатай дампууруулах, мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн гэмт хэрэг үйлдэж, ял сонссон этгээдүүдийг хүлээлгэн өгөх процессыг агуулсан байна.

Төр засаг юуны өмнө боолчлол ба боол худалдаалах, олон улсын шинж чанартай гэмт хэрэгтэй тэмцэхэд идэвхтэй хамтран ажиллах болсон. Тухайлбал, 1899 онд Лондонд садар самуунд ашиглах зорилгоор эмэгтэйчүүдийг худалдахтай тэмцэх олон улсын хурал болж, Англи улс гэрээний процесст нэлээд өвөрмөц өөрчлөлт оруулан шилжүүлэн өгөх харилцааны зэрэгцээ системийг байгуулж эхэлсэн. Нэг талаас Британий Үндэстний Хамтын Ажиллагааны орнууд, нөгөө талаас – бусад бүх л улс орнууд гэрээнд хамрагдах болсон. Түүнчлэн, удаан хугацаанд цагаачлалын харилцаанд төвийг сахисан үзэл болон шилжүүлэн өгөх ажиллагаанд таатай бус ханддагаараа ялгардаг байсан Англи Улс 1870 онд шилжүүлэн өгөх тухай тусгай хууль баталж, энэ нь тухайн асуудлаарх үндэстний зохицуулалтад эрчимтэй хөгжлийн үеийг нээсэн байна.<sup>150</sup>

Бусад улс орнуудтай хийсэн хэд хэдэн хоёр талт гэрээний үндсэн дээр боолыг худалдаалах зорилгоор ашиглаж байгаа далайн хөлөг онгоцыг хураан авах ба устгах, түүнчлэн, гэмт хэрэгтнийг иргэншилд нь байгаа улс орнуудад шилжүүлэн өгөх шийдвэрийг гаргах эрх бүхий олон улсын хамтарсан шүүх байгуулагдсан байна. Энэхүү гэрээнд зөвшөөрөгдсөнөөр олон улсын шинж чанартай гэмт хэргийн шийтгэлийг оролцогч – улс орнуудын үндэстний хууль тогтоомжоор тодорхойлж байжээ.

Шилжүүлэн өгөх эрхийн энгийн ба олон улсын хэв журмыг бүрэлдэн тогтооход энэ хүрээнд хамгийн эртний хуулиудын нэг болох 1833 оны Бельгийн шилжүүлэн өгөх хууль чухал ач холбогдолтой болсон. Энэ хуулиар улс төрийн гэмт хэргийн төлөө шилжүүлэн өгөхийг хориглосон заалт оруулж, энэ нь цаашдын хоёр талын болон олон талт гэрээнүүдэд нөхөн сэргээгдсэн байна.<sup>151</sup>

XIX зууны эцсээр гэмт хэргийн үйлдлийн тодорхой жагсаалттай шилжүүлэн өгөх зөвшилцлүүд олноор хийгдэх болсон байна. Жишээ нь: Англи Францын хооронд 1876 онд хийгдсэн гэрээнд 34<sup>152</sup> төрлийн гэмт хэрэг ба үйлдлийг жагсаасан байдаг. ОХУ-ын хуульч эрдэмтэд болох В.К.Звирбуль, В.П.Шупилов нар: "...хэрвээ ийм гэрээний практик үргэлжилсээр байсан бол өнөө үед шилжүүлэн өгөх гэрээ нь хоёр улсын харьцуулах хууль болж харагдах байсан..."<sup>153</sup> гэж тэмдэглэсэн байдаг.

XX зууны дундуур харилцан туслалцаа үзүүлэх нь улс орнуудын хамтын ажиллагааны чухал чиглэл болж байсан боловч шилжүүлэн өгөх зөвшилцлүүд ихэвчлэн эвсэл бүлэглэлийн схемээр хийгдэж байжээ. Тухайлбал, 1952 онд Арабын орнуудын холбоо шилжүүлэн өгөх бүс нутгийн системийг байгуулахаар олон улсын гэрээ байгуулсан. Мөн Баруун Европт 1957 оны Европын олон улсын гэмт хэрэгтэн хүлээлгэн өгөх гэрээ, 1959 онд эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай, 1962 онд Белилюксийн орнуудын олон улсын гэрээ, 1962 онд гэмт хэрэгтэн хүлээлгэн өгөх тухай Скандинавын гэрээ зэрэг бүс нутгийн шинжтэй эрх зүйн баримт бичгүүд батлагдсан байна.

XX зууны сүүл, XIX зууны эхэн үед НҮБ-ын системийн хүрээнд шилжүүлэн өгөх хамтын ажиллагаа илүү нягт болсон онцлогтой. Энэ үед терроризм, террорист ажиллагааны санхүүжилт, кибер гэмт хэргүүд, эрхтэн шилжүүлэн суулгах зорилгоор хүн хулгайлах, радио удирдлагатай зэвсэг үйлдвэрлэх зэрэг шинэ аюул занал болох үзэгдлийг гаргаж ирснээрээ тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Энэ мэтчилэн үндэстэн дамнан үйлдэгддэг гэмт хэргээр шилжүүлэн өгөх эрх зүйн баримт бичиг боловсруулахад НҮБ-ын үүрэг цаашид нэмэгдсээр байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар шилжүүлэн өгөх эрх зүйн дэвшилттэй байдлуудыг өөртөө тусгасан хүлээлгэн өгөх загварын гэрээг баталсан.

Хүлээлгэн өгөх үзэл баримтлалд аажмаар олон улсын эрх зүйн туслалцааны хэлбэр гэж тодорхойлж болохоор шилжүүлэн өгөх үзэл баримтлал орж ирсээр байна.

Шинэ үзэл баримтлалд шилжиж байгаа нь "шилжүүлэн өгөх" үйл ажиллагааны цаашдын хөгжилд хувь нэмэр оруулж, түүнийг зөвхөн гэмт хэрэгтэн хүлээлгэн өгөх хил хязгаараас гаргаж, ингэснээр шилжүүлэн өгөх нь улс хоорондын олон улсын эрх зүйн хамтын

<sup>150</sup> Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: Юридический центр Пресс, 2004.С. 19

<sup>151</sup> Сафаров Н.А. Экстрадиция в международном уголовном праве. Проблемы теории и практики. — М.: Волтерс Клувер, 2005. С. 26]

<sup>152</sup> Бессарабов В.Г., Волобуев В.П. Процесс экстрадиции в Соединенном Королевстве и Российской Федерации. — М., 2006. С. 12

<sup>153</sup> Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974. С. 66

ажиллагааны өргөн салбараар тархаж байна. Шилжүүлэн өгөх үйл ажиллагааны оролцогчдын хүрээ зохих хэмжээгээр өргөсөж, эрүүгийн шүүн таслах ажиллагааны хүрээн дэх олон улсын хамтын ажиллагааны үр ашиг нэмэгдэж, улс орнууд хүчээ нэгтгэх хандлага нэмэгдэж байна.

XXI зууны эхэн үеийн улс хоорондын эрх зүйн туслалцаа, хүний эрхийг хамгаалах ба хангах гэсэн уриан дор хөгжиж байна. Энэ хүрээнд хамтын ажиллагаа өргөсөж байгаа улс орнууд бие биедээ хүлээлгэн өгч байгаа этгээдийн тоо өсөн нэмэгдэж байгааг үл харгалзан, шилжүүлэн өгөх нь эрх зүйн харилцан туслалцааны харьцангуй хүнд хэлбэр байсаар байгаа нь ажиглагдсаар байна.

Үүнээс үзвэл, шилжүүлэн өгөх талаар улс орны чиг хандлагын үзэл баримтлал аажмаар өөрчлөгдөж байгаа гэсэн дүгнэлт хийж болох юм. Энэ нь дэлхийн хоёрдугаар дайны дараа үеэс хүний эрхийг хамгаалах олон улсын хүрээ улам боловсронгуй болсноор тайлбарлагдаж болно. Шилжүүлэгдсэн этгээд нь - олон улсын гэрээ эсвэл энгийн олон улсын эрхээр баталгаажсан, өөрийнхөө эрхийг хамгаалахыг чармайсан, олон улсын эрх зүйн практикийн бие даасан субъектээр хүлээн зөвшөөрөгдөж байгаа билээ.

Олон улсын шүүн таслах байгууллага, Олон улсын эрүүгийн шүүх үүссэнээр, эдгээр шүүхийн байгууллагын шүүн таслах үйл ажиллагаанд хамаарагдах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүргэж өгөх шинэ хэлбэр үүссэн. Ийм хэлбэрийн хүргэлт нь “дамжуулалт” гэж нэр томъёогоор тодорхойлогдох болжээ.

Энэ нь хүлээлгэн өгөх ажиллагаатай салшгүй холбоотой ба хүлээлгэн өгөх ажиллагааны зарчим дээр суурилагдсан шинэ үйл ажиллагаа нь өөрийн гэсэн онцгойлох шинж тэмдэгтэй биеэ даасан эрх зүйн ангилал юм. Шилжүүлэн өгөх ба дамжуулах нь гарал, үүслийнхээ үндэслэл, субъект, зорилго, үр дагавар зэргээрээ ялгаатай байдаг. Хэрвээ шилжүүлэн өгөх харилцаанд хүний эрх зөрчигдөх бодит боломж байгаа бол хүлээлгэн өгөх нэхэмжлэлийг хойшлуулж болох бөгөөд Олон улсын эрүүгийн шүүхэд мөрдөх, шүүн таслан тогтолцоо өөрөө хүний эрхийг хамгаалах хүчин зүйлийг чухалчлан анхаардаг учраас дамжуулан өгөхдөө хүний эрх зөрчигдөхийг бүрмөсөн үгүйсгэдэг.

Шилжүүлэн өгөх ажиллагааны үүрэг нь түүхийн хөгжлийн үе шатанд зөвхөн гэрээнд үндэслэгддэг гэдгийг харуулж байна. Олон Улсын Эрүүгийн шүүхийн Римийн эрхийг баталсан бөгөөд Олон улсын нийгэмлэгээс олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх зайлшгүй шаардлагатайг бүрэн дүүрэн ухамсарласныг харуулж байна. Энэ тэмцэл, хүлээлгэн өгөх хүрээ хязгаарлалтыг арилгаж, түгээмэл шинж чанартай байх ёстой гэдэг нь тодорхой болсон юм. Иймээс гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөх улс орны эрх нь тэдний олон улсын эрх зүйн хөгжлөөс хамаарч хувьсах зүй тогтолтой байна.

#### Ном зүй

- Мартенс Ф.Ф. Современное международное право цивилизованных народов: В 2 т. — СПб., 1900. — Т. 2
- Панов В.П. Международное уголовное право. — М., 1997.
- Лукашук И.И., Наумов А.В. Выдача обвиняемых и осужденных в международном уголовном праве. — М., 1998.
- Мартенс Ф.Ф. Современное международное право цивилизованных народов: В 2 т. — СПб., 1900. — Т. 2.
- Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974.
- Арцибасов И.Н. Международное право. Законы и обычаи войны. — М., 1975.
- История дипломатии: В 3 т. — М., 1959. — Т. 1.
- Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: 2004.
- Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974.
- Симсон Э. О невыдаче собственных подданных. Международно-правовое исследование. — СПб., 1892. Никольский Д.П. О выдаче преступников по началу между народного права. — СПб., 1884.
- Грабарь В.Э. Римское право в истории международных правовых учений. — Юрьев, 1901.
- Симсон Э. О невыдаче собственных подданных. Международно-правовое исследование. — СПб., 1892.
- Владимирский-Буданов М.Ф. Обзор истории русского права. — Ростов н/Д., 1995.
- Eagleton C. The Responsibility of States in International Law. — N.Y., 1928.
- Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: Юридический центр Пресс, 2004.
- Бойцов А.И. Выдача преступников. — СПб.: Юридический центр Пресс, 2004.

- Сафаров Н.А. Экстрадиция в международном уголовном праве. Проблемы теории и практики. — М.: Волтерс Клувер, 2005.
- Бессарабов В.Г., Волобуев В.П. Процесс экстрадиции в Соединенном Королевстве и Российской Федерации. — М., 2006.
- Звирбуль В.К., Шупилов В.П. Выдача уголовных преступников. — М., 1974.

# ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ /ОХУ, Украин, Казахстан, Киргизстан улсын жишээн дээр/

А.Лхамсүрэн

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн  
дэд профессор, цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** XXI зуун гарснаар гэмт хэрэг нууц далд аргаар, техник технологийн дэвшил ашиглан үйлдэгдэх болсон нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЭХХШТХ гэх/, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн зарим ойлголтыг нэгтгэх, өөрөөр хэлбэл, мөрдөгч зарим төрлийн мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах явуулах шаардлагыг бий болгож, улмаар эрх зүйн үндэслэлийг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ЭХХШТХ-д тусгасан.

Тусгаар улсын хамтын нөхөрлөлийн орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид энэхүү эрх зүйн зохицуулалтыг 2012 онд Украин, 2015 онд Казахстан, 2017 онд Киргизстан улс бүрдүүлсэн бөгөөд энэхүү өгүүллээрээ эдгээр орнуудын мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтын онцлог давуу, сул талыг судлахыг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Мөрдөн шалгах тодорхой ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил, мэдээллийн сүлжээнд хяналт тогтоох, хяналттай хүргэлт, шалгалтын худалдан авалт.

Орчин үед хууль сахиулах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны явцад гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээлэл, баримт сэлтийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд ашиглах, ил болгох хэрэгцээ шаардлага гарсаар ирсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ үе шатанд гэмт хэргийн дийлэнх нотлох баримт, ач холбогдол бүхий нөхцөл байдлууд тогтоогддог тул тухайн нотлох баримт ямар аргаар хэрхэн хавтаст хэрэгт авагдах нь чухал ач холбогдолтой. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах ерөнхий номлол, явуулах үндэслэл, журам, зарчим тодорхой хэмжээгээр төстэй байх боловч зарим ялгаатай байдаг.

Бидний үзэж байгаагаар, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг талаас хэт хүндрүүлсэн үндэслэл журам хэт олон үе шат, зөвшөөрлийн механизм зэрэг нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах тодорхой нөхцөл байдал, үйл баримтыг тогтоох боломжгүй байх<sup>154</sup> зэрэг сул талтай байдаг.

Түүнчлэн, эрх зүйн алдаа, хийдэл, өрсөлдөөн бүхий эрх зүйн хэм хэмжээ, оновчгүй зохицуулалт, хэрэг бүртгэх мөрдөн байцаах, гүйцэтгэх албадын хамтын ажиллагаа уялдаа холбоо муу, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл журам хангалтгүй зохицуулалттай, хамтын ажиллагааг журамаар зохицуулсан зэрэг нь гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах, нотлох баримтаар үнэлэх зэрэг ажиллагаанд хүндрэл учруулж байсан.

Дээр дурдсан сул тал, эрх зүйн хийдэлтэй холбогдуулан ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд 199 удаа, ОХУ-ын Гүйцэтгэх ажлын тухай хуульд 25 удаа нэмэлт, өөрчлөлт<sup>155</sup> орсон байна.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэн тус хуулийн 26 дугаар бүлэгт “Бусад мөрдөн шалгах ажиллагаа” гэж хуульчилсан.

2012 оноос мөрдөгдөж эхэлсэн Украин Улсын Эрүүгийн процессийн хуульд дараах зохицуулалтууд хуульчилагдсан.

Үүнд: 246 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Мөрдөн шалгах нууц ажиллагааг гэмт этгээд, гэмт хэргийн талаар баримт сэлтийг бусад аргаар тогтоох боломжгүй тохиолдолд явуулна. Мөрдөн

<sup>154</sup>Юридическая наука и правоохранительная практика Колосевич.М.С 144-р тал 2015 он №3 Москва

<sup>155</sup>Павличенко Н.В, Самоделкин.А.С Негласность в ОРД Вестник Волгоградской академии МВД РФ 2012 г. №3 Волгоград

шалгах нууц ажиллагааны арга, тактик, баримт сэлтийг задруулж үл болно”<sup>156</sup> гэж заасан байна.

Дээрх хуулиар мөрдөгч явуулах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааг 2 бүлэгт хувааж үзсэн байна.

Украин Улсын Эрүүгийн процессийн хуулийн 20 дугаар бүлэгт ердийн хянан шийдвэрлэх ажиллагаа буюу мэдүүлэг авах /224 дүгээр зүйл/, таниж олуулах /228 дугаар зүйл/, үзлэг /237 дугаар зүйл/, мөрдөн шалгах ажиллагааны туршилт /240 дүгээр зүйл/, шинжилгээ хийлгэх /242-244 дүгээр зүйл/, харьцуулсан шинжилгээнд дээж авах /245 дугаар зүйл/.

Дараагийн бүлэг буюу 21 дүгээр бүлэгт 2 дэд нууц мөрдөн шалгах ажиллааануудыг хуульчилсан байна. Үүнд: 1 дүгээр дэд бүлэгт хүний хувийн харилцаанд хяналт тогтоох бусад мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж тодорхойлсон. Хувийн харилцаанд хяналт тогтоох гэсэн дэд бүлэгт аудио-видео хяналт /260 дугаар зүйл/, шуудан харилцаанд хяналт тогтоох /261 дүгээр зүйл/, холбоо харилцаа, тээврийн сувагаас мэдээлэл, баримт /263 дугаар зүйл/, мэдээллийн цахим сүлжээнд хяналт тогтоох /264 дүгээр зүйл/-ыг тус тус ойлгоно. Бусад мөрдөн шалгах нууц ажиллагаанд орон байр, олон нийтийн газарт нууц үзлэг хийх, /267 дугаар зүйл/, радиоэлектрон хэрэгслийн байршлийг тогтоох /269 дүгээр зүйл/, объектод аудио-видео хяналт тогтоох, хяналттай хүргэлт, шалгалтын худалдан авалт, мөрдөн шалгах ажиллагааны тусгай туршилт буюу гэмт хэргийг үйлдэгдэх нөхцөл боломжийг үүсгэх гэж тус тус тодорхойлсон байна.

Казахстан Улсын Эрүүгийн процессийн хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хуульд мөрдөн байцаагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй гэж хуульчилжээ.

Нэгдүгээр дэд хэсэгт уламжлалт гэж хэлж болох байцаалт /208-217 дугаар зүйл/, нүүрэлдүүлэн байцаах /218 дугаар зүйл/, үзлэг /218-222 дугаар зүйл/ зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой арга хэмжээг тусгажээ.

Хоёрдугаар дэд бүлэгт аудио-видео хяналт тогтоох /242-р зүйл/, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох /243 дугаар зүйл/, үүрэн телефоны сүлжээнд хяналт тогтоох /244 дүгээр зүйл/, компьютер, серверийн мэдээллийн урсгалд хяналт тогтоох, мэдээлэл авах /245 дугаар зүйл/, шуудан харилцааг хянах /246 дугаар зүйл/, нууц үзлэг хийх /247 дугаар зүйл/, нууц ажиглалт /248 дугаар зүйл/, хяналттай хүргэлт /249 дүгээр зүйл/, шалгалтын худалдан авалт /250 дугаар зүйл/, нууц нэвтрэлт-гэмт үйлдэл үйлдэгдэх хиймэл үйлдэл үйлдэх<sup>157</sup> зэрэг тодорхой ажиллагааг хуульчилжээ.

Тус хуульд “Нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зорилтонд хүрэхийн ойлгоно”<sup>158</sup> гэжээ.

Киргизстан Улсын Эрүүгийн процессийн хуулийн гол үзэл санаа нь Европын орнуудын эрх зүйн уламжлалыг дагаж хийгдсэн бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой арга хэмжээнүүдийг дараах байдлаар хуульчилсан байна.

Уг хуулийн 31 дүгээр бүлэгт тусгай мөрдөн шалгах тодорхой ажиллагаа буюу анхны төслөөр нууц мөрдөн шалгах ажиллагаа гэж нэрлэсэн байсан бөгөөд шуудан харилцаа хянах, утсан харилцаа хянах, мэдээллийн сүлжээний урсгалыг хянах, нууц ажиглалт, аудио-видео хяналт, нууц үзлэг, нууцаар харьцуулсан шинжилгээнд дээж авах, нууц нэвтрэлт, тусгай мөрдөн шалгах ажиллагааны туршилт, хяналттай хүргэлт, шалгалтын худалдан авалт гэх тодорхой ажиллагааг хуульчилсан байна.

Мөн хуулийн 45 дугаар зүйлд “Тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь мөрдөн шалгах ажиллагааны нэг төрөл бөгөөд энэ ажиллагааг зохион явуулах хүч арга, арга зүй, технологи нь албаны эсхүл төрийн нууц байх бөгөөд задруулахыг хориглоно. Энэ ажиллагаа явуулах үндэслэл журамыг эрх бүхий байгууллагын дотоод дүрэм, журамаар зохицуулж зөвхөн мөрдөн байцаагчийн үндэслэл бүхий саналыг үндэслэн шүүхийн зөвшөөрлөөр явуулна”<sup>159</sup> гэж заасан.

Дээрх дурдсан улсуудын Эрүүгийн процессийн хуульд мөрдөн шалгах тодорхой ажиллагаа, нууц мөрдөн шалгах ажиллагааны төрлүүд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид, сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр гүйцэтгэж байгаа зэрэг адил төстэй байна.

<sup>156</sup> Уголовно-процессуальный кодекс Украина 2012. г Киев

<sup>157</sup> Уголовно-процессуальный кодекс Казахстана 2014.г Астана

<sup>158</sup> Уголовно-процессуальный кодекс Казахстана статья 7. 2014.г Астана

<sup>159</sup> Уголовно-процессуальный кодекс Киргизстана статья 45. 2017.г Бишкек



ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд тусгайлан нууц мөрдөн шалгах эсхүл тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэж заагаагүй боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоод мэдэгдэхгүй гүйцэтгэдэг ажиллагааг хуульчилсан. Жишээлбэл: шуудан харилцаа хянах, үзлэг хийх /185 дугаар зүйл/, харилцааг хянах /186 дугаар зүйл/, утсан харилцааг хянах /186 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг/<sup>160</sup>.

Нууцаар буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа оролцогчдоод мэдээлэхгүйгээр гүйцэтгэдэг тодорхой ажиллагааны үндсэн шинж чанар нь нууцлалыг хангах бөгөөд тухайн ажиллагаанд оролцогчид, нууцалбал зохих нэгж, арга, тактикийг задруулж үл болоход оршино.

### Дүгнэлт

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 26 дугаар бүлэгт “Бусад мөрдөн шалгах ажиллагаа” гэж хуульчилсан мөрдөн шалгах нууц ажиллагааны талаар зохицуулалт оруулсан боловч практикт хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл учирч байна.

- ЭХХШТХ-ийн 26.6 дугаар заасан “Хяналтын худалдан авалт”-ыг явуулахад “Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан авах, эсхүл худалдан авахаар хэлцэл хийх ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна”<sup>161</sup> гэж заасан. Практикт дээрх ажиллагааг явуулахад хуульд заасан бараа бүтээгдэхүүн эд зүйл нь иргэний эргэлтэд хориглогдсон байдаг тул дээрх ажиллагаанд оролцогчдийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад хүндрэлтэй байдаг.
- ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.26-д “хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн үл мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг<sup>162</sup> хэлнэ гэж заасан боловч 26.7 дугаар зүйлд “Энэ хуулийн 26.2, 26.3-т заасан мөрдөн шалгах хойшлуулшгүй тохиолдолд явуулахыг хориглоно” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл харилцаа, холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох арга хэмжээг хойшлуулшгүйгээр явуулах боломжгүй гэж ойлгогдож байгаа нь зөрчилдөж байна.
- ЭХХШТХ-ийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж **нууц** байна” гэж заасан. Дээрх заалт нь 26.8 дугаар зүйлд нууц мөрдөн шалгах ажиллагааны магадлагаа бичигдэж хавтаст хэрэгт авагдаж байгаа зөрчилдөж байна. Мөн ЭХХШТХ-ийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “нууц” гэх ойлголт нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан ямар зэрэглэлийн нууц болох нь тодорхойгүй.
- Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, хавтаст хэрэгт хэрхэн нотлох баримт болгохыг тодорхойлсон журам, эрх зүйн акт батлагдаагүй.

### Санал

Харьцуулсан судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Зарим улсын Эрүүгийн процессийн хуульд нууц мөрдөн шалгах ажиллагаа, тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэх нэрлэгдэж байгаа бөгөөд ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг 1.10, 4.3, 5.4, 6.2, 16.8, 22.3, 26.7, 26.8, 26.9 дүгээр зүйлүүдэд “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж тодорхойлсон 26 дугаар бүлгийг “Мөрдөн шалгах бусад ажиллагаа” гэж хуульчилсан нь нэр томъёоны хувьд зөрчилдсөн байх тул нэг мөр болгох;
- Нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүний үр дүнг магадлагаа болгож баримтжуулж байгаа нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зарим хэсэг, зарчимтай зөрчилдөж байгааг шийдвэрлэх;
- ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа гүйцэтгэх ажлын арга, хүч хэрэгслээс ялгаж ойлгох. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-д заасан үндэслэл журамаар явагдаж байгаа зарим

<sup>160</sup> Уголовно-процессуальный кодекс РФ 2002 г. Москва

<sup>161</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он. Улаанбаатар хот

<sup>162</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он Улаанбаатар

нууц мөрдөн шалгах ажиллагаанд гүйцэтгэх ажлын хүч, хэрэгслийг ашиглаж явуулж байгаа ойлголтыг салгаж, хуульд заасан мөрдөгч буюу мөрдөн байцаагч ердийн арга хэрэгслээр явуулах;

- Казахстан Улсын Эрүүгийн процессийн хуулийн “Нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зорилтонд хүрэхийн ойлгоно”<sup>163</sup> гэж заасан байгааг туршлагыг хэрэгжүүлж, ЭХХШТХ-д тодорой өөрчлөлт оруулах санал боловсруулах зэрэг саналтай байна.

---

<sup>163</sup> Уголовно-процессуальный кодекс Казахстана статья 7. 2014.г Астана

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Б.Номун-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

**Товч агуулга:** Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь 2007 оноос хойш хэрхэн өөрчлөгдөж, шинэчлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, боловсронгуй болгох санал, зөвлөмжийг энэхүү өгүүллээр дамжуулан илэрхийлэхийг зорьсон болно.

**Түлхүүр үгс:** Хялбаршуулсан ажиллагаа, гэмт хэрэг, хохирогч, яллагдагч, гэм бурууг хүлээн зөвшөөрөх.

*“Сонор соргог төр засаг, өршөөл найргүй шүүх байх нь чухал авч аядуу зөөлөн хуультай хоршиж гэмээнэ шударга сайн үйл болдог”  
Чезаре беккариа<sup>164</sup>*

### Нэг. Үндэслэл

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол ач холбогдол бол эрүүгийн хариуцлагын зорилго болох “...гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх...”<sup>165</sup> байдлыг хангах буюу хохирол нөхөн төлөгдөх механизмийг бий болгох, яллагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, нөгөө талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн ажлын ачааллыг хөнгөвчлөн мөрдөн шалгах ажиллагаа болон шүүхийн зардлыг хэмнэх явдал юм.

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн процессийн эрх зүйн салбарт нэвтэрсэн цагаас хойш өөрийн үр нөлөөг тодорхой хэмжээнд өгсөөр байгаа бөгөөд манай улсын хууль зүйн практикт нэн шаардлагатай зохицуулалт гэдэг нь бидний нүдэнд ил харагдаж байна. Тус зохицуулалтыг хэрхэн хуульчилснаас хамаарч хэргийн оролцогч нарын хялбаршуулсан журмаар хэргээ шийдүүлэх боломжит нөхцөл, мөн тус ажиллагааны практик хэрэгжилтийн үр дүн, жин нь тодорхойлогдох ба зөв томъёолж чадвал практикт саадгүй, бүрэн хэрэгжих боломж бий болно.

Манай улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн тоон үзүүлэлтээс авч үзвэл хялбаршуулсан ажиллагааны хэрэгжилтийг урьд өмнөхөөс илүү нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулах ёстойг илтгэх ба 2007 оноос хойш хуулийн дутагдалтай талуудыг засан сайжруулсаар байгаа боловч эл ажиллагааны мөн чанарыг нийтэд таниулах ажлыг хууль зүйн талаас хөгжүүлэх хэрэгцээ шаардлага одоог хүртэл байсаар байна.

### Хоёр. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ерөнхий нөхцөл

Хялбаршуулсан журмаар хэргээ шийдүүлэх хамгийн эхний нөхцөл бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийн зүйлчлэл нь тус ажиллагааны харьяалалд хамрагдах эсэх тухай асуудал юм. ЭБШ хууль (2002)-д тусгаснаар тусгайлан заасан 41 төрлийн хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр хуульчилсан бол ЭХХШт хууль (2017) анх хэрэгжиж эхлэх үед 15 төрлийн гэмт хэрэг болон хорих ялын доод хэмжээг найман жилээс доош хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийг ангилал харгалзахгүй хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой байсан боловч 2020 оны 01-р сарын 10-ны өдрийн хуулиар нэрлэн заасан 15 төрлийн гэмт хэргийг хасч, хялбаршуулсан журмын харьяалалыг нээлттэй орхисон.

Дээрх зохицуулалт уг ажиллагааг практикт илүү өргөн хэрэглэгдэх боломжийг бий болгосон гэж үзэж болох авч хэд хэдэн ойлгомжгүй зүйл байгаа нь хорих ялын доод хэмжээг найман жилээс доош хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэг гэдэгт аль төрлийн гэмт хэргүүд хамаарагдах вэ эсэх асуудал юм. Үүнд Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн ангилалыг тусгайлан заагаагүй тул түүний үйлдсэн бүхий л төрлийн гэмт хэрэг болон хүний амь насанд халдсан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломж нөхцөл бий болсон байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002) дах “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны ерөнхий нөхцөл нь гэмт хэрэгтэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч хохирогчид учирсан хохирлыг барагдуусан байх, эсхүл хохирол барагдуулахаа хохирогчид

<sup>164</sup> Ч.Беккариа “Гэмт хэрэг ба ялын тухай”. УБ., 2012.25 дахь тал

<sup>165</sup> 2015 оны Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

амласан эсэхээс үл хамаарч хохирогч хохирлын талаар ямарваа маргаагүй гэдгээ илэрхийлсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд сэжигтэн, яллагдагч, хохирогч аль аль тал нь бичгээр хүсэлт гаргадаг байсан. Энэхүү ойлголт нь ЭХХШТ хуульд “Яллагдагч хүсэлтдээ хохирлоо нөхөн төлсөн баримт, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг хавсаргана” гэх байдлаар тусгагдсаар ирсэн боловч 2020 оны 01-р сарын 10-ны өдрийн хуулиар уг зохицуулалтыг халж хохирогчид учирсан хохирлыг заавал нөхөн төлсөн байх буюу “яллагдагч...хүсэлтэд хохирлоо нөхөн төлсөн баримтыг хавсаргана<sup>166</sup>” гэх нөхцөлийг тусгайлан заасан.

ЭХХШТ хуульд хуульчлагдаагүй буюу хасагдсан зохицуулалт бол ЭБШ хуулийн 415 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй” тухай асуудал юм. Энэ нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын ерөнхий ангид “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” шинэ бүлэг нэмэгдсэнтэй холбоотой. Гэвч өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг Хялбаршуулсан журмаар давхар шийдвэрлэж болох эсэх нь одоог хүртэл тодорхойгүй байгаа бөгөөд зарим эрдэмтэн, судлаач нарын зүгээс дээрх зохицуулалтуудыг давхар хэрэглэж болохгүй хэмээн үзэж байна. Тус журмын зохицуулалтаас насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хялбаршуулж болохгүй тухай хуулийн заалт хасагдсанаар энэхүү асуудлыг нээлттэй орхиж байгаагийн нэг хэлбэр байж болох бөгөөд хориглогдоогүй бүхэн зөвшөөрөгдөнө зарчимаар хялбаршуулсан журмыг өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхэд давхар хэрэглэх үндэслэлтэй гэж үзэж болохоор байна.

ЭХХШТ хуулийн “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны журамд яллагдагчийн эрхийг хамгаалах чиглэлд шинэ, онцлог зохицуулалтыг нэмэн хуульчлагдсан нь “Яллагдагчид гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг нь хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглох<sup>167</sup>” тухай юм. Энэ нь Монгол Улс НҮБ-ийн гишүүн улсын хувьд нэгдэн орсон ОУ-ын гэрээ, конвенцийн дагуу үүргээ биелүүлж буй нэг хэлбэр болсон ба “Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 14-р зүйлийн 3 дахь хэсэг (g) “Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтанд өртөхгүй<sup>168</sup>” байх тухай заалтыг хангасан явдал юм.

### **Гурав. Хүсэлтийг шийдвэрлэх**

Эрүүгийн байцаан шийтгэх хууль хэрэгжиж байх үед ямар хуулийн аль зүйл, заалтыг үндэслэн ял оногдуулах талаар тусгаагүй байсан нь хүсэлт гаргасан этгээд өөрт оногдох эрүүгийн хариуцлагыг прокурорын хяналтын шатанд л мэдэх боломжтой байсныг илтгэх бөгөөд энэ нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа дуусч хэрэг шийдвэрлэгдэх үе шатанд сэжигтэн, яллагдагч нь хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлүүлэхээс татгалзах үр дагаврыг бий болгосон байна.

ЭХХШТ хуульд энэхүү байдлыг засч Яллагдагчийг хүсэлт гаргах үед Эрүүгийн хуулийн 5.5-р зүйлийн 4 дэх хэсэг, 6.7-р зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай танилцуулахаар хуульчилсан байгаа нь яллагдагчид энэхүү ажиллагааны талаарх анхан шатны ойлголт, хууль зүйн үр дагаврыг ойлгуулж байгаа явдал юм. Гэвч дээрх зохицуулалтанд “торгох” болон “нийтэд тустай ажил хийлгэх” ялыг хөнгөрүүлж оногдуулах үндэслэлийг дурьдаагүй байгаа нь энэхүү зохицуулалт зарим талаар асуудалтай гэж ойлгож байна.

### **Дөрөв. Прокурорын хяналт**

ЭБШ хуульд заасан “Хялбаршуулсан ажиллагаа”-ны хувьд хуульд заагдсан нотлогдвол зохих байдал (нотолбол зохих байдал)-ыг нэг бүрчлэн тогтоодоггүй байдлаараа онцлог ажиллагаа байсан ба яллагдагчийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг болон хохирогч хохирлын талаар маргаангүй тухай баталгааг үндэслэн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг байсан. Мэдүүлгэн нотлох баримтын хувьд гэмт хэргийн нөхцөл байдлын талаар илүү тодорхой, дэлгэрэнгүй, бүрэн дүүрэн мэдээлэл олж авах боломжтой төдийгүй бусад төрлийн нотлох баримтыг олж авах, түүнээс үл мөрийг хайж бэхжүүлэхээс харьцангуй хялбар<sup>169</sup> тул хялбаршуулсан ажиллагаанд мэдүүлгэн нотлох баримт дээр үндэслэн хэргийг шийдвэрлэдэг байсан байна.

<sup>166</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

<sup>167</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

<sup>168</sup> Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг (g)

<sup>169</sup> Хууль зүйн яам. “Нотолгооны онол”. УБ., 2013. 51 дэх тал

ЭХХШТ хуульд заасан Прокурорын хяналтын зохицуулалтанд прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай танилцаж хуульд заасан гурван нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянах хуулийн зохицуулалт нэмэгдэн орж ирсэн бөгөөд үүний нэг нь “гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэх<sup>170</sup>” тухай асуудал юм. Энэ нь ЭХХШТ хуульд заагдсан нотолбол зохих байдлуудыг заавал нотолсон байх гэх утгыг илэрхийлэх бөгөөд ердийн журмаар хэргийг шийдвэрлэх ажиллагаанаас төдийлөн ялгагдахааргүй байна.

Прокурор нь Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан эсэх талаар хянах ба гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг нь уг нөхцөлийг хангаагүй тохиолдолд хэргийг хялбаршуулсан ажиллагаагаар шийдвэрлэхгүй. Энэхүү зохицуулалтыг ЭХХШТ хуульд 2020 оны 01-р сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлтээр оруулж хуульчилсан ба үүнд “торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульд заасны дагуу хөнгөрүүлэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ” хэрэглэх талаар тусгасан байна. Прокурорын хяналтын шатанд дээрх нөхцөл байдлыг хянахаар хуульчилсан нь нэг талаар дутууг нөхсөн хэрэг боловч хүсэлтийг шийдвэрлэх үед яллагдагчид ял оногдуулах үндэслэлийг танилцуулахдаа торгох болон нийтэд тустай ажил хийх ялыг хөнгөрүүлж оногдуулах үндэслэлийг дурьдаагүй байгаа нь ЭХХШТ хуулийн 17.2-р зүйлийн 1 дэх хэсэг болон 17.3-р зүйлийн 1.2 дэх хэсэг нь хоорондоо зөрчилдөж байгааг харуулж байна.

ЭБШ хуульд тусгаснаар сэжигтэн, яллагдагч, хохирогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, эсхүл хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээс татгалзсан, хохирогч хохирлын талаар санал зөрсөн бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг байсан бол ЭХХШТ хуулиас хохирогч “хохирлын талаар санал зөрсөн, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан” гэх ойлголт хасагдсан буюу хуульчлагдаагүй байна.

Аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэнээр өөр бусад этгээдийн эрх, ашиг сонирхолд ямарваа байдлаар халддаг жамтай ба хохирогчид учруулсан хохиролыг арилгаж, зөрчигдсэн эрхийг сэргээснээр яллагдагч, хохирогч хоорондын харилцаа дуусна. Ингэснээр яллагдагч нь нийгэм, ёс суртахуунд харш, аюултай үйлдэл хийснийхээ үр дүнд хариуцлага хүлээх учир төр болон гэмт этгээд хоорондын харилцаа үлдэнэ. Эрүүгийн хариуцлагын зорилгод “гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино<sup>171</sup>” гэж заасан нь дээрхийг нотлох бөгөөд энэ нь гэмт этгээд, хохирогч, төр хоорондын харилцааг тодорхойлж байна.

Хялбаршуулсан ажиллагаа явуулж дуусан хэргийг шүүхэд шилжүүлэх хуулийн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт хийгдсэн нь “Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзвэл хэргийн зүйлчлэл, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээ, эсхүл ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналыг яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулж, яллагдагч зөвшөөрвөл гарын үсэг зуруулж...” хэмээн хуульчилсан нь нэг талаар яллагдагч өмгөөлөгч хоорондын харилцааг илүү бататгах нөгөө талаар өмгөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцоог нэмэгдүүлэх тал дээр чухал зохицуулалт болсон. Учир нь олон улсын хялбаршуулсан ажиллагааны практикаас үзвэл ялын тохиролцоо нь голчлон прокурор, өмгөөлөгч нарын хооронд явагдах зарчимтай бөгөөд өмгөөлөгч нь үйлчлүүлэгчдээ “хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгч, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр цаг алдалгүй өгөх, өмгөөллийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн агуулга, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах; үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар хориглоогүй арга, хэрэгсэл ашиглан шударгаар, тууштай хамгаалах<sup>172</sup>” үүрэгтэй тул яллагдагч нь хуулийг буруу ойлгохоос сэргийлэх, үйлдсэн гэмт хэрэг, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн дүүрэн ойлгоход чухал нэмэртэй байна. Мөн энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа практикт хуулийн дагуу, саадгүй хэрэгжихэд чухал ач холбогдолтой.

### **Тав. Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам**

ЭБШ хуулийн дагуу шүүх нь хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ тодорхой нөхцөл байдлыг хянахааргүйгээр заагдсан ба хэрэг хянан шийдвэрлэх явцад яллагдагч,

<sup>170</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.3 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг

<sup>171</sup> Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

<sup>172</sup> Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь хэсэг

хохилогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан тохиолдолд хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр хуульчлагдсан.

ЭХХШТ хуулийн хялбаршуулсан ажиллагаанд Шүүх хэргийг шийдвэрлэхдээ 6 төрлийн нөхцөл байдлыг хянах бөгөөд эдгээр нөхцөл байдлын аль нэг хангагдаагүй, эсхүл шүүгдэгч хүсэлтээсээ татгалзсан тохиолдолд хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргана.

Үүнээс асуудалтай зүйл нь:

1. 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “Яллагдагч хохирлоо нөхөн төлөхөө илэхийлсэн” гэх ойлголтыг хялбаршуулсан ажиллагааны журмаас халсан боловч шүүхийн шатанд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэхийлсэн эсэх” тухай хуулийн заалт одоог хүртэл байсаар байна.
2. ЭХХШТ хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4.3 дах хэсэгт заасан “Прокурорын сонгосон ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэх” нөхцөлийг прокурорын шатанд хянаж шийдвэрлэх нь зөв бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагч нь хүсэлт гаргаснаас бий болох хууль зүйн үр дагаврыг ойлгож ухаарах хангалттай боломжтой юм. Үүнийг батлах зүйл нь мөн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан “...шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргана” гэх хуулийн зохицуулалт юм.

### **Зургаа. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацаа**

Гэмт этгээд өөрийн хэргийг Хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтийг прокурорт гаргах ба хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол 14 хоногийн дотор мөрдөн байцаалтын ажиллагаа, ЭБШ хуульд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулдаг байсан нь хэвээр үлдсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн ажлын ачаалал болон бусад онцгой нөхцөл байдлаас хамаарч хэд хэдэн хугацаа өөрчлөгдсөн. Үүнд:

1. ЭХХШТ хуульд “даруй” гэх хугацааг тусгасан ба ЭБШ хуульд “тэр даруй”, “нэн даруй” гэх хууль зүйн цагууд үйлчилдэг байсныг 2015 онд халсан. “Даруй” гэх хугацааг ЭХХШТ хуульд зааснаар “боломжит богино хугацаа<sup>173</sup>” гэж тодорхойлсон байна.
2. ЭБШ хуульд шүүгч хэргийг хүлээн аваад 24 цагийн дотор хянаж, 72 цагийн дотор хэргийг шийдвэрлэж тогтоол гаргадаг байсан бол ЭХХШТ хуульд энэхүү хугацааг 7 хоног болгон сунгасан байна.

### **Долоо. Дүгнэлт, санал**

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн процессийн хууль зүйн практикт үр нөлөөтэй хэрэгжих талаас дараах саналыг дэвшүүлж байна.

- Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан нь мөн хуулийн 2.6 дугаар зүйлд “...хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж заасны дагуу гэмт хэргийн төрөл харгалзахгүй хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэх боломжтой байна. Энэ нь Хуулийн этгээд онц ноцтой, олон хүний эрх, ашиг сонирхол болон бусдын амь биед халдсан гэмт хэргийг үйлдсэн ч хялбаршуулсан ажиллагаагаар хэргийг шийдвэрлэх боломжит нөхцөл байдал үүсч байна. Иймд эрүүгийн хуульд хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт тусгай ангилалыг бий болгох нэн шаардлагатай;
- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй гэж тодорхойлсон нь нэг талаар гэмт хэргийг ангилал харгалзахгүй хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ гэх ойлголт юм. Энэ нь Эрүүгийн хууль дахь 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэх шударга ёсны зарчимд нийцэхгүй байх тул хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийг хялбаршуулахгүй тухай ЭХХШТ хуульд нэмэлтээр оруулж хязгаарлалт тогтоох;
- ЭХХШТ хуульд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ялтай гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж болохоор заасан боловч яллагдагчид ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай танилцуулах хуулийн хэсэгт торгох ял, нийтэд

<sup>173</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг

- тустай ажил хийлгэх ялыг үндэслэх тухай оруулаагүй нь ЭХХШт хуулийн 17.2-р зүйлийн 1 дэх хэсэг болон 17.3-р зүйлийн 1.2 дахь хэсэг нь хоорондоо зөрчилдөж байна. Иймд 17.2-р зүйлийн 1 дэх хэсгийг “Прокурор, мөрдөгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан яллагдагчид Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай..журмыг танилцуулна” гэж хуульчлах;
- ЭХХШт хуулийн 17.1-р зүйлийн 3 дах хэсгээс “...нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн...” гэх агуулга нь хасагдаж өөрчлөгдсөн боловч шүүхийн шатны хяналтын хэсгээс уг ойлголт хасагдаагүй байгаа нь энэхүү ажиллагаа практикт эргэлзээгүй хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байх тул 17.4-р зүйлийн 4.5 дахь хэсгээс “...нөхөн төлөхөө илэрхийлсэн...” гэх агуулгыг хасах;
  - Яллагдагч нь мөрдөн байцаалтын явцад хэргээ хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтийг гаргадаг бөгөөд энэ тохиолдолд прокурор, мөрдөгчийн зүгээс өөрт нь хэрхэн ял оногдуулах тухай ойлгуулж, танилцуулдаг. Мөн прокурорын хяналтын шатанд яллагдагч хүсэлтээсээ татгалзах, хэргийн зүйлчлэл, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санал зөрсөн тохиолдолд хэргээ ердийн журмаар шийдвэрлүүлэх эрхийг олгосон байна. Шүүхийн шатанд дахин энэ эрхийг олгосноор үргүй зардал үүсэх бөгөөд шүүхийн ачаалалтай байдлын хувьд ч сөрөг нөлөө үзүүлэх юм. Яллагдагч нь мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргээ хялбаршуулсан журмаар шийдүүлснээр үүсэх хууль зүйн үр дагаврын талаар мэдэх хангалттай боломжтой ба шүүхийн шийдвэр нь яллагдагч прокурортой тохиролцсон ялын хэмжээнээс дээш хэтрэхгүй юм. Энэ учраас шүүхийн шатны хянавал зохих нөхцөл байдлаас “Прокурорын сонгосон ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрөх” тухай хуулийн заалтыг хасах нь зөв гэж үзэж байна;

#### **Найм. Ном зүй**

Нэг. Хууль тогтоомж

- 1) Өмгөөллийн тухай хууль. 2019
- 2) Эрүүгийн хууль. 2015
- 3) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017
- 4) Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002
- 5) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1968.

Хоёр. Ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

- 6) Ч.Беккариа. “Гэмт хэрэг ба ялын тухай”. Орч Г.Эрдэнэбат. УБ., 2012
- 7) Хууль зүйн яам. “Нотолгооны онол”. УБ., 2013

# ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ГАЛТ ЗЭВСЭГ, ГАЛТ ЗЭВСЭГТЭЙ АДИЛТГАХ ХЭРЭГСЛИЙН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ, ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Ш.Чулуун

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн  
тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн ойлголт, ангилал, түүнийг хэрэглэх аргачлал, хэрэглэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорьсон.

**Түлхүүр үг:** Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг, эрх зүйн зохицуулалт, хэрэглэх үндэслэл.

2015 оны Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсгийн тодорхойлолт, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа галт зэвсгийн талаар дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Галт зэвсэг гэж дарини шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг;
- Байлдааны зориулалттай галт зэвсэг гэж байлдааны болон тусгай ажиллагаанд ашиглах зэвсэг, галт хэрэгсэл, түүний эд ангийг;
- Хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг” гэж цагдаа, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх байгууллага, эсхүл тагнуулын байгууллагын мөрдөн шалгах, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагчийн эзэмшиж байгаа галт зэвсгийг;
- Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг;
- Үйлдвэрийн хийцийг өөрчлөх гэж галт зэвсгийн гол төмөр, замаг, их бие буюу хайрцаг ангийг өөрчилснийг;
- Сум гэж галт зэвсэгт зориулагдсан хонгио, бялт, дарин цэнэг, хошуу бүгд нэг биет болж угсрагдсан, эсхүл гол төмөрт хийж буудлага үйлдэх зориулалттай бүрдэл хэсгийг;
- Сумны зүрхэвч гэж хуяг нэвтлэх чанарыг сайжруулахын тулд тусгай хайлшаар хийж сумны дотор байрлуулсан хэсгийг
- Буудлага үйлдэх байгууламж /тир/ гэж галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслээр спорт-сургалтын дадлага хийх болон энэ хуульд зааснаар ашиглах зориулалтаар тоноглож зассан орчныг хэлнэ<sup>174</sup> гэж тус тус тодорхойлжээ.

Харин галт зэвсгийг ашиглаж байгаа зориулалтаас хамаараад дараах байдлаар ангилсан байна.<sup>175</sup> Үүнд:

- Иргэний
- Харуул хамгаалалтын
- Хууль сахиулах албаны
- Байлдааны

Ан агнах, буудлагын спорт-сургалтаар хичээллэх, үзмэр, цуглуулгын зорилгоор Монгол Улсын иргэний өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсгийг **иргэний зориулалттай галт зэвсэг** гэнэ. Ан агнах зорилгоор ашиглах галт зэвсэг нь автоматаар, эсхүл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг нь өөрчлөөгүй галт зэвсэг байх бөгөөд сумны хошуу нь зүрхэвчгүй байна.

Спорт-сургалтын зорилгоор ашиглах галт зэвсгийн сумны хошуу нь зүрхэвчгүй байна. Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээд зөвхөн үзмэр, цуглуулгын болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор иргэний зориулалттай галт зэвсэг өмчилж болно.

Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, байгаль хамгаалагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор өмчилж, эзэмшиж байгаа галт

<sup>174</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт

<sup>175</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт



зэвсгийг харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг гэнэ. Харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг нь автоматаар буудах боломжгүй, сумны хошуу нь зүрхэвчгүй байна.

Хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна гэжээ.<sup>176</sup>

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль сахиулах байгууллагын санал болгосноор хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг, сумны төрлийн жагсаалтыг баталж, улсын хилээр оруулах зөвшөөрөл олгоно.

Тусгай ажиллагаанд хэрэглэхээс бусад тохиолдолд хууль сахиулах байгууллагын албаны зориулалттай галт зэвсгийн сумны хошуу нь зүрхэвчгүй байна. Тусгай ажиллагаанд зүрхэвчтэй хошуу бүхий сум хэрэглэж болно гэж алба хаагчийн албаны үүрэг гүйцэтгэх нөхцөл байдлаас шалтгаалж зааг, ялгааг нь нарийвчлан тусгаж өгчээ.<sup>177</sup>

Галт зэвсгийн тухай хуулинд хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна гэж заасны дагуу Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэж буй алба хаагчид шаардлагатай тохиолдолд албаны галт зэвсэг тавьж олгодог.

Албаны галт зэвсгийг хэрэглэх эрх, үндэслэлийг нь Цагдаагийн албаны тухай хуульд тусгайлан заасан. Тухайлбал, Галт зэвсэг хэрэглэх сургалтад хамрагдан, галт зэвсэг хэрэглэх эрх олгогдсон цагдаагийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг хадгалах, биедээ авч явах, хэрэглэх эрхтэй гэж зааж өгчээ.<sup>178</sup>

Цагдаагийн алба хаагчийн галт зэвсэг хэрэглэх үндэслэлийг нь хуулиар дор дурдсан нөхцөл байдал бий болсон үед хэрэглэхээр нарийвчлан тусгасан. Үүнд:

- Өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж байдлаар довтолсон, тээврийн хэрэгсэл унаж зугтаан бусдын амь нас, эд хөрөнгөд бодит аюул бий болгосон;
- Цагдаагийн байгууллагад зэвсэглэн, эсхүл бүлэглэн халдсан, эсхүл цагдаагийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон;
- Төрийн тусгай болон эрх бүхий байгууллагын хамгаалалтад байгаа хүн болон бүс, объектод зэвсэг хэрэглэж, эсхүл бүлэглэн довтолсон;
- Хулгайлагдсан, барьцаанд байгаа хүнийг суллах;
- Галт зэвсэг, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- Хуяглан хүргэж яваа сэжиг бүхий этгээд, яллагдагч, шүүгдэгч, ялтанг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;
- Саатуулах, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон;
- Бусдын албаны болон орон байранд зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон хүний дайралтыг таслан зогсоох, эзлэн авсныг чөлөөлөх;
- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, хамгаалсан;
- Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах;
- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах;
- Хоригдож байгаа этгээд, хоригдол оргон зугтсан, эсхүл зэвсэглэсэн хоригдлыг баривчлах гэж тус тус заажээ.<sup>179</sup>

Мөн цагдаагийн байгууллага харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж, мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгаа, сургалт дадлагын, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори<sup>180</sup> болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт, спорт, соён гэгээрүүлэх, мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй байж болно.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл, бусад онцлогийг харгалзан цагдаагийн байгууллагын

<sup>176</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт

<sup>177</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт

<sup>178</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58. 1дэх заалт

<sup>179</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57. 1дэх заалт

<sup>180</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг

бүтэц, орон тооны болон автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг<sup>181</sup> Засгийн газар тогтооно.

Өөрөөр хэлбэл дотооддоо тусгайлан тоногдсон тусгай зориулалтын лаборатори болон тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативын талаар үндэсний стандартыг баталж албанд мөрдүүлэх ажлыг зохион байгуулахаар хуулийн зохицуулалтыг тусгаж өгчээ.

Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх зааврыг Дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална<sup>182</sup> гэж хуулинд тусгасан байна.

Тус хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаал<sup>183</sup> батлагдан гарчээ.

“Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т албан хаагч галт зэвсэг хэрэглэх аргачлал, анхаарах зүйлийн талаар тусгаж өгсөн. Тухайлбал,

- Цагдаагийн алба хаагчаас боломжтой бүх тохиодолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө зохих этгээдэд урьдчилан сануулна. Сануулга өгөх нь цаг алдаж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийг шууд хэрэглэж болно.
- Цагдаагийн албаны тухай хуулийн 58.3.1-д заасан галт зэвсгээ бэлэн байдалд авахдаа буунд дайзыг угсарч, замаг татаж гол төмрийн хоолойд сум оруулан, бууны хошууг цээжний урд аюулгүй зүгт харуулан гохны хажуу замагны дагуу хурууг байрлуулсан байна.<sup>184</sup>
- Алба хаагчдад галт зэвсэг тавьж олгохдоо тэдгээрийг холбогдох сургалтад заавал хамруулж, шалгалт авсны дараа Цагдаагийн байгууллагад ашиглахаар бүртгэсэн галт зэвсгийг олгоно гэжээ.

Өөрөөр хэлбэл, алба хаагч нь цагийн байдалд үнэлэлт өгөн оновчтой шийдвэр гаргах, галт зэвсэгтэй харьцах аюулгүй ажиллагааны зааврыг чанд сахин галт зэвсэг хэрэглэх, өөрийн эзэмшиж буй галт зэвсгийг чадамгай ашиглах талаар зааж өгчээ.

Мөн алба хаагч галт зэвсэгтэй албан үүргээ гүйцэтгэх үедээ Цагдаагийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийг<sup>185</sup> удирдлага болгон ажиллана. Үүнийг тодотгон авч үзвэл:

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх алба хаагчид нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэл, галт зэвсэг олгох бөгөөд алба хаагч нь олгосон тусгай хэрэгсэл, галт зэвсгийг биедээ авч явах эрхтэй.<sup>186</sup>

Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, биедээ авч явах, олгох журам болон галт зэвсэг байнга биедээ авч явах эрх бүхий алба хаагчийн, хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг цагдаагийн төв байгууллагын дарга батална<sup>187</sup> гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, албан үүрэг гүйцэтгэлийн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалж алба хаагчид галт зэвсэг тавьж олгох, галт зэвсэг биедээ авч явах албан тушаалтан болон зэвсэг тавьж олгох албан тушаалтныг нарийвчлан заасан зохицуулалт хийж өгсөн байна.

Галт зэвсгийн тухай хуулинд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журмыг цагдаагийн төв байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална<sup>188</sup> гэжээ.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн сайдын А/249 тоот тушаал<sup>189</sup> батлагдан гарсан бөгөөд түүнд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт болон ойлголтыг дараах байдлаар тусган өгчээ. Үүнд:

<sup>181</sup> “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 26-р тал

<sup>182</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 47-р зүйлийн 47.4 дэх заалт

<sup>183</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

<sup>184</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 6-р зүйлийн 6.3 дахь заалт

<sup>185</sup> Алба хаагчийн агсамж

<sup>186</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 60-р зүйлийн 60.3 дахь заалт

<sup>187</sup> “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 52 дахь тал

<sup>188</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт


- Шахагдсан хийн даралтын хүчээр хошуу буюу үрлийг гол төмрөөс шидэх зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй хийн буу;
- Амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, цочироох үйлчилгээ бүхий химийн бодис ашиглах зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;

Тайлбар: “Тусгай хэрэгсэл” гэж хүний аминд үл хүрэх гэмтэл бэртэл учруулах, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, цочироох зэвсгийг ойлгоно. Тухайлбал:

- Чанга дуу чимээ, гэрэл гаргах зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй дохионы хэрэгслүүд;
- Сумны хошуу нь дангаараа буюу утсаар дамжуулан цахилгаанаар цохих үйлчилгээ үзүүлэх зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;
- Сумны хошуу нь резинэн, хуванцар, давуу болон бусад төрлийн материалаар хийгдсэн цохих /гэмтээх, бэртээх/ зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;
- Зэвт хошуу бүхий сумаар харвах зориулалттай хавчаахай /нумт буу/ гэж тус тус тодорхойлжээ.

Дээр дурдсан галт зэвсэгтэй адилтгах зарим нэр төрлийн хэрэгслийг цагдаагийн байгууллага нь албаны үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тухайлбал,

**Цахилгаан гүйдлээр цохигч буу**



Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх аргачлалын талаар тусгажээ. Үүнийг тодруулбал:

- Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар чиглүүлэн, байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьманд 5 секундээс илүүгүй байхаар тооцох;
- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд боломжтой бүх тохиолдолд хүний биеийн ил харагдах хэсэгт хэрэглэхгүй байх;

<sup>189</sup> Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/249 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт”

- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны үйлчлэл нь хүний биеийн булчинлаг хэсэг зангирах өвдөлт өгөх, мэдрэлийн систем түр сарних хэлбэрээр 5 минут үйлчлэх бөгөөд 20 минутын дараа үйлчлэл бүрэн арилна.
- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны хэвийн ажиллагаа, унтраалгыг шалгаж, ажиллуулах бөгөөд бороо, устай газарт хэрэглэхээс зайлсхийх, чийгтэй газарт хадгалахгүй байх;
- Цахилгаан гүйдлээр цохигчийн дуу, чимээг ашиглаж болох бөгөөд нэг дор 1-5 секундээс илүү хугацаагаар ажиллуулахаас татгалзах нь зүйтэй гэжээ.<sup>190</sup>

Мөн Цагдаагийн Ерөнхий газрын даргын баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд<sup>191</sup> төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн шуурхай удирдлагын албанд албаны бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд байвал зохих галт зэвсэг, тусгай хэрэгслийн талаар тусгайлан заасан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 200.546-хавсралтад “Жижүүр дээр байвал зохих зэвсэг, хэрэгслийн жагсаалт”-ыг дараах байдлаар байхаар зааж өгчээ.

**Цагдаагийн байгууллагын жижүүрт байх зэвсэг техник, тусгай хэрэгсэл:**

№	Зэвсэг техник, тусгай хэрэгсэл	Ширхэг
1.	Мэргэн буудагчийн винтов	1
2.	Автомат АКМ буу 60 сумтай /2/	1
3.	9 мм-ийн Макаров гар буу /тус бүр 16 сумтай/	2
4.	Сүм үл нэвтрэх хантааз	2
5.	Бугуйн гав /үүний нь 2 нь монгол гав байх/	4
6.	Ороох цамц	2
7.	Хүлэг	4
8.	Резинэн бороохой	6
9.	Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн шүршигч	2
10.	Хийн буу	2

Дээр дурдсан галт зэвсгийн жагсаалтаас дүгнэж үзэхэд цагдаагийн байгууллага нь албандаа олон нэр төрөл, загварын галт зэвсгийг хэрэглэж байгаа гэх боловч энэ нь зөвхөн тодорхой нэгж дээр ашиглагдаж байна. Тухайлбал ЦЕГ-ын Тусгай ажиллагааны газрын алба хаагчид тусгай үүрэг гүйцэтгэхдээ олон улсын цэрэг, цагдаагийн байгууллагын зэвсэглэмжинд байдаг зарим нэр төрлийн галт зэвсэг хэрэгслийг хэрэглэж байна.

Харин төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаа болон бэлэн байдлын хүрээнд ашиглах албаны галт зэвсэг нь өнөөдрийн байдлаар ОХУ-д үйлдвэрлэсэн зэвсэглэл байна. Тэр дундаа 9 мм-ийн ПМ /Пистолет Макаров/ гар буу, 7,62 мм-ийн АКМ /Автомат Клашников Модернизация/ буюу цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ түгээмэл ашиглаж байна.

Цагдаагийн алба хаагч нь албанаас тавьж олгосон галт зэвсгийг хуулинд заасан үндэслэл журмын дагуу зайлшгүй тохиолдолд эцсийн шатны арга хэмжээ болгож хэрэглэнэ. Алба хаагчаас галт зэвсэг хэрэглэхдээ дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд:

- Юуны өмнө галт зэвсэг хэрэглэх үндэслэл, шаардлага байгаа эсэхийг тогтооно.
- Хүрэх үр дүн үүсэх үр дагаварыг нарийн тооцох нь чухал гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй.
- Бусад төрлийн арга хэрэгсэл хэрэглээд тодорхой үр дүнд хүрээгүй нөхцөлд л хүч, галт зэвсэг хэрэглэнэ.
- Цагдаагийн алба хаагч бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.
- Галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай, байрлал тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардахдаа тухайн хүний сэтгэл зүйд нөлөөлөхүйц чанга дуугаар хэлж буудна.
- Цагдаагийн эрх бүхий албан тушаалтан, хэзээ хаана, хэнд галт зэвсэг олгогдсон, юунд ашиглагдаж байгааг хянаж байх ёстой бөгөөд онц хүнд гэмт хэрэг гарсан үед болон галт зэвсэг хэрэглэх магадлалтай үед галт зэвсгийг зохих журмын дагуу тавьж олгодог

<sup>190</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3-р зүйлийн 3.14 дэх заалт

<sup>191</sup> ЦЕГ-ын даргын 2017.12.28-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-200 “Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа”

бөгөөд түүнийг хэрэглэх, хэрэглэж болзошгүй ажиллагаа дууссан үед галт зэвсэг болон сумыг тоо ёсоор нь даруй хураан авдаг байх шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч нь албаны галт зэвсгээр буудлагын дасгал, сургуулилт хийж байгаа үед буудлагын үеийн аюулгүйн арга хэмжээний зааврыг ямагт сахин биелүүлэх үүрэгтэй. Энэ нь алба хаагчийг галт зэвсэгтэй зөв харьцах, буу зэвсгээ зохих журмын дагуу эзэмшихэд чухал ач холбогдолтой алхам болж өгдөг.

ЦЕГ-ын даргын баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд<sup>192</sup> зааснаар буудлагын үеийн дараах аюулгүйн арга хэмжээний зааврыг алба хаагч чанд баримтлана гэжээ. Үүнд:

- Буудлага хийж байгаа бие бүрэлдэхүүн буудлагын хэсгийн удирдагчид шууд захирагдана.
- Буудагч бүр өөрийн эзэмшиж байгаа зэвсгийг хүнд дур мэдэн шилжүүлэх, энд тэнд сул тавихыг хориглоно.
- Буудлагын үед буунд гацаа гарвал буудлагын хэсгийн удирдагчид “нөхөр дэд хурандаад –Буу гацлаа” гэж илтгэнэ.
- Буудаж дууссан буудагч буудлагын хэсгийн удирдагчид “Нөхөр дэд хурандаад –Буудаж дууслаа” гэж илтгэнэ.
- Буудлагын талбай буюу хаа нэгтгэйгээс байлдааны /хоосон/ зориулалтын сум олсон хүн буудлагын хэсгийн удирдагчид сум олсон тухайгаа илтгэнэ. Нуун дарагдуулахыг хатуу хориглоно.
- Бууг сумтай ч бай, сумгүй ч бай хэн нэгэн хүн, амьд амьтан руу шагайх болон буудахаас бусад тохиолдолд бууг дур мэдэн сумлахыг хориглоно.
- Буудаж дууссаны дараа буудагч бүр өөрийн бууны сумны байранд /хоолойд/ сум байгаа эсэхийг заавал шалгах, шалгуулах үүрэгтэй.
- Буудлагын талбайд гэнэт илэрч гарч ирсэн хүн, малыг буудлагад өртөхөөс хамгаалахын тулд буудлага хийж байгаа байгууллагаас хянагч томилж хяналт тавина.
- Буудлага зогсоо буюу цагаан дарцаг өргөсөн үеэс хойш буудлага хийхийг хатуу хориглоно гэж нарийвчлан заалт болгон тусгаж өгсөн байна.

### **Дүгнэлт**

Цагдаагийн алба хаагчийн албаны бэлэн байдал, аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд сургалт, дадлагыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь тухай бүр үр дүнтэй зохион байгуулж галт зэвсэгтэй харьцах ур чадвар, дадлыг алба хаагчдад бий болгох, холбогдох хууль тогтоомжийг сайтар судлуулан онолын мэдлэг олгох нь аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үндсэн нөхцлийг бүрдүүлэх юм.

Ялангуяа галт зэвсэг байнга биедээ авч явах эрх бүхий алба хаагч нарт холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаанд албаны сургалтыг тогтмол үр дүнтэй явуулах нь албаны бэлэн байдлыг хангах нэг хөшүүрэг нь болно.

### **Ном зүй**

Нэг. Хууль тогтоомж:

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
- Галт зэвсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2015.08.07
- ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/249 дүгээр тушаалын 1-р хавсралт “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт”
- ЦЕГ-ын даргын 2017.12.28-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-235 “Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох, буудлага хийх журам
- ЦЕГ-ын даргын 2017.12.28-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-200 “Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа”

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

- Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019

5) A loan contract is reflected in the following manner in the Articles 281-285 of the Chapter 24 of the Civil Code<sup>28</sup> of Mongolia which was approved in 2002:

---

<sup>220</sup> Article 265, Chapter 9 of the People's Republic of Mongolia, 1963, Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012. page 180.

<sup>221</sup> Article 269, Chapter 9 of the Civil Code of the People's Republic of Mongolia, 1963, Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012. page 180.

<sup>222</sup> Article 270, Chapter 9 of the Civil Code of the People's Republic of Mongolia, 1963, Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012. page 181.

<sup>223</sup> Civil Code of Mongolia, 1994, Chapter 6, Article 88: Rights of a Non-Owner 1. A non-owner shall possess, use and govern of its property, intellectual property and rights in accordance with the direction of its activity within the powers granted by the owner defined by law or contract.

<sup>224</sup> Article 229, Chapter 23 of the Civil Code of the People's Republic of Mongolia, 1994, Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012. page 296.

<sup>225</sup> Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012. pages 325 and 326.

Under a loan contract, a lender shall be obligated to transfer to the ownership of borrower money or other property that shall be determined by characteristics of type, and a borrower shall be obligated to return the property of the same type, amount, quality, and quantity or money that was received by him/her within the negotiated period.

Under a loan contract, parties may negotiate and determine the interest.

If interest rate is set, loan contract shall be concluded in written form. If this requirement is not satisfied, right to receive interest shall be lost. Loan contract shall be deemed concluded after transferring money or other property to the borrower.

If the time of loan repayment is not fixed by the contract, borrowers shall be obligated to repay the loan on lender's request within one month from the time of request.

If interest rate was not fixed by the contract, the borrower may repay the loan before expiration date specified in the contract. If interest rate was fixed in the contract, borrowers may repay the loan with interest rates only if the interest rate was fixed by contract with the lender's consent.

Unless otherwise provided by contract, the interest rate must be paid each year.

If financial situation of the lender deteriorates and the borrower failed to perform obligations, lender is entitled to demand immediate repayment of the loan.

If circumstances prior to conclusion of the contract, but the lender becomes aware of it after concluding the contract, he or she shall be entitled to demand immediate return of the loan.

If certain circumstances arise under which a borrower may fail to repay a loan due to deterioration of assets' condition, the party that promised to grant the loan shall be entitled to refuse to give the loan.

Relations to give a loan under the pledge procedure are regulated in the Article 286 of the Chapter 24 of the same law as follows:

In order to ensure the fulfillment of loan contract obligations, lender shall be entitled to require immovable property collateral.

Interest rate on a pledged loan shall be determined by parties.

In case, if the borrower fails to repay the loan and interest on time, the lender shall immediately notify borrower in writing of intention to sell mortgaged property to ensure obligation fulfillment. If the borrower fails to perform its obligations within 10 days from the date of notification, pledged property may be sold on a commission basis or auction sale, and proceeds shall be used to perform obligations, and remaining money shall be returned.

Lender is obligated to ensure full safety of mortgaged property but it shall not have the ownership or disposal rights.

Contract for a loan with collateral issued by a lender shall be concluded in writing. A contract not complying with this requirement shall be deemed void.

The Articles 451, 452 and 453 of the Chapter 45 of the same law regulate the loan issuance relations of a bank and legal entity entitled to give loans:

Under a loan contract a bank or credit agency (thereafter "creditor") shall undertake to transfer to the borrower financial assets for certain period of time and according to grounds and procedures set out in law; and the borrower shall undertake to return that sum within the agreed duration and to pay interest if specified in the loan contract.

The loan contract shall be concluded in the written form and the loan from lender may have interest or no interest.

It can be specified in the contract that the borrower shall pay an additional interest but not exceeding 20% of the main interest in case of failure to repay the loan in contract period. The bank or credit agency shall not impose fines for issued loans.

The lender is obliged to make the public known its loan interest rate.

The borrower shall pay interest and, if provided by the contract, additional interest in case of failure to repay the loan on time. In case, if the borrower fails to fulfill its obligations under the loan contract and if the contract provides that the pledge shall be transferred to the lender without dispute, the lender shall exercise the right of disposal over the pledged assets on the next day after the contract expiration.

### **3. Current state of loan contract and its pressing issues**

In 2014, when the economy collapsed, "money lender" provided loans to citizens with a 5-20 percent interest rate and a large amount of public entered into a debt network. For example, citizen D. who received a loan of 2 million MNT /Mongolian national currency/, paid a sum of 4.7MNT million and was reprimanded by a loan from somebody else, and then he was sentenced to a sentence of

fraud. Also, a person who lent 1000 000 MNT /a million tugrug/ is paying 72 000 MNT every day. Thus, the "money lender" or borrower receives a monthly net income of 300-400 million MNT from lenders.

Some researchers believe that widespread interest rate loan service from unlicensed, unregistered entities, especially from individuals, creates a negative impact on the society as well as creating inequalities in the legal regulation, then meeting the financial service needs of citizens.

In other words, money lenders may be victims of fraud, as well as those with short-term and high-interest loans could get pressure from high-interest rates or from economic exploitation.

As stated in clause 282.2 of Civil Law "If the interest rates are clearly detrimental to the rights and legitimate interests of the borrower, the court may reduce the loan interest rates at its request", but the lawyers conclude that there is not enough coordination to protect the legitimate rights of the contracting parties. Thus on December 3, 2015, the "Amendments Law to Civil Law" was approved and the rights of interest-bearing loans were granted only to commercial banks, banks, and financial institutions, and the lending service with interest rates between individuals are banned.

Some researchers have argued that these regulatory amendments in the civil code have diminished money in the market and not a wise decision without considering the financial needs of their citizens in today's weakened condition of the country's economy by allowing the loans only for commercial banks and financial institutions.

"To keep open these issues regarding the transferring or lending money and the loan with interest among citizens is the best way in today's Mongolia's economy." The loan agreement is one of the most common types of contracts between citizens and is usually established with interest rates. There was also a lawyer who criticized the Civil Code amendments as unacceptable, which limit the possibility of individuals to receive interests for issuing a loan for others.

In other words, the implementation of the new Civil Code will have many negative consequences for social, economic and contractual relations. Due to the high demand for loans from the commercial banks with high criteria and requirements and with the time-consuming long procedure, the private entities and individuals prefer more loans from individuals. In this sense, some of the lawyers said that the loans offered by citizens are supporting the cash flow, filling the gap of cash deficiency in the market, which seems a natural tool for the market procedure. On the other hand, interest rates are of great significance in paying the loan contract in time. In 1994, the Civil Code prohibited establishing a loan agreement with the interest rate, which was revised in 2002 by the revised Civil Code. This amendment stated that the loan agreements could be made with or without interest.

The Constitutional Court of Mongolia discussed the relevant provision of the Law on Amendments to the Civil Code issue on May 25, 2016, and evaluated it as "Violation of the Constitution" and suspended the regulation and subsequently abolished the related part.

Even today, the "day" borrowers or "money lenders" are lending to citizens and the citizens are getting subject to credit, interest or economic exploitation.

Thus, there is still debate among lawyers and researchers in Mongolia whether or not the individual may be a lender.

In addition, over 100,000 households nationwide have mortgage loans and repayment of mortgage is a big problem for people with mortgage loans.

One person criticized the unfair repayment of mortgage loans. Specifically, 3 years ago he received 8 percent loan for 80 million MNT housing. During this time, 24.5 million MNT was paid to the bank, but the principal loan rest amount is still MNT 75.7 million. Only for interest rate he paid 20.2 million MNT for the last 3 years.

But I have read news from the website of Business inside of Austria about "A Danish bank is offering mortgages at a 0.5% negative interest rate — meaning it is basically paying people to borrow money<sup>226</sup>." Jyske Bank, Denmark's third-largest bank, said this week that customers would now be able to take out a 10-year fixed-rate mortgage with an interest rate of -0.5%, meaning customers will pay back less than the amount they borrowed. For example, If you bought a house for \$US1 million and paid off your mortgage in full in 10 years, you would pay the bank back only \$US995,000.

A draft law<sup>227</sup> on setting the maximum loan interest rate and combating the loan-sharking has currently been submitted to the Parliament of Mongolia but it has been pending whether it will be discussed at a Parliamentary session.

---

<sup>226</sup> <https://www.businessinsider.com.au/danish-bank-offers-mortgages-at-negative-interest-rates-2019-8>

<sup>227</sup> <http://forum.parliament.mn/projects/295>

Objectives of the draft law have been defined to set the maximum loan interest rates of banks and non-bank financial institutions and to establish the legal grounds for the draft law implementation related activities.

Besides, the objectives of this draft law focus only on the activities of banks and non-bank financial institutions but exclude and omit the loan relations between individuals or citizens.

The draft law reflects the definitions of terminologies including “maximum loan interest rate”, “bank and legal entity entitled to give loans”, and “loan sharking” and distinctively set the maximum loan interest rates as follows:

1. Maximum interest rate of small and medium sized enterprises promotion loans up to MNT 100 million – 18% per annum;
2. Maximum interest rate of salary loan – 18% per annum;
3. Maximum interest rate of pension loan – 12% per annum;
4. Maximum interest rate of other types of loans – 24% per annum.

The draft law also forbids loan-sharking for credit activities, prepayment of loan interest, loan issuance fee, loan extension fee, cash issuance fee, and other kinds of fees.

The draft law developers consider that the following positive consequences will be achieved as a result of approving this law:

- High rate of the loan interest will be reduced and loan-sharking activities will be regulated and limited;
- Business operating cost will be declined, profits and accumulations will be maximized, business environment will be improved, solvency will be upgraded, tax base will be extended, and budget revenue will be increased;
- Loan interest for individuals especially for traders will be reduced extremely and important impacts will be exerted on improvement of the living standards.
- Capital accumulation and financial resource allocation will be oriented correctly or to the creation not to the loan-sharking.

However, some economists and researchers do not accept this draft law and consider that the forced reduction of loan interest will cause reduction in loan issuance and shrink the economy<sup>228</sup>. It is more important to take pragmatic, fundamental and rational measures rather than forced and temporary measures to lower loan interest rates. Some people consider that higher interest rates are due to the Mongolian tugrug against US dollars over the policy rate and inflation.

#### 4. Conclusion

The Civil Codes of Mongolia has been regulating the loan contacts as follows:

1. Participants of the loan contract and their rights and obligations were defined for the first time in accordance with the Civil Code of the Mongolian People’s Republic (MPR) which was adopted in 1926. Besides, it was stated that a loan contract can be oral or written and a contract of loan amounting to MNT 1,000 (one thousand) will be deemed valid if concluded in the written form and certified by the notary public. It was not specifically specified to issue a loan with or without interest but it was specified to pay six “mungu” (a monetary unit of Mongolia, equal to one hundredth of a tugrug) for each one tugrug of the interest for the overdue period per annum if exceeded the repayment period. Furthermore, it was prohibited to borrow human essential items, to consider as invalid a contract set out in order to raise the loan value, and to entitle the court to invalidate the contract if it was identified as ineffective for the borrower or economically exploited. Those were the special regulations of this Civil Code.

2. According to the socialist style Civil Code which was approved in 1953, it was required to conclude a contract for the loan amounting to more than MNT 50 in the written form<sup>229</sup> and a loan can be issued with or without interest.

3. According to the Civil Code adopted in 1963, regulation of a loan contract reflected the issues on overexcitation in the ideological sphere, strengthening the centrally planned economic system, developing state-owned properties, restricting the ownership rights of individuals and strengthening the dominance of two forms of the public socialist properties - state and cooperative properties. For instance, loan issuance of the state, cooperative and public institutions was regulated for particular purposes in accordance with the plan approved by the MPR bank and under the specified procedures. However, in comparison with previous laws, the 1963 Civil Code attempted to

---

<sup>228</sup> <https://dnn.mn/>

<sup>229</sup> The law does not mention whether to get a loan contract notarized, so it is not required to get the loan contract approved by a notary public.

establish in detail the obligations and responsibilities of a loan contract and to regulate the loan contract relations under a special regulation.

4. The Civil Code adopted in 1994 had fundamentally changed the form of ownership, strengthened the forms of private and public properties, defined the rights and obligations of a borrower and lender in a loan contract and methods and liabilities for ensuring the contract, and specifically specified the bank's loan issuance relations. A loan contract was legalized to be concluded in the written form although the form of a loan contract between individuals was not specified.

Besides, a bank loan was specified to be given with and without interest. However, it was stated to repay the amount of principal loan amount regardless of the change in the exchange rate. It was regulated to allow interest-free loans between citizens and to entitle the lender to demand the borrower to pay an undue loss payment if exceeded the loan repayment date.

5. The Civil Code approved in 2002 provided more detailed regulation on cash and property loan contracts than any other law and specifically legalized the regulation of loan contracts to be concluded by individuals, legal entities including banks, institutions entitled to give loans and pawn shops. For instance, the basic consumption of the loan contract set forth in the Article 281 of the Civil Code is a cash loan contract. In this case, the Articles 451 and 453 of this law contain specific regulation for a cash loan contract which will apply when a loan is issued by a bank or a legal entity entitled to give loans. In case, if a bank or any other institution to give a loan did not take part in the loan contract, the Articles 281-286 of the Civil Code will apply. The Article 286 of the same law was regulated to apply when a pawn shop gives a loan.

Furthermore, it legalized the special requirements for establishing a loan contract or a bilateral agreement. If a cash loan contract was concluded to charge interest, the contract must be made in the written form. This regulation applies not only to the cash loan contract but also to a loan contract on other property to be determined by the same type. If the contract was not made in the written form, the lender is not entitled to demand the obligation fulfillment. In other words, the borrower will take the loan for "free of charge".

The Articles 284 and 285 of the Civil Code specifies the lender's prevention from the risk where the party that will take a loan becomes insolvent to repay the loan due to the deterioration of its asset status.

Clause 282.2 of the Article 282 of the Civil Code states, "If interest rate was set in the amount obviously damaging damage to the right and legitimate interests of borrower, then Court may reduce the interest rate at the borrower's request". It was intended to provide creditors with opportunities to approach the court for its counter obligation or in particular to reduce the interest rate. The court must take into account the principle set out in Clauses 56.1.1 and 56.1.4 of the Article 56 of the Civil Code in case of reducing the agreed interest rate of the loan contract or the amount of other liability<sup>230</sup>.

Thus, the Civil Codes of Mongolia retained its own features in line with the social rules and inherited and enriched the previous laws.

Besides, various measures have been taken against interest rate pressure and loan-sharking challenging Mongolian citizens and legal entities.

For instance, a draft on amending the Civil Code of Mongolia was adopted on December 3, 2015 and loans between individuals were ceased but the amendment was voided on May 7, 2016 under the conclusion No 7 of the Constitutional Court which considered it as violating the Constitution of Mongolia.

Besides, a draft law on setting the maximum loan interest rate and combating the loan-sharking has been submitted to the Parliament in order to restrict the loan interest of banks and legal entities which run non-bank financial activities. However, it is inappropriate to consider the above measures or legal regulations as rational measures against the loan-sharking.

Finally, does our country need a law on setting the maximum interest rate and combating loan-sharking or should we establish other legal relations or should we impact on the economic and legal education, formation and ethics of the population of Mongolia? In the Civil Code of Mongolia, it has

---

<sup>230</sup> Article 56 of the Civil Code. Void transaction

Clause 56.1.1 of the Article 56: A transaction which breaches law or contradicts commonly accepted or behavioral norms;

Clause 56.1.4 of the Article 56: A transaction made to represent a specific will, without genuine intention, with recklessness, and with foresight of its disclosure.

been required to answer many questions whether the required regulation of a loan contract was reflected completely or whether to amend it.

I hereby end my article by raising the above issues in order to determine the modern trends which protect the interest of lenders and borrowers, meet the legal interest, and prevent economic exploitation and money laundering.

## References

1. The Constitution of Mongolia, 1992; <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>
2. The Civil Code of Mongolia, 2002; <https://www.legalinfo.mn/law/details/299?lawid=299>
3. Interpretation of the Civil code of Mongolia /general provisions/, Ulaanbaatar, 2005
4. Dr. J. Boldbaatar and D. Lundeejantsan, Historical Tradition of the Mongolian State and Law, Ulaanbaatar, 2011
5. Encyclopaedia of Mongolian History - <https://mongoltoli.mn/history/>
6. Ikh Zasag Law - <https://ikhzasag.edu.mn/storage/app/media/pdf/lawlist.pdf>
7. Ts. Surenjav and P. Tsagaan, "The Khalkh-Oirat Law", Ulaanbaatar, 2018
8. B. Bayarsaikhan, B. Batbayar, B. Oyunbileg, The Khalkh Joram Law, Ulaanbaatar, 2009
9. Main issues of the Civil law by Naranchimeg.D, Ulaanbaatar, 1999
10. Legal Reform of Mongolia – 8 years. A chapter of the Legal Reform History. Compilation of reports and recommendations. Ulaanbaatar, 2003
11. Civil Legislation of Mongolia, (Historical Bulletin), 1206-2012, Compiled by Z. Sukhbaatar, B. Batbayar, P. Oyundelger, UB, 2012
12. Some issues of Mongolian political and legal thinking, Ulaanbaatar, 2002
13. T.Munkhjargal. Legal regulation of economic relations. Ulaanbaatar, 2004
14. Civil Code of Mongolia /1926, 1952, 1963, 1994 (revised), 2002/ amended, Volume II, Ch.Sukhbaatar, P.Oyundelger, Ulaanbaatar, 2002. The second part
15. D. Zundui. Issues of Historic Development Tradition and Modernization of the Civil Law of Mongolia. Journal of Social and Humanitarian Education. 2001/1
16. Sh. Ariunbileg, B.Buyankhishig, Civil law /Guide-book/, Ulaanbaatar, 2013; [http://nli.gov.mn/gariinavlaga/irgenii\\_erh%20zui-4.pdf](http://nli.gov.mn/gariinavlaga/irgenii_erh%20zui-4.pdf)
17. <https://dnn.mn/>
18. <https://en.wikipedia.org/wiki/Usury>
19. <https://www.investopedia.com/terms/u/usury-laws.asp>
20. <https://www.creditkarma.com/personal-loans/i/usury-laws-what-you-need-to-know/>

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ ЦУЦАЛСАН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Э.Чулуунцэцэе  
Монгол Улсын Боловсролын Их сургуулийн  
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн  
Нийгмийн ухааны тэнхимийн эрх зүйн багш

**Товч агуулга:** Төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ цуцалсан шийдвэр хуулийн дагуу гарч буй эсэх, хууль бус гарсан тохиолдлын шалтгааныг тухайн асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт шинжилгээ хийх замаар судлахыг зорилоо. Учир нь шүүхээр шийдвэрлэж буй нийт хөдөлмөрийн маргааны талаас илүү хувь нь хөдөлмөрийн гэрээ цуцалсантай холбоотой үүссэн байгааг жил бүрийн шүүхийн статистик мэдээнээс төвөггүй харж болно. Мөн эдгээр маргааныг таслан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн 90 орчим хувь нь ажилтны талд гарч байгааг улсын хэмжээнд хийгдсэн хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн судалгаа харуулж байна.<sup>231</sup> Энэ нь нэгдүгээрт, нийгэмд сахилгагүй, хариуцлагагүй, чадваргүй ажилтныг шүүх хамгаалж ажил олгогчдыг хохироосон шийдвэр гаргадаг мэт ойлголт бий болгодог. Хоёрдугаарт, хувийн хэвшлийн хувьд эрсдлийг өөрөө хариуцдаг ч төрийн байгууллагуудын хувьд ажил олгогчийн хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг төсөвт суулгаж, улсын төсвөөс гаргуулж төрийн санхүүгийн нөөцөд бага бус хэмжээний хохирол учруулдаг, мөн хөдөлмөрийн гэрээний талуудын хувьд ч эрх ашиг зөрчигдөх гээд олон сөрөг үр дагавартай.

Энэхүү өгүүлэлд shuukh.mn сайтаас санамсаргүй түүврийн аргаар төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг цуцалсан маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн 10 шийдвэрийг сонгон авч судалсан бөгөөд ажил олгогч ямар алдаа дутагдлыг нийтлэг байдлаар гаргаж байгааг тодорхойлох, хуулийн дагуу шийдвэр гаргахад юуг анхаарах шаардлагатай болохыг тодруулахыг эрмэлзсэн болно.

**Түлхүүр үг:** Төрийн үйлчилгээний албан хаагч, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн маргаан, шүүхийн шийдвэр.

Иргэн бүрийн “хөдөлмөрлөх” эрхийг үндэсний болон олон улсын эрх зүйн суурь баримт бичиг, хэм хэмжээгээр баталгаажуулж хамгаалсаар байгаа хэдий ч хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн талаар хэрэг, маргаан практикт цөөнгүй байсаар байна. Тухайлбал, манай улсын хувьд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх явцад үүссэн эрх зүйн маргаан нь шүүн таслах ажиллагааны багагүй хувийг эзэлдэг. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс жил бүр гаргадаг “Монгол Улсын Шүүхийн судалгааны тайлан”-г үзвэл улсын хэмжээнд иргэний хэргийн шүүхэд хөдөлмөрийн маргааныг дараах байдлаар хянан шийдвэрлэсэн байна.

### Хүснэгт 1. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн статистик үзүүлэлт

Статистик үзүүлэлт	Аймаг	2014	2015	2016	2017	2018
Бүгд	Улсын дүн	1,377	1,487	2,220	2,214	1,785
Ажлаас буруу шилжүүлсэн	Улсын дүн	28	18	59	53	31
<b>Ажлаас үндэслэлгүй халагдсан</b>	<b>Улсын дүн</b>	<b>742</b>	<b>910</b>	<b>1,213</b>	<b>1,432</b>	<b>943</b>
Цалин хөлсний маргаан	Улсын дүн	475	415	653	565	637

Сүүлийн таван жилийн дүн мэдээгээр шүүхээр шийдвэрлэсэн нийт хөдөлмөрийн маргааны талаас илүү буюу 54-67% хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан талаарх маргаан байгаа нь энэ төрлийн маргаан бага биш байгааг харуулж байна. 2018 онд 943 ажлаас үндэслэлгүй халагдсан маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс 341 нь төрийн

<sup>231</sup> НХХЯ. (2014). Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтын судалгаа. УБ., 51 дэх тал

үйлчилгээний албан хаагчийг<sup>232</sup> ажлаас үндэслэлгүй халсан хэрэг маргаан байжээ. Тодруулбал,

- Эмч, эмнэлэгийн эрхлэгч, сувилагч, асрагч -13
- Сургуулийн захирал, багш, нийгмийн ажилтан -78
- Цэцэрлэгийн эрхлэгч, багш -25
- Мэргэжилтэн- 52
- Нягтлан бодогч, нярав 32
- Үйлчлэгч, жолооч, галч, харуул, жижүүр- 54 байна.<sup>233</sup>

Нэгдүгээрт, зөвхөн төрийн үйлчилгээний албан хаагчид холбогдох ажлаас үндэслэлгүй халсан гэх маргаан нь тухайн жилд шийдвэрлэсэн нийт 943 хэргийн 37 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Иймээс судалгааны хүрээг төрийн үйлчилгээний гэж хязгаарлах үндэслэл болов. Хоёрдугаарт, төрийн үйлчигээний албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан, ажил олгогчийн хууль бус шийдвэрийн улмаас улсын төсөвт бага бус ачаалал үүсгэсээр байна. Тухайлбал, Монгол улсын 2017 оны төсвийн тодотголын төсөлд төрийн албан хаагчдын буруутай үйл ажиллагааны нөхөн төлбөрийн зардалд зориулж, Хууль зүй дотоод хэргийн сайдын төсвийн багцад 8 тэр бум 818, 8 сая төгрөг тусгагдсан байна. Уг нөхөн төлбөрт төсөвлөсөн нийт хөрөнгийн 14,5 хувь буюу 1 тэр бум 282.2 сая төгрөгийг ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас олгох нөхөн төлбөрт зарцуулсан<sup>234</sup> гэх албан ёсны мэдээлэл байна. Практикт төсөвт тусгаагүй гэх шалтгаанаар төлбөр мөнгийг барагдуулах хугацаа хойшилж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд төлбөр нэмэгдэх, алданги тооцуулах хүртэл хүндрэл учирдаг. Иймээс энэ асуудалд хуульчид, судлаачид, удирдах ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэн гээд анхаарал хандуулах шаардлагатай байна. Мөн судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрт бус ажил олгогчийн хөдөлмөрийн гэрээ цуцалсан хууль зүйн үндэслэлд шинжилгээ хийсэн болохыг онцлох нь зүйтэй.

Шүүхийн практик нь өөрийн зориулалт, мөн чанарын хувьд хуулийг хэрэглэхтэй холбогдсон үр дүнг илэрхийлдэг.<sup>235</sup> Энэ утгаараа дараах шүүхийн шийдвэрүүдээс хөдөлмөрийн хуулийн хэрэглээний бодит байдлын талаар тодорхой мэдээлэл авч болно. Санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан дараах шүүхийн шийдвэрээр төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ цуцалсан үндэслэл хууль бус байна гэж дүгнэн ажилтныг эгүүлэн тогтоож, ажилгүй хугацааны цалин болох 71 591 507 \далан нэгэн сая таван зуун ерэн нэгэн мянга таван зуун долоо төгрөг гаргуулж, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг хариуцагчид даалгахаар шийдвэрлэжээ.

**Нэг. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 184/ШШ2018/02779 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн хөдөлмөрийн гэрээ цуцалсан үндэслэл	СХД-ийн.....цэцэрлэг 40.1.2.ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон; 40.1.4.ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;
----------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

<sup>232</sup> Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахь албан тушаал хамаарна. Үүнд, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал, .ям, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал. (Төрийн албаны тухай. 2017, 14.1)

<sup>233</sup> [www.judcouncil.mn/main](http://www.judcouncil.mn/main)  
(Parliament.mn)

<sup>235</sup> Д.Баярсайхан. (2018). Эрх зүйн онол. УБ., 185 дахь тал



Шүүхийн дүгнэлт	Ажилтны мэргэжил, ур чадварыг шалгасан гэх шалгуур үзүүлэлтүүд нь ойлгомжгүй, тодорхой бус байна. Тухайлбал ямар нөхцөлд 0 үнэлгээ өгөх, ямар нөхцөлд 5 үнэлгээ өгөх нь тодорхой бус байна. Ажил олгогч нь нэг баримт-ыг үндэслэл болгож, ажилтныг сахилгын зөрчил гаргасан, мэргэжил, ур чадварын хувьд тэнцэхгүй гэж үзсэн нь харилцан бие биенээ үгүйсгэсэн гэж үзэхээр байна. Учир нь, ажилтан угаас мэргэжил, ур чадварын хувьд тухайн ажлын байранд тэнцэхгүй байгаа бол түүнд сахилгын шийтгэл ногдуулах бус ажлаас халах үндэслэл болно. СХД-ийн .... цэцэрлэг нь ажилтан Б.Дтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулсан болохоо нотлоогүй. Энэ тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т зааснаар ажилтныг хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан гэж үзэж болохгүй.
-----------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**Хоёр. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2018/01270 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Хариуцагч БЗД-ийн 133 дугаар сургууль Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1.ажилтан санаачилсан.
Шүүхийн дүгнэлт	...ажилтан нь бичгийн хүсэлтээ өөрийн хүсэл зоригийн дагуу сайн дурын үндсэн дээр гаргасан гэж үзэх боломжгүй байна. Хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас чөлөөлөхдөө Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэл журмыг хэрэгжүүлээгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг баримтлаагүй

**Гурав. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2017/02244 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Удирдах газрын Хөдөлмөрийн дотоод журам
Шүүхийн дүгнэлт	Хөдөлмөрийн гэрээ-ний 2 дугаар зүйлийн 2.3, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын Удирдах газрын Хөдөлмөрийн дотоод журам-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгүүдэд заасны дагуу эдгээр зөрчилд хөдөлмөрийн сахилга хариуцлага хүлээлгэхээс бус хяналт шалгалт явуулаад гаргасан Зөвлөмж-нд дурдсан асуудлыг сахилгын ноцтой зөрчил гэж үзэн хариуцлага хүлээлэхээр заасан тодорхой заалт байхгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 сануулах, 131.1.2 үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 131.1.3 ажлаас халах-аар зааснаар сахилгын шийтгэлийг нэхэмжлэгчид оногдуулахдаа шат дараалсан арга хэмжээг аваагүй нь тогтоогдож байна. ....ажил олгогч түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа, Хөдөлмөрийн гэрээ, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн хууль-д заасан үндэслэл бүхий тушаал гаргах ёстой

**Дөрөв. Сүхбаатар аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 134 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4, 40.1.5,
------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------

Шүүхийн дүгнэлт	Хөдөлмөрийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй гэж заасныг зөрчиж хариуцагч Сүхбаатар аймгийн 3 нь нэхэмжлэгч Б.Сг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг ноцтой зөрчиж 2018 оны санхүүгийн тайландаа сөрөг дүгнэлт авч байгууллагад төсөв санхүүгийн хохирол учруулсан гэх үндэслэлээр Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.4, 40.1.5, 131 дүгээр зүйлийн 131.1.3 дахь заалтуудыг баримтлан хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгосон нь хууль зүйн үндэслэлгүй болжээ.
-----------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**Тав. Сүхбаатар аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 507 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.5, 42 дугаар зүйлийн 42.2, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоол
Шүүхийн дүгнэлт	Хэрэгт авагдсан Хэвлэл мэдээллийн ажилтан-ы албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг мэдээлэл сурталчилгаа, мэдээлэл, технологи сүлжээ хариуцсан мэргэжилтний албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолттой харьцуулж үзэхэд нэгжийн нэр, албан тушаалын зэрэглэл, ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаал, ажлын байрны зорилго, үндсэн зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд, ажлын байрны тавигдах шаардлага зэргийн агуулга хэвээр байх тул хэрэгжүүлэх чиг үүрэг нь өөрчлөгдөөгүй, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн байхад 40.1.1-ээр хөдөлмөрийн цуцалсан нь үндэслэлгүй.

**Зургаа. Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182\ШШ2018\00232 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1
Шүүхийн дүгнэлт	Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т Аж ахуйн нэгж байгууллагын харьяалал, өмчлөгч өөрчлөгдсөн нь хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй гэж заажээ. Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д зааснаар ажил олгогч орон тоо, бүтцийн өөрчлөлтийн улмаас хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдаж буй ажилтанд ийнхүү цуцлах тухайгаа ажилтанд нэг сарын өмнө мэдэгдэх үүрэгтэй, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д зааснаар ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно гэсэн заалтыг биелүүлээгүй. ...нэхэмжлэгчийн өмнө эрхэлж байсан албан тушаал, ажлын байр нь шинээр батлагдсан орон тооны бүтцээр түүний гүйцэтгэж байгаа ажлын чиг үүрэг хэвээр хадгалагдаж байгаа тул 40.1.1—д заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ цуцалсан нь хууль бус гэж үзсэн байна.

**Долоо. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 183\шш2018\00259 дугаартай шийдвэр**

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дүгээр зүйл
Шүүхийн дүгнэлт	..хэлтсийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсанаас бус тус хэлтсийн харъяанд ажиллаж байсан төслийн санхүүжилтээр ажиллаж байсан Залуучуудын хөгжлийн төвийг тус байгуулагад нэгтгэж, албан хаагчдыг нь шилжүүлээгүй тул ажил олгогчоос Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан Б.Ж-ыг ажлаас чөлөөлөх хууль зүйн үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл тухайн байгууллагын бүтцэд орж ажилладаггүй төслийн ажилтаныг орон тоо хасагдсан гэсэн үндэслэлээр ажлаас чөлөөлсөн нь буруу юм.

***Найм. Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Дугаар 153/ШШ2018/00011 дугаартай шийдвэр***

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын тамгын газар Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь хэсэг болон Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ажлаас чөлөөлсөн.
Шүүхийн дүгнэлт	Ажилтан зөрчил гаргасан нь баримтаар нотлогдож байгаа боловч ажилтанд эдгээр зөрчлүүдийг гаргаснаас хойш 6 сар, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор шийтгэл ногдуулах эрхийг ажил олгогчид олгосон байхад энэхүү хугацааг өнгөрсний дараа арга хэмжээ тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй байна.

***Ес . Завхан аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 419 дугаартай шийдвэр***

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Б/20 дугаартай тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4, 43 дугаар зүйлийн 43.1, 131 дүгээр зүйлийн 131.1.3, Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 258 дугаар тогтоолын 1.7 дугаар зүйл, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.9, дэх заалт, Хөдөлмөрийн гэрээний 20.б-дэх заалт, Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 03 тоот тогтоол
Шүүхийн дүгнэлт	Хөдөлмөрийн тухай хуульд ажлын үргэлжлэх хугацаа 8 цаг байна гэж заасан ба шөнийн цагаар буюу 22 цагаас амрах хугацаандаа архи хэрэглэснийг ажлын байран дээр архи согтууруулах ундаа хэрэглэсэн гэж үзэхгүй. Хэдийгээр хариуцагч байгууллага нь С.Га-ын гаргасан зөрчил нь Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 03 тоот тогтоолоор тогтоогдсон гэх боловч уг тогтоол нь хэргийн бодит нөхцөл байдалд тулгуурлаж гаргаагүй, үндэслэл муутай байх тул шүүх дээрх тогтоолыг үнэн зөв гэж үнэлэх боломжгүй байна.

***Арав. Говь-алтай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 399 дугаартай шийдвэр***

Ажил олгогчийн шийдвэрийн үндэслэл	“Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газар Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.2, 40.5, 42.1 дэх заалт, “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2018 оны А/03 дугаар тушаал, “Албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, ур чадварын түвшин тогтоох шалгалт явуулах журам”-ын 5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.12, 2.13, 2.14 дэх заалтууд
------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Шүүхийн дүгнэлт	эдийгээр Ц.Б-г ажлаас чөлөөлсөн тушаал нь хууль зүйн үндэслэлтэй байх боловч хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ цуцлах тохиолдолд мөн хуулийн 40.5-д заасны дагуу ажилтанд нэг сарын өмнө мэдэгдэх үүргээ ажил олгогч хуульд заасан агуулгаар буюу заасан хугацааны өмнө бичгийн хэлбэрээр мэдэгдэж, гарын үсэг зурж баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтыг шинжлэн судлахад хариуцагч хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд 1 сарын өмнө мэдэгдэх үүргээ биелүүлсэн болох нь баримтаар тогтоогдохгүй байна.
-----------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд дүгнэхэд төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ цуцлахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн дараах заалтыг түгээмэл байдлаар хэрэглэжээ. Үүнд:

- 40.1.1.аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;
- 40.1.2.ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;
- 40.1.4.ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;
- 40.1.5.мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон<sup>236</sup>

Зарим шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг сайн бичигдээгүй боловч шүүхээс ажил олгогчийн хөдөлмөрийн гэрээ цуцалдаа дараах нийтлэг алдаа дутагдлыг гаргажээ. Үүнд, нэгдүгээрт ажил олгогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй, хоёрдугаарт, хуулийг зөв ойлгож хэрэглээгүй, гуравдугаарт, ажил олгогч шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхдээ хөдөлмөрийн тухай хуулийн процедурын хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой байна.

**Ажил олгогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй-** Ажил олгогч буюу түүний эрх олгосон албан тушаалтан иргэнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй.<sup>237</sup> Талууд гэрээний гол болон бусад, нөхцөлүүдийг харилцан тохиролцон, түүнийгээ хоёр хувь үйлдэж гарын үсэг зурснаар гэрээг байгуулсанд тооцдог. Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх нь ажил олгогчийн үүрэг юм. Энэ үүргээ ажил олгогч хэрэгжүүлээгүй тохиолдолд ажилтнаас ажлын үр дүн болоод ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардах эрхгүйгээс гадна хэдийгээр ажилтны буруу байсан ч шүүх ажил олгогчийн шийдвэрийг хууль бус гэж дүгнэх үндэслэл болж байна. Учир нь ажил олгогч ажилтнаас мэргэжил, ур чадварын хувьд сайн байх, сахилгын зөрчил дутагдал гаргахгүй ажиллах зэрэг бүх шаардах эрхээ алдсан гэсэн үг юм. Мөн “хүнийг ажилд авахдаа түүнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулахгүйгээр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн”<sup>238</sup> бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах хууль зүйн зохицуулалттай. \I, IV шийдвэр\

Хэдийгээр манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хууль нь стандарт хэм хэмжээ тогтоосон эрх зүйн эх сурвалж хэдий ч иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор ажил олгогч нь зөвхөн тус хуулийн 40 дүгээр зүйлд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд л хөдөлмөрийн гэрээг цуцлах боломж бүрдэнэ гэсэн императив хэм хэмжээг тогтоож өгсөн. Гэтэл ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн тодорхой заалтыг үндэслэхгүйгээр байгууллагын дотоод хэм хэмжээ, бусад хуулийн зүйл заалтыг үндэслэн хөдөлмөрийн гэрээ цуцалж байгаа нь ажил олгогчийн хувьд гаргаж үл болох алдаа дутагдал гэж дүгнэж болно. Энэ жишээ баримтыг III шийдвэрээс харж болно.

**Ажил олгогч хуулийг зөв ойлгож, хэрэглээгүй** – Дараах хэд хэдэн зохицуулалтыг хэрэглэхэд зайлшгүй анхаарах асуудлуудын талаар бүрэн бус ойлголттой байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-т заасан “аж ахуйн нэгж,

<sup>236</sup> <https://www.legalinfo.mn/law/details/565>

<sup>237</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1

<sup>238</sup> Зөрчлийн тухай хуулийн 10.16

байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн” гэсэн зохицуулалтыг хэрэглэхдээ хэд хэдэн асуудалд анхаарал хандуулбал зохино. Үүнд:

- “Эсхүл” гэх функтор буюу логик холбоос нь “..хоёр бодомжийн аль нэгийг болзон сонгох утга илэрхийлсэн нийлмэл бодомж бүтээдэг”<sup>239</sup> болохыг анхаарч орон тоо хасагдсан, татан буугдсан, орон тоо цөөрүүлсэн аль нь болохыг тушаалд тодорхой ялган салгаж, тусгах шаардлагатай.
  - Мөн зүйлийн “орон тоо хасагдах” гэдгийг тухайн байгууллагын бүтцээс тодорхой ажил, албан тушаалын байр байхгүй болохыг, “орон тоо цөөрүүлэх” гэдгийг ажил, албан тушаалын нэг ижил орон тооноос тодорхой тоогоор багасгахыг тус тус ойлгоно. Эдгээр ойлголтуудад ажил, албан тушаалын нэг байрны асуудал хамааралтай болохыг анхаарвал зохино.<sup>240</sup> Энэ тохиолдолд ажил олгогч зөвхөн хасагдсан орон тооны ажлын байранд ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцална. \V, VI, VII шийдвэрт дээрх алдаа гаргасан тул ажил олгогчийн шийдвэр хууль бус болсон байна.\
2. Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасан “ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон” гэсэн зохицуулалтыг хэрэглэхдээ дараах асуудал анхаарах нь зүйтэй. Үүнд:
- Мэргэжлийн хувьд тэнцэхгүй байгаа юу, эрүүл мэндийн хуульд тэнцэхгүй байна уу гэдгийг ялгаж, тушаалд тодорхой зааж өгнө.
  - Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 буюу “Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон” гэдэгт салбарын буюу тухайн байгууллагын мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комисс, аттестатчиллын комисс болон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын албан ёсны дүгнэлт, шийдвэр хамаарах хэдий ч “орон тоо цөөрүүлэх”-ийн тулд шалгалт явуулж, улмаар дүгнэлт, шийдвэр гаргаж буй нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэхгүй.<sup>241</sup> Удирдлагын субъектив үнэлгээ бус аль болох мэргэжлийн, бие даасан, хөндлөнгийн комиссын үнэлгээг зайлшгүй шаардлагатай.
  - Мөн тухайн байгууллага өөрийн ажил, үүргийн онцлогт тохирсон хөдөлмөрийн үнэлгээний журмыг нарийн тодорхой боловсруулж мөрдөөгүйгээс комиссын үнэлгээг хууль бус гэж дүгнэх тохиолдол гарч байна. \I шийдвэр\
3. Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т “ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан” бол хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно. Энэ зохицуулалтыг хэрэглэхдээ дараах үндсэн шаардлагуудыг анхаарч үзвэл зохино. Үүнд:
- Ноцтой зөрчил, сахилгын зөрчил давтан гаргасан эсэхийг ялгаж салгаж шийдвэрт тусгах шаардлагатай.
  - Энэ зүйлийн ноцтой зөрчил болоод сахилгын зөрчлийг ялгаж салгаж ойлгох нь зүйтэй. Учир нь “практикт зөрчил бүрийг ноцтой гэж тооцох нь элбэг байна. ...үр дагаврын хувьд ялгаатай бөгөөд ноцтой зөрчил нь ажил олгогч байгууллагын нэр хүнд, санхүүгийн болоод бусад үйл ажиллагаа, эрх ашиг сонирхолд онцгой хор уршигтай байх төдийгүй энэ зөрчлийг гэрээнд заавал тусгасан байх шаардлагатай”<sup>242</sup> эс бөгөөс нэг удаагийн үйлдлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл бүрдэхгүй юм.
  - Энэ зүйлийн “ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан” гэдэгт хөдөлмөрийн сахилгын зөрчлийг 2 буюу түүнээс дээш удаа гаргасан байхыг ойлгоно. Зөрчил бүр тус тусдаа тогтоогдсон байх шаардлагатай боловч тус бүрд нь сахилгын шийтгэл заавал ногдуулсан байхыг

<sup>239</sup> Нэмэхжаргал, Т. (2019). Логик. Х-53

<sup>240</sup> УДШ. (2012). Зөвлөмж. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал

<sup>241</sup> УДШ. (2012). Зөвлөмж. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал

<sup>242</sup> Уранцэцэг Б. Сахилгын зөрчил хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болох нь: хуулийн зохицуулалт ба практик. МУИС. Эрх зүй сэтгүүл. 2017. №1. х-132

шаардахгүй”<sup>243</sup> гэхдээ зөрчил гаргасан болох нь тогтоогдсон байх шаардлагатай.

4. Ажил олгогч хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5. –д заасан “мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон” тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлахдаа дараах асуудлыг харгалзан үзвэл зохино. Үүнд:
  - Талуудын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь итгэлд тулгуурласан үүрэг юм.<sup>244</sup> Энэ заалтын хувьд итгэл хүлээсэн тусгай субъект байна. Өөрөөр хэлбэл, “ажил олгогчийн мэдлийн өмч хөрөнгийг бүртгэн авч, бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бусдад шилжүүлэх үүрэг хүлээсэн эд хариуцагч байхаас гадна тодорхой зориулалт, чиглэлээр эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх мэдлийг өмчлөгчөөс шилжүүлэн авсан удирдах албан тушаалтан, мөн удирдах албан тушаалтантай зохих хэмжээгээр эд хөрөнгийг хамтран захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих эрх бүхий санхүүгийн албан тушаалтныг ойлгоно.
  - Хууль заасан эсвэл хөдөлмөрийн гэрээнд тусгасан бол захиргааны итгэлийг алдагдуулсан үйлдлийг нэг удаагийн эсвэл давтан эсэхийг үл харгалзахаас гадна итгэл алдсан үйлдлийг санхүүгийн болон эрх бүхий байгууллагын шатгалтаар тогтооно.<sup>245</sup> Ийнхүү тогтоогоогүй бол хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болохгүй юм.

**Ажил олгогч шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхдээ процедурын хэм хэмжээг зөрчсөн –** Хөдөлмөрийн тухай хуульд ажил ологчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ цуцлах шийдвэрийг хуулийн дагуу гаргасан хэдий ч заавал биелүүлэх шинжтэй хэм хэмжээг хэрэгжүүлээгүйгээс шүүх тухайн шийдвэрийг хууль бус гэж дүгнэх шалтгаан практикт нэлээд түгээмэл байгааг дээрх судалгаанаас харж болно. Тухайлбал,

- Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40. 3. Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглоно. 40.4. Аж ахуйн нэгж, **байгууллагын харьяалал, өмчлөгч өөрчлөгдсөн** нь хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болохгүй. \V шийдвэр\
- Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5. Ажил олгогч энэ хуулийн 40.1.1, 40.1.2 -т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд нэг **сарын өмнө мэдэгдэнэ.**
- Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх **тэтгэмж олгоно.** \II, IV, VI, X дугаар шийдвэр\
- Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1. Хууль болон хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай өргөдлөө ажил олгогчид өгсөн өдрөөс **хойш 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхих эрхтэй**, энэ тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлагдсанд тооцно. \II шийдвэр\
- Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2.Сахилгын зөрчил гаргаснаас хойш зургаан сар, **илрүүлснээс хойш нэг сарын** дотор сахилгын шийтгэл ногдуулна. 131.4.Сахилгын шийтгэл ногдуулснаас **хойш нэг жил** өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно. \IV, V шийдвэр\

Ажил олгогч хэдийгээр хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг зөв ойлгож хэрэглэж хуулийн дагуу шийдвэр гаргасан ч дээрхи процедурын хэм хэмжээг зөрчсний улмаас шийдвэр хууль бус гэж тооцох шууд үндэслэл болж байна.

Нөхөн төлбөрийн тухайд судлагдсан 10 шийдвэрийн хүрээнд авч үзэхэд 100-гаад сая төгрөг болж байна. Зөвхөн Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх “Төрийн

<sup>243</sup> УДШ. (2012). Зөвлөмж. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал

<sup>244</sup> Банзрагч, Л. Гэрээний ерөнхий онолын зарим асуудал. Монголын төр эрх зүй сэтгүүл. 2012. №2 (68). х-11

<sup>245</sup> Баасан, Л. (2010). Хөдөлмөрийн эрх зүй. УБ.,х-217

албанаас халсан, чөлөөлсөн, шилжүүлсэн, албан тушаал бууруулсантай холбоотой маргаанд нэхэмжилсэн ажилгүй байсан хугацааны 2.089.478.711 төгрөгийг нэхэмжилсэн ба тус шүүхээс 496.098.260 төгрөгийн цалин хөлсийг төрөөс гаргуулахаар шийдвэрлэсэн<sup>246</sup> байх жишээтэй, энэ байдлаар улсын хэмжээнд 1 тэр бумаар тогтохгүй нь ойлгомжтой юм. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Э.Золзаяа, Д.Дэлгэрцэцэг нарын судалгаагаар ...нийслэлийн давж заалдах шатны шүүх 2015, 2016 онуудад ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой олговорт 1.2-1.5 тэрбум төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн. Тус шүүхийн хэмжээнд жилд 150 орчим энэ төрлийн хэргийг шийдвэрлэдэг бол улсын хэмжээнд 1700-2200 хэргийг шийдвэрлэдэг гэсэн тоон үзүүлэлттэй харьцуулбал олговрын хэмжээ 15-20 тэр бум төгрөг байхаар байна гэж тооцжээ.

Төрийн албаны тухай хуульд төрийн алба мэргэшсэн байх<sup>247</sup> зарчмыг удирдлага болгож ажиллана гэж тодорхой заажээ. Гэтэл төрийн албаны хууль бус шийдвэрийн улмаас улсын төсөвт жил бүр асар их хэмжээний хохирол, дарамт үүсгэдэг.

Манай улсын хувьд ажилтны хөдөлмөрлөх эрхийг сэргээхдээ зөвхөн нөхөн төлбөрийн хариуцлага тооцдог. Харин бусад улс орнууд олон өртөг, зардлыг гаргуулдаг, жишээ нь: "... АНУ-д compensatory буюу нөхөн төлбөрийн, punitive буюу торуулийн хариуцлагын аль аль төрлийг хэрэглэж байна."<sup>248</sup> Энэ нь ажилтны авах ёстой байсан цалин хөлс, торгуулийн шинжтэй хохирол, манайхаар бол шүүхийн зардлыг хохирогч нэмж гаргуулдаг туршлага ч байна.

Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний хувьд авч үзвэл, аливаа нийгмийн бүлгийн амжилт юуны тэргүүнд уг бүлгийн гишүүдийн эдэлж буй суурь эрх, эрх чөлөөгөөр тодорхойлогдог<sup>249</sup> бөгөөд энэхүү эрх, эрх чөлөөт хөдөлмөр нь зүйрлэшгүй их бүтээмжтэй<sup>250</sup> байдаг гэх бидний сонгосон нийгмийн хөдөлмөрийн суурь зарчмыг удирдлага болгож манай улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хөдөлмөрийн хуулийн зохицуулалт маш альтернатив, стандарт хэм хэмжээ тогтоосон байдаг. Энэ байдал нь ихээхэн ухаалаг шийдэл бөгөөд байгууллагад өргөн хүрээтэй, сонголттой эрхийн боломжийг олгосон. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хэм хэмжээг \хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт гэх мэт\ баталж мөрдүүлэх, тэрхүү хэм хэмжээ нь хуулийн нэг адил хүчин төгөлдөр үйлчлэх тогтолцоог бий болгохыг хичээсэн гэж хэлж болно. Учир нь нийгмийн бүх харилцааг зөвхөн төрийн хуулиар зохицуулах боломжгүй бөгөөд хөдөлмөрийн харилцаанд мөрдөж буй хэм хэмжээг бодит амьдралд нийцсэн эрх зүйт \rule of law\ байлгахын тулд энэ шийдэл нь хамгийн зохист хувилбар мөн.

Хөдөлмөрийн харилцаанд оролцогч талууд тэр дундаа ажил олгогчид асуудалд шүүмжлэлтэй хандахаас илүү утга мөн чанар, суурь зарчмыг ойлгож, хэрэглэх нь чухал юм. Үүний тулд байгууллагын дотоод хэм хэмжээг Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн боловсруулах, дотоод хэм хэмжээ болон хууль хэрэглэх боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, хууль зүйн мэргэжлийн заавар зөвлөгөө туслалцаа авах гээд олон асуудалд анхаарах нь зүйтэй юм.

Мөн төрийн зүгээс зүйн онолын суурь зарчмын дагуу зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг тухайн шийдвэр гаргасан албан тушаалтан хариуцах хариуцлагын тогтолцоог нэг мөр болгох зайлшгүй шаардлагатай байна.

## Ашигласан материал

### Ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл:

- Амартия Сен. (2014). Хөгжил бол эрх чөлөө. Улаанбаатар
- Баасан. Л. (2002). Хөдөлмөрийн маргаан онол, практикийн асуудал. Улаанбаатар
- Баасан. Л. (2010). Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй. Улаанбаатар
- Баярсайхан, Д. (2018). Эрх зүйн онол. Улаанбаатар
- Болормаа. С. (2013). Хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудлууд, Улаанбаатар
- Жамбалдорж. О. (1982). БНМАУ-ын хөдөлмөрийн эрх зүй Улаанбаатар
- Людвиг фон мезис. (2004). Либерализм, Улаанбаатар
- Нэмэхжаргал, Т. (2019). Логик. Улаанбаатар

<sup>246</sup> [http://admincourt.gov.mn/site/full\\_story/774](http://admincourt.gov.mn/site/full_story/774)

<sup>247</sup> Төрийн албаны тухай хууль. 2017, 14.1

<sup>248</sup> Susan R.Mendelsohn, Wrongful Termination Litigation in the United States and it's Effect on the Employment Relationship OECD, 1990, p-5

<sup>249</sup> Амартия сен "Хөгжил бол эрх чөлөө", Уб.,2014 он, 25 дахь талаас

<sup>250</sup> Людвиг фон мезис. Либерализм, Уб.,2004, 25 дахь тал

- Уранцэцэг, Б. (2012). Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн сургалтын гарын авлага. Улаанбаатар
- ХЗДЯ. (2007). Хөдөлмөрийн эрх зүйн гарын авлага. Улаанбаатар
- УДШ. (2012). Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал, зөвлөмж. Улаанбаатар
- УДШ. (2006). Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай тогтоол дугаар 133. Улаанбаатар
- НХХЯ. (2014). Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтын судалгаа. Улаанбаатар
- Susan R.Mendelsohn, Wrongful Termination Litigation in the United States and it's Effect on the Employment Reletionship OECD, 1990

**Сайтууд:**

- <https://www.ilo.org/>
- <https://www.legalinfo.mn/>
- <http://shuukh.mn/>
- <http://www.supremecourt.mn/>
- <http://www.judcouncil.mn/>
- <http://mlsp.gov.mn/>
- <https://mojha.gov.mn>

**Эрдэм шинжилгээний өгүүлэл:**

- Уранцэцэг, Б. (2017). Сахилгын зөрчил хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болох нь: хуулийн зохицуулалт ба практик. Эрх зүй, №1, 126-139
- Бямбасүрэн, Ч. (2016). Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох эрх зүйн зохицуулалт. Хууль дээдлэх ёс. 3(58). 89-93 дахь тал
- Банзрагч, Л. Гэрээний ерөнхий онолын зарим асуудал. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2012. №2. 20-25 дахь тал



# ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ

## ФОРМИРОВАНИЯ ПРОФЕССИОНАЛЬНОЙ КУЛЬТУРЫ БУДУЩИХ ЮРИСТОВ НА ОСНОВЕ КОНТЕКСТНОГО ОБУЧЕНИЯ

**Светличный Евгений Григорьевич**<sup>251</sup>

*ОХУ-ын Дотоод явдлын яамны Краснодарын их сургуулийн Крым дахь салбарийн  
Галын бэлтгэл, тусгай тактикийн тэнхимийн эрхлэгч, сурган хүмүүжүүлэх ухааны  
доктор*

**Лейнова Ольга Сергеевна**<sup>252</sup>

*ОХУ-ын Дотоод явдлын яамны Санкт-Петербургийн их сургуулийн  
Криминалистикийн тэнхимийн дэд дарга, хууль зүйн доктор*

**Светличная Надежда Ивановна**<sup>253</sup>

*ОХУ-ын Крымийн бүгд найрамдах улсын «Лицей № 1»,  
сургуулийн багш, 1-р зэргийн багш*

**Товч агуулга:** Ирээдүйн хуульчийн мэргэжлийн чиг баримжаа, мэргэжлийн төлөвшил, хөгжил нь хууль мэргэжлийн төлөвшилд чухал хүчин зүйл болдог. Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа нь хүний сэтгэн бодох үйл ажиллагаа, түүний үр дүнгээр материаллаг ертөнцөд тусгалаа олдог бөгөөд эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн ухамсар, мэргэжлийн ёс зүй, чиг баримжаа зэрэгтэй уялдаж байдаг. Иймд ирээдүйн хуульчийг сургах үйл ажиллагаанд дээр дурдсан хүчин зүйлийг хэрхэн ашиглах талаар энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** Суурь мэдлэг, мэргэжлийн соёл, ухамсар, мэргэжлийн чадвар, харилцааны урлаг, оюун ухааны чадвар, бүтээлч сэтгэлгээ, шуурхай байдал.

В условиях развития в Российской Федерации демократического, правового государства и гражданского общества особое значение приобретает уровень профессиональной подготовки юристов, обеспечивающих соблюдение законности и правопорядка. Широкий спектр профессиональных проблем, возникающих перед будущими юристами, многообразие сфер применения навыков юридической деятельности и реализации своих возможностей, обуславливают потребность в определении основ профессионального успеха представителей юридического сообщества, выявления внутренних механизмов регуляции их профессионального развития.

Определяющим критерием качества подготовки будущих юристов является сформированность профессиональной культуры личности, оказывающей значительное влияние на содержание, характер и эффективность профессиональной деятельности. Профессиональная культура, как комплекс специальных знаний, умений, способностей, качеств, норм и ориентаций личности, необходимых для включения в профессиональную среду, способствует успешному овладению профессией, обеспечивает направленность личности на самоопределение и самореализацию, что позволяет рассматривать ее в качестве внутренней предпосылки становления профессионализма.

**Профессиональная культура юриста** – совокупность профессиональных знаний, умений и навыков, профессионально значимых качеств, профессионально-этических норм и ценностей личности, влияющих на организацию и осуществление юридической деятельности и определяющих поведение юриста в профессиональной среде.

Специфическими чертами профессиональной культуры будущих юристов являются:

<sup>251</sup> Крымский филиал Краснодарского университета МВД России, начальник кафедры тактико-специальной и огневой подготовки, г. Симферополь (**Россия**), кандидат педагогических наук, **e-mail:** [svetlichniyeg@yandex.ru](mailto:svetlichniyeg@yandex.ru)

<sup>252</sup> Заместитель начальника кафедры криминалистики Санкт-Петербургского университета МВД России, кандидат юридических наук, доцент. Санкт-Петербург (**Россия**), **Email:** [vinolia@mail.ru](mailto:vinolia@mail.ru)

<sup>253</sup> Муниципальное бюджетное образовательное учреждение «Лицей № 1», учитель высшей категории г. Симферополь (**Россия**), **e-mail:** [svetlichnaya.1960@list.ru](mailto:svetlichnaya.1960@list.ru)

– профессиональная компетентность – умение профессионально правильно трактовать и применять правовые нормы;

– социально-профессиональная ответственность – восприятие юристом правовых и этических норм в качестве определяющего основания для принятия решений и совершения действий, противостояние попыткам влияния заинтересованных лиц при принятии юридически значимых решений, наличие властных полномочий, которые юрист обязан применять исключительно в рамках закона;

– коммуникативность – предрасположенность к функциональному общению, установлению контактов с различными возрастными и социальными группами людей; готовность к деловому сотрудничеству, изменению ситуации общения с целью получения информации, достижения взаимопонимания, уменьшения недоразумений, устранения конфликтов; способность к осуществлению контроля над собой в процессе общения, терпимость к чужому мнению;

– практический интеллект – способность к продуктивному решению практических проблем и профессиональных задач на основе ситуативного подхода и профессиональной интуиции;

– профессиональная креативность – способность к принятию оригинальных, отличающихся новизной, решений при выполнении профессиональных задач; поиск нестандартных путей установления истины и отдельных обстоятельств дела, построения моделей происшедшего события;

– профессиональная мобильность – готовность юриста к смене видов деятельности в рамках характерных обязанностей и задач профессии, а также к выбору последовательности действий и их изменению в зависимости от сложившейся ситуации;

– эмоциональная устойчивость – способность преодолевать состояние излишнего эмоционального возбуждения при выполнении профессиональной деятельности; устойчивость к стрессогенному воздействию трудных ситуаций; наличие навыков адекватного реагирования на сильные эмоциональные воздействия.

Развитие профессиональной культуры будущего юриста как системного личностного образования, структурными взаимосвязанными компонентами которого выступают общекультурные и профессиональные знания, умения, навыки, профессионально значимые качества, профессионально-этические нормы юридической деятельности, ценности и ценностные ориентации юристов, опосредовано процессом профессиогенеза и реализуется в процессе профессиональной подготовки.

Формирование профессиональной культуры – это целостный непрерывный процесс, начинающийся с момента выбора будущей профессии и продолжающийся в течение профессиональной подготовки юриста и его активной профессиональной деятельности, одно из направлений развития личности, в рамках которого разрешается специфический комплекс противоречий, присущий социализации личности.

Несмотря на наличие определенного фактического материала по проблеме формирования профессиональной культуры будущих юристов в системе высшего юридического образования на сегодняшний день остаются нерешенными ряд противоречий между:

– возрастающими требованиями общества к подготовке конкурентоспособных юристов, обладающих высоким уровнем профессиональной культуры, и недостаточной разработанностью теоретических и практических основ формирования профессиональной культуры в рамках традиционной системы образования;

– активностью самого обучаемого, стремящегося стать высококвалифицированным специалистом в области юриспруденции, и неготовностью к компетентному выполнению профессиональной деятельности;

В контексте нашего исследования юриспруденцию необходимо рассматривать как разновидность профессиональной деятельности, направленной на обеспечение функционирования механизма правового регулирования, поддержание и охрану общественных отношений правовыми методами и средствами.

Анализ особенностей основных видов профессиональной деятельности в области юриспруденции позволяет отметить, что, зачастую, они являются наиболее общими для многих из них, при чем наиболее характерной составляющей этой общности выступает профессиональная культура юриста.

Одним из важнейших компонентов профессиональной культуры юристов является владение системой профессионально-предметных конструктов – компетентностей,

компетенций и профессионально значимых качеств, обеспечивающих продуктивность профессиональной деятельности.

Важным компонентом профессиональной культуры будущих юристов являются профессиональные ценности и ценностные ориентации. Наличие сформированной системы ценностей и ценностных ориентаций обеспечивает целостность и устойчивость личности профессионала, определяет и контролирует его мотивационную сферу, стратегии и виды деятельности, направленные на решение профессиональных задач.

Овладение опытом профессиональной деятельности предполагает соответствующее развитие способностей человека, становление его личностных качеств, целостное развитие личности и в педагогической литературе определяется как процесс:

- обеспечивающий вхождение человека в профессиональную среду, усвоение им профессионального опыта, овладение стандартами и ценностями профессионального сообщества [1, с. 36];

- гармонизации реализуемых сущностных возможностей человека и требований его профессии [2, с. 21];

- формирования и совершенствования тех личностных установок и качеств, которые согласуются с профессией (специальностью);

- изменения личности под влиянием социальных воздействий, профессиональной деятельности и собственной активности, направленной на самосовершенствование и самоосуществление [3, с. 76].

Обобщение теоретических положений, раскрывающих сущность и специфику профессиональной культуры, позволило выделить ряд присущих ей особенностей:

- профессиональная культура будущих юристов представляет собой системное образование, включающее ряд взаимосвязанных компонентов (профессионально-предметных конструкторов);

- формирование профессиональной культуры осуществляется в процессе становления профессионала, его индивидуального профессионально-личностного развития;

- развитие профессиональной культуры обусловлено рядом внешних и внутренних факторов;

Традиционная система обучения не решает проблемы использования возможностей образовательного процесса для формирования профессиональной культуры будущих юристов, концептуальной основой решения этой задачи может стать теория контекстного обучения.

Базируясь на моделировании целостного предметного и социального содержания профессионального труда, контекстное обучение за счет оптимального использования совокупности традиционных и новейших педагогических технологий в формах учебной деятельности (учебная деятельность академического типа, квазипрофессиональная, учебно-профессиональная) обеспечивает максимальные возможности для развития личности обучающегося, как отмечал А.А. Вербицкий: «Целью становится «выращивание» личностного потенциала человека, воспитание его способностей к адекватной деятельности в предстоящих предметных и социальных ситуациях, а содержанием – все то, что обеспечивает достижение этой цели» [4, с. 20].

Основу теории контекстного обучения составляет понимание смыслообразующего влияния предметного и социального контекстов общей и профессиональной культуры, и будущей профессиональной деятельности специалиста на процесс и результаты его образовательной деятельности и профессиогенеза: «базовым принципом становится принцип контекстуальности, предполагающий единство знаний и навыков и их применения с учетом социальных, межличностных и предметных особенностей контекста» [5, с. 206].

В результате анализа основных положений теории контекстного обучения сделан вывод, что будущий юрист, обладает своим внутренним контекстом как результатом жизнедеятельности и образовательного опыта, и находится под влиянием нескольких внешних контекстов:

- Первый контекст, обусловлен нормативными, моральными и другими требованиями общества к профессии юриста; интересами и ценностями людей, имеющих определенные представления о стереотипах поведения специалистов в рамках нормотворческой, правоприменительной, правоохранительной деятельности.

- Второй контекст обусловлен образовательной средой, в которой реализуются основные образовательные программы подготовки будущих юристов, направленные на

формирование профессиональной компетентности и создаются условия для изменения основных структурных составляющих личности, свидетельствующих о ее профессиогенезе.

– Третий контекст обусловлен профессиональной средой. Принадлежность к юридической профессии создает условия для проявления культурного своеобразия как общественного, характерного для деятельности данного профессионального сообщества, так и индивидуального – формирующегося в результате выбора форм и способов поведения каждым специалистом.

Концепт профессиональной культуры содержит в качестве важнейшего компонента представление (образ) о профессиональной деятельности, отраженной в действиях, поступках, выборе решений, психических механизмах духовно-деятельностного сознания личности. Понимание смыслообразующего влияния предметного и социального контекстов общей и профессиональной культуры, будущей профессиональной деятельности юриста на процесс и результаты его профессиогенеза, обуславливает определение концептуальной основой формирования профессиональной культуры юристов теорию контекстного обучения. Базируясь на моделировании предметного и социального содержания профессионального труда, контекстное обучение за счет оптимального использования различных форм учебной деятельности (учебная деятельность академического типа, квазипрофессиональная, учебно-профессиональная); решения профессионально ориентированных ситуаций и проблемных заданий, построенных на содержании специализированных дисциплин; организации форм совместной деятельности по моделированию профессиональных действий, характерных для разных видов юридической деятельности, обеспечивает максимальные возможности для развития профессиональной культуры личности обучающегося.

#### **СПИСОК ИСПОЛЬЗОВАННОЙ ЛИТЕРАТУРЫ**

1. Левицкая И.А. Концепция профессионализации: социальные и личностные факторы [Электронный ресурс] / И.А. Левицкая // Современная наука: Актуальные проблемы теории и практики. Серия «Гуманитарные науки». – 2014. – № 1 – 2.– Режим доступа: <http://www.nauteh-journal.ru/index.php/ru/--gn14-01/1109>;
2. Сидоров П.И. Адаптивный профессиогенез преподавательского корпуса [Электронный ресурс] / П.И. Сидоров, Е.И. Васильева – Режим доступа: <http://ebiblioteka.ru/browse/doc/35874185>;
3. Зеер Э.Ф. Психология профессиональных деструкций : учеб. пособ. для вузов / Э.Ф. Зеер. – М. : Академический проект; Екатеринбург : Деловая книга, 2005. – 240 с. – («Gaudeamus»);
4. Вербицкий А.А. Школа контекстного обучения как модель реализации компетентностного подхода в общем образовании / А.А. Вербицкий, О.Б. Ермакова// Инновационные проекты и программы в образовании. – 2009. – №4. – С. 19 – 22.
5. Светличный Е.Г., Балдецкий О.А., Осипченко Н.И. Методологические основы формирования профессиональной культуры будущих юристов в образовательном процессе ВУЗа // Проблемы современного педагогического образования. – Ялта. – 2018. – Выпуск 58 (1). – С. 204-207

## НИЙГМИЙН АЖИЛТАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ АРГА ЗҮЙ

*О.Баяржаргал  
ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, ахмад*

**Товч агуулга:** Хувь хүнд үйлчилгээ үзүүлэхэд мэргэжилтний хувьд ашиглах гол арга, хэрэгсэл нь хувь хүнтэй хийх ганцаарчилсан ярилцлага юм. Нийгмийн ажилтан бүр ярилцлага хийх өөрийн арга барилтай байдаг хэдий ч нийгмийн ажилтнуудын ярилцлага хийхдээ зайлшгүй мэдвэл зохих зүйл нь ярилцлагад бэлтгэх, ярилцлагыг тодорхой үе шатын дагуу явуулах ба ярилцлага хийх үр чадваруудаа хөгжүүлэх хэрэгтэй.

Ярилцлага хийх үр чадварт үгэн болон үгэн бус харилцааг хамруулан ойлгодог. Үгээр илэрхийлж буй хэл нь хувь хүн болон соёлоос хамааран өөр өөр байдаг. Ярианы хэлийг ойлгох нь төвөгтэй асуудал байдаг бөгөөд нөгөө талаар олон утга агуулсан эргэлзээтэй нөхцлүүдийг илэрхийлэх тохиолдол байдаг үүн дээр мэргэжилтнүүд анхаарлаа хандуулж ажиллах хэрэгтэй. Биеэрээ өгүүлнэ гэдэг нь биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал болон дууны өнгө өөрчлөгдөх багтах бөгөөд үүнийг ойлгох нь төвөгтэй ч үйлчилгээнд чухал ач холбогдолтой байдаг.

**Түлхүүр үг:** нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч, ярилцлага, ажиглах үр чадвар, сонсох үр чадвар, асуулт тавих үр чадвар.

Ярилцлага бүр тодорхой зорилго, зорилтын үндсэн дээр хийгддэг бөгөөд ярилцлагыг ямар зорилгоор явуулах нь үйлчлүүлэгч ба нийгмийн ажилтны хамтын ажиллагааны аль үе шатанд хийгдэж байгаа, байгууллагын үйл ажиллагаа хийгээд үйлчилгээний арга барил, үйлчлүүлэгчийн хэрэгцээ болон тухайн нөхцөл байдлаас шалтгаалдаг.

Ярилцлагын зорилгоос гадна дор дурдсан хэдэн хүчин зүйл ярилцлагад нөлөөлдөг. Үүнд:

- Ярилцлага хийх санаачлага хэрхэн гарсан тухай -Энэ нь үйлчлүүлэгчийн сайн дурын үндсэн дээр төлөвлөгдсөн үү? Энэ нь тогтмол хийгддэг, төлөвлөгдсөн, албан ёсны ярилцлага уу эсвэл гэнэтийн, албан бус ярилцлага уу?
- Ярилцлагыг хаана хийх вэ? Ярилцлага албан өрөөнд, эмнэлэгийн өрөөнд, эсвэл өөр ямар нэгэн газар болох уу?
- Нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоёр бие биенийхээ талаар хэр сайн мэдэх вэ? Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй урьд нь уулзаж байсан уу?

Ярилцлагын зорилго, үйлчлүүлэгчийн хэрэгцээнээс шалтгаалж нийгмийн ажилтан ярилцлагыг төлөвлөх, явуулахдаа уян хатан байх шаардлагатай.

### **Ярилцлага хийх үе шат:**

- Ярилцлагын бэлтгэлийг хангах
- Ярилцлагын эхлэл - Ярилцлагын нээлт буюу эхлэл хэсэг харилцаа холбоо тогтоох, хөгжүүлэх ба үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын тухай мэдээлэл цуглуулахад чиглэдэг.
- Ярилцлагын дунд буюу өрнөл үе - Дунд буюу хамтран ажиллах үе нь үнэлгээ хийх, төлөвлөх ба үйл ажиллагаа явуулахад чиглэгдэнэ. Энэ нь төлөвлөгөөний дагуу амжилттай ажиллахад нөлөөлсөн ололт амжилт, саад бэрхшээлийг үнэлэх, төлөвлөгөөг цааш нь үргэлжлүүлэх ба өөрчлөх эсэхийн талаар шийдвэр гаргах, ололт амжилтыг хадгалах ба бэрхшээл саадыг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргийг багтаана.
- Төгсгөл үе - Төгсгөл хэсэг нь ярилцлагыг дуусгах, хаахад чиглэнэ.

### **Ярилцлага хийхэд бэлтгэх нь**

Ярилцлагын бэлтгэл ажил нь дараах гурван үйл ажиллагааг хамарна.

1. Ярилцлага хийх орчноо бэлтгэх
2. Ярилцлагын агуулгыг төлөвлөх
3. Ярилцлагад өөрийгөө тохируулан бэлтгэх үйл ажиллагаа хамрагдана

### **Ярилцлага хийх орчин бүрдүүлэх:**

- Ярилцлага хийх орчныг бүрдүүлэхдээ хамгийн гол нь тохитой, элдэв чимээ шуугиан, саад тотгоргүй байлгахыг хичээх ёстой.
- Утасны дуудлага, хаалганы хонх зэрэг хөндлөнгийн гэнэтийн дуу чимээ нь

ярилцлагыг амжилтгүй болоход ихээхэн нөлөөлдөг.

- Хэрвээ нийгмийн ажилтан тэмдэглэл хөтлөх юмуу, ярилцлагын явцыг дуу хураагч болон видео камераар бичихээр төлөвлөж байгаа бол үүнийг ярилцлагад саад болохооргүй байдлаар тохируулж, үйлчлүүлэгчид энэ тухай бүрэн мэдээлсэн байх шаардлагатай. Түүнчлэн, өөрийн хувцаслалтын байдал үйлчлүүлэгчид ямар нөлөө үзүүлж болохыг бодолцох нь зүйтэй.
  - Ярилцлагын хугацааг төлөвлөхдөө үйлчлүүлэгч нийгмийн ажилтан аль аль нь яархааргүй, тохиромжтой цаг хугацаанд төлөвлөж, хэтэрхий урт сунжирсан байлгахааргүй зохицуулах шаардлагатай.
- Ярилцлагын агууллагыг төлөвлөхдөө нийгмийн ажилтан дараах зүйлүүдийг анхаарна.


Үүнд:

- Ярилцлагын агуулгыг төлөвлөхдөө нийгмийн ажилтан үйлчилгээний зорилгоо сэргээн санаж, үүндээ тулгуурлан тухайн үеийн ярилцлагын зорилгыг тодорхойлно.
- Мөн ярилцлагын үед гүйцэтгэх үүрэг, даалгаврыг ч мөн тодорхой болгох шаардлагатай.
- Аливаа шаардлагатай нэмэлт мэдээлэл, мэдлэгийг мөн ярилцлагын үед олж авах ёстой.
- Ярилцлага хийх бүтэц, дэс дараалал, ярилцлагын үед асуух асуултууд зэргийг боловсруулсан байна.

Нийгмийн ажилтан ярилцлагад өөрийгөө тохируулан бэлдэхдээ:

- Ярилцлагад өөрийгөө тохируулан бэлдэхдээ нийгмийн ажилтан юуны түрүүнд үйлчлүүлэгчийн хэрэгцээ, мэдрэмжийг урьдчилан төсөөлж, тэрхүү мэдрэмж, хэрэгцээнд өөрөө ямар хариу үйлдэл үзүүлж болох тухай бодно. Түүнчлэн, үр дүнтэй харилцаа бий болгоход саад тотгор үзүүлж болохуйц өөрийн мэдрэмж, хандлагыг бодолцох хэрэгтэй. Энэ бүхнийг тооцоолсноор ярилцлагын үед үзүүлж болох тэдгээр мэдрэмж, хандлагын сөрөг нөлөөг багасгах боломжтой юм.
- Ярилцлагад өөрийгөө тохируулан бэлтгэхтэй холбоотой хүчин зүйлүүдийг үзүүлэн 3 дахь зураглалаас харж болно. Нийгмийн ажилтан үгэн болон үгэн бус харилцааны чадвартай байх нь чухал гэдэг нь харагдаж байна.

Түүнчлэн, ярилцлагын үед шаардагдах олон ур чадварууд байна. Үүнд:



Ярилцлагын үед шаардагдах ур чадварууд:

- Уучлах
- Шүүмжлэн буруушаахгүй байх

- Чин сэтгэлээсээ хандах
- Тустай байх
- Өөрийгөө илэрхийлэх
- Холбоо тогтоох
- Импати
- Бууж өгөх
- Сонсох
- Итгэлцэл бий болох

Ярилцлага хийхэд нийгмийн ажилтанд шаардагдах ур чадварууд

- Ажиглах чадвар
- Сонсох, ялангуяа тусган сонсох чадвар
- Асуулт асуух чадвар
- Таатай уур амьсгал бүрдүүлэх, бий болгох чадвар
- Биеийн үйлдлээрээ харуулах

**Ажиглах чадвар.** Үйлчлүүлэгч ярилцлагын үед өөрийн гаргаж буй зан үйл, үйлдэл, биеийн хөдөлгөөн зэрэг үгэн бус үйлдлээрээ өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж байдаг. Түүнчлэн үйлчлүүлэгчийн өгч буй мэдээлэл нь цаанаа өөр мэдээлэл агуулж, тодорхой мэдрэмжийг тусгасан байх нь бий. Үйлчлүүлэгчийн иймэрхүү өөрийн хэл яриагаараа шууд илэрхийлээгүй мэдээ, мэдээлэл, зан үйлд мэдрэмжтэй байх нь нийгмийн ажилтан өөрийгөө тухайн нөхцөлд тохируулах, үйлчлүүлэгчийн ярих явцдаа өгсөн мэдээллийн үнэн эсэхийг тодруулах, ямар хариу үйлдэл үзүүлэх зэргийг тодорхойлоход хэрэгтэй.

Үйлчлүүлэгчтэй ярилцах үед ажиглах зүйлс:

- Биеийн хөдөлгөөн - Үйлчлүүлэгчийн сууж буй байдал, нүүр царайны хувирал, гар хурууны хөдөлгөөн, дохио зангаа зэрэг нь ямар нэгэн юмыг илтгэж байна уу?
- Эхний ба төгсгөлийн өгүүлбэрийн утга, санаа - Ярианы эхэнд юмуу төгсгөлд хэлж буй өгүүлбэр нь цаанаа ямар нэгэн чухал зүйл агуулж байх магадлалтай байдаг.
- Яриа, хэлэлцүүлгийн явцад гаргаж буй шилжүүлэг, өөрчлөлт, зайлсхийлт
- Үйлчлүүлэгч ямар нэг сэдвийн тухай ярихаас олонтаа зайлсхийх, яриаг өөр тийш нь шилжүүлэн залах нь тухайн сэдэв үйлчлүүлэгчид хэцүү, шаналгаатай байгааг илтгэнэ.
- Үйлчлүүлэгчийн хэл буй санаануудын хоорондын уялдаа, авцалдаа
- Олонтаа давтан хэлж буй санаа
- Хоорондоо нийцгүй, зөрчилтэй санаа
- Хямрал, зөрчлийн байдал зэргийг анхааралтай ажиглах нь чухал.

**Сонсох чадвар.** Аливаа ярилцлагын үед нийгмийн ажилтанд шаардагдах хамгийн чухал ур чадварын нэг нь сонсох юм. Нийгмийн ажилтан ярилцлагын үед үйлчлүүлэгч юуны тухай ярьж байна, асуултанд хэрхэн юу гэж хариулж байгааг анхааралтай, бүрэн дүүрэн сонсох шаардлагатай. Нийгмийн ажилтан хэлэх, ярих байдлаараа харилцан адилгүй хүмүүстэй уулздаг учраас тэдний яриаг бүрэн дүүрэн сонсож ойлгох өөрийн ур чадвараа хөгжүүлэх явдал чухал.

Үйлчлүүлэгчийн яриаг сонсох үед хамгийн чухал нь үйлчлүүлэгч тухайн хэлж байгаа үг, өгүүлбэрээрээ чухам юуны тухай хэлэх гээд байгаа, ямар санааг илэрхийлээд байгааг тунгаан бодож, ойлгох явдал байдаг. Түүнчлэн өөрийн мэдрэмжээ илэрхийлсэн үгнүүд, тэдгээрийн тухай ярихдаа гаргаж буй сэтгэл хөдлөлийн байдал зэргийг мөн сайтар сонсох шаардлагатай.

Сонсох ур чадвар:

- Сонсож, дэмжиж байгаагаа дохио зангаа, үйл хөдлөл, хэл яриагаараа илэрхийлэх
- Тодруулах асуулт асуух
- Үйлчлүүлэгчийн хэлсэн үг, өгүүлбэрийг өөрчилсхийж хэлж, зөв ойлгосон эсэхээ баталгаажуулж, нэгтгэн үйлчлүүлэгчид эргэж хэлэх
- Нийгмийн ажилтан өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх

**Асуулт тавих чадвар.** Нийгмийн ажилтны асуулт тавих ур чадвар нь ярилцлагын үед тавих асуултын төрлүүд ба тэдгээрийг ямар нөхцөлд хэрхэн асуух тухай мэдэж байх төдийгүй

тэдгээрийг тохирох нөхцөлд чадварлагаар хослуулан ашиглах чадвараар тодорхойлогддог. Асуултын нээлттэй ба хаалттай төрлүүд байдаг.

Ярилцлагын үед нийгмийн ажилтан асуулт тавихдаа дараах алдаануудыг түгээмэл гаргадаг байна. Үүнд:

- Нэг дор олон асуулт тавих
- Хаалттай асуултыг хэт их хэрэглэх
- Яагаад? асуултыг болгоомжгүй, олонтаа хэрэглэх
- Өөрийн санаа бодол, сэтгэгдэл, мэдрэмжид хэт хөтлөгдөн чиглүүлсэн асуулт тавих

### Ярилцлагын үед тавих асуултын төрлүүд

• Нээлттэй асуулт	Хаалттай асуулт
Нээлттэй асуулт нь үйлчлүүлэгч хариултаа өөрийн мэдрэмж, туршлага, санаа бодол дээр үндэслэн бодож, боловсруулж хариулах асуулт юм.	Үйлчлүүлэгчээс тодорхой, хязгаарлагдмал хариулт шаардсан асуулт юм. Заримдаа энэ тийм, үгүй гэсэн хариултын аль нэгийг шаардсан хэлбэрээр тавигддаг.
<ul style="list-style-type: none"> <li>• Ямар?</li> <li>• Хэрхэн?</li> <li>• Тэгнэ үү, болох уу?</li> <li>• Яагаад?</li> </ul> Жишээ нь Танай хүүхэд сургуульдаа явах дургүй байгаагийн шалтгааныг та юу гэж бодож байна вэ? Таны нөхөр таныг архинаас гарахад хэрхэн тусалж байна бэ?	Жишээ нь: Та хэдэн настай вэ? Та хүүхэдтэйгээ хамгийн сүүлд хэзээ уулзсан бэ? Та гэрийн даалгавар хийхдээ өдөрт хэдэн цаг зарцуулдаг вэ?

Нээлттэй асуултын хэлбэрүүд:

- Юу, Ямар? - Энэ төрлийн асуулт нь юуны тухай ярих ёстойг тодотгож өгснөөрөө үйлчлүүлэгчид ойлгомжтой бөгөөд хариулахад хялбар байдаг.
- Хэрхэн? - Энэ төрлийн асуулт нь тодорхой арга зам, үйл явцыг дэлгэрүүлэн асууснаараа үйлчлүүлэгчийн хандлага, мэдрэмж, сэтгэгдэл, санаа бодлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бололцоог олгодог.
- Тэгнэ үү, болох уу, чадах уу? - Энэ төрлийн асуулт нь үйлчлүүлэгчийг хүндэтгэсэн, дэмжсэн өнгө аясыг хадгалдаг учраас тодорхой сэдвийг дэлгэрүүлэн ярих, нэмэлт мэдээлэл цуглуулахад гол төлөв хэрэглэгдэнэ.
- Яагаад?-Энэ асуултыг нийгмийн ажилтнууд маш болгоомжтой хэрэглэх шаардлагатай. Учир нь яагаад гэсэн асуулт үйлчлүүлэгчийг өөрийгөө хамгаалах байр сууринд хүргэж болзошгүй байдаг. Ийм замаар үйлчлүүлэгчтэй харьцахад үйлчлүүлэгчид шүүгдэж байгаа мэт сэтгэгдэл төрж болзошгүй учраас ярилцлагын үед үйлчлүүлэгчид тухайн асуулт ямар сэтгэгдэл, мэдрэмж төрүүлж болохыг бодолцон шаардлагатай үед хянуур хэрэглэнэ.

### Дүгнэлт

Харилцаа нь ярилцлагын цөм болдог бөгөөд сонсох, асуух, ажиглах нь харилцааны чухал чадварууд бөгөөд эдгээр нь мэдээллийг авах итгэл бий болгох, харилцааг хөгжүүлэх, үйлчлүүлэгчийг ойлгох үйл явцыг дэмждэг. Үйлчилгээний үе шатууд тэр дундаа эхний үеүүдэд нийгмийн ажилтанд эдгээр ур чадварууд хамгийн чухал байдаг. Мэргэжилтний хувьд туслах гэсэн хүсэл, анхны уулзалтын түгшүүр зэрэг нь асуудлыг хэт эрт шийдэх, сургамж өгөх, хэт хаалттай асуулт тавих, дуугүй байдлыг эвдэх гэж яарах гэх мэт алдаанд хүргэж болохыг санах хэрэгтэй.



**Ном зүй:**

- Батхуяг, С., Төртогтох, Б., Цогзолмаа. Н. (2015). Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник. Улаанбаатар хот. Хүслийн өнгө хэвлэх үйлдвэр.
- Мягмарсүрэн, Б., Нямдорж, Н., (2001). Нийгмийн ажлын зуны сургалтын гарын авлага” Улаанбаатар хот
- Мариане Воодсайд, Триса Маклам, Саунна Вильсон (2003). “Кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл” Монгол Улсын Боловсролын Их сургууль, Save the Children
- Солонго,Д, Саранчулуун,О, Роман Стриженец (2010). "Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил" Каритас Чех Репаблик, Хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр. УБ
- Оюут-Эрдэнэ,Н. (2008) Нийгмийн ажлын дадлагын арга зүй, ач холбогдлол Улаанбаатар хот, МУБИС-ийн хэвлэх цех

## HEAD OF THE STATE AUTO INSPECTION THE MAIN SUBJECT OF MAKING ROAD SAFETY

*Yagaantsetseg Battulga*  
*Student of the 2nd faculty*  
*(Academy of Management of the Ministry of Internal Affairs of Russia)*  
*police colonel*

**Annotation:** In solving the diverse and laborious tasks of ensuring road safety, the main role is assigned to the State Road Safety Inspectorate of the Ministry of Internal Affairs of Russia and the Mongolian Traffic Police, including the authorities. In addition, control by Internal Affairs acts as a mandatory and effective means of preventing road traffic offenses and crimes, because it has a direct or indirect relation with road safety.

**Key words:** ensuring road safety, task and function of the head of the State Traffic Inspectorate, ensuring road safety

With the democratization of social relations, the content and the nature of state administration changes – it is becoming more organizational, which means that, along with direct influential actions associated with the process of developing and making decisions (we mean the management function), we use motivation, prediction, and control.

Therefore, it is reasonable to talk about the management of traffic safety, or the coordination functions, which include organizational principles. Moreover, it is necessary for the regulation to enshrine full powers of the corresponding authorities.

The process of road safety management by the state administration can be divided into following parts:

- preparation for management decision making;
- management decision making;
- implementation of management decisions;
- monitoring the implementation of management decisions;
- adjustments in case of insufficient implementation of the management decision.

Management decision has a number of scientific definitions. Common to all definitions is that the decision must be imperious, binding. That is, it obliges, prohibits, allows, because it is an act of the governing body or authorities. In addition, the decision is binding on the establishment of a socially necessary action or behavior, always aimed at the future, at achieving certain goals [2, p. 152].

A variety of definitions of the concept of "management decision" necessitates the identification of signs of a managerial decision:

- has an executive, strong-willed character;
- adopted by authorized state bodies (their officials);
- is a form of expression of the targeted governing influence of the subject of public administration on its object;
- the management decision is binding or recommending to the management object;
- management decision is an action by which the management problem is solved
- is conscious in nature;
- management decision considers existing feedbacks.

Based on these signs, a management decision can be defined as an act of the subject of management - the head of the State traffic inspectorate. Such a decision has a conscious-volitional nature, considers existing feedbacks and is aimed at the practical implementation of a targeted influence on the object of public administration - road safety.

Since management decisions are made by authorized bodies (officials) in the process of managing road safety on a legal basis, they (decisions) implement the rule of law. Hence, one

can distinguish three types of managerial decisions in accordance with a certain form of implementation of the rule of law:

- permissive;
- prohibitive;
- obligatory.

Permissive decisions are decisions taken on the basis of permissive norms, that is, management entities carry out certain actions to which they are permitted by law.

A managerial authorization decision will be legitimate if management entities carry out actions permitted by law.

Prohibitive decisions made on the basis of prohibitive norms, consist in the fact that the subjects of legal relations in the field of road safety management refrain from misconduct that is prohibited by the rules of law. In the event that the prohibiting decision is not implemented, the implementation of the sanction of the relevant legal norm enters into force.

Mandatory decisions are made in accordance with state and departmental regulatory legal acts. Their meaning lies in the fact that the subject of traffic safety management performs targeted actions to fulfill the legal duties assigned to him.

This position on the allocation of certain types of managerial decisions is due to the existence of legal and non-legal forms of government. If we look at legal forms, we mean the legal consequences of using these forms - the creation or amendment of the legal regime, the generation, modification or termination of specific legal relations. That is, the legal consequences that occur when issuing management acts, entering into transactions, and the implementation of rule-making activities by state bodies.

For example, The State Traffic Inspectorate, in accordance with the tasks assigned to it, participates in the development of draft laws, other normative acts, documents, including rules, norms, standards, state and regional programs for ensuring road safety and its participants. Decree of the President of the Russian Federation of June 15, 1998 N 711 "On Additional Measures to Ensure Road Safety [1]" clarifies the competence of the Chief of the State Traffic Inspectorate as follows:

- a) take part in the development and implementation of the main directions of state policy in the field of ensuring road safety, as well as in coordinating the activities of federal executive bodies and executive bodies of the constituent entities of the Russian Federation;
- b) represent the Ministry of Internal Affairs of the Russian Federation in relations with the Government of the Russian Federation, federal executive bodies, state authorities of the constituent entities of the Russian Federation;
- c) conduct correspondence on behalf of the Ministry of the Interior of the Russian Federation;
- d) request and receive in the prescribed manner from federal bodies of state power, bodies of state power of the constituent entities of the Russian Federation, local authorities of municipalities, organizations and officials information on their compliance with the legislation of the Russian Federation in the field of road safety;
- e) make orders (decrees, representations, decisions) , in accordance with the legislation of the Russian Federation, to federal bodies of state power, bodies of state power of constituent entities of the Russian Federation, bodies of local self-government of municipalities and organizations, to eliminate violations of the laws of the Russian Federation in the field of road safety;
- f) create expert bodies (councils, commissions, groups) on issues related to the prevention of road traffic accidents and the reduction of the severity of their consequences, in agreement with interested state bodies and organizations;
- g) represent the interests of the Russian Federation in international organizations and in foreign relations, in accordance with the legislation of the Russian Federation;


- h) manage the activities of the main state road safety inspectors in the constituent entities of the Russian Federation.

Thus, the activity of the heads of the traffic police bodies is associated with the adoption of a whole range of managerial decisions, since the road safety management process is characterized by the following features:

- is an expression of the functioning of the management system;
- has a certain structure in the form of stages;
- the change in stages is cyclical in nature, which manifests itself in the fact that after receiving reporting information on the implementation of the management decision, the stages of the management process are repeated;
- The main stages and stages of the road safety management process are enshrined in law;
- the management process is carried out by authorized state bodies (officials), the powers of which are fixed by the legal norm.

As we have already analyzed the functional aspect of the activity of the heads of the State Traffic Inspectorates that are revealed in these areas through the corresponding managerial tasks, which form a certain structure for the performance of work, reflects rather a behavioral one.

Professor Elagin A.G., identified three directions of the leader's actions (strategic, organizational, support) and identified certain tasks in each direction [3, p. 20]



*Pic. 1. Safety Leaders' Activities*

The effective and purposeful activity of the chiefs, who ensure safety, is processed firstly through the organization of joint actions of the personnel of special structures. Certain determinant factors, such as thought, motivation, knowledge, and action, influence this activity. Those factors are the most important predictors of successful achievement of the set goals.

#### **List of references**

1. Decree of the President of the Russian Federation of June 15, 1998 N 711 (as amended on September 15, 2018) "On Additional Measures to Ensure Road Safety" (Regulation on the State Road Safety Inspection of the Ministry of Internal Affairs of Russia) [Electronic resource]: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW) (accessed: 12/19/2019).
2. Bezhentsev A. A. Road safety: Textbook / - Moscow: University textbook, SIC INFRA-M, 2019.
3. Elagin A. G. Security (theory, support, management): scientific publication / Academy of Management of the Ministry of Internal Affairs of Russia. - M., 2013.

---

<sup>i</sup> UCP 600, Article 4 "Credits v. Contracts"

a. A credit by its nature is a separate transaction from the sale or other contract on which it may be based. Banks are in no way concerned with or bound by such contract, even if any reference whatsoever to it is included in the credit. Consequently, the undertaking of a bank to honour, to negotiate or to fulfil any other obligation under the credit is not subject to claims or defences by the applicant resulting from its relationships with the issuing bank or the beneficiary.

A beneficiary can in no case avail itself of the contractual relationships existing between banks or between the applicant and the issuing bank.

b. An issuing bank should discourage any attempt by the applicant to include, as an integral part of the credit, copies of the underlying contract, proforma invoice and the like.